Дархан нэхий ХК, Дархан минж ХК үйлдвэрүүд нь ус хэмнэх, эрчим хүч бага зарцуулах, хаягдал багасгах чиглэлээр боловсруулах үйлдвэртээ тэргүүлэх технологи нэвтрүүлж байгаа юм байна. Тухайлбал арьсны захалгаанаас гарч буй хог хаягдал нь Нэхий ХК-д их хэмжээгээр хураагдсан байгаа бөгөөд энэхүү хаягдлыг шахмал ширний үйлдвэрт түүхий эдийн нөөц болгон ашиглахаар хадгалж байна. Шахмал ширний үйлдвэр удахгүй ашиглалтад орох юм байна. Мөн захалгаанаас гарч буй будагтай, хромтой нэхийний захалгаагаар хавтан болон шаахай хийдэг бөгөөд жижиг гар аргаар үйлдвэрлэгч нарт зарж борлуулдаг байна.



Зураг 16. Арьсны захалгаанаас гарсан хаягдал



Зураг 17. Нэхий тайрах дамжлагаас гарсан ноос

Нэхий тайрах дамжлагаас гарч буй ноосыг ашиглан эсгий хийхээс гадна жижиг дунд бизнес эрхлэгчдэд зардаг.

Дархан нэхий ХК-ны хувьд нэхий болон шир, савхины хог хаягдал гардаг. Нэхийн хог хаягдал нь хуурай ба нойтон хэлбэрээр жилд дунджаар  $136 \text{ м}^3$  хаягдал гардаг. Хуурай хаягдлын хувьд хөвсгөр жин багатай байх ба 7-р сараас бусад бүх саруудад ажиллаж 7 хоногт  $2 \text{ м}^3$ , сард  $8 \text{ м}^3$  жилдээ  $88 \text{ м}^3$  хаягдал гардаг. Харин нойтон хаягдлын хувьд жин ихтэй арьсны шар махны хаягдал орох ба 10 сараас 3 сар хүртэлх хугацаанд гардаг.



## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хүснэгт 3. Нэхийнээс гарах хог хаягдал. м<sup>3</sup>

Нэр төрөл	7 хоногт	1 сард	6 сарын хугацаанд	1 жилд	Нийт
Хуурай хаягдал	2	8		88	136
Нойтон хаягдал	2	8	48		

Хүснэгт 4. Шир. савхинаас гарах хаягдал. м<sup>3</sup>

Нэр төрөл	7 хоногт	1 сард	4 сарын хугацаанд	Нийт
Нойтон хаягдал	3	12	48	48

Шир, савхины хаягдал нь нойтон хэлбэрээр 12 сараас 3-н сарыг дуустал 4 сарын хугацаанд гардаг бөгөөд 7 хоногт 3 м<sup>3</sup>, 1 сард 12 м<sup>3</sup>, 4 сарын хугацаанд 48 м<sup>3</sup> хаягдал гардаг байна. Эдгээр хог хаягдлыг нийтийн аж ахуйн үйлчилгээний машинаар ачиж хаядаг байна. Дархан нэхий ХК нь боловсруулах үйлдвэрээс гарах хаягдлыг дахин боловсруулах эдийн засгийн эргэлтэд оруулах тал дээр бодлого боловсруулж ажиллаж байгаа тул гол хаягдал болох бараат хогийн цэгт хаягдаж байгаа арьсны шар махны хаягдлыг боловсруулах талын судалгааг цаашид хийх шаардлагатай байна.

### Хүндрэл бэрхшээл:

- Үйлдвэрүүдийн хог хаягдлын талаарх мэдээлэл судалгаа хомс
- НААҮГ-тай гэрээ байгуулж хамтран ажилладаг үйлдвэр цөөхөн
- Байгууллагуудын хог тээвэрлэж буй машин техник стандарт шаардлага хангадаггүй
- Хяналтын систем байхгүй
- Хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтэн байдаггүй
- Энгийн болон аюултай хог хаягдлын бүртгэл судалгаа хийдэггүй
- Хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах менежмент, төлөвлөлт байдаггүй

# ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## 1.3.5. Барилгын хог хаягдал


Дархан-Уул аймгийн хувьд 2020 оны байдлаар 245.05 тн орчим барилгын хатуу хог хаягдал гарсан байна. Дархан орчмын шохойн үйлдвэрүүдээс жилд дунджаар 22200тн хаягдал гардаг. Мөн хайрга, дайраг, элсний карьеруудаас жилд дунджаар 300000м<sup>3</sup> хаягдал гардаг байна.

Хүснэгт 5. ДДЦС ТӨХК-ийн үнсэн сангийн мэдээлэл

Хог хаягдлын нэр	Байршил	Талбай	Хэмжээ /жилийн дундаж/	Бохирдол
Хаягдал үнс	Дархан-Уул аймаг 15-р баг үйлдвэрийн районд	64.52 га	58000-65000 тн	Химийн болон ахуйн бохирдол байхгүй

Дархан сумд бүтээн байгуулалтын ажил эрчимтэй явагдаж байгаа өнөө үед барилгын сууриас гарах хаягдал шорооны хэмжээ улам нэмэгдэж гарсан шорооны 25-35% нь эргэн булалт, өндөршилт зэрэгт ашиглагдаж, үлдсэн 65-75% нь дурын газарт хаягдаж байна. Мөн дараагийн нэг эх үүсвэр нь амины орон сууц, хашаа, байгууламж, зам талбай хөрс зэргийг буулгах, шинэчлэх ажлуудыг гүйцэтгэх явцад бетон, тоосго, блок, мод, бусад материал, бохирдсон хөрс, шороо, элс хайрга зэрэг барилгын хог хаягдал ихээхэн хэмжээгээр гарч байна.

Дархан сумын хэмжээнд 2019 оны байдлаар 1000 тн барилгын хог хаягдал Бараат хогийн цэг дээр буусан нь нийт хог хаягдлын 3% эзэлж байгаа хэдий ч барилгын талбай дээр нь булагдсан, хууль бусаар татан зайлуулсан хогийн хэмжээ энэ дүнд ороогүй.



Зураг 18. Хууль бусаар хаясан барилгын хог хаягдал

Барилгын хог татан зайлуулах нэгдсэн тогтолцоо байхгүйгээс иргэн, ААН-үүд хууль бусаар тээвэрлэлт хийн албан бус хогийн цэгүүд үүсгэдэг. Хууль бусаар тээвэрлэж нийтийн эзэмшлийн зам талбайд бий болгосон албан бус барилгын хогийн цэгүүд нь цэвэрлэх, татан зайлуулахад техник, хүн хүч их шаарддаг тул цаашид барилгын хаягдлыг татан зайлуулах, дахин боловсруулах бодлого менежментийг сайжруулах хэрэгцээ шаардлага зүй ёсоор тавигдаж байна.


### Хүндрэл бэрхшээл:

- Барилгын хог хаягдлыг татан зайлуулах тодорхой эрхзүйн зохицуулалт байхгүй
- Барилгын хог хаягдлын хэмжээ, төрлийн талаар бүртгэл судалгаа байхгүй

## 1.3.6. Аюултай болон эмнэлгийн хог хаягдал

Хог хаягдлын тухай хууль 2017 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанаар шинэчлэн баталсан хуульд 4.1.2-т “Аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг хэлнэ гэж заасан.

Хог хаягдлын тухай хуулийн 7.1.3-т заасныг үндэслэн Аюултай хог хаягдлын жагсаалтыг баталсан ба тус жагсаалтад багтсан хог хаягдлыг Аюултай хог хаягдалд авч үзнэ.



Зураг 19. Аюултай хог хаягдлын төрөл

Дархан сумын хэмжээнд аюултай хог хаягдлын зохицуулалт хангалтгүй, энэ талаарх мэдлээлэл хязгаарлагдмал байна. Улсын хэмжээгээр жил тутам гаргасан аюултай хог хаягдлын хэмжээг 27000–54000 тонн орчим гэж тооцоолж байна.

Бараат хогийн цэг дээр хаягдаж байгаа аюулгүй болон аюултай хог хаягдлуудаас үүдэлтэй хүнд металл, хорт бодис агуулсан шүүрэл нь хөрсөөр дамжин газрын доорх усыг бохирдуулах, цаашлаад хур борооны ус, салхиар дамжин орчинд тархаж бохирдуулах өндөр магадлалтай. Хогийн цэгт байнгын шаталт явагдаж байгаагаас диоксин, фуран зэрэг онцгой хорт бодисууд агаарт ялгарч агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Иймд Дархан сум аюултай хог хаягдлын тайлагнах механизмыг сайжруулах хэрэгтэй байна.

Дархан сумын нутаг дэвсгэрт химийн бодис ашигладаг. аюултай хог хаягдал үүсгэж болзошгүй аж ахуйн нэгж байгууллага 39 байгаагаас арьс шир боловсруулах үйлдвэр 2, эрүүл мэндийн чиглэлийн үйлчилгээ эрхэлдэг 24 байгууллага байна.

Дархан-Уул аймагт үүсдэг аюултай хог хаягдлын төрлийг нарийвчлан “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл 2017”-д зааснаар хавсаргав (Хавсралт 6). Аюултай хог хаягдлын жагсаалтад хог хаягдлыг эх үүсвэрээр нийт 20 бүлэгт ангилан хуваасан ба “Аюултай” буюу “А” тэмдэглэгээтэй хог хаягдал нь түүнд агуулагдаж байгаа хортой, аюултай бодисын агууламжаас үл харгалзан шууд аюултай хог хаягдалд тооцогдоно. “Хяналттай” буюу “Х” тэмдэглэгээтэй хог хаягдлын хортой, аюултай бодисын агууламж нь зөвшөөрөгдөх хэмжээнээс их байвал аюултай хог хаягдалд хамааруулна. Бохирдлын хэмжээг тогтмол хяналтад байлгах шаардлагатай бөгөөд хортой, аюултай бодисын агууламж нь тогтоох боломжгүй тохиолдолд “хяналттай” хог хаягдлыг аюултай хог хаягдалд шууд хамруулан авч үзнэ. Аюултай хог

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

хаягдлын жагсаалтад тусгагдсан 10. 16. 17 бүлгүүдэд тусгагдсан барилгын хог хаягдал болон Дулааны станцаас үүсэх үнс, гангийн үйлдвэрээс үүсэх доторлогооны материал, үнс, шаарга зэрэг нь барилгын дахин сэргээгдэх материалаар буюу тэдгээрийг дахин боловсруулан бага даацтай бетон, цемент үйлдвэрлэх боломжтой. Барилгын хог хаягдлыг боловсруулах үйлдвэрийн төслийн түүхий эдэд эдгээр хаягдлын талаар тусгагдсан.

Дархан сумын нийт 39 аж ахуйн нэгж, байгууллагад давхардсан тоогоор 1586 төрлийн 5160 тн химийн аюултай болон хортой бодис, арьс ширний үйлдвэрлэл, эмнэлэг, сургууль нэр бүхий 8 аж ахуйн нэгжид устгах шаардлагатай 261 нэр төрлийн 8.79 тн химийн аюултай болон хортой бодис байна.

- Үйлдвэрлэл (17)
- Үйлчилгээ (2)
- Туршилт судалгаа (1)
- Оношилгоо шинжилгээ (5)
- Сургалт (14) -ын зорилгоор ашиглагдаж байна. (Онцгой байдлын газар, 2019)

Дархан-Уул аймаг тээврийн хэрэгсэл болон автомашины тооллогоор 2018 онд 25291 болон 24133, 2019 онд 26984 болон 25673 тоо бүхий тээврийн хэрэгсэл, автомашиныг тус тус тоолуулсан байна. Тээврийн хэрэгсэлд ашиглагдсан 10 орчим төрлийн аюултай хог хаягдал гарах бөгөөд нийт тоологдсон тээврийн хэрэгсэлтэй харьцуулан хэдий хэмжээний аюултай хог хаягдал ялгарахыг тооцож болдог байна. Тухайлбал, Аккумулятор /2 жилд 1 удаа аккумулятороо сольдог/, хүхрийн хүчил, моторын тос, хурдны хайрцагны тос, тосны фильтр, хөлддөггүй шингэн, тормозны шингэн, накладкын хаягдлууд томоохон жин дарж байна. Мөн ахуйн хэрэглээнээс гарах утас, зөөврийн компьютер, бусад цахилгаан төрөөмжүүдээс гарах батарейн хаягдлын боловсруулалт анхаарал татсан асуудал болоод байна.

Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг энэ чиглэлээр судалгаа, сургалт, үйлдвэрлэл, хяналтын ажил эрхэлдэг байгууллагуудаас гарах хий, шингэн, хатуу хаягдлыг эрүүл мэндийн байгууллагын "нийт" хог хаягдал гэнэ. Хүн ба мал эмнэлгийн байгууллагаас эмнэлгийн хог хаягдлыг тусгай зориулалтын уутанд цуглуулан авч, ангилан ялгах үйлдвэрт ангилан, ангилсан хатуу хог хаягдлыг автоклавт халдваргүйжүүлж, бутлуурын тусламжтайгаар бутлан жижиглэнэ. Ангилсан биологийн хог хаягдлыг 900-1200°C хэмийн шатаах зууханд шатаадаг бөгөөд эцэст нь ландфиллд булаж устгадаг боловсруулалтын технологи Улаанбаатар хотод хэрэгжиж байна.



Зураг 20. Дархан сумын аюултай хог хаягдлын эх үүсвэрүүд



# ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Дархан сумд аюултай хог хаягдлыг хэрэглэх, устгах, хадгалах, тээвэрлэх, боловсруулахтай холбоотой жин дарж буй дараах төрлийн хог хаягдлууд байна. Үүнд:

- Эмнэлгийн хог хаягдал
- Тээврийн хэрэгслийн хог хаягдал
- Химийн бодис, түүнтэй холбоотой хаягдал
- Ахуйн болон цахилгаан хэрэгслийн хуурайбатарей
- Үйлдвэрээс гаралтай хаягдал


## 1.3.6.1. Эмнэлгийн хог хаягдал

Дархан сумд нэгдсэн эмнэлэг 2, өрхийн эмнэлэг 5, ортой эмнэлэг 12, үүдэн эмнэлэг 52, сувилал 5, эм ханган нийлүүлэх болон эмийн сан 44 ажиллаж байна. 2020 оны жилийн эцсийн хог хаягдлын тоо мэдээнээс дүн шинжилгээ хийж үзсэн. Эмнэлгийн хог хаягдлын эх үүсвэрүүд нь нэгдсэн, өрхийн, ортой, үүдэн, шүдний эмнэлэг, эмийн сан, COVID 19 болон сонгуулиар үүссэн эмнэлгийн болон байгууллагуудаас татан төвлөрүүлсэн хог хаягдал байна. Хаягдлыг улирлын дүнгээр нь авч үзвэл: нэгдсэн эмнэлэг хамгийн өндөр хаягдал үүсгэдэг буюу I улиралд 6036 кг, II улиралд 5885 кг, III улиралд 6474 кг, IV улиралд 3151 кг хог үүссэн. 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 52156 кг /52.15 т/ байна.

Дархан сумд үүсэж буй эмнэлгийн хог хаягдлыг аюулгүй эмийн хайрцаг, халдвартай болон эмгэг хог гэж төрөлжүүлэн ангилдаг ба 2020 оны жилийн эцсийн байдлаар аюулгүй эмийн хайрцаг 8.73 тн халдвартай хог 41.52 тн эмгэг хог 1.96 тн тус тус үүссэн байна. Халдвартай хог хаягдал ихэнх жинг дарж байна.




Зураг 21. Эмнэлгийн хог хаягдал /2020 оны байдлаар/



Зураг 22. Эмнэлгийн хог хаягдлын төрөл

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дархан сумд эмнэлгийн хог хаягдлыг устгах, боловсруулах аргачлал нь уламжлалт арга барилаар эх үүсвэр дээр нь цуглуулах, тээвэрлэх, шатааж ариутгах болон шууд газарт булшлах байдлаар өнөөдрийг хүртэл явагдаж ирсэн. Эрүүл мэндийн сайдын 2011 оны 05 сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалын дагуу эмнэлгийн хог хаягалыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж цуглуулах зарчмыг баримталж байгаа сайн талтай боловч хог хаягдлыг эмнэлгийн байгууллагаас зориулалтын бус техник хэрэгслээр тээвэрлэн байгальд шууд шатаах замаар ариутгал хийн газар ухсан нүхэнд дарж булшилж байгаа нь байгальд хор нөлөөтэй, шатсан хорт хий ойр орчимд тархах зэрэг эрсдэлийг дагуулсаар байна.



Зураг 23. Эмнэлгийн хог хаягдлыг устгаж буй байдал

### 1.3.6.2. Тээврийн хэрэгслийн хог хаягдал

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2019 онд манай улсад 1043028 машин бүртгэлтэй байсан бол 2020 онд 1136734 болж өсжээ. Автомашины ихэнх эд анги аюултай хог хаягдлын тоонд ордог. Тээврийн хэрэгслээс дараах аюултай хог хаягдал гардаг байна.

Үүнд: Ашиглалтаас гарсан машин, механизм тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх хаягдал, хаягдал тос ба шингэн түлш, полихлорт бифенил (PCBs) агуулсан эд анги, тэсрэмтгий эд анги (хамгаалалтын дэр г.м), асбест бүхий тоормосны жийргэвч (накладка), тоормосны шингэн, батарей, аккумулятор, цахилгаан ба цахим тоног төхөөрөмж гэх мэт.

Тээврийн хэрэгслийн моторын ашигласан тос нь маш аюултай бохирдуулагч бодис юм. Энэхүү бодис нь олон төрлийн хүнд металлын (Pb, Zn, Cu, Cr, Ni, Cd гэх мэт) нэгдлүүд, РАН зэрэг хавдар үүсгэгч органик нүүрс устөрөгчийг агуулдаг. Иймд эдгээр моторын ашигласан тос хөрсөнд нэвчих, усанд урсаж орох, шатаасны дараа хүнд нэгдлүүд агаарт дэгдэх замаар хүрээлэн буй орчныг бохирдуулж, амьд организмыг хордуулдаг. Улмаар хөрсний бичил орчныг хордуулж удаан хугацаанд ургамал ургах боломжгүй болгож нөхөн сэргээгдэхэд хэдэн арван жил шаардлагатай болдог.

Дархан-Уул аймгийн хэмжээнд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 2017 онд 23222 байсан бол 2020 онд 28802 болж өсжээ. Дархан-Уул аймагт бүртгэлтэй байгаа автомашины тоог сүүлийн 4 жилээр наслалтаар нь ангилж харуулав.

Хүснэгт 6. Дархан-Уул аймгийн тээврийн хэрэгслийн тоо /2019-2020 он/

№	Машины насалт	2017	2018	2019	2020
1	0-3	179	326	308	352
2	4-6	580	859	379	366
3	7-9	1728	2526	3066	2583
4	10 ба түүнээс дээш жил	20735	21580	23231	25501
5	<b>Нийт</b>	<b>23222</b>	<b>25291</b>	<b>26984</b>	<b>28802</b>


## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Манай улсын хувьд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн ихэнх нь хуучин буюу ашиглагдаж байсан автомашиныг импортоор оруулж ирсэн байдаг тул автомашиныг үйлдвэрлэсэн оноос нь хойш ашигласан хугацаагаар нь тогтоодог байна. Дархан-Уул аймагт сүүлийн 4 жилд бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслийн 85-89 % нь 10 болон түүнээс дээш жил ашиглагдаж байгаа машин байна. Мөн ашиглалтаас аль хэдийн гарсан ч тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь улсад бүртгэлтэй хэвээр байдаг учраас жилд хэчнээн машин ашиглалтаас гарч байгаа талаарх нарийн мэдээлэл манай аймагт төдийгүй улсын хэмжээнд алга байна.

Дархан-Уул аймагт бүртгүүлсэн тээврийн хэрэгслийг (2020 он) дунджаар жилд 2 удаа моторын тос, 2 жилд нэг удаа аккумулятор сольдог гэвэл 230 тн орчим тос, 14400 ширхэг аккумулятор аюултай хог хаягдал болон хаягддаг байна. Мөн нэг засварын газар сардаа 40-50 дугуй цуглардаг гэнэ. Иймд гол жин дарж байгаа хаягдал нь ажилласан тос, аккумулятор, дугуй байна.



хаягдал тос  
200- 230 тн



аккумулятор  
14000-15000 ш



дугуй  
9600-12000 ш

Дархан сумд тээврийн хэрэгслээс гарч буй аюултай хог хаягдлыг хэрхэн хадгалж, тээвэрлэж, дахин боловсруулж байгаа талаар ямар ч мэдээлэл, тоо баримт алга байна. Зарим машин засвар, дугуй засвар, түүхий эд худалдан авах газруудаас машины ашигласан тос, аккумулятор, дугуй зэргийг хэрхэн хадгалж, зөөвөрлөж, устгаж байгаа талаар явуулсан судалгааны дүнг нэгтгэвэл:

- суудлын машин 4000-5000 км зам туулаад моторын тосоо сольдог
- ихэнх машин 1-2 сард тосоо сольдог
- солих тоолонд 3-5 л ажилласан тосыг юулж авдаг
- ажилласан тосыг хадгалж байгаад хувь хүмүүст 1л тосыг 500-1000 төгрөгөөр зардаг
- ажилласан тос ашигладаг зууханд шатаах зорилгоор хувь хүмүүс худалдаж авдаг
- цуглуулсан тосоо дахин боловсруулах үйлдвэрт тээвэрлэж өгч байгаагүй
- тос хадгалдаг зориулалтын сав, агуулах байхгүй
- дугуй засварын газарт сардаа 40-50 ширхэг хаягдал дугуй цуглардаг
- хаягдал дугуйгаа 300-500 төгрөгөөр зардаг /ихэвчлэн малчид авдаг/
- аккумуляторыг ихэвчлэн биржийн түүхий эд цуглуулах газарт авдаг
- хүчин чадлаасаа хамаараад 6000-10000 төгрөгөөр худалдаж авдаг
- аккумулятороо хэрхэн яаж боловсруулдаг, хэнд зардаг талаар мэдээлэл байхгүй

### 1.3.6.3. Химийн бодис, түүнтэй холбоотой хаягдал

Дархан сумд хорт болон аюултай бодисын тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллагуудын тоо 2021 оны байдлаар 67 байна. Зөвшөөрлийн төрлөөр нь авч үзэхэд 2008 онд 2 байсан бол 2020 оны байдлаар 112 болж өссөн бөгөөд ашиглах 51, импортлох 43, үйлдвэрлэх 1, худалдах 17 байна.

Дархан сумд 2019 оны байдлаар химийн бодис ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага 38 байсан бөгөөд эдгээрт 15865 төрлийн 5160.5 тн орчим химийн бодис ашиглаж байжээ. Ашиглалтын чиглэлээр нь авч үзвэл Дархан ДЦСТӨХК, ДДС ХК, Дулаан Шарын гол ТӨХК, Дархан Төмөрлөг, Эрэл цемент, Эйч Эс

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эм Жи ХХК зэрэг үйлдвэрүүд үйл ажиллагаандаа 2108 орчим кг химийн бодис, Дархан нэхий ХК, Дархан Минж ХК, Эко ноос үйлдвэрүүд 319.9 тн, Дархан хүнс ХК, Алтан хүнс групп, Монгол Алтан тос ХК, Дархан Меат Фүүдс болон хиам үйлдвэрлэлийн чиглэлийн цехүүд 1524 кг орчим, УГТХ, УЦУОШЛ, Ус Сувгийн лаборатори, МХА лабораториудад 788 орчим кг бодис ашиглаж Ус Сувгийн газар 180 кг шингэн хлор үйлдвэрлэлд ашигласан байна. Мөн хими цэвэрлэгээний газруудад 470 кг уусгагч бодисуудыг ашиглаж байгаа бол 3 их дээд сургууль, коллежид 130 орчим кг бодис, 11 дунд сургуулийн химийн лабораторид 300 орчим кг бодисыг тус тус сургалтад ашиглан, хадгалж байна.



Зураг 24. Дархан сумын химийн бодис ашигладаг аж ахуйн нэгж, байгууллага

Эдгээр ашиглаж байгаа бодисуудад химийн хорт болон аюултай бодисын ангилалд орсон хортой болон аюултай шинжтэй бодисууд нэлээдгүй байгааг анхаарч хадгалалт болон хэрэглээнд нь байнгын хяналт тавих шаардлагатай.

Аж ахуйн нэгж, байгууллага дээр хадгалагдаж байгаа чанарын шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй болон нэр хаяг нь тодорхойгүй химийн бодисын нэр төрөл, тоо хэмжээ, хадгалалтын нөхцөлийг тодорхойлох зорилгоор 2014 химийн бодисын тооллогыг улсын хэмжээнд хийсэн байна. Энэхүү тооллогоор Дархан-Уул аймгийн хэмжээнд устгах шаардлагатай хорт болон аюултай бодисын хэмжээ 445 төрлийн 691.2 кг хатуу, 52 төрлийн 131.39 л шингэн бодис хадгалагдаж байгааг тогтоожээ.

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дархан сумын хэмжээнд 2019 оны байдлаар 39 аж ахуйн нэгж байгууллагын 5160 гаруй тонн химийн хорт болон аюултай бодис, ашиглалтын шаардлага хангахгүй устгах шаардлагатай 261 төрлийн 897.34 кг химийн хорт болон аюултай бодис тус тус бүртгэгджээ. Энэхүү судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын 37.5 хувийг ерөнхий боловсролын сургууль эзэлж байгаа бөгөөд ашиглах, хадгалах хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй болсон, нэр томьёо, ашиглах хугацаа тодорхойгүй химийн бодисууд зориулалтын бус агуулахад хадгалагдаж байна. Энэ нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй байна.

Ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн бодис, сав баглаа боодлыг ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиуд, аж ахуйн нэгжүүд устгах шийдвэр гарах хүртэл холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагад нийцүүлэн байгууллага дээрээ хадгалах үүрэг хүлээж байна.

Устгах шаардлагатай химийн бодис, химийн бодисын сав баглаа боодол үйлдвэрлэл болон ахуйн хэрэглээнээс гарч байгаа химийн гаралтай хог хаягдал зэргийг байгальд ээлтэй аргаар устгах, булшлах, хоргүйжүүлэх төвлөрсөн байгууламж байхгүй тул зарим нь зориудын бус газар хадгалагдаж аюул үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

### 1.3.6.4. Ахуйн болон цахилгаан хэрэгслийн хуурай батарей

Зайг мөнгөн ус, цайр, хар тугалга тэргүүтэй химийн элементүүд, хүнд металлуудын оролцоотой бүтээдэг. Монгол улсад хуурай зайг боловсруулах, ашиглах, хадгалах хууль эрх зүй, үйлдвэрлэл байхгүйгээс цагны зай, хүүхдийн тоглоомын зай, гар утасны батарей, автомашины аккумулятор гээд ахуйн өргөн хэрэглээний зайг цэнэг нь дуусахад шууд хог дээр хаядаг.

Хуруу, гар утасны батарей болон бусад төрлийн хуурай зайг ямар ч хяналтгүй ил задгай хаягдаж байгаа нь хүний эрүүл мэндэд болон байгаль орчинд ямар их хор хөнөөл сөрөг нөлөөлөл үзүүлж эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна. Энэхүү олон хорт бодис агуулсан зай газрын хөрсөнд шигдэж, илжирч, агаарт уусан задарч бид түүгээр нь амьсгалдаг. Нэг ширхэг жижигхэн хуруу зай дөрвөн метр квадрат талбай хордуулж, 800 мянган литр ус бохирдуулдаг гэсэн дэлхий нийтийн судалгаа байдаг. Зай нь байгальд задралгүй 100 жил хадгалагдан улмаар задралд орж озоны давхаргад гарч нэг нэгж хорт бодис нь 16 нэгж талбайг цоолж маш их хор хохиролтой болохыг АНУ-ийн зарим эрдэмтэд аль хэдийн тогтоогоод байдаг. Зайг химийн найрлагынх нь хувьд маш олон ангилдаг бөгөөд манай оронд хамгийн түгээмэл хэрэглэгддэгт никель кадми (NiCd), никель металлийн холимог (NiMH) никель цинк (NiZn), литиум ион (Li-ion), мөнгөн ус (Mercury), шүлтэн (Alkaline) батарей зайнууд өргөн хэрэглэж байна.



Зураг 25. Хуурай зайн хувьсал



## **ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Хүн төрөлхтний хуурай зайн хэрэглээ жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа нь техник, технологийн хөгжилтэй шууд холбоотой. 2018 оны судалгаагаар нэг хүний хуурай зайн жилийн дундаж хэрэглээ 8-12 ширхэг байгаа боловч жил бүр өсөн нэмэгдэж байна. Монгол улсад нэг хүний хэрэглээг тодорхойлсон судалгаа байхгүй, хаягдал зайн цуглуулга, хуримтлал байхгүй тул тоон хэмжээг тодорхойлох боломж байхгүй байна.

Дархан-Уул аймгийн 2020 оны хүн амын тоон статистикаас авч үзвэл 105000 орчим хүн ам тоологдсон. Нэг хүнд оногдох хуурайн зайн хэмжээг гадны судлаачдын материалтай харьцуулж тооцож үзвэл жилд 1 сая орчим аюултай хуурай зайн хаягдал хаягдаж байгаа тооцоолол гарч байна.

### **Хүндрэл бэрхшээл:**

- Орон нутагт хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах бодлого хөтөлбөр хэрэгждэггүй тул аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрлийн талаарх нарийвчилсан мэдээлэл, судалгаа хомс
- Одоо ашиглагдаж буй эмнэлгийн хог хаягдлыг халдваргүйжүүлэх, шатаах зуух эвдэрсэн
- Эмнэлгийн хог устгах булшлах үйл ажиллагаа нь стандартад нийцдэггүй
- Аюултай хог хаягдлыг цуглуулан хадгалах, булшлах зориулалтын агуулах, ланdfилл байдаггүй
- Үйлдвэр, ААНБ, иргэд энгийн болон аюултай хог хаягдлаа ангилж хэвшээгүй
- Иргэд олон нийт аюултай хог хаягдлын талаарх мэдлэг ойлголт муу
- Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл судалгаа, бүртгэл, зохицуулалтыг хариуцсан мэргэжилтэн байхгүй
- Аюултай хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэл байхгүй

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 1.4. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭ

Дархан-Уул аймгийн НААҮГазрын цэвэрлэгээ, үйлчилгээний алба нь 553580м<sup>2</sup> авто зам, 97352м<sup>2</sup> явган зам, 263535 м<sup>2</sup> ногоон байгууламж, 250744 м<sup>2</sup> эзэнгүй талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажилладаг бөгөөд одоогийн байдлаар 97 үйлчилгээний ажилтан ажиллаж байна.

Хүснэгт 7. НААҮГ-ын хариуцсан нийтийн эзэмшлийн талбайн хэмжээ

№	Хэсэг нэгж	Авто замын хэмжээ			Явган замын хэмжээ		Ногоон байгууламж	Эзгүй талбайн цэвэрлэх м2	Нийт талбайн хэмжээ м2
		М	МКВ	МКВ	М	МКВ			
1	Зам талбайн 1-р хэсэг	20.026	155.072	8.199	11.707	23.414	75.463	53.500	315.648
2	Зам талбайн 2-р хэсэг	20.659	176.527	18.394	11.697	23.396	51.080	50.800	320.197
3	Зам талбайн 3-р хэсэг	7.869	78.003	22.762	10.299	20.598	87.793	50.600	259.756
4	Зам талбайн 4-р хэсэг	10.950	83.844	10.779	13.200	26.400	44.999	52.300	218.322
5	ДА -50 цогцолбор, жишиг хороолол				1.772	3.544	4.200	43.544	51.288
	Нийт	<b>59.504</b>	<b>493.446</b>	<b>60.134</b>	<b>48.675</b>	<b>97.352</b>	<b>263.535</b>	<b>250.744</b>	<b>1.165.211</b>

Эх үүсвэр: НААҮГ-ын тайлан мэдээ

Дээрх хүснэгтээс үзэхэд 1 үйлчилгээний ажилтан дунджаар 12012.48 м<sup>2</sup> талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллаж байгаа нь норматив хэмжээнээс давсан үзүүлэлттэй байна. Цаашид ажиллагчдын тоог нэмэгдүүлэх, техник, тоног төхөөрөмжийг бүтээмжийг сайжруулахад анхаарах зайлшгүй шаардлагатай.

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Одоогоор нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хүрз, дэрсэн шүүр ашиглан явуулдаг бөгөөд 2020 онд орон нутгийн төсвийн 17.5 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар 3 дугуйтай цахилгаан мотоцикл 5-ыг худалдан авч ашиглаж байн.



Зураг 26. Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн сав


Дархан сумын нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн болох Дархан-50 цогцолбор, Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн, Морин хуур цогцолборт нийтдээ 122 ш хогийн сав байршуулсан байгаа энэхүү хогийн савнууд нь иргэд хогоо ангилан ялгаж хаях боломжгүй савнууд байна. Цаашид эдгээр газруудад стандарт шаардлага хангасан хогийн сав байршуулах зайлшгүй шаардлагатай.

### Хүндрэл бэрхшээл:

- Хог хаягдлаа ангилан ялгадаггүй
- Нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдлын хэмжээ, бүтэц, төрлийн талаар бүртгэл судалгаа байхгүй
- Хог цуглуулах машин, төхөөрөмжийн хүчин чадал тааруу, ажлын багажны хангалт муу
- Ажилчдын ажлын ачаалал их, мэргэжилтэй боловсон хүчин хангалтгүй
- Хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах менежмент, төлөвлөлт байдаггүй
- Ажлын болон хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийн хангалт муу

## 1.4.1. Албан бус хогийн цэг

Дархан-Уул аймгийн хэмжээнд хог цуглуулах, татан зайлуулах, тээвэрлэх үйлчилгээг дан ганц төр хариуцан үзүүлдэг. Энэ үйлчилгээг хариуцан гүйцэтгэдэг НААҮГ-ын техник, хүн хүчний хангамж нь жил бүр өсөн нэмэгдэж байгаа хог хаягдлыг цуглуулах, татан зайлуулах, тээвэрлэх үйлчилгээг тогтмол чанартай үзүүлэх боломжгүй юм. Иймд жил бүр Дархан сумын нутаг дэвсгэрт бий болох албан бус хогийн цэг болон хогийн хэмжээ нэмэгдэх хандлагатай байдаг. 2018 онд албан бус хогийн цэг 144 байсныг 2019-2020 онуудад НААҮГ нь Дархан сумын захиргаа, баг, иргэд, ААН, байгууллагуудын оролцоотойгоор цэвэрлэж одоогоор 50 орчим хувиар бууруулсан байна.




Зураг 27. Үйлдвэрийн бүс орчмын хог хаягдлын тархалт, овоолго

НААҮГ нь сар бүр хууль бусаар үүссэн хур хогийг цэвэрлэдэг боловч 2021 оны 9 сарын байдлаар Дархан сумын хэмжээнд 688772.4 м<sup>3</sup> хог бүхий хэд хэдэн албан бус хур хогийн цэгүүд байгаагаас үйлдвэрийн бүсэд 664532.5 м<sup>3</sup> хур хог бүхий овоолго байна.



## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ




Зураг 28. Бараат төвлөрсөн хогийн цэгийн овоолго тархалтын өнөөгийн байдал

Бараат төвлөрсөн хогийн цэг орчимд 27773.72 м<sup>2</sup> талбайг хамарсан 16782.5 м<sup>3</sup> албан бус хогон овоолго бий болсон байна. Эдгээр хур хог бүхий хогон овоолгуудыг түрж цэвэрлэхэд багагүй хүн хүч техникийн хэрэгцээ шаардлагатай байна.

Албан бус хогийн цэг нь дараах шалтгаануудын улмаас үүсэж байна. Үүнд:

1. Иргэд, ААН, байгууллага нь барилга угсралт болон буулгалт, айл өрхийн урсгал засвараас гарсан бетон, тоосго, хөөсөнцрийг дур мэдэн гуу жалганд хаядаг
2. Иргэдийн хог хаягдлыг ангилах, ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах талаар мэдлэг хомс, ухамсаргүй байдал
3. ААН, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулж хогоо ачуулах үүргээ биелүүлдэггүй
4. Хог хаягдалд тавьж буй хяналт сул
5. НААҮГ нь айл, өрхийн хог хаягдлыг хугацаанд нь ачдаггүй
6. Иргэдэд хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийн талаарх мэдээлэл хангалтгүй

# ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ




Зураг 29. 15-р баг орчмын хог хаягдлын тархалт, овоолго

Дархан сумын 15-р багийн нутаг дэвсгэрт нийт 1759.3 м<sup>3</sup> хог бүхий албан бус хогийн цэг байгаа бөгөөд үүний нэлээдгүй хэсгийг барилгын хог хаягдал эзэлж байна.



Зураг 30. 15-р багийн нутаг дэвсгэрт үүссэн хууль бус хогийн цэг

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Зураг 31. Ширээ нуруу орчмын хог хаягдлын тархалт, овоолго

НААҮГ-ын хог тээвэрлэлтийн үйлчилгээг авдаггүй, хогийн төлбөр төлдөггүй айл өрх, ААН-үүд эдгээр албан бус хогийн цэгүүдийг үүсгэж байна.

### Хүндрэл бэрхшээл:

- Жил бүр албан бус хогийн цэгүүдийг цэвэрлэх, устгах ажил хийгддэг боловч дахин бий болдог
- Хяналтын тогтолцоо, камержуулалт байхгүй
- Торгох, шийтгэх механизм сул
- Хог татан зайлуулах тээвэрлэлт тогтмол хуваарийн дагуу хийгддэггүй
- Бохирдуулагч төлөх болон хог хаягдлын хэмжээнд суурилсан үнийн систем байхгүй
- Хөнгөлөлт урамшууллын систем байхгүй
- Иргэдийн хог хаягдлыг ангилах, ялгах тухай мэдлэг, дадал муу
- ААН, байгууллага, иргэд хогийг эдийн засгийн эргэлтэнд оруулж, зардлаа бууруулах боломжтой гэдгийг мэддэггүй



## 1.5. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хүн төрөлхтний оршин тогтнох, өсөж үржих, хийж бүтээх зэрэг амьдралын бүхий л үйл ажиллагааны анхдагч нөхцөл нь хүнс, хоол, тэжээл юм. Гэвч хүнс, тэжээлийн гуравны нэг нь үйлдвэрлэл, борлуулалт, хэрэглээний явцад хаягддаг гэсэн тооцоо бий. Бидний судалгаагаар Дархан-Уул аймгийн хэмжээнд жилд дунджаар мах боловсруулах үйлдвэрээс 487.9 тонн яс, 1199.2 тонн сэвс, 453 мян.л цус, 138393 ширхэг арьс шир, 1408.6 тонн дотор эрхтэн, хүнсний захаас 474.5 тонн яс, тахиан фермеес 265 тн сангас, 30000 орчим өндөгний хальс, ногооны зоориноос 285 тн ногооны хаягдал, мөн 399.4 кг хаягдал цаас гардаг гэсэн тооцоолол гарч байна. Мөн Дархан -Уул аймагт Азийн хөгжлийн банкны “Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах” төслийн хүрээнд айл өрхийн хог хаягдлын бүтцэд хийсэн судалгаагаар хүнсний хаягдлын эзлэх хувь хэмжээ 24%, ХААИС-ийн АЭБС дээр хэрэгжсэн “Төв суурингийн ахуйн хог хаягдлаар компост бордоо бэлтгэх” судалгааны төслийн хүрээнд Дархан сумын 18 багийн 540 өрхөөс авсан судалгааны дүнгээр 23%-ийг эзэлж байна.

2007 онд Япон улсын “Жайка” ОУБ-аас хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын хог хаягдлын мастер төлөвлөгөө боловсруулах судалгааны төсөл”-ийн тооцоогоор өрхийн нийт хог хаягдлын 20.7%, 2014 онд Б.Намхайням нарын хийсэн “Хүлэмжийн хийн ялгаралт ба шингээлтийн үзүүлэлтийг Монгол орны нөхцөлд тогтоох судалгаа”-ны хог хаягдлын бүтцийн 24%, 2019 онд хийсэн НҮБ-ийн байгаль орчны хөтөлбөр, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Уур амьсгалын өөрчлөлт ба хог хаягдал” төслийн хүрээнд “Улаанбаатар хотын хог хаягдлын бүтцийн судалгаа”-нд 30.4%-ийг хүнсний хог хаягдал тус тус эзэлж байгаа гэсэн дүн нь Дархан-Уул аймгийн органик хог хаягдлын эзлэх хувь, хэмжээтэй дүйцэж байна.

Дархан-Уул аймгийн органик хог хаягдлын өнөөгийн нөхцөл байдлыг хураасан ургац, мал, тэжээвэр амьтны тоо, өрхийн махны хэрэглээнд үндэслэн тооцон үзэхэд (Хавсралт 7 ) жилд дунджаар 79.65 мян.тн хаягдал гардаг байна.

Хүснэгт 8. Дархан-Уул аймгийн зарим органик хог хаягдлын хэмжээ, мян.тн

	Бод малын ялгадас	Бог малын ялгадас	Шувууны сангас	Гахайн ялгадас	Ногооны хаягдал	Хаягдал яс	Нийт
2012	31.07	29.05	0.26	0.81	4.07	1.84	<b>67.10</b>
2013	34.32	29.80	0.42	1.33	3.55	1.95	<b>71.38</b>
2014	39.99	34.61	0.53	1.30	3.66	1.96	<b>82.05</b>
2015	40.56	29.78	0.31	0.57	1.16	2.10	<b>74.47</b>
2016	43.39	33.92	0.25	0.47	3.27	2.11	<b>83.41</b>
2017	44.23	32.01	0.16	0.45	3.34	2.11	<b>82.30</b>
2018	40.72	32.07	0.14	0.50	3.60	2.14	<b>79.16</b>
2019	43.85	36.87	0.24	0.42	3.07	2.02	<b>86.46</b>
2020	45.29	38.32	0.22	0.85	3.80	2.03	<b>90.52</b>
<b>Дундаж</b>	<b>40.38</b>	<b>32.94</b>	<b>0.28</b>	<b>0.74</b>	<b>3.28</b>	<b>2.03</b>	<b>79.65</b>



## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Зураг 32. Органик хог хаягдлын өнөөгийн байдал


Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан хаях, цуглуулах, татан зайлуулах тогтолцоо байхгүйн улмаас хүнсний хаягдал ахуйн бусад хатуу хог хаягдалтай цуг хаягддаг, цуг татан зайлуулагддаг тул байгаль орчинд ихээхэн бохирдол үүсгэхээс гадна зуны улиралд үнэр орох, шавж, мэрэгч, золбин муур, нохой үржих, өвлийн улиралд барьцалдан хөлдөх зэргээр ачилт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

### Хүндрэл бэрхшээл:

- Эх үүсвэр дээр ангилан ялгадаггүй
- Амархан үнэр орж, мууддаг
- Ахуйн хог хаягдалтай цуг хаягддаг
- Ахуйн хогтой хаягдлаас ялгахад хүндрэлтэй
- Ахуйн хог хаягдалтай хамт татан зайлуулагддаг
- Органик хог хаягдлын бүртгэл судалгаа, мэдээлэл хомс
- Боловсруулах үйлдвэр цөөн

## 1.6. БАРААТ ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Бараат төвлөрсөн хогийн цэгт сард 2-3 мян. тонн хүн, амьтан ургамлыг өвчлүүлэх гэмтээх тэдгээрийн үр удамд хор хөнөөлтэй байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой идэмхий исэлдүүлэгч шатамхай тэсэрч дэлбэрэх аюултай цацраг идэвхтэй халдвартай шинж чанартай хатуу шингэн хийн аюултай хог хаягдал болон ахуйн хог хаягдал бүгд нэг дор хөрсөнд стандартын бус аргаар булшлагддаг. Бараат төвлөрсөн хогийн цэг нь аргачлал, стандартын хувьд хяналттай хогийн цэгт хамаарах боловч хамгаалалтын хашаа, гэрэлтүүлэг, хяналтын цэг болон худаг зэрэг байхгүй нь хогийн тархалт овоолго нэмэгдэх, мал амьтан идэж хордох, шаталт нэмэгдэх зэрэг байгаль орчинд олон сөрөг нөлөөллийг үзүүлдэг.




Зураг 33. Дархан сумын төвлөрсөн хогийн цэг Бараатын байршил

Бараат төвлөрсөн хогийн цэг 1957 оны үеэс үүссэн бөгөөд 2021 оны 6 сарын байдлаар 90-130 га талбайд 225 мян.м<sup>3</sup> хог хаягдал хуримтлагдсан байна. Дархан сумд сард дунджаар 1500-3000 тн, жилд дунджаар 30-50 мянган тонн хогийг түрж булдаг бөгөөд үүнийг ойролцоогоор 100 га талбайд ил хаяж байна. Бараат төвлөрсөн хогийн цэгт ангилан ялгагдаагүй ахуйн, үйлдвэрлэлийн хатуу хог хаягдлаас гадна мал амьтны гаралтай органик хаягдлууд холилдон булагддаг тул хөрсөнд хүнд металлууд үүсэх боломжтой юм. Хүнд элементийн бохирдол нь нянгийн бохирдлыг бодвол тогтвортой удаан хугацаагаар хөрсөнд хадгалагддаг онцлогтой.

Дархан-Уул аймгийн Засаг даргын захирамжаар 2021 оны 7 сард нийт талбайн 12.5 га орчимыг түрж хөрсөөр булаж хогийн тархалт овоолгийн хэмжээг 225133.5 шоо метр хогийн овоолгын хэмжээг 16782.5 шоо метр болгож цэвэрлэж бууруулсан.

# ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Зураг 34. Бараат төвлөрсөн хогийн цэгийн хогийн тархалт, овоолгын хэмжээ /2021 оны 6-р сарын байдлаар/



Зураг 35. Бараат хогийн цэгийн хогийн тархалт, овоолгын хэмжээ




## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Зураг 36. Бараат хогийн цэгийн одоогийн нөхцөл байдал  
/2021 оны 9 сарын байдлаар/

Бараат төвлөрсөн хогийн цэгт бүх төрлийн хогийг ил задгай хаядаг тул исэлт явагдаж байнгын шаталт үүсдэг. Ил шаталтын үед нам температурт шаталт явагддаг, шаталгүй уугьдаг зэргээс олон төрлийн хортой, аюултай химийн бодисууд үүсдэг байна. Эдгээр нэгдлүүд нь хол зайд тархаж, хур тунадастай хамт хөрс, ургамал болон усанд бууж, бохирдуулна. Мал амьтад бохирдуулагч бодисыг залгиж тэдгээрийг биедээ хуримтлуулдаг бол ургамал тэдгээрийг өөрсдийн навчаараа шингээж авдаг. Ийм бохирдсон хүнсийг идсэнээр бохирдуулагч бодис хүнд дамжина. Үүнээс гадна, ил задгай шаталтаас үүссэн утаа, тортог нь амьсгалын замын эрхтэнд нөлөөлөх бөгөөд ялангуяа, хүүхэд, хөгшид, багтраа өвчтэй болон бусад амьсгалын замын өвчтэй, зүрх уушгины архаг өвчтэй хүмүүст хортой нөлөө үзүүлдэг.

ХААИС-ийн эрдэмтдийн баг Бараат төвлөрсөн хогийн цэгт хөрсний бохирдол ямар түвшинд байгааг тодорхойлох, түүнд салхи болон газрын гадаргын налуугийн байдал хэрхэн нөлөөлдгийг судлан тодруулах зорилгоор тус хогийн цэг орчмын хөрсний дээжийг 5 цэгт, мөн хамгийн ойр орших “Хөтөл” гэр хороолол орчмын хөрсний бохирдолтыг хянах зорилгоор 1 цэгт тус тус дээж авч шинжилгээ хийв.



Зураг 37. Дархан сумын Бараат төвлөрсөн хогийн цэг орчимд хөрсний дээж авсан цэгүүдийн байршил



## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хөрсөн дэх хүнд элементийн агууламжийг Монгол улсын стандарт "Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" (MNS 5850:2008)-ийн стандартыг үндэслэн элемент тус бүрээр хүлцэх агууламжийн хэмжээтэй харьцуулан үзвэл хүнд металлын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс 1-2 дахин хэтэрсэн ба ойролцоох эрүүл газрын хөрстэй харьцуулбал хром, кадми, зэс зэрэг бодисоор бохирдсон байна.

Хүснэгт 9. Бараат хогийн цэг орчмын хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

№	Лаб дугаар	Дээжний нэр	Үе давхарга					
			Никель (Ni)	Кадми (Cd)	Тугалга (Pb)	Цайр (Zn)	Хроми(Cr)	Зэс (Cu)
1	4695	Төв цэг	33.3	1.7	162.2	176.6	166.6	100.1
2	4696	Нам дор талын цэг	57.9	0.8	250	171.5	78.3	185.2
3	4697	Өндөрлөг талдаа	27	0	124.6	160.4	0	126.2
4	4698	Салхины дээд чиглэлд	12	0	22.2	44.2	0	6.34
5	4699	Салхины дагуу чиглэлд	19.1	0	15.0	11.9	0	16.1
6	4700	Хяналтын цэг	2.76	0	56.9	84.9	0	0
Хүлцэх агууламж /MNS 5850:2008/			150.0	3.0	100.0	300.0	150.0	100.0
Хортой агууламж /MNS5850:2008/			1000.0	10.0	500.0	600.0	400.0	500.0
Аюултай агууламж /MNS5850:2008/			1800.0	20.0	1200.0	1000.0	1500.0	1000.0

Хэдийгээр хүнд металлын агууламжийн хувьд хортой /MNS5850:2008/ болон аюултай агууламж /MNS5850:2008/ -ийн стандартаас хэтрээгүй байгаа ч тус хог хаягдлын цэг нь Хөтөл хороололоос 2 километрээс дотогш зайд, газрын гадаргын нам дор талд нь сууршилийн бүс байршиж байгаа нь ихээхэн эрсдэлтэй, гэр хорооллын оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрахад сөргөөр нөлөөлөх нөхцөл болж байна. Учир нь хүн ам суурьшлын бүсэд задгай хогийн цэг хэт ойрхон байснаас хогийн үнэр болон шаталтаас үүссэн хорт утаа тархаж үнэртэх, нян бактери үржих, экологийн тэнцвэр алдагдах зэргээр хүн болон амьтны амьдрах орчинг доройтуулдаг. Мөн задгай хогийн цэг ойрхон байршсанаас амьсгалын замын өвчин, арьсны харшил, тоосны харшил гэх мэт өвчнүүд гардаг. Хөрс нь халдварт өвчин үүсгэгчийг дамжуулах эх үүсвэр болдог тул Бараат хогийн цэгийн хөрсөнд бактерийн тоо, гэдэсний бүлгийн савханцар (Endo agar), E.COLI титр зэргийг дараах судалгааны үр дүнгээс харж болно.

Хүснэгт 10. Хогийн цэг орчмын дээжний нянгийн бохирдлын шинжилгээний дүн

№	Хувилбар	Байршил	1г хөрсөнд агуулагдах бичил биетний тоо		
			Нийт бактери (МПА)	Гэдэсний бүлгийн савханцар (Endo agar)	E.COLI
1	Дээж 1	Төв цэг	6.4*10 <sup>9</sup>	Илрээгүй	Илрээгүй

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2	Дээж 2	Нам дор талын цэг	$1.25 \cdot 10^8$	Илрээгүй	Илрээгүй
3	Дээж 3	Өндөрлөг талдаа	$3.3 \cdot 10^8$	120	Илрээгүй
4	Дээж 4	Салхины дээд талд	$7.5 \cdot 10^9$	400	1
5	Дээж 5	Салхины дагуу чиглэлд	$1.8 \cdot 10^8$	1700	2
6	Дээж 6	Хяналтын цэг	$3.6 \cdot 10^8$	Илрээгүй	Илрээгүй

### Шинжилгээний дүн:

- Нянгийн бохирдол маш их байх нь гарцаагүй боловч хяналтын цэгтэй харьцуулахад 1-2 дахин их байна.
- *E. COLI* *тип* нь стандартаар “илрээгүй” байх ёстой хэдий ч дээжний шинжилгээгээр 4,5-р цэгүүдэд 1 ба 2 гэсэн үзүүлэлттэйгээр илэрсэн байна. *E. coli* нь ходоод гэдэсний замын халдвар, суулгалт, цөсний замын халдвар, мухар олгойн үрэвсэл, элэгний буглаа зэрэг ходоод гэдэсний замын олон төрлийн эмгэг үүсгэдэг байна.
- *Гэдэсний бүлгийн савханцар (Endo agar)* нь стандартаар “илрээгүй” байх ёстой боловч шинжилгээгээр 3, 4, 5-р цэгүүдээс авсан дээжнээс тус тус илэрсэн үзүүлэлттэй байна. Гэдэсний савханцар нь эшерихи колигоор үүсгэгдэж, суулгах хам шинжээр илэрдэг цочмог халдварт өвчин үүсгэдэг.

Дээрх судалгааны үр дүнгээс харахад ил задгай хог хаягдал болон шаталтаас хүний эрүүл мэнд болон байгаль орчинд учруулж болох эрсдэл маш өндөр байна. Иймд Бараат төвлөрсөн хогийн цэгийн түрж булсан хэсэгт нөхөн сэргээлт хийх, ашиглалтын талбайд газар ашиглалтын болон хаалтын төлөвлөгөөг боловсруулж ландфиллийн аргыг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

“Хог хаягдлын тухай хуулийн 3.1.5-д “ландфиллийн арга” гэж байгаль орчинд нөлөөгүйгээр хог хаягдлыг хөрсөөр дарж устгах үйл ажиллагааг хэлнэ гэжээ. Харин олон улсад ландфилл нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр тусгай төхөөрөмжөөр төхөөрөмжлөн зохион байгуулсан талбайд дахин боловсруулж ашиглах боломжгүй хог хаягдлыг хүлээн авах, зөөх, хаях, ариутгах ажиллагааны цогц юм гэж тодорхойлжээ.

### Хүндрэл, бэрхшээл

- Хамгаалалтын болон тусгаарлах хашаа байхгүй
- Эрчим хүчинд холбогдоогүй
- Хяналтын худаг байхгүй
- Пүүний байрлал төвлөрсөн цэгээс хол
- Хяналтын систем, камер байхгүй
- Машин техник хангамж дутагдалтай
- Ариутгалын систем байхгүй
- Аюултай хог хаягдал булшлах зориулалтын цэг байхгүй
- Инженерийн зарим байгууламжууд байхгүй

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 1.7. ХОГ ХАЯГДАЛ ТАТАН ЗАЙЛУУЛАХ, БУЛШЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ

Дархан-Уул аймгийн НААҮГ-ын техник үйлчилгээний хэлтэс аймгийн ИТХурлаас тогтоосон хогийн хураамжийг айл өрхөөс авч, хог тээвэрлэн татан зайлуулах үйлчилгээг хэрэгжүүлдгээс гадна гудамж талбайг цэвэрлэх үйлчилгээг иргэдэд үзүүлдэг.

Дархан сумын ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдаанаар хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоодог. Дархан-Уул аймгийн иргэдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 76 дугаар тогтоол Дархан –Уул аймгийн засаг даргын 375 дугаар захирамжаар айл өрхийн хог хаягдлыг 1 өрхөөс 1000 төгрөг, гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг 1м.куб хог 4000 төгрөг, ААН, албан байгууллагыг ангилан тогтоосон тарифаар хураамж авч үйлчилж байгаад 2019 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн Дархан сумын ИТХ-ын ээлжит хуралдаанаар хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэмэгдүүлсэн байна. Энэ шийдвэрийн хүрээнд гэр хорооллын айл өрхөөс авах хураамжийн хэмжээг 1000 төгрөгөөр бууруулан тогтоосон байна.

Хүснэгт 11. Хураамжийн хэмжээний өөрчлөлт /төгрөг/

Нэгжийн нэр	Хэмжих нэгж	Хураамжийн хэмжээ /төг/	
		2013 он	2019 он
Орон сууцны хорооллын айл өрх	төг	1000	2000-2500
Гэр хорооллын айл өрх	төг	4000	3000
Хувийн сууцны хороолол	төг	2500	3500
Аж ахуй нэгж	м/куб	5000-7000	2000-25000
Барилгын хог хаягдал	м/куб		1000-25000
Аюултай хог хаягдал	м/куб		4000

Эх үүсвэр: НААҮГ-ийн тайлан


Тус байгууллагын орлогын дүн 2019-2020 онуудад 12.4 – 23.3 хувиар өссөн нь 2019 онд хог хаягдлын хураамжийн үнэлгээг нэмэгдүүлсэнтэй холбоотой хэдий ч дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Хүснэгт 12. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын судалгаа /төг/

Орлогын бүтэц	2015	2016	2017	2018	2019	2020
Орон сууцны өрхүүдээс	116.095.950	120.821.000	125.274.500	141.855.000	168.639.360	189.472.000
Зоорины болон нэг давхрын ААН-ээс	42.485.400	49.040.300	48.849.300	54.145.000	65.874.750	74.012.500
Гэр хорооллын өрхүүдээс	84.678.400	89.473.600	107.862.300	100.194.000	129.114.510	145.064.500
Тусгай объектод АА эрхэлдэг ААН байгууллагаас	112.747.130	104.430.819	118.908.754	131.356.000	163.369.380	183.551.000
<b>НИЙТ</b>	<b>355.979.880</b>	<b>63.765.719</b>	<b>400.894.854</b>	<b>427.550.000</b>	<b>526.998.000</b>	<b>592.100.000</b>

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хог хаягдлыг татан зайлуулах, тээвэрлэх, булшлах үйлчилгээний зардал хог хаягдлын үйлчилгээний хураамжаас орох орлогын хэмжээнээс ямагт давсан үзүүлэлттэй байна.




Зураг 38. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого ба зарцуулсан зардал

Тус байгууллагын айл, өрх, ААН, байгууллагаас хог хаягдлыг татан зайлуулсан үйлчилгээний төлбөр хураамжийн орлого 80 орчим хувийн гүйцэтгэлтэй байдаг нь тухайн жилийн төсвийн орлогыг гүйцэд бүрдүүлэх боломжгүй байдлыг үүсгэдэг. Түүнчлэн жил ирэх тусам шатахуун, тослох материалын зардал, хөдөлмөр хамгаалал, түүхий эд материалын зардал нэмэгдэж байгаа нь хураамжийн орлогоос байгууллагын нийт зардал илүү гарахад нөлөөлж байна.

Иргэн, айл өрх, ААН байгууллагын хог хаягдлын талаарх бүртгэл судалгаа бүхий нэгдсэн мэдээллийн сан бий болгож 100% үйлчилгээ үзүүлж төлбөр хураамжийг авдаг болохоос гадна сэргээн ашиглах, дахин боловсруулах боломжтой хог хаягдлын ялган авч эдийн засгийн эргэлтэд оруулснаар энэ харьцааг бүрэн өөрчлөх боломжтой юм.


НААҮГ-ын нийт зардалд хог хаягдалтай холбоотой гарах зардал 3,4 тэрбум төгрөг буюу 72.2 хувийг эзэлж байна.



Зураг 39. Хог хаягдалтай холбоотой гарах зардал

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

НААҮГ-ын 2020 оны нийт зардлыг ангилан авч үзвэл цалин, НДШ 1,7 тэрбум төгрөг буюу 50.25 хувь, хөрөнгө оруулалтын зардал 35.1 хувь, бусад зардал 14.1 хувийг тус тус эзэлж байна.



Зураг 40. Нийт зардлын ангилал

- Хог хаягдлын нэгдсэн бааз бүхий бүртгэл судалгаа байхгүй
- Айл өрх, АА, байгууллагууд хогийн төлбөрөө 100% төлдөггүй
- Бохирдуулагч төлөх болон хог хаягдлын хэмжээнд суурилсан үнийн систем байхгүй
- Хөнгөлөлт урамшууллын систем байхгүй
- Иргэдийн хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар мэдлэг дутмаг
- Зарим ААН, байгууллагууд НААҮГ-тай гэрээ байгуулалгүй, өөрсдөө хогоо ачиж тээвэрлэдэг
- Шатахууны зардал өндөр гардаг тул машин техникийн засвар, үйлчилгээ муу хийгддэг
- Машин, техникийн сэлбэг хэрэгслийн үнэ өссөн



## 1.8. ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН АШИГЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТОГТОЛЦОО

Дархан сумын төвлөрсөн хогийн цэгт татан зайлуулсан нийт хог хаягдлын хэмжээ 2020 оны байдлаар 52160.1 тонн байгаагаас дахин боловсруулах боломжтой энгийн хог хаягдлын хэмжээ 80 орчим хувь буюу 41728 тонн байх боловч дахин боловсруулах үйл ажиллагаа хийгдэхгүй байгаагаас тухайн жилийн бүх хог хаягдал төвлөрсөн хогийн цэгрүү ачигдаж байна. Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй оёдлын цех, хуучин буйдан засварлах газар, гутал, цүнх засварын газар, эвдэрсэн цахилгаан барааны засварын газрууд нь хаягдал бүтээгдэхүүнийг дахин ашиглах, эдийн засгийн эргэлтэнд оруулж буй чухал бааз суурь юм.

Дархан-Уул аймгийн хэмжээнд 105 сэргээн завсварлах төв үйл ажиллагаа явуулж байгаагийн 81 нь Дархан сумд үйл ажиллагаа явуулж байна

Хүснэгт 13. Дархан-Уул аймаг дахь засварын газрын төрөл, тоо

№	Засварын газрын төрөл	Дархан сум	Хонгор сум	Шарын гол сум	Орхон сум	Нийт
1	Хувцас захиалга, оёдлын цех	61	8	7	-	76
2	Гутал, цүнх засварын газар	12	-	-	-	12
3	Хуучин буйдан, тавилга засварлах газар	4	-	4	5	13
4	Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл засварын газар /электрон бараа засварын газар	4	-	-	-	4
<b>Нийт</b>		<b>81</b>	<b>8</b>	<b>11</b>	<b>5</b>	<b>105</b>




Зураг 41. Дархан сумын гутал болон цүнх засварын газрын өнөөгийн байдал



Зураг 42. Дархан сумын буйдан засварын газрын өнөөгийн байдал

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Зураг 43. Дархан сумын хоёрдогч түүхий эд авдаг цэгүүдийн байршил

2020 оны байдлаар Дархан сумын хэмжээнд хоёрдогч түүхий эд авдаг 12 газар байгаа бөгөөд төмөр, зэс, гуулин ороомог, хайлш, хөнгөн цагаан, лааз зэргийг авдаг байна. Эдгээр хоёрдогч түүхий эд авдаг газруудад хувь хүн, албан байгууллага, хог түүгч иргэд хоёрдогч түүхий эдийг авчирч тушаадаг бөгөөд Дархан- Уул аймагт дээрх төрлийн хоёрдогч түүхий эдийг боловсруулах үйлдвэр хомс байдгаас үүдэн ихэнх нь цугларсан түүхий эдийг Улаанбаатар хотруу тээвэрлэдэг байна.

Дархан сумд хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулдаг 1 байгууллага байгаа нь Сан-Оргиу ХХК юм. Сан-Оргиу ХХК нь 2005 онд байгуулагдсан бөгөөд гялгар уут, хуванцар савыг дахин боловсруулж гадна тохижилтын сандал, траншейны таг зэрэг 30 гаруй төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Түүхий эдээ уут, хуванцар сав, ахуйн хэрэглээний зөөлөн хуванцар сав, пакет тор зэргийг түүдэг иргэдээс худалдан авахаас гадна байгуулагуудаас гэрээгээр авдаг байна.



Зураг 44. Хуванцар хог хаягдлыг цуглуулж, ангилан ялгалт хийж буй байдал.

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сан- Оргиу ХХК нь Дархан-Уул аймагт хуванцар хаягдал, гялгар уутыг дахин боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн анхны хувийн хэвшлийн компани боловч хог хаягдлыг үүсвэр дээр ангилдаг тогтолцоо байхгүйн улмаас түүхийн эдийн хомсдол үүсэж үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд доголдол үүсээд байна.



Зураг 45. Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулан үйлдвэрлэж буй Сан-Оргиу ХХК-ийн зарим бүтээгдэхүүн

Дархан сумд НААҮГ-т бүртгэлтэй байнгын хог түүгч 25-30 иргэн байдаг бөгөөд НААҮГ болон багийн төв, цагдаагийн хэсэг хамтран шаардлагатай тохиолдолд эдгээр иргэдийг сургалт, уулзалтуудад хамруулдаг байна.

Одоогоор эдгээр иргэдийн нийгмийн баталгаа тодорхойгүйгээс гадна хог хаягдлыг ангилан ялгах талаарх мэдлэг тааруу байдаг байна.

### Хүндрэл бэрхшээл:


- Энэ чиглэлийн үйл ажиллагааг зангидсан нэгдсэн холбоо байдаггүй
- Бизнесийн зээлийн шаардлага өндөр
- Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, тоног төхөөрөмжөө шинэчлэхэд санхүүгийн тусламж дэмжлэг хомс
- Хүний нөөц дутмаг
- Гутлын үндсэн түүхий, эд материалуудыг БНХАУ-аас худалдан авдаг бөгөөд мөнгөний ханшны уналттай холбоотойгоор түүхий эдийн үнэ тасралтгүй өсдөг
- Зах зээлд хуучин буйдангаа засуулах эрэлт хэрэгцээ их байдаг ч цехийн хүчин чадал, хүний нөөцийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалт шаардлагатай байдаг



## 1.9. ХҮНИЙ НӨӨЦ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

НААҮГазар нь 3 алба хэлтэс, 245 албан хаагчтай бөгөөд 187 нь техник, үйлчилгээний хэлтэст, 13 нь захиргаа, хүний нөөцийн хэлтэст, 22 нь санхүү, бүртгэлийн хэлтэст, 22 гэрээт ажилтан ажиллаж байна.

Техник үйлчилгээний хэлтэс нь автотехникийн алба, тохижилт үйлчилгээний алба, цахилгаан гэрэлтүүлгийн алба, цэвэрлэгээ үйлчилгээний алба гэсэн 4 албанаас бүрдэнэ. Нийт ажиллагчдын 49,5 хувийг цэвэрлэгээ, үйлчилгээний алба, 20.3 хувийг авто техникийн алба, үлдсэн 30.2 хувийг бусад алба, хэлтсийн ажиллагчид эзлэж байна. Тус байгууллагын үндсэн орон тоо 245 хүнээр батлагдсан хэдий ч 202 ажилтан ажиллаж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд хүрч байна.



Зураг 46. НААҮГ-ын удирдлага, зохион байгуулалтын бүтэц

НААҮГ-ын ажиллагчдын боловсролын түвшинг 2021 оны байдлаар авч үзэхэд 59.4 хувийг бага, бүрэн бус болон бүрэн дунд боловсрол болон боловсролгүй ажиллагчид эзлэж байгаа бол 15.9 хувийг бакалавр, магистр зэрэгтэй албан хаагч, үлдсэн 24.7 хувийг тусгай дунд боловсролтой ажиллагчид эзлэж байна. Хэлтэс, албадаар авч үзвэл автотехникийн албаны ажиллагчдын 73.2 хувийг боловсролгүй болон бүрэн бус, бүрэн дунд боловсролтой ажиллагчид, үлдсэн 26.8 хувийг тусгай болон бакалавр зэрэгтэй ажилтан эзлэж байгаа бол цахилгаан үйлчилгээний албаны ажиллагчдын 50 хувийг бүрэн дунд боловсролтой ажилтан, үлдсэн 50 хувийг тусгай болон бакалавр зэрэгтэй ажилтан эзлэж байна.

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хүснэгт 14. Хэлтэс, албадын ажиллагсдын боловсролын түвшин

№	Боловсролын түвшин	Техник үйлчилгээний хэлтэс				Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	Санхүү бүртгэлийн хэлтэс	нийт
		автотехникийн алба	тохижилт үйлчилгээний алба	цахилгаан гэрэлтүүлгийн алба	цэвэрлэг үйлчилгээний алба			
1	Бага	7			13			20
2	Бүрэн бус дунд боловсрол	5			10			15
3	Бүрэн дунд	5	7		5	1	2	20
4	Тусгай дунд	10	3	8	16	3	10	50
5	Бакалавр	1	4	3	4	8	10	30
6	Магистр					2		2
7	Боловсролгүй	13			52			65
	<b>Нийт</b>	<b>41</b>	<b>14</b>	<b>11</b>	<b>100</b>	<b>14</b>	<b>22</b>	<b>202</b>

Ажиллагсдын боловсролын зэргийг дээшлүүлэх, мэдлэг боловсролыг ахиулах талаар байгууллагын зүгээс тэр бүр анхаардаггүй. Учир нь байгууллагын төсөв сургалтын зардал тусгагдаггүйтай болон ажлын ачаалалтай холбоотой байна. Цаашид байгууллагын төсөвт сургалтын зардлыг нэмж оруулах шаардлагатай байна.

НААҮГ-ын хэлтэс, албаны ажлын чиг үүргийг судлаж үзэхэд техник үйлчилгээний хэлтэс нь ажлын гол үүргийг хариуцан ажиллаж байгаа байна. Тус хэлтэс нь 4 чиглэлийн үйл ажиллагааг голлон хариуцан ажиллаж байна. Үүнд:

- Хог хаягдлыг татан тээвэрлэх,
- Ногоон байгууламжийн зохион байгуулалт, хашаа, хайсын арчилгаа, орон сууцны хорооллын дундах жишиг хорооллуудын талбайн тохижилт үйлчилгээний ажлыг жилийн 4 улирлын туршид хариуцан ажиллана.
- 23523 гэрэл гэрэлтүүлэг, гэрлийн шон, фасадны гэрлийн засвар үйлчилгээ, цахилгааны аюулгүй байдлыг хариуцна.
- Авто замын 60134 м<sup>2</sup>, явган замын 97352 м<sup>2</sup>, талбай болон ногоон байгууламж, эзэнгүй талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах болон орон сууцны хорооллын дундах жишиг хорооллуудын талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцна.

Эндээс үзэхэд НААҮГ-ын нэг хэлтэс сумын хэмжээнд бүх цэвэрлэгээ үйлчилгээ, тохижилтын ажлыг хариуцан ажиллаж байгааг харглан ажлын ачаалал, бүтээмжийг бууруулах шаардлагатай байна.

Хүснэгт 15. Хэлтэс, албадын ажлын чиг үүрэг

№	Хэлтэс, нэгж	Харьяалагдах алба	Чиг үүрэг
1	Техник үйлчилгээний хэлтэс	Автотехникийн алба	Хог хаягдал татан тээвэрлэх үйлчилгээг хариуцна.
		Тохижилт үйлчилгээний алба	Ногоон байгууламжийн зохион байгуулалт, хашаа, хайсын арчилгаа, орон сууцны хорооллын дундах жишиг хорооллуудын талбайн тохижилт үйлчилгээний ажлыг жилийн 4 улирлын туршид хариуцан ажиллана. Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн, Дархан 50, Морин хуур, Бурхан багшийн сэрэг дүр цогцолбор, 5 га ногоон төглийн арчилгаа, хамгаалалт, засвар үйлчилгээг хариуцна.



## **ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

		Цахилгаан гэрэлтүүлгийн алба	23523 гэрэл гэрэлтүүлэг, гэрлийн шон, фасадны гэрлийн засвар үйлчилгээ, цахилгааны аюулгүй байдлыг хариуцна.
		Цэвэрлэгээ үйлчилгээний алба	Нийтийн эзэмшлийн талбай, авто зам, явган замын цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцна. Орон сууцны хорооллын дундах жишиг хорооллуудын талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцна.
2	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс		Бусад алба хэлтсийг удирдлагаар хангах Өдөр тугмын хог тээвэрлэлтэд хяналт тавина.
3	Санхүү бүртгэлийн хэлтэс		Байцаагчид хог хаягдлын хураамж бүрдүүлэх Байгууллагын орлого, зарлагыг төлөвлөх, гүйцэтгэлд хяналт тавих

Цаашид сумын хүн ам, ААН, байгууллагын тоо, хүчин чадал нэмэгдэхийн хирээр тус байгууллагын ачаалал нэмэгдэх нь тодорхой байна. Иймд зарим нэг ажил үйлчилгээг хувийн хэвшилд хариуцуулах, гэрээгээр гүйцэтгүүлэх зэргээр менежментийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **Хүндрэл бэрхшээл:**

- Төсөв, орон тоо хүрэлцдэггүй
- Цалин хөлс бага
- Хүний нөөцийн төлөвлөлт, хөгжлийн асуудал орхигдсон, төсөвгүй
- Ажлын болон хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийн хангалт муу
- Хүний нөөцийн сургалт, хөгжлийн төсөлгүй
- Удирдлагын менежмент хангалтгүй
- Мэргэжилтэй боловсон хүчин хангалтгүй
- Хяналтын тогтолцоо сул
- Ажилчдын нийгмийн халамжийн, бодлого, дэмжлэг хангалтгүй
- ХАБЭА-ны зааварчилгаа дутмаг, хэрэгжилт муу

# ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## 1.10. ТЕХНИК ХАНГАМЖ, МАТЕРИАЛЛАГ БААЗ

НААҮГ-ын хог тээвэрлэлтийн парк ашиглалтад ЗИЛ-130 маркийн ачаа тээврийн 5тн багтаамжтай 8 автомашин, битүү бүхээгт буюу тусгай зориулалтын нягтруулах механизмаар тоноглогдсон 3.5-5тн багтаамжтай 8 автомашин байна.

Эдгээрээс одоогийн байдлаар өдөрт тусгай зориулалтын нягтруулдаг 6 автомашин, өөрөө буулгагч ЗИЛ-130 маркийн 5 автомашин нийт 11 машинтайгаар сумын хэмжээнд иргэн, байгууллагын хогийг тээвэрлэн хог хаягдлын нэгдсэн цэгт төвлөрүүлж байна.

НААҮГ газар нь гэр хорооллын айл өрх, орон сууцны хороолол, албан газар, аж ахуйн нэгж байгууллага, барилгын хог хаягдлыг цэвэрлэж, тээвэрлэж, устгадаг байна. Тээвэрлэлтийн тогтсон графикайн дагуу гэр хорооллын хогийг сард нэг удаа, орон сууцны хогийг долоо хоногийн 5 өдөр, аж ахуйн нэгжийн хогийг дуудлага өгсөн тухай бүр ачиж байна.



Зураг 47. Хог тээвэрлэлтэд ашиглагдаж буй автомашин

Авто техникийн албаны жилийн төсөв 30 сая төгрөг олгодог бөгөөд энэ нь зөвхөн сэлбэгэд шаардагдах зардлын 42 хувийг л хангадаг байна. Одоогийн парк ашиглалт нь машины найдварт ажиллагааны нормативыг хангахгүй тул жилд шаардагдах автомашины засвар, ашиглалтын үеийн зардалд 100 гаруй сая төгрөгний төсөв шаардлагатай болдог байна. Энэ нь эдийн засгийн хувьд маш их сөрөг нөлөөтэй байна. Машины ашиглалтын журнал, саатлын бүртгэл, парк ашиглалтын тухай сар, улирал, жил, ээлжийн тайлан мэдээ, засварын тухай баримт бичиг зэрэгт үндэслэн тооцоход:

1. Нягтруулах машин- Ашиглалтын үеийн засвар хийх, агрегат засвар бага буюу жилийн хуримтлагдсан элэгдэл багатай.
2. ЗИЛ-130 машин- Ашиглалтын үеийн засвар хийх, агрегат засвар их буюу жилийн хуримтлагдсан элэгдэл ихтэй нь харагдаж байна.

Тээврийн хэрэгслийн ашиглалтын үеийн найдварт ажиллагааны төвшинг үнэлэхэд агрегат засвар байнга хийх шаардлагатай сул зогсолттой, хуримтлагдсан элэгдэл ихтэй ЗИЛ-130 маркийн автомашиныг тээвэрлэлтэд ашигласаар байгаа нь дутагдалтай байна.

Хүснэгт 16. Дархан сумын НААҮГ-ын хог тээврийн автомашины ашиглалтын судалгаа

№	Машины төрөл	Марк	Даац	Үйлдвэрлэсэн улс, он	Улсын дугаар	Ашиглалтад орсон он, сар, өдөр	Шага- хууны төрөл	Норм /100 км/	Машины найдварт ажиллагааны норматив	Хөдлөх бүрэлдэхүүн (Одоо ажиллаж байгаа эсэх)
1		ЗИЛ-130		ОХУ 1987	80-20 ДАА	2011-07-01	бензин	37.5л	Ашиглалт дууссан	
2				ОХУ 1993	13-53 ДАХ	2011-10-01	бензин	37.5л	Ашиглалт дууссан	

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3	Тээштэй буюу өөрөө буулгагч		5тн	ОХУ 1990	74-33 ДАР	2012-02-12	бензин	37.5л	Ашиглалт дууссан	
4				ОХУ 1993	42-12 ДАХ	2014-12-30	бензин	37.5л	Ашиглалт дууссан	Агрегат засвартай
5				ОХУ 1995	30-11 ДАХ	2014-12-30	бензин	37.5л	Ашиглалт дууссан	Агрегат засвартай
6				ОХУ 1995	10-24 ДАХ	2014-12-30	бензин	37.5л	Ашиглалт дууссан	
7				ОХУ 1988	21-93 ДАХ	2014-12-30	бензин	37.5л	Ашиглалт дууссан	
8				ОХУ 1995	09-63 ДАХ	2017-04-25	бензин	37.5л	Ашиглалт дууссан	Агрегат засвартай
9	Битүү бүхээгт буюу тусгай зориулалтын нягтруулах механизмаар тоноглогдсон (компактор)	Hyundai	7.5 м <sup>3</sup>	Солонгос 2013	19-13 ДАР	2013-12-30	дизель	22 л	Ашиглалт дуусаагүй	
10		Hyundai	7.5 м <sup>3</sup>	Солонгос 2012	19-14 ДАР	2013-12-30	дизель	22 л	Ашиглалт дуусаагүй	
11		Hyundai	5тн	Солонгос 2001	06-71 ДАР	2018-09-01	дизель	22 л	Ашиглалт дууссан	
12		Kia rhino	4тн	Солонгос 2000	06-70 ДАР	2018-09-01	дизель	21 л	Ашиглалт дууссан	Ашиглалтын засвартай
13		Hyundai HD-120	5тн	Солонгос 2019	06-69 ДАР	2019-09-31	дизель	22 л	Ашиглалт дуусаагүй	
14		Hyundai	3.5 тн	Солонгос 2010	13-33 ДАХ	2019-12-27	дизель	20 л	Ашиглалт дууссан	
15		Hyundai	5тн	Солонгос 2011	09-13 ДАХ	2020-09-01	дизель	22 л	Ашиглалт дуусаагүй	
16		Hyundai	5тн	Солонгос 2011	34-68 ДАХ	2020-09-01	дизель	22 л	Ашиглалт дуусаагүй	

Эх үүсвэр: НААҮГ-ын машин ашиглалтын журнал 2011-2020 он, Парк ашиглалтын тайлан мэдээ 2011-2020 он.

Дээрх тайланд ашиглалтын үнэлгээ хийхэд ОХУ-д үйлдвэрлэсэн ЗИЛ-130 маркийн автомашин нь 26-34 жил ажилласан учир элэгдэлд ихээр орсон тул эргономикийн үзүүлэлтийг 90 хувь хангахгүй, экологийн үзүүлэлтийг 70 хувь хангахгүй, машины найдварт ажиллагааны нормативыг 100 хувь хангахгүй байгаа тул Дархан сумын хог тээвэрт ашиглаж болохгүй нь харагдаж байна.

ЗИЛ-130 маркийн автомашины хувьд агрегатын саатал, гэмтэл ихээр гарч захиалгаа ОХУ-аас хуучин автомашинд ашиглагдаж байсан сэлбэгийг өндөр үнээр авах, удаан хугацааны сул зогсолт (3-6 сар) хийдэг байна. Харин нягтруулах автомашины хувьд ашиглалтын үеийн саатал, гэмтэл илэрч сэлбэг захиалгаа орон нутгаасаа авч засварлан сул зогсолт огт хийдэггүйгээрээ давуу талтай байна.

### Хүндрэл, бэрхшээл:

- МУ-ын стандарт MNS 4599:2003, MNS 5344:2003 стандартуудыг мөрддөггүй
- Машины найдварт ажиллагаа хангахгүй ашиглалтын хугацаа дуусан, зориулалтын бус машин техниктэй
- Агрегат сэлбэг олдоц хомс
- Машины өртөг, зардал их
- Ачигчийн ажлын нөхцөл хүнд, эрүүл мэндэд хортой
- Тэвш металлын язралтад орсон, битүүмжлэл муу, орчны бохирдол үүсгэдэг

## 1.11. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Хог үүсэхээс эхлээд хогийн цэг хүртэлх үйл явцад олон асуудлууд шийдлээ хүлээж байна. Тухайлбал:

### Үйл ажиллагаатай холбоотой

- Ил задгай үүсмэл хог хаягдал үүсэх
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах соёл нэвтрээгүй
- Гудамж, зам, талбайн цэвэрлэгээ хангалттай хэмжээнд хийгдэхгүй
- Орон сууцны дундах нийтийн эзэмшлийн зам талбай, гэр хорооллын дундах зам талбайн өдөр тутмын цэвэрлэгээ орхигдсон
- Гэр хороолол болон ААН-ийн хог тээвэрлэлт тогтмол бүрэн хамарч хийгддэггүй
- Иргэдийн хог хаягдлын талаарх ойлголт, хандлага, ухамсар, соёлын төвшин доогуур
- Барилгын хог хаягдлыг хууль бусаар их хэмжээгээр асгах
- Ахуйн болон бохир шингэн хог хаягдлыг зориулалтын бус газар асгах
- Хогийн татвар, үнэ тарифийн систем оновчтой бус
- Хог хаягдлын талаарх судалгаа, нэгдсэн мэдээлэл, өгөгдөл байхгүй
- Хог хаягдлыг цуглуулах, татан зайлуулах үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоо байхгүй
- Эмнэлгийн болон аюултай хог хаягдлыг хадгалах, татан зайлуулах, устгах тогтолцоо байхгүй
- Хүнсний болон шингэн хог хаягдлыг зохицуулах бодлого механизм байхгүй
- Ангилсан хог цуглуулах, татан зайлуулах тогтолцоо байхгүй

### Техник, технологийн шийдэлтэй холбоотой

- Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээнд хэрэглэгдэж байгаа багаж хэрэгсэл хомс, хоцрогдсон
- Хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах техник, технологийн шийдэл, боловсруулах үйлдвэрлэлийн туршлага байхгүй
- НААҮГ-ын хог татан зайлуулах үйлчилгээнд ашиглагдаж буй автомашин, техникүүд хүрэлцээ муу, хоцрогдсон, парк шинэчлэл хийгдээгүй
- Төвлөрсөн хогийн цэг эрүүл ахуйн шаардлага хангасан үйл ажиллагаа, технологи байхгүй
- Мониторингийн тогтолцоо байхгүй
- Орчны бохирдлын шинжилгээ хийх судалгааны орчин муу, хүний нөөцийн чадавх сул

### Оролцогч талуудтай холбоотой:

- Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэн, ААН зэрэг бүх талын оролцоог тэгш хангагдаагүй
- Хог хаягдлын менежментэд оролцогч талуудын чиг үүргийг оновчтой болгох, хамтын ажиллагаа, уялдааг бэхжээгүй
- Боловсон хүчний хангамж хүрэлцээ, бодлого сул
- Хог хаягдлын талаарх харилцааг зохицуулах эрх зүйн орчин орон нутгийн төвшинд тодорхой болоогүй
- Хяналт, шалгалт, мониторингийн тогтолцоо хангалтгүй



## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 1.12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Хүснэгт 17. Нөхцөл байдлын шинжилгээ

Давуу тал “S”	Сул тал “W”
<ul style="list-style-type: none"> <li>- Мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлэх ЭШХ, их дээд болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй</li> <li>- Сумын засаг, захиргаа, байршлын хувьд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд тохиромжтой</li> <li>- Иргэд, олон нийтийн дунд хог хаягдлыг дахин ашиглах талаарх эерэг хандлага, өөрчлөлт гарч байгаа</li> <li>- Тогтмол үйл ажиллагаа явуулдаг дахивар авах цэгүүд үйл ажиллагаа явуулдаг /хөнгөн цагаан, зэс/</li> <li>- Хогийн төлбөрөө төлөх айл өрх, ААН-уудын тоо нэмэгдэж байгаа</li> <li>- Хог тээврийн автомашин, хүнд механизмын ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг төлөвлөдөг.</li> <li>- Сэргээн засварлах, дахин ашиглах чиглэлийн үйл ажиллагааны явуулдаг зөөлөн дэд бүтэцтэй /буйдан засвар, гутал засвар/</li> <li>- Сумын хог хаягдлын менежментийн асуудалд орон нутгийн удирдлага, бодлого боловсруулагчид анхаарал хандуулж байгаа</li> <li>- Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чадамж бүхий дээд боловсролын сургалтын байгууллага, хүний нөөцийн чадамжтай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Айл өрх, ААН байгууллагууд эх үүсвэр дээр нь ялгагдаггүй</li> <li>- Ажилчдын ажлын ачаалал их, мэргэжилтэй боловсон хүчин хангалтгүй</li> <li>- Цалин хөлс бага</li> <li>- Тогтсон хуваарийн дагуу ачилт хийгддэггүйн улмаас хууль бус тээвэрлэлт, албан бус хогийн цэгүүд үүсдэг</li> <li>- Иргэд, олон нийтийн хог хаягдлын менежментийн талаарх мэдлэг, ойлголт, хандлага муу</li> <li>- Хогийн төлбөр оновчтой бус</li> <li>- Хог тээвэрлэлтийн машин техник стандарт шаардлага хангадаггүй, хүрэлцээ муу</li> <li>- ААН байгууллага, нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн савны тогтсон стандарт байхгүй</li> <li>- ААН, байгууллагуудын хог хаягдлын хэмжээ, бүтцийн талаарх бүртгэл судалгаа, мэдээлэл хомс</li> <li>- Барилгын хог хаягдлын хэмжээ, төрлийн талаар бүртгэл судалгаа байхгүй</li> <li>- Одоо ашиглагдаж буй эмнэлгийн хог хаягдлыг халдваргүйжүүлэх, шатаах зуух эвдэрсэн</li> <li>- Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл судалгаа, бүртгэл, зохицуулалтыг хариуцсан мэргэжилтэнгүй, мөн тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэл байхгүй</li> <li>- Нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдлын хэмжээ, бүтэц, төрлийн талаар бүртгэл судалгаа байхгүй</li> <li>- Гэр хороололын айл өрхийн хогийн сав нь хашаан дотор байдаг, тухайн айлд хүн байхгүй тохиолдолд ачилт хийх боломжгүй</li> <li>- Бараат хогийн цэг нь эрүүл ахуйн стандарт шаардлагыг бүрэн хангахгүй байгаа /байршил, байгаль орчинд нөлөөлөх байдал, хашаа, хяналтын худаггүй, ариутгалын системгүй.</li> </ul>

## ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Боломж “О”	Аюул занал “Т”
<ul style="list-style-type: none"> <li>- Хөрөнгө оруулалт, хөгжлийн төсөл боловсруулж НҮБ-ын хэрэгжүүлэгч байгууллагууд, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, ЕСХБ, ШХАгентлаг, Японы Өвсний үндэс болон Койка, Жайка зэрэг ОУБ-уудаас хөрөнгө оруулалт авах боломжтой</li> <li>- Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр батлагдсан</li> <li>- Азийн хөгжлийн банкнаас хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжиж байгаа</li> <li>- Үйлдвэрийн районд БОАЖЯ-аас аюултай хог хаягдлыг түр хадгалах 50 тн агуулах баригдаж байгаа.</li> <li>- ИНБ, ТББ, иргэд хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаарх санал санаачилгууд гаргаж байгаа</li> <li>- Байгаль орчны ISO14001:2015 стандартуудыг төр, хувийн хэвшлийн байгууллагууд хэрэгжүүлж эхэлсэн.</li> <li>- Бараат хогийн цэгийн хаалтын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ</li> <li>- Эрүүл ахуйн шаардлага хангасан 2-р түвшний ландфилл шинээр төлөвлөх боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн бодлогын залгамж холбоо сул</li> <li>- Мөнгөний ханш уналтаас болоод төсөвлөсөн төсөв хүрэлцэхгүй байх</li> <li>- Иргэд олон нийт эх үүсвэр дээр ангилахад бэлэн биш</li> <li>- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төсөв санхүү хүрэлцэхгүй байх</li> <li>- Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилл байгуулахад мэргэжлийн инженер техникийн ажилтан байхгүй</li> <li>- Улс төрийн нөлөө урт хугацааны төлөвлөлтийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх</li> <li>- Төрийн байгууллагуудын бодлого үйл ажиллагааны уялдаа, холбоо сул</li> </ul>

# ДАРХАН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээний дүн

		Физик хүчин зүйлүүд	Үнэлгээ
1.1	Нийгмийн эрүүл мэнд хог хаягдал - цуглуулах үйлчилгээ	Хаягдал цуглуулах үйл ажиллагааны хамрах хүрээ	
1.2		Хог хаягдал цуглуулах үйлчилгээний хүрээнд нийт татан авалт хийгдсэн хогийн хэмжээ	
1C		Хог хаягдал цуглуулах, татан зайлуулах үйлчилгээний чанар	
2	Байгаль орчны хяналт-хаягдал боловсруулалт, устгах үйл ажиллагаа	Хаягдал боловсруулах, булшилж устгахад тавих хяналт	
2E		Хог хаягдал боловсруулах болон устгах үйл ажиллагааны байгаль орчинд халгүй байдал	
3	Нөөцийн менежмент – бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулалт	Хог хаягдал дахин боловсруулалтын хувь хэмжээ	
3R		3R – Бууруулах, дахин боловсруулалтын чанар	
		Засаглалын хүчин зүйлүүд	Үнэлгээ
4U	Хүртээмжтэй байдал	Хэрэглэгчийн оролцооны хүрээ	
4P		Үйлчилгээ үзүүлэгч талын оролцооны хүрээ	
5F	Санхүүгийн тогтвортой байдал	Санхүүгийн тогтвортой байдал	
6N	Салбарын институциуд болон бодлогын үзүүлэлтүүд	Үндэсний хэмжээнд хог хаягдлын менежментийн хамрах хүрээ	
6L		Орон нутгийн институцүүдийн уялдаа холбоо	



Сул



Сул/дунд



Дунд



Сул/сайн



Сайн

## 2. 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, СТРАТЕГИ

### 2.1. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Төлөвлөгөөнд баримтлах зарчмыг дараах байдлаар томъёолов.



1. ХУУЛЬ ДЭЭДЛЭХ



2. ЗАЛГАМЖ ЧАНАРАА ХАДГАЛАХ



3. ШУДАРГА, ИЛ ТОД БАЙХ



4. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ



5. ХАРИУЦЛАГАТАЙ БАЙХ



6. ЭРХ ТЭГШ БАЙХ



7. БОДИТОЙ, ҮР ДҮНТЭЙ БАЙХ



8. АСУУДЛЫН ШИЙДЛИЙГ ОНОВЧТОЙ  
ТОМЬЁОЛОХ



# 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

## 2.2. АЛСЫН ХАРАА



Зураг 48. Дархан сумын хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги

Ногоон хөгжлийн үзэл санааг дэлгэрүүлэн хог хаягдлын менежментийг шинэ шатанд гаргаж нөөц, түүхий эдийн хэмнэлттэй, үр ашигтай, хаягдал багатай цэвэр технологийг дэмжих замаар хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, бохирдуулагч нь төлбөр төлөх, 9R зарчимд тулгуурлан иргэдийн сэтгэлгээ хандлагыг өөрчилж, ухамсрыг дээшлүүлэх, хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, ангилах, дахин ашиглах, татан зайлуулах, дахин боловсруулах, байгальд халгүй булшлах, устгах дэд бүтцийг бий болгох, чадавхыг бэхжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлж, бүх нийтийн оролцоотойгоор хамтдаа хог хаягдлыг бууруулж, цэвэр эрүүл орчинг бүрдүүлэх чиглэлээр зорилго, үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлж үе шаттайгаар хэрэгжүүлэх зүй ёсны шаардлага урган гарч байна.

## 2.3. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Дархан сумын хэмжээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах, цуглуулах, татан зайлуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, булах үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн онцлогт тохирсон мини технологиудыг дэмжих, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, нэгэнт бий болсон зөөлөн дэд бүтцийг дэмжин хөгжүүлэх, иргэдэд хог хаягдлын боловсрол олгох, иргэд олон нийтийн оролцоонд тулгуурлах замаар хог хаягдлын менежментийг сайжруулж, орчны эрүүл ахуй өнгө үзэмжийг дээшлүүлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж амьдралын чанарыг дээшлүүлэхэд энэхүү төлөвлөгөөний зорилго оршино.

### ЗОРИЛТУУД:

**Зорилт 1.** Иргэд, олон нийтэд ногоон хэрэглээний соёл, эх үүсвэр дээр бууруулах, хог хаягдлыг ангилан ялгах, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх

- 1.1. Сургалтын жишиг хөтөлбөрүүд боловсруулах
- 1.2. Дахин ашиглагдах болон боловсруулагдах хаягдлын жагсаалт гаргах
- 1.3. Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах зааварчилгаа боловсруулах
- 1.4. Орон нутгийн хэвлэл мэдээлэл болон олон нийтийн сүлжээгээр нөлөөлийн ажил хийх
- 1.5. Иргэдийн оролцоонд тулгуурласан олон нийтийн ажил зохион байгуулах
- 1.6. Ангилсан хогийн жигд сав бий болгох, байршуулах
- 1.7. Хогийн зориулалтын ууттай болох
- 1.8. Дахивар авах цэгүүд бий болгох
- 1.9. Зорилтот байршлуудад гэрэлтүүлэг, камер байрлуулах
- 1.10. Ангилсан хог цуглуулах, тээвэрлэх зориулалтын машин техникийг нэмэгдүүлэх

**Зорилт 2.** Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэнд оруулах, ногоон ажлын байр бий болгох, жижиг дунд бизнесийг дэмжих, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх

- 2.1. Тавилга, цахилгаан бараа, гутал хувцас засварын газруудыг бодлогоор дэмжих, нэмж байгуулах
- 2.2. Органик хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах
- 2.3. Пластик хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах
- 2.4. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах
- 2.5. Хог тээвэрлэх, татан зайлуулах үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог дэмжих

**Зорилт 3.** Үйлдвэрлэлийн хог хаягдал болон Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулж, байгаль орчинд ээлтэй аргаар зайлуулах чадавхийг бий болгох

- 3.1. Аюултай хог хаягдлын бүртгэл судалгааг сайжруулж мэдээллийн санд оруулах
- 3.2. Аюултай хог хаягдлын татан зайлуулалтыг боловсронгуй болгох
- 3.3. Аюултай хог хаягдал булшлах зориулалтын талбай бий болгох
- 3.4. Үйлдвэрлэлийн хог хаягдлын татан зайлуулах тогтолцоо
- 3.5. Барилгын хог хаягдлын татан зайлуулах тогтолцоо

**Зорилт 4.** Булаж зайлуулах хог хаягдлын хэмжээг бууруулах, төвлөрсөн хогийн цэгийг байгаль орчинд халгүйгээр тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, техник хангамжийг сайжруулах

- 4.1. “Бараат” төвлөрсөн хогийн цэгийн дахин төлөвлөлт боловсруулах

4.2. Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилл байгуулах байршлын тохиромжтой байдлын үнэлгээ хийх

**Зорилт 5.** Хог хаягдлын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгож хэрэгжилтийг сайжруулах, хяналт болон урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, борлуулагч болон үйлдвэрлэгч үйлдвэрлэлийн нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, дахин ашиглах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгох замаар урт хугацааны төлөвлөлт бүхий тогтвортой үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх

5.1. Хог хаягдлын хэмжээнд суурилсан үнийн системийг хэрэгжүүлэх

5.2. Үйлдвэрлэгч хариуцлага хүлээх системийг хэрэгжүүлэх

**Зорилт 6.** Хог хаягдал, хорт бодисын ялгарлаас үүдэлтэй орчны бохирдлыг хянах хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, судалгаа шинжилгээний лабораторийн чадавхийг бэхжүүлэх, хог хаягдлын нарийвчилсан тоо бүртгэл, судалгаа хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх замаар хүрээлэн буй орчны чанарын бодит мэдээллээр хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах

6.1. Дархан сумын хог хаягдлын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх

6.2. УЦУОШГ-ын орчны шинжилгээний лабораторийн хүчин чадлыг сайжруулах

6.3. НААҮГ, СӨХ-ны ажилтан ажилчид, багийн нийгмийн ажилтан, дахивар цуглуулагч иргэдэд сургалт зохион байгуулах, чадавхжуулах

# 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД


## 2.4. СТРАТЕГИ

Дархан-Уул аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулахад дараах стратегиудыг баримтлан ажиллана. Үүнд:

1. Хог хаягдлыг бууруулах чиглэлээр иргэд олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах
2. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах тогтолцоог бүрдүүлэх
3. 9-R буюу 9-Дахин зарчмыг иргэн, байгууллага, аж ахуйн нэгж, институцийн бүх төвшинд хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах
4. Хог хаягдлыг татан зайлуулах, тээвэрлэх механизмыг боловсронгуй болгох, хамгийн бага хэмжээтэй байгаль орчинд халгүйгээр булшлах
5. Хог хаягдлыг бууруулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх
6. Хог хаягдлыг бууруулахад хяналт, судалгаа шинжилгээ, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020 он), "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030" бодлогын баримт бичиг (2016 он), Монгол улсын "Ногоон хөгжлийн бодлого" (2014 он), "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" (2015 он), Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2016 он), "Гурван тулгуурт хөгжлийн бодлого" (2018 он), "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги 2015-2020 он (2015 он), "Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр" (2014 он) Аймгийн ЗДТГ-ын гаргасан Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого 2009-2021, Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2035 зэрэг үндэсний болон орон нутгийн бодлогын бичиг баримтад хог хаягдлыг дахин боловсруулах талаар дурджээ. Үндэсний хэмжээнд хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг тасралтгүй нэмэгдүүлснээр 2030 онд нийт хог хаягдлын 40 %-ийг дахин боловсруулан эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлтэй байна (ХХААХҮЯ 2019).

Дархан сумын хог хаягдлыг бууруулахад баримтлах стратеги нь иргэд олон нийтэд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, бууруулах эерэг соёлыг төлөвшүүлэх, хандлагыг өөрчлөх, хог хаягдлыг ангилан ялгах, бууруулах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэх ба дэлхий нийтийн өнөөгийн чиг хандлагатай уялдуулан хаягдал багатай технологи, арга ажиллагаанд шилжих, хог хаягдлыг эргүүлэн ашиглах замаар байгалийн нөөц, баялгийг хэмнэх, эцсийн булж устгах хог хаягдлын хэмжээг бууруулахад чиглэгдэнэ.



Зураг 49. Дархан сумын хог хаягдлыг бууруулах бодлогын чиглэл



## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИИУД

Хүн төрөлхтөн анх үүссэн цагаасаа хог хаягдал бий болгосоор ирсэн ба техник, технологийн өсөлтийг дагаад хог хаягдлын бүтэц өөрчлөгдөж байгаль, экологи, хүний эрүүл мэндэд үзүүлэх хор хөнөөл нь улам бүр ихсэж байна. Дархан сумын хүн амын тогтвортой өсөлт, орон нутгаас сумыг зорьж буй шилжилт хөдөлгөөн болон үйлдвэрлэл, технологийн өсөлт нь хотжилт хурдацтай явагдахад нөлөөлж, хог хаягдлын хэмжээг ихэсгэж байна.

Хог хаягдлыг бууруулахад дэлхийн улс гүрнүүд бодлогын хэмжээнд анхаарал хандуулж, томоохон үйлдвэрлэл эрхлэгчид хэрэглээгээ хянах замаар эко шийдлийг эрэлхийлж байна. Энэ хүрээнд дэлхий даяар “Zero Waste” буюу “Тэг Хаягдал” хөдөлгөөн идэвхтэй өрнүүлж, хог хаягдлыг анхнаас нь үүсгэхгүй байх тал дээр ихээхэн анхаарч 3R, 5R, 7R зарчмыг баримталж буй юм.

Дээрх зарчмыг Дархан-Уул аймгийн хувьд орон нутгийн онцлогтой уялдуулан 9R буюу 9Дахин зарчим болгон өргөтгөж хог хаягдлыг бууруулах стратегидаа үндсэн зарчим болгон ажиллана.

### 9-R зарчим



1. **Rethink**- Аливаа зүйлийг худалдан авалт хийхдээ үнэхээр хэрэгцээтэй зүйл мөн эсэхийг дахин бодож нягтлах,
2. **Refuse**- Алхам тутамдаа хог хаягдал гаргахаас татгалзах,
3. **Reduce**- Удаан эдэлгээтэй зүйлс худалдан авах, нэг удаагийн зайг, цэнэглэдэг зайгаар орлуулан хэрэглэх,
4. **Reuse**- Дахин ашиглах хаягдлаар бүтээгдэхүүн хийж хэрэглэх,
5. **Return**- Дахин боловсруулагдах бүтээгдэхүүний хуванцар сав, баглаа боодол, шил лааз зэргийг буцаан тушаах,
6. **Repair**- Хуучин эд зүйлсээ сэргээн засварлаад хэрэглэх,
7. **Repurpose**- Боломжтой хог хаягдлыг өөрчлөн хэрэглэх, өөрсдийн хэрэглээний бүтээгдэхүүн хийх
8. **Recycle**- Хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгах
9. **Rot**- Хоол, хүнсний үлдэгдлийг бууруулах, ялзруулж бордоо болгох



Зураг 50. Дархан сумын хог хаягдлыг бууруулахад баримтлах 9R- 9Дахин зарчим

## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

Орон нутгийн хог хаягдлыг бууруулах 9R буюу 9Дахин зарчмын үндсэн ухагдахуун нь иргэдийг ухамсартай худалдан авалт хийхэд сургах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, сэргээн ашиглах хандлага төлөвшүүлэх, иргэдийн оролцоонд тулгуурласан хог хаягдлын менежментийг бэхжүүлэхэд чиглэгдэнэ. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, бууруулахад 9R буюу 9Дахин зарчмыг институцын бүх түвшинд нэвтрүүлэх, төлөвшүүлэхэд анхаарч ажиллана.

Дархан-Уул аймгийн хог хаягдлыг бууруулахад баримтлах үндсэн 6 стратегийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

### Хүснэгт 19. Хог хаягдлыг бууруулахад баримтлах стратеги, хэрэгжүүлэх арга хэмжээ

	Баримтлах стратеги	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Оролцогч тал
1	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахивар нөөц, дахин ашиглагдах, дахин боловсруулах, сэргээн ашиглагдах хог хаягдлыг бэлтгэн нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах	Дархан-Уул аймгийн хэмжээнд мөрдөх хог хаягдалтай холбоотой харилцааг зохицуулах цогц журам боловсруулах Хог хаягдлын үнэ тарифыг шинэчлэн тогтоох /бохирдуулагч төлөх болон хог хаягдлын хэмжээнд суурилсан үнийн системийг нэвтрүүлэх/ Урамшууллын бодлого боловсруулах Дахин ашиглагдах болон боловсруулагдах хаягдлын жагсаалт гаргах Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах зааварчилгаа боловсруулах Иргэн, гэр бүл, үйлдвэрлэл аж ахуйн нэгж, байгууллагын төвшинд хог хаягдлыг бууруулах зааварчилгаа боловсруулах Ангилсан хогийн стандартад нийцсэн жигд сав бий болгох, байршуулах Хогийн зориулалтын ууттай болох Дахивар авах цэгүүд бий болгох	Аймгийн ЗДТГ, бүх шатны засаг дарга нар, ИТХ, холбогдох газар, хэлтсийн дарга нар, судалгааны байгууллага, ТББ болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл
2	Хог хаягдлыг бууруулах чиглэлээр иргэд олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах бууруулах чиглэлээр нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хог хаягдлын албан болон албан бус сургалтын хөтөлбөр/модулиудыг боловсруулах Иргэдийн оролцоонд тулгуурласан олон нийтийн ажил зохион байгуулах. Жишээ нь: Хуучин номын үзэсгэлэн, хэрэглэхгүй илүүдэл зүйлсээ солилцох, хандивлах, тушаах, зарж борлуулах нөхцөлийг бүрдүүлсэн нээлттэй үзэсгэлэн худалдаа (Open market), сургуулиудад эцэг эх, багш, сурагчдын хамтарсан ахуйн хог хаягдлаа хамтран ялгах өдөрлөг сургалт (Recycling Day), сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх өдөрлөг Гарын доорх материал болон дахин ашиглагдах боломжтой хаягдлаар бүтээгдэхүүн хийх, сэргээн засварлах сургалтыг зохион байгуулах. Жишээ нь: Хуучин хувцас, өөдөс материал зэргийг	Аймгийн ЗДТГ, НААҮГ, Үйлдвэрлэл, Аж ахуйн нэгжүүд, бүх шатны боловсролын байгууллага, судалгааны байгууллага, ТББ

## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

		<p>ашиглан даавуун тор, буйдангийн бүтээлэг хийх сургалт гм</p> <p>Хаягдал ашиглан шинэ бүтээгдэхүүн гаргах бүтээлч санаачилгыг дэмжсэн, олон нийтийн уралдаан зохион байгуулах</p> <p>НААҮГ, СӨХ-ийн ажилтан, ажилчид, багийн нийгмийн ажилтан, хувийн хэвшлийн төлөөлөл, дахивар цуглуулагч иргэдэд сургалт зохион байгуулах</p>	
3	<p>9-R буюу 9-Дахин зарчмыг иргэн, байгууллага, аж ахуйн нэгж, институцын бүх түвшинд хэрэгжүүлэх /Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, сэргээн засварлах, дахин ашиглах, бууруулах/</p>	<p>9-R зарчмыг иргэд, олон нийтэд таниулах нөлөөллийн ажлыг орон нутгийн хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр зохион байгуулах</p> <p>R-9 буюу 9-Дахин зарчим, хандлагыг төлөвшүүлэх цуврал Сошиал контент хөгжүүлэх</p> <p>R-9 буюу 9-Дахин зарчмын хүрээнд хог хаягдлыг ангилан ялгах, сэргээн засварлах, дахин ашиглах чиглэлээр аян зохион байгуулах, Жишээ нь: “Нэг хэрэглээний бүтээгдэхүүнээс татгалзая”, “Био бордоог гэртээ”, “Zero waste- Тэг хаягдал”, “Хоолны үлдэгдэлгүй таваг” хөдөлгөөн гм.</p> <p>Борлуулсан бүтээгдэхүүний сав баглаа болон дахин ашиглах, боловсруулах боломжтой хаягдыг буцаан авдаг хүнсний дэлгүүрийг баг бүрт ажиллуулах, хогийн төлбөрөөс чөлөөлөх, зээл төсөл хөтөлбөрт хамруулах зэрэг бодлогоор дэмжин тоог нэмэгдүүлэх. Жнь: ус, ундаа, архи, пивоны шил, хуванцар сав, даршилсан ногооны шил, тортны хайрцаг гм.</p>	<p>Төрийн байгууллага, Хувийн хэвшил, ААН байгууллага, Судалгааны байгууллага, ТББ, Иргэн</p>
4.	<p>Хог хаягдлыг ангилах, татан зайлуулах, хамгийн бага хэмжээтэй байгальд халгүй менежментийг сайжруулах</p>	<p>Хог хаягдлыг татан зайлуулах хуваарийг шинэчлэн, үйлчилгээг цахим болгох</p> <p>Хогийг ангилсан чиглэлийн дагуу зориулалтын техник хэрэгслээр татан зайлуулалт, тээвэрлэлтийг хийх</p> <p>Хог хаягдлыг татан зайлуулах техник хангамжийг шинэчлэх, сайжруулах</p> <p>Дахивар авах цэгүүдийн түүхий эдээ татан авалт хийхэд бодлогын дэмжлэг үзүүлэх, эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилл байгуулах</p>	<p>Аймгийн ЗДТГ, НААҮГ, сумын ЗДТГ, баг</p>
5	<p>Хог хаягдлыг бууруулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх</p>	<p>Хог хаягдлыг бууруулах, сэргээн ашиглах, дахин боловсруулах чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагуудын авч хэрэгжүүлж буй дэвшилтэт техник, технологи, инновацийн санаачилгыг дэмжих, түгээн дэлгэрүүлэх</p> <p>Хог хаягдлыг ангилах, татан зайлуулах үйл ажиллагаанд хувийн хэвшлийг татан оролцуулах</p> <p>Тавилга, цахилгаан бараа, гутал хувцас засварын газруудыг чадавхижуулах,</p>	<p>Аймгийн ЗДТГ, Хувийн хэвшил, Донор байгууллага</p>

## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

		тогтвортой санхүүжилттэй болоход бодлогын дэмжлэг үзүүлэх	
6	Хог хаягдлыг бууруулахад хяналт, судалгаа шинжилгээ, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх	Зорилтот байршлуудад гэрэлтүүлэг, камер байрлуулах Жнь: Бараат болон албан бус хогийн цэгүүдийн орчимд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр ажилладаг гэрэлтүүлэг, камер байрлуулах Иргэдийн оролцоотой хяналтын тогтолцоог бий болгох, “Ахмадын зөвлөл”, “Сайн дурын бүлгэм”, “Иргэний зөвлөл” гэх мэт иргэний нийгмийн болон сайн дурын байгууллага, иргэд олон нийтийг түшиглэн хяналтын тогтолцоог бэхжүүлэх, сайн болон муу жишээг олон нийтэд мэдээлэх, хөхүүлэн дэмжих, торгох шийтгэх арга хэмжээг ил тод болгох УЦУОШГ, МХЕГ-ын орчны шинжилгээний лабораторийн хүчин чадлыг сайжруулах Дархан сумын хог хаягдлын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, цахимжуулах	Аймаг, сумын ЗДТГ, УЦУОШГ, МХЕГ, Их дээд сургууль, судалгааны байгууллага

## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

### 2.5. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад урьдчилан тооцоолоогүй эрсдлүүд учирч болзошгүй тул ямар эрсдэл, бэрхшээлүүд гарч болох, түүнийг хэрхэн даван туулах талаар дараах томъёоллыг гаргаж байна.

Хүснэгт 20. Учирч болох эрсдэл, шийдвэрлэх арга зам

№	Учирч болох эрсдлүүд	Шийдвэрлэх арга замууд	Хариуцах байгууллага
<b>Зорилт 1. Иргэд, олон нийгэд ногоон хэрэглээний соёл, эх үүсвэр дээр бууруулах, хог хаягдлыг ангилан ялгах, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэхэд учирч болох хүндрэлүүд</b>			
1	Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах бэлтгэл ажил хангалтгүй байх	<ul style="list-style-type: none"> <li>- 3 сард багтаж Дархан-Уул аймагт мөрдөх хог хаягдлын журмыг ИТХ-аар батлуулна</li> <li>- 2022 оны 1-3 сард хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон хог хаягдлын журмыг хэвлэл мэдээлэл болон социал сүлжээгээр сурталчлан таниулах төлөвлөгөөний хэрэгжилтийн бэлтгэл ажлууд хийгдэнэ.</li> <li>- 4-р сарын 1-ээс орон сууцны 2 хороололд Цаас, Шил Лааз, Хуванцар, Органик, бусад гэсэн 5 ангиллаар, гэр хорооллын 2 багт тус тус 2 гудманд үнс, дахин ашиглах боломжтой, органик, бусад гэсэн 4 ангиллаар, 10 ААН байгууллагад Цаас, Шил Лааз, Хуванцар, Органик, аюултай, бусад гэсэн 5 ангиллаар эхлүүлнэ.</li> <li>- Гэр хорооллын айл өрхүүдийн дахин ашиглагдах дахиваруудыг гудамж гудамжаар зохион байгуулалтанд оруулж цуглуулна.</li> <li>- 9 сарын 1-нээс блокын системээр болон бусад ААН байгууллагад эхлүүлнэ.</li> <li>- Томоохон супермаркетуудад ухаалаг дахиварын машинуудыг /drop-off/ байрлуулна.</li> <li>- Бараат төвлөрсөн хогийн цэг дээр дахин ангилах үйл ажиллагааг албан бус дахивар цуглуулагч иргэдийн оролцоотойгоор хийнэ</li> </ul>	<p>Дархан сумын ЗДТГ</p> <p>ЗАА, Дархан сумын ЗДТГ</p> <p>Дархан сумын ЗДТГ, НААУГ, СӨХ, ГӨХ</p> <p>Дархан сумын ЗДТГ, НААУГ, ГӨХ</p> <p>Дархан сумын ЗДТГ, НААУГ, СӨХ, ГӨХ</p> <p>НААУГ</p>
2	Дархан сумын хүн амын ухамсар бэлэн эсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн хэмжээнд сургагч багш нарыг бэлтгэнэ.</li> <li>- Орон нутагт хэрэгжүүлэх хог хаягдлын журам болон хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, ангилах хөтөлбөрийн талаар орон нутгийн ТВ, FM радио, социал сувгуудаар сургалт сурталчилгаа, танилцуулгын ажил хийнэ.</li> </ul>	Монголын Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо, НҮТББ, ХААИС, ШУТИС



## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

		<ul style="list-style-type: none"> <li>- Бүх шатны боловсролын байгууллага, багийн хөгжлийн төвүүд, томоохон үйлдвэр, худалдааны байгууллагуудаар дамжуулан мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна.</li> <li>- Бүх шатны боловсролын байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн сайн дурын бүлэг, холбоодоор дамжуулан сурталчилгаа, танилцуулгын ажил хийнэ.</li> <li>- Үлгэр жишээ иргэн, ААН, СӨХ зэргийг урамшуулж, алдаршуулна.</li> </ul>	<p>ЗАА, БСУГ, Дархан сумын ЗДТГ, социал маркетингийн алба</p>
3	Ангилсан хогийн савыг зориулалтаар нь ашиглахгүй байх, эвдэлж сүйтгэх	<ul style="list-style-type: none"> <li>- Орон сууцны хорооллын нийтийн хогийн савыг СӨХ-д хариуцуулна.</li> <li>- Зорилтот байршлуудад гэрэлтүүлэг камерууд байрлуулна.</li> <li>- Дахивар түүгч иргэдэд сургалт явуулж, жигд хувцас, үнэмлэх олгож, ажлын байршлуудыг хуваарилж нэгдсэн зохион байгуулалтанд оруулна.</li> <li>- Ахмадын холбоо, сургуулиудын эко клубын гишүүд, Хөршийн холбоодуудын үйл ажиллагааг дэмжиж татан оролцуулна.</li> <li>- Зөрчил гаргагч иргэн, ААН-д хуулийн хариуцлага тооцно, олон нийтийн сүлжээгээр анхааруулж жигшүүлэх</li> </ul>	<p>Дархан сумын ЗДТГ, НААҮГ, СӨХ, ГӨХ, Ахмадын холбоо, Эмэгтэйчүүдийн холбоо, Оюутны холбоо, социал маркетингийн алба</p>
4	Дахивар авах төвүүдийн үйл ажиллагаа доголдох	<ul style="list-style-type: none"> <li>- Гарааны хөрөнгийг төсөл, орон нутгийн төсөв, хувийн хэвшилтэй хөрөнгө оруулалттай гэрээний зарчмаар шийдвэрлэх</li> <li>- Ус, дулаан гэх мэт тогтмол зардлуудыг тэглэнэ</li> <li>- Дахин боловсруулах үйлдвэрүүд баригдаж үйл ажиллагаа жигдэрч эхлэх хүртэл цугларсан дахиваруудыг Улаанбаатар хотод мэргэжлийн дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх болон Дархандаа нөөцлөх ажлуудыг зохион байгуулах</li> </ul>	<p>Аймгийн ЗДТГ, Дархан сумын ЗДТГ</p>
5	Овор хэмжээ ихтэй болон ахуйн электрон хаягдал төлбөртэй цуглуулахад иргэн ААН-үүд бэлэн эсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Иргэд, олон нийт, аж ахуйн нэгжүүдэд хогийг зөв соёлыг төлөвшүүлэх, овор ихтэй ахуйн болон электрон хаягдлыг төлбөртэй цуглуулах, өөр хоорондоо солилцох нөхцөлийг бүрдүүлсэн арга хэмжээ зохион байгуулах, сэргээн засварлах үйлчилгээний талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах</li> <li>- Овор ихтэй хог хаягдлыг тушаах, тээвэрлэх, дахин ашиглах, зөрчил гаргасан тохиолдолд төлбөр төлүүлэх, арга хэмжээ авах</li> <li>- Хог хаягдлын менежментийн нэгдсэн вэб сайт (платформ) ажиллуулах, тухайн вэб сайтаар дамжуулан иргэд овор ихтэй хог</li> </ul>	<p>Аймгийн ЗДТГ, ЗАА, Дархан сумын ЗДТГ, ХАҮТ, МХГ, НААҮГ, ТББ</p>

## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

		<p>хаягдлаа тээвэрлүүлэх захиалгаа өгөх, хогийн төлбөр тооцоогоо тушаах зэрэг нэгдсэн үйлчилгээг цахимаар явуулах нөхцөлийг бүрдүүлэх</p> <p>- Ахуйн цахилгаан хэрэгсэл, гар утас худалдаалдаг дэлгүүр, төвүүдэд электрон хаягдал эргүүлэн авах цэг, сав байрлуулах</p>	
6	Одоо байгаа албан бус болон хур хогийг устгах, цэвэрлэхэд хүн хүч, техник дутагдах	- ААН, олон нийтийг зохион байгуулалттайгаар татан оролцуулна	Аймгийн ЗДТГ, ЗАА, Дархан сумын ЗДТГ, НААҮГ, ААНБ, ТББ
<p><b>Зорилт 2. Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэнд оруулах, ногоон ажлын байр бий болгох, жижиг, дунд бизнесийг дэмжих, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэхэд учирж болох хүндрэлүүд</b></p>			
1	Сэргээн засварлах үйл ажиллагаа явуулдаг иргэн ААН-үүд бэлэн эсэх	<p>- Форум хэлэлцүүлэг зохион байгуулахаас өмнө сэргээн засварлах үйл ажиллагаа явуулдаг иргэн, ААН-ийн судалгааг нарийвчлан гаргана</p> <p>- Форум хэлэлцүүлэгт бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх гэх мэт бүх талуудыг оролцуулна</p> <p>- Сэргээн засварлах төвүүдийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу мэргэжлийн холбоодыг байгуулах / Оёдолчдын холбоо, Электрон бараа засварчдын холбоо гм/</p> <p>- Мэргэжлийн холбоодоор дамжуулан сэргээн засварлах үйл ажиллагаа явуулдаг иргэд, ААН-г чадавхижуулах, төсөл хөтөлбөрт хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх</p> <p>- Сэргээн засварлах үйл ажиллагаа явуулдаг иргэд, ААН-н үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангаж, бодлогын дэмжлэг үзүүлэх</p> <p>- Сэргээн засварлах үйл ажиллагааны сайн туршлагыг мэргэжлийн чиглэлийн дагуу үйл ажиллагаа эрхлэгч бусад иргэн, ААН-д сурталчилах, түгээн дэлгэрүүлэх ажлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулах</p>	Аймгийн ЗДТГ, ЗАА, Дархан сумын ЗДТГ, ХАҮТ
2	Ангилсан хог хаягдлуудыг тус тусад нь татан тээвэрлэхэд техник, хүн хүч, үйл ажиллагааны хүндрэл үүсэх	<p>- Хувийн хэвшлийг татан оролцуулахдаа тухайн ААН-ийн хүчин чадалд үндэслэн баг, багаар хэсэгчлэн гэрээ байгуулна</p> <p>- Хувийн хэвшилтэй гэрээ байгуулахдаа ангилсан хогийн төрөл бүрээр тус тусад төрөлжүүлэн гэрээ байгуулна</p> <p>- Дахивар бүрээр татан тээвэрлэх хуваарийг баталж үйл ажиллагааг тогтмолжуулна</p>	Дархан сумын ЗДТГ

## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

3	ЖДҮ, бизнес эрхлэгчид бэлэн эсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Шинжлэх ухааны байгууллагууд ЖДҮ, бизнес эрхлэгчдийн түншлэлийн дэмжсэн бодлого хэрэгжүүлж, нэгдсэн платформ бий болгоно</li> <li>- Орон нутгийн нөхцөлд нийцсэн технологиудыг ЖДҮ, бизнес эрхлэгчдээр дамжуулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ</li> <li>- Сум хөгжүүлэх сан болон бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд гарааны компаниудыг дэмжинэ</li> <li>- Хөнгөлөлттэй зээлд хамруулах, татвараас чөлөөлөх зэрэг бодлогуудаар дэмжиж ажиллана</li> </ul>	Аймгийн ЗДТГ, Дархан сумын ЗДТГ, ХАҮТ, Европийн холбоо Дархан хотын Бизнес Инновацийн Төв
4	Дахин боловсруулах үйлдвэрүүдийг байгуулахад байршил тодорхойлж газар олгоход хүндрэл үүсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлан оновчтой байршлыг тодорхойлох</li> </ul>	Дархан-Уул аймгийн засаг дарга, сумын ЗДТГ, ГХБХБГ, УЦУОШГ
5	Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулахад санхүүгийн болон нөөцийн хомсдол үүсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Концессийн гэрээ байгуулан ажиллах боломжтой компани ААН-д нээлттэй тендер зарлах, мэдээллээр хангах</li> <li>- Эх үүсвэр дээр ангилах үйл ажиллагааг 2022 оны төлөвлөсөн хугацаанд эхлүүлэх</li> <li>- Нөөцийн хомсдолд орохгүйн тулд эхний ээлжинд хашаагаа бариад үйлдвэрлэл эхэлтэл цугларсан хуванцаруудаа нөөцлөн хадгалах, зэргэлдээх аймаг, сумдаас түүхий эд нийлүүлэх боломжийг нэмэгдүүлэх</li> <li>- Орон нутагт шууд эхлүүлчих боломжтой мини технологит суурилсан хуванцараар хашааны шон, модны хайс хийх зэрэг ЖДҮ-ийг дэмжих</li> <li>- Төсөл боловсруулан грант, хөрөнгө оруулалт татах</li> </ul>	Дархан-Уул аймгийн ЗДТГ, Сумын ЗДТГ
6	Органик хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулахад санхүүгийн болон нөөцийн хомсдол үүсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Концессийн гэрээ байгуулан ажиллах боломжтой компани ААН-д нээлттэй тендер зарлах, мэдээллээр хангах</li> <li>- Графикийн дагуу ангилсан хог хаягдлын татан авалт хийх, зэргэлдээ аймгуудаас нэмэлт түүхий эд татах</li> <li>- Газрын асуудлыг шийдвэрлэж хашаагаа бариад цугларсан хаягдлаа нөөцлөн нуруулдаж эхлэх</li> <li>- Төсөл боловсруулан грант, хөрөнгө оруулалт татах</li> </ul>	Дархан-Уул аймгийн ЗДТГ, Сумын ЗДТГ

## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

7	Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулахад санхүүгийн болон нөөцийн хомсдол үүсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Иргэд, аж ахуйн нэгжүүдэд барилгын хог хаягдлыг дахин ашиглах талаар сургалт зохион байгуулах</li> <li>- Хаягдал татан төвлөрүүлэх ажлын менежментийг сайжруулах</li> <li>- Барилгын хог, хаягдлыг ашиглах үйлдвэрлэлийн технологийн зөвлөгөө өгөх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих</li> <li>- Барилгын хог хаягдлыг ашиглах үйлдвэрийн төсөл боловсруулах</li> <li>- Хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх</li> </ul>	Дархан-Уул аймгийн ЗДТГ, Сумын ЗДТГ ШУТИС-ийн ДаТС-ийн Барилгын материал судлалын төв
8	Дахин боловсруулах үйлдвэрүүдийг байгуулахад үүсэх дэд бүтцийн асуудал	<ul style="list-style-type: none"> <li>- Цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй холбох</li> <li>- Ус- Гүний худаг гаргах</li> <li>- Дулааны асуудлыг шийдвэрлэх</li> <li>- Харуул хамгаалалттай болгох</li> </ul>	Дархан-Уул аймгийн ЗДТГ, Сумын ЗДТГ, төрийн өмчит компаниуд
9	Машин, техникийн тоо хүчин чадал хүрэлцэхгүй байх	<ul style="list-style-type: none"> <li>- Дахин ашиглагдах хаягдлыг цуглуулах тээвэрлэх ажлыг сэргээн засварлах төвүүд буюу 2-догч түүхий эдээр хөдөлмөр эрхлэгчид болон дахиварын төв ажиллуулах хувийн хэвшлийнхэнтэй хамтран ангилсан дахин ашиглагдах хаягдлыг тээвэрлэх үйл ажиллагааг сумын ЗДТГ зохион байгуулна.</li> <li>- Цаг үеийн зохицуулалтыг сумын засаг дарга, НААҮГ-ын удирдлага хариуцан зохион байгуулна.</li> <li>- Жил бүр парк шинэчлэл хийж 1 блокт 1 хог тээврийн машин нэмэх. Улсын болон орон нутгийн төсөвт суулган жил бүр дутагдалтай байгаа хэрэгцээт машиныг авах ажлыг зохион байгуулна.</li> <li>- Аймгаас зарлах сонгон шалгаруулалтын дагуу хог тээвэрлэгч байгууллагуудыг оруулах замаар асуудлыг шийдвэрлэнэ.</li> </ul>	Дархан сумын ЗДТГ, НААҮГ
<p><b>Зорилт 3. Үйлдвэрлэлийн хог хаягдал болон аюултай хог хаягдлын менежментийг сайжруулж байгаль орчинд ээлтэй аргаар зайлуулах чадавхийг бий болгоход учирч болох хүндрэлүүд</b></p>			
1	Аюултай хог ангилахад бэлэн эсэх, хэзээнээс эхлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн хэмжээнд БОАЖГ-т аюултай хог хаягдал хариуцсан мэргэжилтэнтэй болж холбогдох үйл ажиллагааг удирдана</li> <li>- 2022 оны 1-3 сард айл өрхөөс гардаг аюултай хог хаягдал, тэдгээрийн хор хохирол, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлдэг сөрөг нөлөөллийн талаар социал сүлжээгээр сурталчилан таниулна</li> <li>- Одоо үйл ажиллагаа явуулж байгаа 2-догч түүхий эд хүлээн авах цэгүүд, машин засварын газруудтай уулзалт форум хийж хамтран ажиллах гэрээ байгуулна</li> </ul>	<p style="text-align: center;">БОАЖГ</p> <p>ЗАА, Дархан сумын ЗДТГ, социал маркетингийн алба, ЭМГ, БОАЖГ, МХГ</p> <p style="text-align: right;">Дархан сумын ЗДТГ, НААҮГ,</p>

## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

		<ul style="list-style-type: none"> <li>- Эмийн сан, өрхийн эмнэлэгүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулна</li> <li>- 2022 оны 4 сарын 1-ээс айл өрхөөс гарч буй аюултай хог хаягдлыг ангилан дахин ашиглагдах дахиваруудыг /дугуй, ажилласан тос, аккумулятор гэх мэт/ 2-догч түүхий эд хүлээн авах цэг, машин засварын газруудаар дамжуулан цуглуулна, хугацаа дууссан эм тариа халдвар бүхий хаягдлыг эмийн сан, өрхийн эмнэлэгүүдээр дамжуулан цуглуулна</li> <li>- 2022 оны 4 сарын 1-ээс айл өрх, аж ахуйн нэгжүүдээс гарах баттерей цуглуулах цэгийг гэр ахуйн худалдаа эрхэлдэг дэлгүүрүүдэд байршуулж тэндээс НААҮГ-т төвлөрүүлэн түр хадгална</li> <li>- 2022 оны 4 сарын 1-ээс айл өрхийн хугацаа нь дууссан эм, тарианы хаягдлыг ойролцоох эмийн сан, өрхийн эмнэлэгүүдээр дамжуулан цуглуулна</li> <li>- 2022 оны 6 сараас ИДС, ЕБС, судалгааны болон үйлдвэрийн лабораториуд, цехүүдэд хадгалагдаж байгаа хугацаа нь дууссан химийн бодис зэргийг аюултай хог хаягдал түр хадгалах агуулахад төвлөрүүлнэ</li> <li>- 2022 оны 6 сараас үйлдвэрийн газрууд үйлдвэрлэлээс үүсч буй хог хаягдалдаа мониторинг хийлгэж хэрэв аюултай хог хаягдал үүсгэж байгаа бол хуульд заасны дагуу ангилан БОАЖГ, НААҮГ мэдэгдэнэ</li> </ul>	<p>2-догч түүхий эд хүлээн авах цэгүүд</p> <p>Дархан сумын ЗДТГ, ЭМГ</p> <p>Дархан сумын ЗДТГ, сүлжээ дэлгүүрүүд, НААҮГ</p> <p>Дархан сумын ЗДТГ МХГ, ОБГ, БОАЖГ</p> <p>Дархан сумын ЗДТГ, ЭМГ</p> <p>ЗАА, Дархан сумын ЗДТГ, БОАЖГ</p>
2	Эмнэлгийн хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах ажлыг эхлүүлэхэд санхүүгийн болон үйл ажиллагааны хүндрэл үүсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Эмнэлгийн аюултай хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ариутгах, бутлах, шатаах, устгах тоног төхөөрөмж бий болгох хөрөнгө оруулалтын төсөл бичнэ</li> <li>- Эмнэлгийн аюултай хог хаягдлыг устгахад улсын төсвөөс татаас авах</li> <li>- Хаягдлыг халдваргүйжүүлж, буталж, устгах ажилтныг сургалтад хамруулна</li> </ul>	Дархан сумын ЗДТГ, ЭМГ
3	Аюулгүй хадгалах тээвэрлэхэд техникийн хүчин чадал болон үйл ажиллагааны хүндрэл	<ul style="list-style-type: none"> <li>- 2023 оны 1 сараас эхлэн тусгай зориулалтын лого тэмдэг бүхий бүхээгтэй машинаар тээвэрлэнэ</li> <li>- 2022 оны 6 сараас аюултай хог хаягдлыг цуглуулж, түр хадгалж байгаа газрыг стандарт шаардлагад нийцүүлэх</li> <li>- 2022 оны 6 сараас дахин боловсруулах боломжтой аюултай хог хаягдлыг УБ хот руу тээвэрлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай /зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж/ хамтран хийнэ</li> </ul>	Дархан сумын ЗДТГ, зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, МХГ, ОБГ, БОАЖГ



## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

<b>Зорилт 4. Булж зайлуулах хог хаягдлын хэмжээг бууруулах, хогийн төвлөрсөн цэгийг байгаль орчинд халгүйгээр тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, техник хангамжийг сайжруулахад учирж болох хүндрэлүүд</b>			
1	Бараат хогийн цэгийн нөхөн сэргээлтийн талбай дахь модны ургалтанд гадаад орчны сөрөг нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> <li>- Нөхөн сэргээлтийн талбайн хашаажуулалтыг бат бэх хийгээгүйгээс мал амьтан ногоон байгууламжийг эвдэлж сүйтгэх тул хашаажуулалтыг хийсний дараа нөхөн сэргээлтийн ажил хийж эхлэх</li> <li>- Хөрсний бохирдол ургамлын ургалтанд нөлөөлж болзошгүй тул шимт хөрсөөр хучих, компост бордоог ашиглах.</li> <li>- Мэргэжлийн хүн болон байгууллагын зөвлөмжид тулгуурлан ногоон байгууламжийг байгуулах</li> <li>- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд иргэн, ААНБ-ын дэмжлэг тусламжтайгаар тарих модны ханган нийлүүлэлтийг шийдвэрлэх</li> </ul>	Аймаг сумын ЗДТГ, БОАЖГ, НААҮГ, ХААИС
2	Бараат хогийн цэгийн нөхөн сэргээлтийн талбай дахь худаг уст цэгийн ундарга, байршил өөрчлөгдөх, усны нөөцийн хомсдол бий болох	<ul style="list-style-type: none"> <li>- Худгийн ундарга байршлыг мэргэжлийн байгууллагаар гаргуулах, нөөцийг тогтоох</li> <li>- Усны нөөцийг хадгалах цөөрөм байгуулж болно.</li> <li>- Усны нөөц хангалтгүй бол худгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх</li> </ul>	Аймаг сумын ЗДТГ, БОАЖГ, Мэргэжлийн байгууллага
3	Бараат төвлөрсөн хогийн цэгийн нөөц талбайн ашиглалтын хугацаа дуусах	<ul style="list-style-type: none"> <li>- Хогийг ангилан ялгахгүйгээр булах тохиолдолд 3 жил ашиглагдах нөөцтэй тул хогийг 50-70 хувь хүртэл ангилан ялгаж хэмжээг бууруулах</li> <li>- Эргэн тойрон албан бус хогийн цэг үүсэхээс сэргийлэх зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг төлөвлөгөөнд тусгагдсан тохиромжтой байршилд бий болгох</li> <li>- Өндөр хүчин чадалтай хүнд даацын тоног төхөөрөмжөөр нягтруулалтыг хийх</li> </ul>	Аймаг сумын ЗДТГ, ЗАА, НААҮГ
<b>Зорилт 5. Хог хаягдлын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгож хэрэгжилтийг сайжруулах, хяналт болон урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, борлуулагч болон үйлдвэрлэгч үйлдвэрлэлийн нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, дахин ашиглах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгох замаар урт хугацааны төлөвлөлт бүхий тогтвортой үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд учирж болох хүндрэлүүд</b>			
1	Хог хаягдлын харилцааг зохицуулах журам хэзээнээс мөрдөгдөх	<ul style="list-style-type: none"> <li>- 2022 оны 1-3 сард “Хог хаягдлын харилцааг зохицуулах журам”-ыг иргэн, ААН нийгмийн бүх институциудад таниулан сурталчлах</li> <li>- 2022 оны 4-8 сард “Хог хаягдлын харилцааг зохицуулах журам”-ын хүрээнд оролцогч талуудтай гэрээ байгуулах</li> </ul>	Аймаг сумын ЗДТГ, ЗАА, Мэргэжлийн зөвлөл, ИНБ

## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

		<ul style="list-style-type: none"> <li>- 2022 оны 9 сарын 1-ээс “Хог хаягдлын харилцааг зохицуулах журам”-ыг мөрдөж эхлэх</li> </ul>	
2	Хог хаягдлын хэмжээнд суурилсан үнийн системийг мөрдөхөд бэлэн эсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Одоо мөрдөж байгаа хог хаягдлын хураамж болон хог хаягдлын хэмжээнд суурилсан үнийн тарифын ялгаа, зарчмын талаар олон нийтийн хэлэлцүүлэг, нэвтрүүлэг, форум зохион байгуулах</li> <li>- Эх үүсвэр дээр хог хаягдлыг ангилах үйл ажиллагааны хүрээнд Дархан-Уул аймагт ашиглах зориулалтын хогийн уутыг бэлэн болгох</li> <li>- Хогийн уутыг худалдаалах дэлгүүрүүдтэй гэрээ байгуулах</li> <li>- Дархан-Уул аймгийн хэмжээнд хогийн зориулалтын бусад гялгар уутны худалдааг хориглох</li> <li>- 2022 оны 4 сарын 1-ээс орон сууцны 2 хороолол, гэр хорооллын 2 багийн тус тус 2 гудамжинд болон 10 ААНБ дээр туршилтаар эхлүүлнэ</li> <li>- 2022 оны 8 сард үр дүнгийн тайлан хэлэлцэнэ</li> <li>- 2022 оны 9 сараас блокын системээр хэрэгжүүлж эхлэх</li> </ul>	Аймаг сумын ЗДТГ, ЗАА, НААУГ, мэргэжлийн зөвлөл, ИНБ, баг, СӨХ, ГӨХ
3	Үйлдвэрлэгчид хариуцлага хүлээх системийг хэзээнээс мөрдөх	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэгч болон борлуулагч байгууллагуудын судалгааг чиглэл бүрээр гаргана</li> <li>- Үйлдвэрлэгч хариуцлага хүлээх (EPR) системийн талаар бүх талуудын оролцоог хангасан хэлэлцүүлэг, форум зохион байгуулах</li> <li>- Хамтран ажиллах гэрээний эх бэлтгэл боловсруулах</li> <li>- ААН байгууллагуудтай гэрээ байгуулах</li> <li>- Хог хаягдал ангилан ялгаж, цуглуулах үйл ажиллагаа эхлэсэн өдрөөс мөрдөж эхлэнэ</li> </ul>	Аймаг сумын ЗДТГ, ЗАА, ХАУТ, НААУГ, мэргэжлийн зөвлөл, ИНБ
<p><b>Зорилт 6. Хог хаягдал, хорт бодисын ялгарлаас үүдэлтэй орчны бохирдлыг хянах хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, судалгаа шинжилгээний лабораторийн чадавхийг бэхжүүлэх, хог хаягдлын нарийвчилсан тоо бүртгэл, судалгаа хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх замаар хүрээлэн буй орчны чанарын бодит мэдээллээр хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулахад учирч болох хүндрэлүүд</b></p>			
1	Хяналт, шинжилгээний лабораторийн хүчин чадал хангалтгүй байх	<ul style="list-style-type: none"> <li>- 2022 оны 1 сараас эхлэн агаар, ус, хөрсний шинжилгээний тоног төхөөрөмж бий болгох хөрөнгө оруулалтын төсөл бичих</li> <li>- 2022 оны 6 сараас орчны шинжилгээ хийх мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж, мэргэшүүлнэ</li> </ul>	ЗАА, Дархан сумын ЗДТГ, МХГ, УЦУОШГ
2	Мэдээллийн сан байгуулах, эхлүүлэх ажилд гарах хүндрэл	<ul style="list-style-type: none"> <li>- 2022 оны 1 сараас БОАЖГ-ын хог хаягдал хариуцсан мэргэжилтнийг түшиглэн мэдээллийн сангийн төв байгуулан ажлыг гүйцэтгэнэ</li> </ul>	ЗАА, Дархан сумын ЗДТГ, БОАЖГ, Их

## 2032 ОН ХҮРТЭЛ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛГО, СТРАТЕГИУД

		<ul style="list-style-type: none"> <li>- 2022 оы 1-2 сард хаягдал үүсгэгчдийн судалгааг гаргана</li> <li>- 2022 оноос 3-9 сард мэдээллийн бааз үүсгэх өгөгдлийг цуглуулна</li> <li>- 2022 оны 10-12 сард мэдээ, тайлан хүлээн авах, айл өрх, ААН, үйлдвэрүүдийн статистик мэдээллийг нэгтгэнэ</li> <li>- 2023 оны 1 сараас эхлэн хаягдал үүсгэгчдээс тайлан мэдээг ангиллын дагуу хүлээн авч хэвшинэ</li> </ul>	<p style="text-align: center;">дээд сургуулиуд, ААН, НААҮГ, Үйлдвэрүүд</p>
	Санхүү, хөрөнгө мөнгөний дутагдал түүнээс үүсэх эрсдэл	<ul style="list-style-type: none"> <li>- Хаягдал үүсгэгч бүрийн хогийн төлбөрт хяналт тавих, бүрэн хамруулах</li> <li>- Хогийн төлбөрийн үнэ, тарифыг шинэчлэнэ</li> <li>- Улс, орон нутгийн төсвөөс нэмэлт санхүүжилтийг гаргах, ОУ-ын төсөл хөтөлбөр, хандив тусламжийг нэмэгдүүлнэ</li> </ul>	<p style="text-align: center;">Дархан сумын ЗДТГ, НААҮГ</p>

## **2.6. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН**

### **Нийгэмд үзүүлэх үр өгөөж:**

- Иргэд, ААН, байгууллага хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвшсэнээр булшлах хогийн хэмжээ 30% хүртэл буурна.
- Хог хаягдлын менежментийн засаглал оновчтой болж талуудын эрх, үүрэг тодорхой болно.
- Хог хаягдлын үйлчилгээ үзүүлж буй ААНБ-ын үйлчилгээний чанар сайжирна.
- Төр, хувийн хэвшлийн түншлэл бэхжиж үйлчилгээний хүртээмж дээшилнэ.
- Иргэдийн аюулгүй цэвэр орчинд амьдрах нөхцөл бүрдэж амьдралын чанар дээшилнэ.

### **Байгаль орчинд үзүүлэх үр өгөөж:**

- Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилл бий болно.
- Хогийн шаталтаас үүсдэг диоксин, фуран зэрэг хортой бохирдуулагчийн хэмжээ буурна.
- Булшлах хогийн хэмжээ буурснаар хаягдлаас ялгарах хүлэмжийн хийн хэмжээг 20-30% бууруулна.
- Байгаль орчны хяналт, шинжилгээ, баталгаажуулалт сайжирснаар хог хаягдлаас үүсэлтэй хөрс, ус, агаарын бохирдол буурч байгаль орчинд нөлөөлөх байдал стандартын түвшинд хүрнэ.

### **Эдийн засагт үзүүлэх үр өгөөж:**

- Шинээр 67 ажлын байр бий болно.
- Орон нутгийн ДНБ нэмэгдэнэ. (Жилд 3.3 тэрбум)
- ЖДҮ-ийн үйл ажиллагаа сайжирч, үйлдвэрлэлийн хэмжээ тэлнэ.
- Старт-апууд хөгжиж хаягдалгүй эдийн засгийн суурь нөхцөл бүрдэнэ.
- Хог хаягдлын үйлчилгээний нийт зардлын 60%-ийг хувийн хэвшил хариуцах боломжтой болно.

### 3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

#### 3.1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮЕ ШАТ

Дархан сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь 2022-2032 хүртэл хэрэгжинэ.

Хүснэгт 21. Төлөвлөгөөний хэрэгжих үе шат

Үйл ажиллагааны төлөвлөгөө	Хэрэгжүүлэх үе шат			Хариуцах эзэн
	2022-2024	2025-2028	2029-2032	
<b>Зорилт 1. Иргэд, олон нийтэд ногоон хэрэглээний соёл, эх үүсвэр дээр бууруулах, хог хаягдлыг ангилан ялгах, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх</b>				
<i>Сургалтын ажил:</i>				
• Салбарын хүний нөөцийн чадавхжуулах сургалт				АЗДТГ, Захирагчийн ажлын алба, БОАЖГ, ХААИС-ийн АЭБС, ТББ
• Их, дээд мэргэжлийн сургуулиудын оюутнуудад зориулсан сургалт				БСУГ, БОАЖГ, Их дээд мэргэжлийн сургуулиудын консорциум, ХААИС-ийн АЭБС, ДаТИС
• ЕБС-ийн хүүхдүүдэд зориулсан сургалт				БСУГ, БОАЖГ, ХААИС-ийн АЭБС, ДаТИС
• СӨБ-ийн хүүхдүүдэд зориулсан сургалт				БСУГ, ХААИС, ШУТИС
• Багийн нийгмийн ажилтан, СӨХ, хэсгийн ахлагч нарыг чадавхжуулах сургалт				АЗДТГ, сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба, БОАЖГ, ХААИС-ийн АЭБС, ДаТИС, ТББ
• Иргэний нийгмийн байгууллагуудын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт				АЗДТГ, БОАЖГ, ХААИС-ийн АЭБС, ТББ
• ААНБ-ын хог хаягдлын мэргэжилтэнүүдийг чадавхжуулах				Аймгийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба, Аймгийн Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, ХААИС-ийн АЭБС, ДаТИС
• Дахивар цуглуулагч иргэдийг сургах				Захирагчийн ажлын алба, Сум, багийн нийгмийн ажилтан, ХААИС-ийн АЭБС
• Дахивар цуглуулагч иргэдийг коджуулж, хувцас жигдэлж, ажлын талбарууд хуваарилж				Захирагчийн ажлын алба, НААҮГ, Сумын ЗДТГ, багийн нийгмийн ажилтан



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

зохион байгуулалтанд оруулах				
<b>Нөлөөллийн ажил:</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Хуучин номын үзэсгэлэн худалдаа</li> </ul>				БСУГ , Номын сан, Хүүхдийн номын ордон, ХААИС-ийн АЭБС, ТББ,
<ul style="list-style-type: none"> <li>“Нэг хэрэглээний бүтээгдэхүүнээс татгалзъя” аян</li> </ul>				АЗДТГ, Захирагчийн ажлын алба, БОАЖГазар, ТББ-ууд
<ul style="list-style-type: none"> <li>“Zero waste-Тэг хаягдал” аян</li> </ul>				ЗАА, ТББ-ууд
<ul style="list-style-type: none"> <li>Дахивар нөөц ашиглаж хийсэн шилдэг бүтээгдэхүүний уралдаан, үзэсгэлэн</li> </ul>				Дархан хот Европийн Холбооны Бизнес Инновацийн Төв, АЗДТГ, Сум хөгжүүлэх сан
<ul style="list-style-type: none"> <li>Цахим контентүүд</li> </ul>				Аймгийн ЗДТГ, МТГ, Орон нутгийн телевиз, нийгэмд эерэг нөлөө үзүүлэгч /influencer/
<ul style="list-style-type: none"> <li>Гарааны компаниудыг дэмжих үйл ажиллагаанууд</li> </ul>				Дархан хот Европийн Холбооны Бизнес Инновацийн Төв, АЗДТГ, сумдын ЗДТГ, Худалдаа Аж Үйлдвэрийн танхим
<b>Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах сав байршуулах:</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Орон сууцны хороолол</li> </ul>				Захирагчийн ажлын алба, Сумын ЗДТГ, НААҮГ, СӨХ
<ul style="list-style-type: none"> <li>Гэр хороолол</li> </ul>				Сумын ЗДТГ, НААҮГ, багийн засаг дарга, ГӨХ, хэсгийн ахлагч
<ul style="list-style-type: none"> <li>ААНБ</li> </ul>				Сумын ЗДТГ, ААНБ
<ul style="list-style-type: none"> <li>Үйлдвэрүүд</li> </ul>				Сумын ЗДТГ, Үйлдвэрүүд
<b>Дахивар авах төвүүд байгуулах:</b>				
<ul style="list-style-type: none"> <li>АХБ-ний төслийн шугамаар байгуулагдах дахиварын 5 төвийг ажиллуулах ААН-тэй гэрээ байгуулах</li> </ul>				Захирагчийн ажлын алба, Сумын ЗДТГ
<ul style="list-style-type: none"> <li>Дахивар авах төвийг нэмэх (3)</li> </ul>				Сумын ЗДТГ, ААН
<b>Овор хэмжээ ихтэй хаягдал болон электрон хаягдал цуглуулах төв байгуулах:</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Байршлыг тодорхой болгох</li> </ul>				Аймгийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба, НААҮГ, ГХБХБГ

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

<ul style="list-style-type: none"> <li>Төвийн барилгыг барих, ашиглалтанд оруулах</li> </ul>				Аймгийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба НААҮГ
<ul style="list-style-type: none"> <li>Ажиллуулах ААН-тэй гэрээ байгуулах</li> </ul>				Аймгийн ЗДТГ, НААҮГ
<b>Хог тээвэрлэлтийн техник, хангамжийг сайжруулах:</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Цас цэвэрлэх машин авах</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, НААҮГ
<ul style="list-style-type: none"> <li>Бусад хог тээвэрлэх компактор машин авах</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, НААҮГ
<b>Зорилт 2. Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэнд оруулах, ногоон ажлын байр бий болгох, жижиг, дунд бизнесийг дэмжих, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх</b>				
<b>Сэргээн засварлах төвүүдийн үйл ажиллагаа бодлогоор дэмжих нэгдсэн менежменттэй болгох:</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Уулзалт форумууд зохион байгуулах</li> </ul>				Аймгийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба, Худалдаа Аж Үйлдвэрийн танхим
<ul style="list-style-type: none"> <li>Гэрээ байгуулах</li> </ul>				Аймаг сумын ЗДТГ, Аймгийн Худалдаа Аж Үйлдвэрийн танхим
<b>ЖДҮ-ийг хөгжүүлэх, бодлогоор дэмжих</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Дахивар нөөц ашиглах шилдэг технологийн уралдаан зохион байгуулах</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба , Дархан хот Европийн Холбооны Бизнес Инновацийн Төв
<ul style="list-style-type: none"> <li>Шалгарсан технологиудыг үйлдвэрлэгчдэд танилцуулах форум, семинарууд зохион байгуулах</li> </ul>				
<ul style="list-style-type: none"> <li>Технологи бий болгогч үйлдвэрүүдийг холбосон платформ хөгжүүлэх</li> </ul>				
<ul style="list-style-type: none"> <li>Шилдэг старт-апуудыг дэмжих, урамшуулах</li> </ul>				
<b>Хог тээвэрлэлтийн техник, хангамжийг сайжруулах:</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Хуванцар болон органик хаягдал тээвэрлэх машин авах</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Цаас, шил, лааз тээвэрлэх машин авах</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Барилгын хог тээвэрлэх машин авах</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, хувийн хэвшил

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

<ul style="list-style-type: none"> <li>Электрон болон овор хэмжээтэй хаягдал тээвэрлэх машин авах</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Аюултай болон эмнэлгийн хог хаягдал тээвэрлэх машин авах</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ
<b>Хуванцар боловсруулах үйлдвэр байгуулах:</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Байршлыг тодорхой болгож хашаа барих</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Бэлдэц үйлдвэрлэх</li> </ul>				Хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Хогийн уут үйлдвэрлэх</li> </ul>				Хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Бортого үйлдвэрлэх</li> </ul>				Хувийн хэвшил
<b>Органик хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах:</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Байршлыг тодорхой болгож хашаа барих</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба, хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Компост бордоо үйлдвэрлэх</li> </ul>				Хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Тэжээл үйлдвэрлэх</li> </ul>				Хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Саван үйлдвэрлэх</li> </ul>				Хувийн хэвшил
<b>Барилгын хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах:</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Байршлыг тодорхой болгож хашаа барих</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба, хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Үнс бэлтгэх</li> </ul>				Хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Хайрга, дайрга бэлтгэх</li> </ul>				Хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Бетон эдлэл үйлдвэрлэх</li> </ul>				Хувийн хэвшил
<ul style="list-style-type: none"> <li>Хуурай хольц үйлдвэрлэх</li> </ul>				Хувийн хэвшил
<b>Зорилт 3. Үйлдвэрлэлийн хог хаягдал болон аюултай хог хаягдлын менежментийг сайжруулж байгаль орчинд ээлтэй аргаар зайлуулах чадавхийг бий болгох</b>				
Аюултай хог хаягдал хариуцсан мэргэжилтэнтэй болох				Аймаг, сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба, БОАЖГ, ОБГ
Автомашинаас үүсэх аюултай хог хаягдлыг цуглуулдаг түүхий эд хүлээн авах цэгүүдийг стандартын шаардлагад нийцүүлэх, хяналт тавих				Аймаг, сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба, МХГ, ОБГ, хувийн хэвслүүд
Аюултай хаягдлыг түр хадгалах зориулалтын агуулах байгуулах				Аймаг, сумын ЗДТГ, МХГ, ОБГ, БОАЖГ
Ахуйн баттерей цуглуулах цэгүүдийг байршуулж, нэгдсэн				Аймаг, сумын ЗДТГ, МХГ, ОБГ

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

нэг цэгт төвлөрүүлж түр хадгалах				
Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаанд хяналт тавих				Аймаг, сумын ЗДТГ, МХГ, ОБГ, БОАЖГ
<b>Эмнэлгийн хог хаягдал устгах тоног төхөөрөмж авах:</b>				
• Төсөл бичих				ЭМГ
• Тендэр зарлах, шалгаруулах				ЭМГ
• Цех байгуулах				ЭМГ
• Хүний нөөцийг чадавхжуулах				ЭМГ, ХААИС, ШУТИС
• Үйл ажиллагааг эхлүүлэх				ЭМГ, МХГ, БОАЖГ, ОБГ, НААҮГ
<b>Зорилт 4. Булж зайлуулах хог хаягдлын хэмжээг бууруулах, хогийн төвлөрсөн цэгийн байгаль орчинд халгүйгээр тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, техник хангамжийг сайжруулах</b>				
<b>Бараат төвлөрсөн хогийн цэгийн нөөц талбайн ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх:</b>				
• Хашаа барих				Аймаг, сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба, НААҮГ
• Авто пүү байршуулах				Сумын ЗДТГ, НААҮГ
• Цахилгаан татах				Аймаг, сумын ЗДТГ, ДСЦТС
• Хяналтын худаг байгуулах				Аймаг, сумын ЗДТГ, БОАЖГ
• Ажилчдын байрны барилга, байгууламж барих				Аймаг, сумын ЗДТГ
• Аюултай хог хаягдлын байгууламж барих				Аймаг, сумын ЗДТГ, БОАЖГ, МХГ
• Зам тавих				Аймаг, сумын ЗДТГ, НААҮГ
• Гэрэлтүүлэг хийх				Аймаг, сумын ЗДТГ, НААҮГ, ДСЦТС
• Камержуулалт хийх				Аймаг, сумын ЗДТГ, НААҮГ
<b>Бараат хогийн цэгийн техник, хангамжийг сайжруулах:</b>				
• Бараат төвлөрсөн цэгт бульдозер авах				Аймаг, сумын ЗДТГ, НААҮГ
• Бараат төвлөрсөн цэгт эксковатор авах				Аймаг, сумын ЗДТГ, НААҮГ
• Бараат төвлөрсөн цэгт ковш авах				Аймаг, сумын ЗДТГ, НААҮГ

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

<b>Бараат төвлөрсөн хогийн цэгийн нөхөн сэргээлтийн ажил</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Хашаа барих</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба, НААҮГ
<ul style="list-style-type: none"> <li>Худаг гаргах</li> </ul>				Дархан хот Европийн Холбооны Бизнес Инновацийн Төв
<ul style="list-style-type: none"> <li>Нөхөн сэргээлтийн талбай 1 (12840 ш улиас, агч, чацаргана, хайлаас тарих)</li> </ul>				БОАЖГ, ААН, байгууллагууд
<ul style="list-style-type: none"> <li>Нөхөн сэргээлтийн талбай 2 (12840 ш улиас, агч, чацаргана, хайлаас тарих)</li> </ul>				БОАЖГ, ААН, байгууллагууд
<ul style="list-style-type: none"> <li>Нөхөн сэргээлтийн талбай 3 (12840 ш улиас, агч, чацаргана, хайлаас тарих)</li> </ul>				БОАЖГ, ААН, байгууллагууд
<b>Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфиллын ТЭЗҮ боловсруулах</b>				Аймаг, сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба, Мэргэжлийн зөвлөл
<b>Зорилт 5. Хог хаягдлын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгож хэрэгжилтийг сайжруулах, хяналт болон урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, борлуулагч болон үйлдвэрлэгч үйлдвэрлэлийн нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, дахин ашиглах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгох замаар урт хугацааны төлөвлөлт бүхий тогтвортой үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх</b>				
<b>Хог хаягдлын харилцааг зохицуулах журмыг мөрдүүлэх:</b>				Аймаг, сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба
<ul style="list-style-type: none"> <li>Үйлдвэр, ААН, хувийн хэвшилтэй байгуулах гэрээний төсөл боловсруулах</li> </ul>				Хууль эрх зүйн хэлтэс, ЗАА, сумын ЗДТГ
<ul style="list-style-type: none"> <li>Иргэд, олон нийт, нийгмийн институциудад таниулах, хүргэх зорилгоор сошиал маркетинг хийх мэдээллийн албатай гэрээ байгуулах</li> </ul>				ЗАА, БОАЖГ, Дархан сумын ЗДТГ
<ul style="list-style-type: none"> <li>Үйлдвэрүүдтэй журмын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх агуулга бүхий хамтран ажиллах гэрээ хийх</li> </ul>				Дархан сумын ЗДТГ
<ul style="list-style-type: none"> <li>ААНБ-тай журмын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх агуулга бүхий хамтран ажиллах гэрээ хийх</li> </ul>				Дархан сумын ЗДТГ
<ul style="list-style-type: none"> <li>Дархан сумд худалдаа үйлчилгээний үйл</li> </ul>				Дархан сумын ЗДТГ



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

ажиллагаа явуулж байгаа байгууллагуудтай (EPR) хамтран ажиллах гэрээ байгуулах				
<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдал татан тээвэрлэх хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажлын гэрээ байгуулах</li> </ul>				Дархан сумын ЗДТГ
<ul style="list-style-type: none"> <li>Дахин боловсруулах үйлдвэр байгуулах ААН-тэй концессийн гэрээ байгуулах</li> </ul>				АЗДТГ, Дархан сумын ЗДТГ
<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжлийн зөвлөл байгуулах</li> </ul>				Дархан-Уул аймгийн засаг дарга
<ul style="list-style-type: none"> <li>Иргэдийн хяналтын бүлэг байгуулах</li> </ul>				Багийн засаг дарга нар, СӨХ, ГӨХ, хэсгийн ахлагч нар
<ul style="list-style-type: none"> <li>Сайн оролцоотой иргэд, ААНБ-ыг шагнаж урамшуулах, сурталчлах</li> </ul>				Сумын засаг дарга
<ul style="list-style-type: none"> <li>Ухаалаг Дархан платформд суурилсан мэдээллийн урсгалыг бий болгох</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, ЗАА
<ul style="list-style-type: none"> <li>Журам зөрчсөн иргэн, ААНБ-тай хариуцлага тооцох, олон нийтэд мэдээлэх</li> </ul>				Аймаг, сумын засаг дарга, Мэргэжлийн хяналтын байцаагч нар
<b>Хяналтын төв байгуулах:</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Төвийн техник хэрэгсэл худалдан авах</li> </ul>				ЗАА, Сумын ЗДТГ, НААҮГ
<ul style="list-style-type: none"> <li>Зорилтот байршлуудад камер, гэрэлтүүлэг байрлуулах</li> </ul>				Сумын ЗДТГ, НААҮГ
<b>Хог хаягдлын үнэ, тарифыг оновчтой тогтоох</b>				
<ul style="list-style-type: none"> <li>Хогийн уут захиалгаар хийлгүүлэх</li> </ul>				ЗАА, Сумын ЗДТГ
<ul style="list-style-type: none"> <li>Зорилтот баг хорооллуудад туршиж эхлэх</li> </ul>				ЗАА, Сумын ЗДТГ, НААҮГ
<ul style="list-style-type: none"> <li>Хогийн уутаа үйлдвэрлэж эхлэх</li> </ul>				Сумын ЗДТГ, хувийн хэвшил
<b>Зорилт 6. Хог хаягдал, хорт бодисын ялгарлаас үүдэлтэй орчны бохирдлыг хянах хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, судалгаа шинжилгээний лабораторийн чадавхийг бэхжүүлэх, хог хаягдлын нарийвчилсан тоо бүртгэл, судалгаа хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх замаар хүрээлэн буй орчны чанарын бодит мэдээллээр хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах</b>				
Хог хаягдлын мэдээллийн сан байгуулах:				Аймаг, сумын ЗДТГ, ЗАА, НААҮГ
<ul style="list-style-type: none"> <li>Платформ хөгжүүлэлт</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, ЗАА

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

<ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрүүдийн энгийн болон аюултай хог хаягдлын хэмжээ, төрлийг тогтоох</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, Мэргэжлийн зөвлөл, Их дээд сургуулиуд
<ul style="list-style-type: none"> <li>• Тусгай объект бүхий ААНБ-ын энгийн болон аюултай хог хаягдлын хэмжээ, төрлийг тогтоох</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, Мэргэжлийн зөвлөл, Их дээд сургуулиуд
<ul style="list-style-type: none"> <li>• Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ын энгийн болон аюултай хог хаягдлын хэмжээ, төрлийг тогтоох</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, Мэргэжлийн зөвлөл, Их дээд сургуулиуд
<ul style="list-style-type: none"> <li>• Орон сууцны хорооллын байрнуудын зоорийн болон 1 давхаруудад үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ын энгийн болон аюултай хог хаягдлын хэмжээ, төрлийг тогтоох</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, Мэргэжлийн зөвлөл, Их дээд сургуулиуд
<ul style="list-style-type: none"> <li>• Орон сууцны айл өрхүүдийн хатуу болон органик хог хаягдлын хэмжээ, төрлийг тогтоох</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, Мэргэжлийн зөвлөл, Их дээд сургуулиуд
<ul style="list-style-type: none"> <li>• Гэр хорооллын айл өрхүүдийн хатуу болон органик хог хаягдлын хэмжээ, төрлийг тогтоох</li> </ul>				Аймаг, сумын ЗДТГ, Мэргэжлийн зөвлөл, Их дээд сургуулиуд
Хогийн цэг орчмын мониторинг судалгааг хийх:				
<ul style="list-style-type: none"> <li>• Төсөл бичих</li> </ul>				АЗДТГ, Захирагчийн ажлын алба, НААҮГ, УЦУОШГ, ХААИС
<ul style="list-style-type: none"> <li>• Тендэр зарлах, шалгаруулах</li> </ul>				УЦУОШГ
<ul style="list-style-type: none"> <li>• Орчны шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах</li> </ul>				УЦУОШГ
<ul style="list-style-type: none"> <li>• Хүний нөөцийг чадавхжуулах</li> </ul>				УЦУОШГ, ХААИС
<ul style="list-style-type: none"> <li>• LCD дэлгэц байршуулах</li> </ul>				УЦУОШГ
<ul style="list-style-type: none"> <li>• Орчны хяналт, шинжилгээг эхлүүлэх</li> </ul>				УЦУОШГ

## 3.2. ИРГЭД, ОЛОН НИЙТЭД НОГООН ХЭРЭГЛЭЭНИЙ СОЁЛ, ЭХ ҮҮСВЭР ДЭЭР БУУРУУЛАХ, ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАН ЯЛГАХ, АМЬДРАХ ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВ ДАДЛЫГ ТӨЛӨШҮҮЛЭХ ЗОРИЛТЫГ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛЫН АГУУЛГА, АРГАЧЛАЛ

### 3.2.1. Хог хаягдлын талаарх иргэд, олон нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулах

#### 3.2.1.1. Сургалт нөлөөллийн ажил

Дархан сумын хог хаягдлын менежментийн суурь стратеги нь иргэд, олон нийтэд ногоон хэрэглээний соёл, хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах, зөв дадлыг төлөвшүүлэх бөгөөд үүнд түшиглэн иргэдийн оролцоотой хяналтын тогтолцоог бий болгох, хууль бус хог хаягдлын хэмжээг бууруулахад чиглэгдэх юм.



Зураг 51. Сургалт нөлөөллийн ажлын нэгдсэн төлөвлөгөө

Уг төлөвлөгөөний хүрээнд иргэдийг насны бүлгээр болон бусад чиглэлээр зорилтот бүлгүүдэд хувааж сургалт, нөлөөллийн ажлууд үе шаттайгаар зохион байгуулагдана (Хавсралт 8).

Мөн хог хаягдлын чиглэлээр шинэ санаачлага гаргаж ажиллаж байгаа хувь хүн, албан байгууллагуудыг сурталчилах, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлууд багтаж байна.

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 22. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах, дахин боловсруулах стратегийн хүрээнд иргэд, олон нийтэд зохион байгуулагдах сургалт, нөлөөллийн ажлын төлөвлөгөө

	Зохион байгуулагдах үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Хамрагдах иргэдийн тоо			Үйл ажиллагааны давтамж	Зохион байгуулагч, гүйцэтгэгч
			2022-2024	2025-2028	2029-2032		
<b>I. Иргэд, олон нийтэд чиглэсэн сургалтын ажлын төвөвлөгөө</b>							
<b>1.1 Иргэд, олон нийтэд чиглэсэн сургалт</b>							
1	Бага насны хүүхдүүдэд зориулан хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах дадал хэвшил төлөвшүүлэх сургалт	41 цэцэрлэгийн хүүхэд багачууд	1 жилд 8000 Нийт 32000	1 жилд 8000 Нийт 32000	1 жилд 8000 Нийт 32000	Нийт 44 /жилд 4, улиралд тутамд 1 сургалт/	БСУГ, ХААИС-ийн АЭБС, ДаТИС, ТББ
2	ЕБС-ийн сурагчдад зориулсан хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах дадал хэвшил төлөвшүүлэх сургалт	26 ЕБС-ийн сурагчид	1 жилд 23000 Нийт 92000	1 жилд 23000 Нийт 92000	1 жилд 23000 Нийт 92000	Нийт 44 /жилд 4, улиралд тутамд 1 сургалт/	ХААИС-ийн АЭБС, ДаТИС, ТББ
3	Их, дээд, мэргэжлийн сургуулиудын оюутнуудад зориулсан хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах дадал хэвшил төлөвшүүлэх сургалт	Их, дээд, мэргэжлийн сургуульд суралцагч оюутнууд	1 жилд 6500 Нийт 26000	1 жилд 6500 Нийт 26000	1 жилд 6500 Нийт 26000	Нийт 44 /жилд 4, улиралд тутамд 1 сургалт/	БСУГ, Их дээд мэргэжлийн сургуулиудын консорциум, ХААИС-ийн АЭБС, ДаТИС
<b>1.2 Төр болон хог хаягдлын мэргэжлийн байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт</b>							
4	“Zero-waste- Тэг хаягдал” болон Хаягдалгүй эдийн засаг- хог хаягдлын тогтвортой менежментийн системийг бүрдүүлэх нь	Холбогдох төрийн байгууллагын мэргэжилтнүүд, НААҮГ, СӨХ-ийн ажилтан, ажилчид,	1 жилд 300 Нийт 900	1 жилд 300 Нийт 1200	1 жилд 300 Нийт 1200	Нийт 22 /жилд 2, 6 сар тутамд 1 сургалт/	АЗДТГ, БОАЖГ, ХААИС-ийн АЭБС, ТББ
5	ДУ аймгийн Хог хаягдлын менежментийн засаглалыг бэхжүүлэх нь	багийн нийгмийн ажилтан, албан хаагчид	1 жилд 500 Нийт 1500	1 жилд 500 Нийт 1500	1 жилд 500 Нийт 1500	Нийт 22 /жилд 2, 6 сар тутамд 1 сургалт/	АЗДТГ, БОАЖГ, ХААИС-ийн АЭБС, ТББ
<b>1.3 ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын мэргэжилтнүүдэд зориулсан сургалт</b>							
6	Байгууллага, аж ахуйн нэгжийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах, дахивар	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч ААНэгж байгууллагын	1 жилд 500 Нийт 1500	1 жилд 500 Нийт 1500	1 жилд 500 Нийт 1500	10 удаагийн сургалт	ЗАА, ХААИС-ийн АЭБС, ДаТИС

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

	нөөцийг тушаах, дадал хэвшил төлөвшүүлэх сургалт	ажилтан мэргэжилтэн, удирдлагууд / Гугал, хувцас засвар, цахилгаан хэрэгсэл, буйдан засварын төвүүд				/ жилд 1 удаа/	
7	“Zero-waste- Тэг хаягдал” болон Хаягдалгүй эдийн засаг- хог хаягдлын тогтвортой менежментийн системийг бүрдүүлэх сургалт	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч ААНэгж байгууллагын ажилтан мэргэжилтэн, удирдлагууд / Гугал, хувцас засвар, цахилгаан хэрэгсэл, буйдан засварын төвүүд	1 жилд 500 Нийт 1500	1 жилд 500 Нийт 1500	1 жилд 500 Нийт 1500	10 удаагийн сургалт / жилд 1 удаа/	АЗДТГ, ХААИС-ийн АЭБС, ДаТИС, ТББ
8	Үйлдвэр, аж ахуйн нэгжийн захиалгаар инженер, техникийн ажилтнуудыг гадаад, дотоодын байгууллагуудад урт, богино хугацааны туршлага судлах сургалтанд хамруулах	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч ААНэгж байгууллагын мэргэжилтнүүд	Жилд 10 Нийт 30	Жилд 10 Нийт 40	Жилд 10 Нийт 40	10 удаагийн туршлага судлах хөтөлбөр / дотоодод болон гадаад улс оронд/	АЗДТГ, Дархан хот Европийн Холбооны Бизнес Инновацийн Төв
<b>1.4 Дахивар нөөц авагч болон хог түүгч иргэдэд зориулсан сургалт</b>							
9	Дахивар нөөц худалдан авагч иргэдэд зориулсан Хог хаягдлыг кодны дагуу ангилан ялгах сургалт		1 Жилд 12 Нийт 36	1 Жилд 12 Нийт 48	1 Жилд 12 Нийт 48	Нийт 22 /жилд 2 удаа, 6 сар тутамд 1 сургалт/	Сумын ЗДТГ, ХААИС-ийн АЭБС
10	Хог түүгч иргэдэд зориулсан Хог хаягдлыг кодны дагуу ангилан ялгах сургалт		1 Жилд 25 Нийт 75	1 Жилд 25 Нийт 100	1 Жилд 25 Нийт 100	Нийт 22 /жилд 2 удаа, 6 сар тутамд 1 сургалт/	Сум, багын нийгмийн ажилтан, НААҮГ, ХААИС-ийн АЭБС
<b>II. Иргэд олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлын төлөвлөгөө</b>							
1	"Нэг хэрэглээний бүтээгдэхүүнээс татгалзъя" аян	иргэд, олон нийт	2	4	4	10 удаагийн аян /жилд 1 /	БОАЖГ, ТББ
2	"Zero waste- Тэг хаягдал" аян	иргэд, олон нийт	2	4	4	10 удаагийн аян /жилд 1 /	БОАЖГ, ТББ



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

3	Хуучин номын үзэсгэлэн, худалдаа	Иргэд, олон нийт	1 жилд 200 Нийт 800	1 жилд 200 Нийт 800	1 жилд 200 Нийт 800	Нийт 10 удаагийн үзэсгэлэн	Аймгийн төв номын сан, БСУГ, ХААИС-ийн АЭБС, ТББ
4	Хаягдлаар бүтээгдэхүүн хийх бүтээлч санаачлагыг дэмжсэн уралдаан, дахивар нөөц ашиглаж хийсэн шилдэг бүтээгдэхүүний үзэсгэлэн	Цэцэрлэгийн хүүхэд багачууд, ЕБС-ийн сурагчид, Их дээд мэргэжлийн сургуулийн оюутнууд, Иргэн, ААН	1 жилд 200 Нийт 800	1 жилд 200 Нийт 800	1 жилд 200 Нийт 800	Нийт 10 Жилд 1 удаагийн уралдаан, үзэсгэлэн	ЗАА, Дархан сумын ЗДТГ, Дархан хот Европийн Холбооны Бизнес Инновацийн Төв, БСУГ
5	Гарын доорх хаягдал материал, түүхий эдийг ашиглан бүтээгдэхүүн хийх сургалт /цахим контент/ Жнь: 1. Хаягдал цаасаар бүтээгдэхүүн хийх, 2. Хоол, хүнсний үлдэгдэл, органик хог хаягдлаар гэрийн нөхцөлд био бордоо хийх	Иргэд, олон нийт	4	8	8	Нийт 20 контент Жилд 2 контент хийх	ЗАА, Орон нутгийн телевиз, социал маркетингийн алба
6	Орон нутагт хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, сэргээж ашиглан бүтээгдэхүүн хийж байгаа сайн туршлагыг түгээх нэвтрүүлэг /иргэн, гэр бүл, аж ахуйн нэгжийг сурталчилах/ / цахим контент/	Иргэд, олон нийт	2	4	4	10 Нэвтрүүлэг бэлтгэх Жилд 1 нэвтрүүлэг бэлтгэх	ЗАА, Орон нутгийн телевиз, социал маркетингийн алба
7	9R буюу 9Дахин зарчмыг олон нийтэд ойлгуулах, төлөвшүүлэх цахим контент	Иргэд, олон нийт	4	8	8	Нийт 20 контент Жилд 2 контент хийх	ЗАА, Орон нутгийн телевиз, социал маркетингийн алба
8	Хог хаягдлыг дахин боловсруулах, инновацийн санал, санаачлагыг дэмжсэн төсөлт уралдаан зохион байгуулах / Start-up/ бизнесийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн	Иргэд, ААН	2	4	4	10 удаагийн уралдаан /жилд 1 удаа/	БОАЖГ, ТББ

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

## Хүснэгт 23. Иргэд олон нийгэд зориулагдсан нөлөөллийн ажлын төсөв

	Зохион байгуулагдах үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Оролцогчийн тоо	Үйл ажиллагааны давтамж	Сургалтын хэлбэр	Зохион байгуулагч, гүйцэтгэгч	Төсөв
<b>1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах, дахин боловсруулах стратегийн хүрээнд зохион байгуулагдах сургалт, нөлөөллийн ажил</b>							
1	Бага насны хүүхдүүдэд зориулан хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах дадал хэвшил төлөвшүүлэх сургалт	41 цэцэрлэгийн хүүхэд багачууд	8324	2	танхим	БСУГ, Дархан ХААИС	9,500,000
2	ЕБС-ийн сурагчдад зориулсан хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах дадал хэвшил төлөвшүүлэх сургалт	26 ЕБС-ийн сурагчид	22721	2	танхим	БСУГ, Дархан ХААИС	25,500,000
3	Их, дээд, мэргэжлийн сургуулиудын оюутнуудад зориулсан хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах дадал хэвшил төлөвшүүлэх сургалт	Дархан-Уул аймгийн их, дээд, мэргэжлийн сургуульд суралцагч оюутнууд	6315	2	танхим, зайн сургалт	БСУГ, Их дээд мэргэжлийн сургуулиудын консорциум, Дархан ХААИС	17,500,000
4	Хуучин номын үзэсгэлэн, худалдаа	иргэд, олон нийт		жилд 1 удаа		Аймгийн төв номын сан, БСУГ, ХААИС ТББ	2,000,000
5	Хаягдлаар бүтээгдэхүүн хийх бүтээлч санаачлагыг дэмжсэн уралдаан	цэцэрлэг, ЕБС, Их дээд мэргэжлийн сургуулийн оюутнууд, Иргэн, ААН		жилд 1 удаа		Дархан хот ЕХолбооны бизнес инновацийн төв, БСУГ, ТББ	2,300,000
6	Гарын доорх хаягдал материал, түүхий эдийг ашиглан бүтээгдэхүүн хийх сургалт	иргэд, олон нийт		6 дугаар	цуврал видео контент	Аймгийн ЗДТГ, Орон нутгийн телсвиз	3,000,000
7	Орон нутагт хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, сэргээж ашиглан бүтээгдэхүүн хийж байгаа сайн туршлагыг түгээх нэвтрүүлэг /иргэн, гэр бүл, аж ахуйн нэгжийг сурталчилах/	иргэд, олон нийт		3 дугаар	цуврал видео нэвтрүүлэг	Аймгийн ЗДТГ, Орон нутгийн телевиз	1,500,000
8	9R буюу 9Дахин зарчмыг олон нийтэд ойлгуулах, төлөвшүүлэх цахим контент	иргэд, олон нийт		12 дугаар	цуврал видео контент	Аймгийн ЗДТГ, Орон нутгийн телевиз	10,000,000
9	"Нэг хэрэглээний бүтээгдэхүүнээс татгалзай" аян	иргэд, олон нийт		жилд 1 удаа		БОАЖГ, ТББ	3,000,000
10	"Zero waste- Тэг хаягдал" аян	иргэд, олон нийт		жилд 1 удаа		БОАЖГ, ТББ	3,000,000
11	Хог хаягдлыг дахин боловсруулах, инновацийн санал, санаачлагыг дэмжсэн уралдаан зохион байгуулах	Иргэд, ААН		жилд 1 удаа		Дархан хот ЕХолбооны бизнес инновацийн төв, БОАЖГ, ТББ	7,500,000
12	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, бууруулах чиглэлээр сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	НААҮГ, СӨХ-ийн ажилтан, ажилчид, багын нийгмийн ажилтан, хувийн хэвшлийн төлөөлөл, дахивар цуглуулагч иргэд	200	12	Танхим болон ажлын байран дээр	БОАЖГ, ИДМСК, ТББ	7,200,000
13	Үйлдвэр, аж ахуйн нэгжийн захиалгаар инженер, техникийн ажилтнуудыг гадаад, дотоодын байгууллагуудад урт, богино хугацааны туршлага судлах сургалтанд хамруулах		50		Танхим болон зайн сургалт	Аймгийн ЗДТГ, Аймгийн Худалдаа Аж Үйлдвэрийн танхим	10,000,000
<b>НИЙТ</b>							<b>102,000,000</b>

## 3.2.1.2. Салбарын хүний нөөцийг чадавхжуулах бодлого, төлөвлөлт

НААҮГ-ын хүний нөөцийг чадавхжуулахын тулд тасралтгүй сургалт, хөгжлийн төлөвлөгөө шаардлагатай байгаа тул сургалт, хөгжлийн хөтөлбөрийн загварыг санал болгож байна.



Зураг 52. Сургалтын хэлбэр

### “НААҮГ” ын шинэ ажиллагчдад зориулсан чиглүүлэх сургалтын хөтөлбөр

Сургалтын зорилго:

Шинээр ажилд орж буй ажиллагчдад компани, салбар нэгж болон ажлын байрны талаар бодитой үнэн зөв мэдээллийг өгөх замаар тэднийг ажилд мэргэжилд нь зөв чиглүүлэх.

Сургалт явуулах байршил: “НААҮГ” оффис

Сургалтын үргэлжлэх хугацаа: Танхимд 2 цаг, Ажлын байранд 1 сар хүртэл

Сургалтыг зохион байгуулагч: Хүний нөөцийн менежер

Сургалт явуулах албан тушаалтан: Хүний нөөцийн менежер, хэлтсийн дарга нар

Сургалтад хэрэглэх техник, хэрэгсэл: LCD projector, PC эсвэл laptop, ОНТ, TV

Сургалтын агуулга: Компанийн товч танилцуулга, дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажлын байранд хийгдэх үндсэн ажил үүргүүд

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

### Хүснэгт 24. Чиглүүлэх сургалт

№	Сэдэв, түүний агуулга	Үргэлжлэх хугацаа	Сургалт явуулах хүний албан тушаал	Сургалтын арга	Сургалтад хэрэглэх техник хэрэгсэл
1	Компанийн товч танилцуулга: түүхэн хөгжил, эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл, нэр хүнд, удирдлагын нэр, ажлын утас, бүтэц зохион байгуулалтын схем, дотоод журмаас	30 минут	Хүний нөөцийн менежер	Танилцуулах лекц, ярилцлага, гарын авлага тараах, Видео ба аудио хичээл	LCD projector, PC, TV бусад
2	Хөдөлмөрийн тухай хууль:	20 минут	Хүний нөөцийн менежер эсвэл хуулийн зөвлөх	Тайлбарлан ярих, жишээ татах, асуултад хариулах	LCD projector, PC
3	Ажлын байрны тодорхойлолт: үндсэн хийх ажил үүрэг, хариуцлага	20 минут	Хэлтсийн дарга нар, инженер		LCD projector, PC, ОНТ
4	Технологийн дараалал, стандарт. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, түүний зааварчилгаа	30 минут	Инженер	Лекц, жишээ, асуултад хариулах	LCD projector, PC, ОНТ


Ажиллах хүчинтэй холбоотой зардалд нийт ажиллагчдын цалин, байгууллагаас төлөх НДШ, ХАБЭА-н зардал, сургалтын зардлыг оруулж тооцов. Ажиллагчдын цалин хөлсийг инфляцитай уялдуулан нэмэгдүүлэхээр, ХАБЭА-н зардлыг байгууллагын нийт төсвийн 0.5 хувийг эзлэхээр тооцоололыг хийв. Мөн хүний нөөцийн сургалт, хөгжлийн зардлыг жилд 20.0-25.0 сая төгрөг байхаар тооцов.

### Хүснэгт 25. Ажиллах хүчинтэй холбоотой гарах зардал

	2022-2024	2025-2028	2029-2032
Цалин	5,606,683,299	8,970,693,278	9,718,251,052
НДШ	700,835,412	1,166,190,126	1,263,372,637
ХАБЭА-ны зардал /0.5/	118,680,160	275,352,428	314,688,490
Сургалтын зардал	20,000,000	80,000,000	100,000,000
Шагнал, урамшууллын зардал	6,763,509	28,000,000	40,000,000
<b>Нийт зардал</b>	<b>6,446,198,871</b>	<b>10,492,235,833</b>	<b>11,396,312,178</b>

## 3.2.2. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тогтолцоог нэвтрүүлэх

Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр дахивар нөөцийн 5 цэг байгуулагдахаар болсон нь хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах тогтолцоог бий болгох эхлэлийн ажил болж байна. Эдгээр дахин боловсруулах хог хаягдлыг хүлээн авах цэгүүдийг Дархан сумын худалдаа үйлчилгээний томоохон газрууд болон суурьшлын бүсүүдэд байрлуулахаар төлөвлөсөн.



Зураг 53. Дахивар авах цэгүүдийн байршил



# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ




Зураг 54. АХБ-ны төслийн санхүүжилтээр хийгдэх дахивар нөөцийн цэгийн төсөл

Дээрх төслийн хүрээнд 20 тоннын багтаамжтай шинэчлэн өөрчилсөн төмөр чингэлгийг дахивар нөөцийг хүлээн авах болон түр хадгалах гэсэн хоёр зорилгоор ашиглах бөгөөд өвлийн улиралд үйл ажиллагааг нь хэвийн явуулах үүднээс чингэлэгт хүйтнээс хамгаалсан дулаалгыг хийнэ.

Тус цэгүүдэд цаас, картон, PET, HDPE, LDPE болон PVC хуванцарууд, шилэн сав, хөнгөн цагаан, металл лааз зэргийг хүлээн авах юм. Тус дахивар нөөцийн цэгүүдийг байгуулснаар айл өрх, олон нийт болон бизнесийн байгууллагуудаас дахивар нөөцийг худалдан авах, хатуу хог хаягдал дахин боловсруулах, ашиглах талаар олон нийтэд сурталчлах компани ажлыг зохион байгуулах цэг болгох цаашлаад хог хаягдлын дахин боловсруулалтыг хянах, бүртгэх хэрэгсэл болох боломжтойгоороо орон нутагт эерэг өөрчлөлтүүдийг авчрах юм.

Уг дахивар авах цэгүүд нь цахилгаанд холбогдсон, халаалтын төхөөрөмжтэй, сайжруулсан нүхэн жорлонтой байхаар төлөвлөгдсөн. Төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд иргэдтэй фокус группын ярилцлага хийхэд хамрагдсан иргэдийн нэлээдгүй хувь нь цаг зав хомс байдлаас шалтгаалан дахивар авах цэгт аваачиж өгөхөөс байрны гадаа ангилдаг хогийн савтай байхыг илүүд үзэж байна гэж хариулж байсан. Иймд дахиварын төвийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.



Зураг 55. Дахивар авах цэг нэмж байрлуулах шаардлагатай байршлууд

Дээрх дахивар авах цэгүүдэд дахин боловсруулагдах боломжтой дараах хаягдлуудыг төвлөрүүлэх боломжтой. Үүнд:

- Бүх төрлийн цаасны хаягдал
- Бүх төрлийн шил, лааз зэрэг дахивар нөөц
- Бүх төрлийн хуванцар хаягдал, гялгар уут зэрэг дахивар нөөц

Дахивар авах цэгүүдэд иргэн, ААН өөрсдөө тээвэрлэн хүргэж өгөхөд орон нутагт мөрдөх хог хаягдлын талаарх харилцааг зохицуулах журмын дагуу урамшуулал олгох бөгөөд дахивар нөөцийн жишиг доод үнэлгээг тогтоож өгнө.

## Эх үүсвэр дээр ангилан ялгах стандарт:

### Өнгөний код

**Хар өнгө** - дахин ашиглах боломжгүй ахуйн хатуу хаягдлыг;

**Цэнхэр өнгө** - бүх төрлийн цаасны хаягдлыг;

**Улбар шар өнгө** – бүх төрлийн шил, лааз зэрэг дахивар нөөцийг;

**Ногоон өнгө** – бүх төрлийн хуванцар хаягдал, гялгар уут зэрэг дахивар нөөцийг;

**Бор өнгө**- бүр төрлийн органик хаягдлыг;

**Шар өнгө** – Эмнэлгийн болон аюултай хог хаягдал




Зураг 56. Хог хаягдлын өнгөний код

Органик хаягдал буюу хүнсний хаягдалд яс, хоолны үлдэгдэл, хүнсний ногооны хаягдал, хэрэглэсэн хүнсний тос зэрэг орно.

МУ-ын хог хаягдлын тухай хуулийн 4.1.5-т “овор хэмжээ ихтэй хог хаягдал” гэж 0.75 куб метрээс дээш эзлэхүүнтэй хог хаягдлыг хэлнэ хэмээн тусгасан байдаг.

Овор хэмжээ ихтэй хог хаягдалд:

- Гэр ахуйн цахилгаан бараа /хөргөгч, угаалгын машин, плитка, аяга таваг угаагч машин болон бусад овор ихтэй цахилгаан хэрэгсэл/
- Хивс, дроз
- Тавилга /буйдан, сандал, ширээ, хувцасны шүүгээ, ор гм/
- Зурагт /телевизор
- Матрас зэргийг хамруулан үзэх бөгөөд “Овор ихтэй хаягдлыг цуглуулах цэгт” дээрх нэр бүхий хог хаягдлыг төвлөрүүлнэ.



Зураг 57. Овор хэмжээ ихтэй хог хаягдлын менежментийн тогтолцоо

Овор хэмжээ ихтэй хог хаягдлыг төвлөрүүлэн цуглуулахад:

1. Овор хэмжээ ихтэй хог хаягдлыг цуглуулах 1 цэг байгуулах. /Хуучин болон Шинэ Дарханы дунд/
2. Дархан-Уул аймгийн хэмжээнд гарч буй овор хэмжээ ихтэй хог хаягдлын нэр төрлийг тодорхойлон, овор хэмжээ ихтэй хог хаягдлын жагсаалтыг гаргах
3. Овор хэмжээ ихтэй хог хаягдлыг тээвэрлэхтэй холбоотой үнэ тарифыг тусгайлан журам батлан гаргаж эрхзүйн орчныг бүрдүүлэх
4. Овор хэмжээ ихтэй хог хаягдлыг цуглуулах төвд ажиллах хүний нөөц, техник хангамжийн асуудлыг шийдвэрлэх
5. Хувийн хэвшлийг татан оролцуулах, засварын цэгүүд өөрөө татан авалтаа хийхэд бодлогын дэмжлэг үзүүлэх



Зураг 58. Овор хэмжээ ихтэй хаягдал нөөцийн цэг

Зурагт үзүүлсний дагуу овор ихтэй хаягдал нөөцийг төвлөрүүлэх цэгт 7 ажилтан /Зохион байгуулагч-1, Ачигч-2, жолооч-2, эд анги салгаж, угсрагч-2/ ажиллана. Энэхүү төв нь Дархан-Уул аймгийн НААҮГ-ын харьяа үйл ажиллагаагаа явуулна.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 26. Овор хэмжээ ихтэй хог хаягдлыг цуглуулах төвийн ажлын хуваарь

















<b>Даваа:</b>	Амарна.
<b>Мягмар:</b>	Овор ихтэй хог хаягдлыг зөөвөрлөх дуудлага хүлээн авах, баталгаажуулах, Цугларсан овор ихтэй хаягдал нөөцийг ангилах, салгах, угсрах,
<b>Лхагва:</b>	Овор ихтэй хог хаягдлыг зөөвөрлөх дуудлага хүлээн авах, баталгаажуулах, Цугларсан овор ихтэй хаягдал нөөцийг ангилах, салгах, угсрах Шаардлагатай тохиолдолд төвлөрсөн хогийн цэгрүү зөөвөрлөх
<b>Пүрэв гариг:</b>	Овор ихтэй хог хаягдлыг зөөвөрлөх дуудлага хүлээн авах, баталгаажуулах, Шинэ Дарханы багуудын айл өрхөөс ирсэн захиалгын дагуу овор ихтэй хог хаягдлыг зөөвөрлөх.
<b>Баасан гариг</b>	Овор ихтэй хог хаягдлыг зөөвөрлөх дуудлага хүлээн авах, баталгаажуулах, Цугларсан овор ихтэй хаягдал нөөцийг ангилах, салгах, угсрах
<b>Бямба:</b>	Овор ихтэй хог хаягдлыг зөөвөрлөх дуудлага хүлээн авах, баталгаажуулах, Хуучин Дарханы багуудын айл өрхөөс ирсэн захиалгын дагуу овор ихтэй хог хаягдлыг зөөвөрлөх.
<b>Ням:</b>	Амарна.

Овор ихтэй хаягдал нөөцийг айл өрхөөс татан зөөвөрлөхөд иргэд, албан байгууллагад дараах тарифаар үйлчилгээ үзүүлнэ. Доор тогтоосон үнийн тариф нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болох бөгөөд эд ангийг нь салгаж угсрах ажиллагаа шаардсан овор ихтэй хаягдал нөөцийн үнэлгээг арай өндөр үнээр тооцож тогтоосон болно.



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 27. Овор хэмжээ ихтэй хог хаягдлыг төвлөрүүлэх цэгт зөөвөрлөх үйлчилгээний үнэ, тариф

Ерөнхий зураг		Эд хогшлын нэр	Үнийн тариф	Хэмжих нэгж
<b>Гэр ахуйн тавилга, эд хогшил</b>				
		Түшлэгтэй зөөлөвчтэй сандал	3000	1-4ш 1 багц
		Түшлэгтэй зөөлөвчтэй сандал	6000	5-8ш 2 багц
		Түшлэгтэй энгийн сандал	2000	1-4ш 1 багц
		Түшлэгтэй энгийн сандал	4000	5-8ш 2 багц
		Түшлэггүй сандал	1500	1-4ш 1 багц
		Түшлэггүй сандал	3000	5-8ш 2 багц
		Орны дэргэдэх болон булангийн жижиг шүүгээ	1000	1 ш
		Урт сандал	2000	1 ш
		Гал тогооны болон бусад төрлийн угсармал шүүгээнүүд	6000	1м3
		Хивс, дрож	8000	1м3
		Булангийн болон ханын шүүгээ	6000	1м3

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Бүх төрлийн ширээ	6000	1м3
		Бүх төрлийн буйдан	8000	1м3
		Ханын болон номын тавиур	6000	1м3
		Ор / матрастай/	10000	1м3
		Ор /матрасгүй/	6000	1м3
		Матрас	8000	1м3
		Бүх төрлийн хувцасны шүүгээ	8000	1м3
		Хөнжил, гудас, хөшиг, ширээний бүтээлэг, хуучин хувцас, гутал	800	1 кг
<b>Гэр ахуйн цахилгаан бараа</b>				
		Лед телевизор 32-43 инч	2000	1 ш
		Лед телевизор 50-60 инч	3000	1 ш
		Лед телевизор 65-75 инч	4000	1 ш
		Лед телевизор 80-с дээш инч	6000	1 ш
		Суурин компьютер /иж бүрэн/	4000	1 ш

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Хөргөгч	10000	1м3
		Хөргүүр болон Хөлдөөгч	10000	1м3
		Халаагч /тень/	4000	1ш
		Бүх төрлийн плитка	10000	1м3
		Бүх төрлийн угаалгын машин	10000	1м3
		Бичил долгионы халаагч зуух	4000	1ш


### 3.2.2.1. Орон сууцны айл өрхүүдийн хог хаягдлыг татан зайлуулах тогтолцоо

Дархан сумын өрхийн тоонд харьцуулсан хог хаягдлын нөөцийг /тн жилээр/ гэр хороолол, орон сууц, хаус гэх мэтээр ангилан 2022-2050 он хүртэл тооцоолоход 2022-2030 он хүртэл хог хаягдлын нөөц 2020 оноос 1% -ийн өсөлттэй, 2022-2030 он хүртэл өмнөх жилүүдээс 0.9 % -ийн өсөлттэй, 2031-2040 он хүртэл өмнөх жилүүдээс 0.9 % -ийн өсөлттэй, 2041-2050 он хүртэл өмнөх жилүүдээс 0.8 % -ийн өсөлттэй байна гэж харагдаж байна.

Хүн ам, нийгэм, эдийн засгийн өсөлтийг даган зогсолтгүй өсөх хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулахаас гадна ангилан ялгаж эдийн засгийн эргэлтэнд оруулах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Одоогийн байдлаар Дархан сумын хэмжээнд орон сууцны хороолол бүхий 11 багийн 13270 өрхийн ахуйн хог хаягдлыг цуглуулах 174 цэгт хогийн сав, бункерийг хогийг ангилах зориулалтаар шинэчлэн сайжруулах хэрэгтэй байна. Дархан-Уул аймгийн хэмжээнд 10 барилга, орон сууцанд хог хаях хогийн 20

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

бункерийн системтэй. Бункерийн систем нь нэг давхараас хамгийн дээд давхар хүртэл байрлуулсан босоо хоолойгоор айл өрхүүд давхар, давхараасаа хогоо хаях зориулалтаар хийгдсэн байдаг тул эх үүсвэр дээр хог хаягдал ангилахад тохиромжгүй юм. Иймд эдгээр 20 бункерийг хааж орон сууцны бусад хорооллын адил ангилан ялгах 20 сав байршуулах шаардлагатай.



Зураг 59. Орон сууцны хорооллын айл өрхийн хог хаягдал түр хадгалах цэг

Эдгээр хогийн савны урт нь 4м, өргөн нь 1.5м, өндөр нь 2 м байх бөгөөд доторх тасалгаа нь төмрөөр хийгдэнэ. Дахин ашиглагдах боломжгүй ахуйн хатуу хог хаягдал хийх тасалгаа нь хар өнгөтэй байх ба өргөний хэмжээ нь 1м, цаасны хаягдал хийх тасалгаа нь цэнхэр өнгөтэй байх ба өргөний хэмжээ нь 1м, бүх төрлийн шил лаазны хаягдал хийх тасалгаа нь улбар шар өнгөтэй, өргөний хэмжээ нь 1 метр, бүх төрлийн хуванцар хаягдал, гялгар уут хийх тасалгаа нь ногоон өнгөтэй байх ба өргөний хэмжээ нь 1м урттай хогийн сав байна. Бусад хогийг зориулалтын хогийн уутанд савлаж хийнэ. Дахин ашиглагдах хаягдлуудыг журамд заасан зааврын дагуу хамаарах тасалгаануудад хийнэ.

“Бусад хог хаягдал” гэдэгт дахин ашиглагдах болон боловсруулагдах боломжгүй хог хаягдлыг хэлнэ.

Бусад хогийн тасалгаанд дахин боловсруулагдах боломжгүй төвлөрсөн хогийн цэгт булшлагдах хогийг хар өнгийн зориулалтын уутанд савлан хийнэ. Үүнд:

- Ариун цэврийн хэрэглэлийн хаягдал
- Номын хавтас, сэтгүүл, фото цаас
- Дахин ашиглагдахгүй урагдаж хуучирсан хувцас, хэрэглэл
- Нэг удаагийн аяга таваг хэрэгсэл
- Шаржигнасан гялгар уут (талх, нарийн боов, чихрийн уут)
- Хагарсан шаазан эдлэл, палантай сав



Зураг 60. Бусад хогийн уут

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Айл өрх болон орон сууцны хонгилийн болон нэг давхарт байрлах ААН-ууд ландфилд дарж булшлагдах бусад ангиллын хогийн зориулалтын уутыг хэрэгцээндээ тохируулан хүнсний дэлгүүр, СӨХ, дахиварын цэгүүд болон хог хаягдлын байцаагчаас худалдан авна. Бусад хог гэсэн ангилалд хамаарах хаягдлыг савлах уут нь 45см\*50см, 45см\*55см, 55см\*75см хэмжээтэй байна.

Цэнхэр өнгийн тасалгаанд бүх төрлийн цаасны хаягдлыг хийнэ. Үүнд: хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савалгаа гэх мэт хаягдлууд хамаарна. Цаасны хаягдлыг журамд заасан зааврын дагуу ялгаж цэвэрлэн овор хэмжээг нь багасган эмх цэгцтэй хийнэ.

Улбар шар өнгийн тасалгаанд бүх төрлийн шил лаазны хаягдлыг ялгаж хийнэ. Үүнд: хүнсний болон бүх төрлийн шилэн сав, эдлэл, таглаа болон бүх төрлийн лаазалсан бүтээгдэхүүний сав, таглаа, тугалган цаас гэх мэт хаягдлууд хамаарна. Шил лаазны хаягдлыг журамд заасан зааврын дагуу ялган цэвэрлэж хийнэ. Эмх цэгцтэй байх үүднээс иргэн дурын уутанд савалж зориулалтын тасалгаанд хийж болно. Шилийг хагарч гэмтээхгүйгээр зориулалтын тасалгаанд хийнэ. Эсвэл гэрийн ойролцоох хүнсний дэлгүүр, дахивар авах төвд иргэн өөрийн биеэр тушааж эдийн засгийн эргэлтэд оруулна.

Ногоон өнгийн тасалгаанд бүх төрлийн хуванцар болон гялгар уутны хаягдлыг хийнэ. Үүнд: Төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, кетчуп, ургамлын тос, угаалга, цэвэрлэгээний нунтаг, шингэний хуванцар сав, авто машины тос, тослогооны шингэний хуванцар сав, нэг удаагийн хуванцар сав, 0.025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол гэх мэт хаягдлууд хамаарна. Хуванцар болон гялгар уутны хаягдлыг журамд заасан зааврын дагуу ангилж иргэн дурын уутанд савлаж зориулалтын тасалгаанд хийнэ.

Органик хог хаягдал гэдэгт амархан муудаж гэмтдэг хоол хүнсний үлдэгдэл хог хаягдлыг хэлнэ. Үүнд бүх төрлийн жимс, хүнсний ногооны хальс болон үлдэгдэл, хоолны үлдэгдэл, яс, өндөгний хальс, хэрэглэсэн хүнсний тос зэргийг хамааруулна.



Зураг 61. Орон сууцны айл өрхүүдийн органик хог хаягдал хадгалах сав

Орон сууцны органик хог хаягдал хадгалах сав нь 2 тасалгаатай байх бөгөөд нэг тасалгаанд ясны хаягдлыг, нөгөө нэг тасалгаанд бусад хүнсний хаягдлыг органик хаягдлын зориулалтын уутанд савлаж хийнэ.



# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 62. Хүнсний хаягдал хийх уут



Зураг 63. Ясны хаягдал хийх уут

Органик хаягдлын уут 20см\*30см, 20см\*40см хэмжээтэй байна. Айл өрх болон орон сууцны хонгилийн болон нэг давхарт байрлах ААНБ-ууд органик хаягдлын уутыг хамгийн ойр байрлах хүнсний дэлгүүр, СӨХ, дахиварын цэгүүд болон хог хаягдал хариуцсан байцаагчаас худалдан авна.

Хүнсний ашигласан тосийг саванд хийж тагны битүүмжийг нягтлан шалгаж органик хаягдал хийх савны гадна талд эсхүл дахиварын цэгт хүлээлгэн өгч эдийн засгийн эргэлтэнд оруулна.

Ахуйн нөхцөлд аюултай хог хаягдал бий болсон тохиолдолд айл өрхүүд зориулалтын уутанд хийж журамд заасны дагуу хадгалж зайлуулна. Аюултай хаягдлын уут нь 20см\*40см, 45см\*50см хэмжээтэй байна. Ахуйн нөхцөлд үүсэх аюултай хог хаягдалд бүх төрлийн батерей, химийн хортой бодис түүнийг агуулсан сав, халдвар дамжуулах эрсдэлтэй биологийн шингэн, цус агуулсан хаягдал, зүү, тариур, эмийн хаягдал гэх мэт хамаарна. Аюултай хаягдлын уутыг айл өрх болон орон сууцны хонгилийн болон нэг давхарт байрлах ААНБ-ууд хамгийн ойр байрлах эмийн сан, хүнсний дэлгүүр, СӨХ, дахиварын цэгүүд болон хог хаягдлын байцаагчаас худалдан авна.



Зураг 64. Аюултай хаягдлын уут


Дархан-Уул аймагт хэрэглэгдэх зориулалтын хогийн уутнууд нь журамд заасан стандарт хэмжээ, өнгөний код, таних тэмдэгийг мөрдөж хийгдсэн байх бөгөөд аймаг болон хөтөлбөрийн нэр, хогийн уутны зориулалт, зааварчилгаа бичигдсэн байна.

Хүснэгт 28. Орон сууцны хороололд тавигдах хогийн савны зардал

Орон сууцны хороолол	Нийт тоо, ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Нийтийн ангилдаг хогийн сав	174	3,500,000	609,000,000
Органик хаягдлын сав	174	1,000,000	174,000,000
<b>Нийт зардал</b>			<b>783,000,000</b>

## 3.2.2.2. Гэр хорооллын айл өрхүүдийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах

Гэр хорооллын айл өрх тус бүр дараах ангилан ялгах тасалгаат хог хаягдал түр хадгалах савтай байна. Энэ тооцоогоор гэр хороололд 11040 ширхэг хогийн сав шаардагдана. Тус хогийн сав нь 2000x1000x1200 мм хэмжээтэй 2 тасалгаат 3 мм-ийн зузаантай лист төмрөөр хийгдэнэ. Тухайн өрхөд хүн байхгүй байсан ч ачигч хашааны гаднаас хогийн савийг онгойлгож савласан хог хаягдлыг орж аван машинд ачина. Ингэснээр ачигчид хогийн савыг зөөвөрлөх, өргөх, хогийг гараараа хүрздэж хийхгүй байх зэрэг эрүүл ахуйн шаардлагын дагуу хогоо ачих боломжтой болно.



Зураг 65. Гэр хорооллын айл өрхийн хог түр хадгалах сав

Хогийн савны 1 дэх тасалгаанд зөвхөн ахуйн гаралтай дахин боловсруулагдах боломжгүй хатуу хог хаягдлыг бусад хог савлах зориулалтын уутанд савлаж хийнэ. 2 дахь тасалгаанд зөвхөн түлшний хаягдал болох үнснийг зориулалтын үнсний уутанд савлаж хийнэ. Харин дахин ашиглагдах болон боловсруулагдах боломжтой хаягдал болох бүх төрлийн хуванцар, гялгар уут, цаас, шил, лааз зэргийг хашаандаа цуглуулан хамгийн ойр байрлах дахивар авах цэгүүдэд тушаан эдийн засгийн эргэлтэнд оруулна.

**Үнсний уут:** Япон улсад ашиглагддаг үнсний уут нь шилэн даавуун (хоёр талт силикон бүрхүүл) материалаар хийгдсэн дулаанд тэсвэртэй, шатамхай биш, ус нэвтэрдэггүй, нүүрсний дэгдэмтгий үнснийг хийх зориулалттай бөгөөд үнс болон шуудай гэсэн 2 хаягдлаас татгалзсан хувилбар юм. Гэр хорооллын айл өрхийн хогийг сард 2 удаа тогтмол хуваарийн дагуу татан зайлуулах ба үнсний уутыг айл өрх өөрсдийн хэрэгцээнд тааруулан сэлгүүлэн дахин ашиглах зарчмаар ашиглана. Тус уутны зохимжит хэмжээ 520x1200 мм байна.



Зураг 66. Япон улсад ашиглагддаг үнсний уут



Зураг 67. Үнсний уут

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнсний уут болон бусад хогийн уутыг гэр хорооллын хамгийн ойр байрлах эмийн сан, хүнсний дэлгүүр, дахиварын цэгүүд болон хог хаягдлын байцаагчаас худалдан авна. Хүнсний хаягдал буюу органик хог хаягдлыг айл өрхүүд хашаандаа цуглуулна. Гэр хорооллын айл өрхүүд органик хог хаягдлаа хашаандаа Бокаши сав буюу ахуйн нөхцөлд ногоо, жимсний үлдэгдлийг эсгэн ялзмагжуулах саванд журамд заасан зааврын дагуу хурааж шингэн болон компост бордоо болгон хашааныхаа ногоон байгууламжид ашиглах замаар эргэлтэнд оруулна.



Зураг 68. Бокаши сав



Зураг 69. Биолан бордоошуулах сав

Цаашдаа гэр хорооллын айл өрхүүдийн нүхэн жорлонг хуурай технологийн био 00 болгон өөрчлөх хэрэгтэй бөгөөд энэ тохиолдолд айл өрхүүд био 00-ийн хаягдлаа хоолны үлдэгдэлтэйгээ Биолан бордоошуулах саванд цуглуулж бордоо болгон ашиглах бүрэн боломжтой.

Хүснэгт 29. Гэр хорооллын 1 айл өрхөд шаардагдах материалын зардал

№	Материалын нэр	Тайлбар	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Лист төмөр	3 мм зузаантай 1.5x6 м хэмжээтэй	1.6 ш	144000	230400
2	Квадрат төмөр	15x15 зузаантай 1.3 м хэмжээтэй	36.4 м	2100	76440
3	Нугас		8 ш	2500	20000
4	Бариул		4 ш	2500	10000
5	Бокаши сав	Биолан бордоошуулах сав	1 ш	85000	85000
6	Үнсний уут	520x1200 мм	2 ш	15000	30000
<b>Нийт дүн</b>				<b>451840</b>	

### 3.2.2.3. Аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилал

ААНБ-ын хог хаягдлыг энгийн ба аюултай хог хаягдал гэж 2 ангилна. ААНБ-ын энгийн хог хаягдлыг цаас, шил лааз, хуванцар гялгар уут, органик хаягдал болон бусад хог гэсэн ангиллаар ангилна.

Дархан сумд үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ыг байршилийн хувьд 2 ангилж болно.

1. Орон сууцны хонгилийн болон нэг давхарт үйл ажиллагаа явуулдаг ААНБ
2. Тусдаа объект бүхий ААНБ

Орон сууцны хонгилийн болон нэг давхарт үйл ажиллагаа явуулдаг ААНБ хог хаягдлаа айл өрхүүдийн адил гэж ангилна. Эдгээр ААНБ-ууд орон сууцны хорооллын айл өрхүүдийн адил ангилсан хогийн зориулалтын уутнуудыг хаягдлын хэмжээндээ тохируулан хамгийн ойр байрлах хүнсний дэлгүүр, эмийн сан, СӨХ, дахиварын цэгүүд

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

болон хог хаягдлын байцаагчаас худалдан авна. Дархан сумын хэмжээнд орон сууцны хонгилийн болон нэг давхарт үйл ажиллагаа явуулдаг 620 ААНБ байна.


Тусдаа объект бүхий ААНБ-ууд үйл ажиллагааны чиглэл онцлог, хог хаягдлын хэмжээ төрлөөсөө хамааруулан энгийн хог хаягдал түр хадгалах савыг дурын хэмжээтэй хийж байрлуулж болно. Энгийн хог хаягдал түр хадгалах сав нь хэмжээний хувьд харилцан адилгүй байж болох хэдий ч Дархан-Уул аймагт мөрдөгдөх хог хаягдлын харилцааг зохицуулах журамд заасан хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах зааварчилгаа, өнгөний код, таних тэмдэгийн стандартыг баримтлана. Тусдаа объект бүхий ААНБ-ын аюултай хог хаягдалд тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлууд орно. Үүнд: бүх төрлийн батерей, химийн хортой бодис түүнийг агуулсан сав, барилгаас гарсан дахин ашиглах, дахин боловсруулах боломжгүй хаягдал, асбест болон хортой бодис агуулсан, хортой бодисоор бохирдсон, мөнгөн ус агуулсан агуулсан хөрс, шороо, чулуу, нунтаг шороо, бетон, тоосго, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал, мод, шил, хуванцар зэрэг хаягдлууд болон биологийн шингэн, цус агуулсан хаягдал, зүү, тариур, цацраг идэвх, хүний эд эрхтэн, тайрдас, эмийн хаягдал, урвалж, химийн бодис зэрэг эрүүл ахуйн хувьд эрсдэл бүхий эмнэлгийн хаягдал гэх мэт хамаарна.

Үйлдвэрлэл болон үйлчилгээний гаралтай аюултай хог хаягдал үүсгэгч нь тухайн хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх, устгах эрх бүхий ААНБ-д шилжүүлэх хүртэл зориулалтын саванд савлаж байгууллага дээрээ түр байршуулан хадгална. Үйлдвэрлэлийн гаралтай аюултай хог хаягдлыг ангилахдаа дараах зүйлсийг баримтална.

Үүнд:

- Үйлдвэрлэлийн явцад үүсч байгаа хог хаягдал аюултай эсэхийг тогтооно. Хог хаягдлын аюулын шинж чанар болон аюултай, хортой, идэмхий, цочроомтгой, шатамхай зэрэг шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг агуулсан болохыг тодруулах бол итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулна.
- Өөрийн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлын төрөл, кодыг хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтооно.
- Аюултай хог хаягдлын хэмжээ 1 сард 1000 килограммтай тэнцүү буюу түүнээс бага үүсч байвал 180 хоног, 1000 килограммаас их хэмжээтэй үүсч байвал 90 хоног хадгална.
- Аюултай хог хаягдал хадгалах газрыг зөв сонгоно. Энэ нь тухайн аюултай хог хаягдлыг бий болгодог газартай ойрхон байх ёстой.
- Гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материалыг шаардлагатай газар байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангана.
- Аюултай хог хаягдлын шинж чанар, онцлогоос нь хамааруулж, төрөлжүүлэн тухайн онцлогт тохирсон зориулалтын саванд савлаж битүүмжлэн, “Аюултай хог хаягдал” гэсэн нэр, стандартаар тогтоосон тэмдэг тэмдэглэгээг нүдэнд ил харагдахуйц байдлаар байрлуулж, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна
- Өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаа аюулгүй устгах болон дахин боловсруулах боломжгүй бол тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлнэ.
- Аюултай хог хаягдал хариуцсан ажилтан нь аюултай хаягдлын талаарх бүртгэл мэдээллийг хөтөлж мэдээллийн санд оруулдаг байна.


## 3.2.3. Хог хаягдлыг татан зайлуулах тогтолцоох сайжруулах



Зураг 70. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах ерөнхий схем

### 3.2.3.1. Орон сууцны айл өрхүүдийн хог хаягдлыг татан зайлуулах тогтолцоо

Орон сууцны хорооллын айл өрхүүдийн хог хаягдлыг хуваарьт өдрүүдэд дахиваруудыг нь дахивар авах төв болон боловсруулах үйлдвэрүүд рүү татан авалт хийнэ. Бусад хогийг батлагдсан хуваарийн дагуу ландфилл руу тээвэрлэнэ.



Зураг 71. Орон сууцны хорооллын айл өрхийн хог хаягдлыг татан зайлуулах схем

Орон сууцны хорооллын айл өрхийн ахуйн хог хаягдлыг Дархан сумын хэмжээнд 174 хог түр хадгалах цэгээс дахиварууд болон бусад хогийг тус тусад нь дараах байдлаар татан зайлуулна.

Орон сууцны хонгилын болон нэг давхарт үйл ажиллагаа явуулдаг ААНБ хог хаягдлаа айл өрхүүдийн адил гэж ангилна. Эдгээр ААНБ-ууд орон сууцны хорооллын айл өрхүүдийн адил ангилсан хогийн зориулалтын уутнуудыг хаягдлын хэмжээндээ тохируулан хамгийн ойр байрлах хүнсний дэлгүүр, эмийн сан, СӨХ, дахиварын цэгүүд болон хог хаягдлын байцаагчаас худалдан авна. Дархан сумын



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

хэмжээнд орон сууцны хонгилын болон нэг давхарт үйл ажиллагаа явуулдаг 620 ААНБ байна.

Хүснэгт 30. Орон сууцны айл өрхийн хог тээвэрлэлтийн хуваарь

Хуваарилалт	Хогийн төрөл	Хогийн цэгийн тоо	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба
Блок-1 / 9, 10,11,12-р баг/	Бусад хог хаягдал	60					Машин -1	
	Цаас		Машин -2					
	Шиллааз					Машин -2		
	Хуванцар			Машин -3			Машин -3	
	Органик хаягдал		Машин -4			Машин -4		
Блок-2 /4,5, 8,17-р баг/	Бусад хог хаягдал	58	Машин -1					
	Цаас			Машин -2				
	Шиллааз				Машин -3		Машин -2	Машин -3
	Хуванцар							
	Органик хаягдал			Машин -4			Машин -4	
Блок-3 /13, 14, 15-р баг/	Бусад хог хаягдал	56			Машин -1			
	Цаас				Машин -2			
	Шиллааз							Машин -2
	Хуванцар		Машин -3			Машин -3		
	Органик хаягдал					Машин -4		Машин -4


## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 31. Орон сууцны айл өрхийн хог тээвэрлэлтийн зардлын тооцоо

№	Материалын нэр	Марк	Зориулалт	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
Хог хаягдлыг татан зайлуулах, тээвэрлэхэд ашиглах техник хэрэгсэл							
1	Компактор автомашин	Hyundai HD120	Хог хаягдал тээвэрлэх	ш	4	259.200.000	1.036.800.000
Хөдөлмөр зарцуулалт							
2	Жолооч	В,С ангиллын жолооч		хүн	4	5.040.000	20.160.000
3	Ачигч	Суурь боловсрол эзэмшсэн		хүн	8	5.040.000	40.320.000
Шатах, тослох материалын зардал							
4	Шатахуун	Дизель түлш		Машин/жил	4	14.636.160	58.544.640
5	Масло	Супер тос	Жилд 2 удаа	Машин/жил	4	260.000	1.040.000

### 3.2.3.2. Гэр хорооллын айл өрхүүдийн хог хаягдлыг татан зайлуулах тогтолцоо

Дархан сумын хэмжээнд 2021 оны байдлаар гэр хорооллын 11040 өрх байна. Гэр хорооллын айлуудын хог хаягдал түр хадгалах савнуудаас дараах байдлаар дахин боловсруулагдах боломжгүй бусад хог болон үнсний хаягдлыг цуглуулж тээвэрлэнэ.




Зураг 72. Гэр хорооллын айл өрхийн хог тээвэрлэлтийн схем

Дахин ашиглагдах болон дахин боловсруулагдах боломжгүй бусад хогийг Бараат төвлөрсөн хогийн цэг рүү шууд тээвэрлэнэ. Үнсний хаягдлыг барилгын материал дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ. Дархан сумын гэр хорооллын 7 багийн бусад хогийг дараах хуваарийн дагуу тээвэрлэлт хийнэ.

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 32. Гэр хорооллын айл өрхийн хог тээвэрлэлтийн хуваарь

ӨВЛИЙН УЛИРАЛ							
Хуваарилалт	Хогны төрөл	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба
Блок-1 /1,2,3-р баг/	Хатуу хог хаягдал	Машин -1				Машин -1	
	Үнсний хаягдал		Машин-2				Машин-2
Блок-2 /6,7,8-р баг/	Хатуу хог хаягдал		Машин -1		Машин -1		
	Үнсний хаягдал			Машин-2		Машин-2	
Блок-3 /Малчин баг/	Хатуу хог хаягдал			Машин -1			
	Үнсний хаягдал				Машин-2		
Блок-4 /15-р баг/	Хатуу хог хаягдал					Машин -1	
	Үнсний хаягдал						Машин-2
ЗУНЫ УЛИРАЛ							
Хуваарилалт	Хогны төрөл	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба
Блок-1 /1,2,3-р баг/	Хатуу хог хаягдал	Машин -1					
Блок-2 /6,7,8-р баг/	Хатуу хог хаягдал		Машин -1				
Блок-3 /Малчин баг/	Хатуу хог хаягдал			Машин -1			
Блок-4 /15-р баг/	Хатуу хог хаягдал					Машин -1	



Зураг 73. Гэр хорооллын айл өрхийн хог тээвэрлэлтийн хуваарь

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

### Хүснэгт 33 Хог хаягдлыг тээвэрлэхэд гарах зардлын тооцоо

№	Материалын нэр	Марк	Зориулалт	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
Хог хаягдлыг татан зайлуулах, тээвэрлэхэд ашиглах техник хэрэгсэл							
1	Компактор автомашин	Hyundai HD120	Хог хаягдал тээвэрлэх	ш	5	259.200.000	1.296.000.000
Хөдөлмөр зарцуулалт							
2	Жолооч	В,С ангиллын жолооч		хүн	5	5.040.000	25.200.000
3	Ачигч	Суурь боловсрол эзэмшсэн		хүн	10	5.040.000	50.400.000
Шатах, тослох материалын зардал							
4	Шатахуун	Дизель түлш		Машин/жил	5	14.636.160	73.180.800
5	Масло	Супер тос	Жилд 2 удаа	Машин/жил	5	260.000	1.300.000

#### 3.2.3.3. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээг сайжруулах

Нийтийн эдэлбэр газар, сумын гудамж, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний ажил “Дархан-Уул аймгийн хог хаягдлын харилцааг зохицуулах журам”-ийн 4-р бүлэгт заасны дагуу зохицуулагдана.

Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах хогийн саванд тавигдах шаардлага

1. Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн саванд тавих шаардлага  
Хогийн сав нь бат бөх, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, зэврэлтээс хамгаалагдсан байх.


- 1.1. Хогийн савны хог цуглуулах хэсгүүд нь цаасан дахивар болон бусад хог хаях зориулалтыг заасан стандарт мэдээлэх тэмдэгтэй байх.
- 1.2. Хогийн сав нь хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн байх.
- 1.3. Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн тагтай байна.
- 1.4. Түгээмэл хэрэглэгддэг угаалга цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодист тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалаар хийгдсэн байна.
- 1.5. Хогийн савны металл хийцийн эд ангийг зэврэлтээс хамгаалж стандарт шаардлага хангасан будгаар, энэхүү стандартад заасан өнгөөр, технологийн дагуу будсан байна.
- 1.6. Нийтийн эзэмшлийн хогийн савны стандартад нийцсэн байх

2. Төрөл ангилал

- 2.1. Нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгт хүрээлэн, зам, талбайд байрлуулах хогийн савыг ус, ундааны, зөөврийн болон тамхи татах цэгт зориулсан гэж ангилна.

Хүснэгт 34. Хогийн савны хэмжээ

Таних тэмдэг	Төрөл	Хэмжигдэхүүн	Хэмжээ /м/
H	Тамхины цэгийн хогийн сав	Өндөр	1.05
B		Өргөн	450(±20)
L	Хуванцар цуглуулах хогийн сав	Урт	2.0
H		Суурийн өндөр /урд хөл/	1.0
H		Суурийн өндөр /хойт хөл/	0.5



Зураг 74. Тамхи татах цэгийн хогийн сав



Зураг 75. Хуванцрын сав



Зураг 76. Түр байрлуулах, зөөврийн хогийн сав

### 3. Хогийн савны өнгө

№	Нэр, тэмдэглэгээ	Өнгө	Өнгөний код
1	Ногоон RAL 6016 /#00694c/		C - 84, M - 11, Y - 98, K - 1
2	Саарал RAL 7035 /#c5c7c4/		C - 0, M - 0, Y - 0, K - 30



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дархан сумын нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэнгүүдэд хог хаягдлыг ангилан ялгах сав байршуулах шаардлагатай байгаа бөгөөд хуванцар сав цуглуулах хогийн сав 3-ыг хийж байршуулна.

Харин сумын хэмжээнд байгаа албан бус цэгийн хур хог хаягдлыг ойрын 2 жилийн хугацаанд олон нийтийг хамарсан ажил зохион байгуулж татан зайлуулах шаардлагатай бөгөөд энэ үйл ажиллагаанд 57.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 35. Албан бус хог хаягдлыг татан зайлуулахтай холбогдон гарах зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Жолоочийн цалин	мян.төг	40	700.000	28.000.000
2	Шатахуун	л	9686	2.040	19.759.158
3	Бусад /бээлий, хүрз, маск/				10.000.000
	<b>Нийт дүн</b>				<b>57.759.158</b>

Нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэдэг ажилчдын ажлыг хөнгөвчлөх үүднээс бага оврын цас цэвэрлэгч машин 5, олон үйлдэлт цас цэвэрлэх машин 1-ийг тус тус худалдан авч үйл ажиллагаанд ашиглахаар тооцоог хийв.

Хүснэгт 36. Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээтэй холбогдон гарах зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хогийн сав /ш	ш	3	380.000	1.140.000
2	Хогийн шүүр	ш	400	9.000	3.600.000
3	Хүрз	ш	400	8.500	3.400.000
4	Цас цохигч /лоом/	ш	200	15.000	3.000.000
5	Цас түрэгч /модон/	ш	200	12.000	2.400.000
6	Бага оврын цас цэвэрлэгч машин	ш	5	5.000.000	25.000.000
7	Олон үйлдэлт цас цэвэрлэх машин	ш	1	396.000.000	396.000.000
	<b>Нийт дүн</b>				<b>434.540.000</b>

### 3.2.3.4. Парк шинэчлэл, техник хангамжийг сайжруулах

Автомашин парк шинэчлэлтэй холбоотойгоор 2 байршилд автогражийн барилга төлөвлөсөн.

#### 1. 20x40 метрийн хэмжээтэй авто автограж

Тус автогражийг НААҮГ-ын засварын хашаан дахь хуучин гражийг засварлан өргөтгөж байгуулна.


Архитектур төлөвлөлтийн хувьд 20x40 харьцаатай барилга нь 28 автомашин багтах тулаас гүй орон зайтай нэгдсэн талбай төлөвлөв. Авто машины 1, явган хүний 1 хаалгатай төмөр карказан сендвичин барилга байна. Барилгын ажлын нийт өртөг 105.295.000 төгрөг.

Суурийн барилга нь төмөр бетон аяган болон шугаман суурьтай байна. Хучилт болон дээвэр нь металл дам нуруун дээр  $b=150\text{мм}$  зузаантай сандвичэн хавтангаар 2 налуу

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

дээвэр маягаар угсарна. Ургамлан хөрсийг хуулж шалыг  $b=300\text{мм}$  зузаантай нягтруулсан хайрган дэвсгэр дээр БМ-150 маркийн бетоноор  $b=150$  зузаантай цутгана.

Хаалгыг  $b=150$  зузаантай сэндвичин хавтангаар хийх ба вакуум цонхтой байна. Халаалтыг төвийн холболтод холбохоор төлөвлөсөн ба агаар сорох ердийн салхивчтай байна.



Зураг 77. Автогражийн загвар, машин механизмын төлөвлөлт

Дархан сумын хог тээвэрлэх, дахин ашиглах, дарж булшлахад шаардлагатай машин механизм худалдан авахад дараах нөхцөл байдлыг харгалзан үзэх нь зүйтэй.

- Машины найдварт ажиллагааг хангахуйц байх
- Техникийн тодорхойлолтод заасан автомашин байх
- Өндөр хүчин чадалтай орчин үеийн дэвшилтэт техник нь ашиглалтын хугацаа сайтай, эрүүл ахуйн шаардлага хангасан, хуримтлалын элэгдэл багатай зэрэг ач холбогдолтой.

Хог тээвэрлэлтийн үйл ажиллагаа, үйлчилгээг хангахад дараах автомашины сонголтыг хийв.

Авто машины парк шинэчлэлт хийхэд нийт 6.158.095.000 төгрөгийн санхүүжилт шаардлагатай.

Хүснэгт 37. Дархан сумын хог хаягдал татан авалт гүйцэтгэх автомашин, механизмын үзүүлэлт, худалдан авах төсөв

№	Шаардлагатай машин механизмын нэр	Тоо ширхэг	Марк	Даац	Зориулалт	Нэгж үнэ /сая/	Нийт үнэ /сая/
<b>Хог хаягдлыг татан зайлуулах, тээвэрлэхэд ашиглах техник хэрэгсэл /Ландфилл руу явах/</b>							
1	Компактор автомашин	3	Hyundai HD120 /хог шахагч/	6тонн	Орон сууцны айл өрх, ААН хог хаягдлыг ачиж тээвэрлэх	259	777.6
2	Компактор автомашин	5	Hyundai HD120 /хог шахагч/	6тонн	Гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг ачиж тээвэрлэх	259.2	1296
<b>Дахивар авах цэгт ашиглах техник хэрэгсэл</b>							
3	Компактор автомашин	1	Hyundai HD120 /өөрөө буулгагч/	5тонн	Хуванцар, цаасны хаягдал цуглуулах тээвэрлэх	259.2	259.2

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

4	Бүхээгтэй ачааны машин	1	Hyundai HD45 /Бүхээгтэй/	2.5тонн	Шил, лааз цуглуулан тээвэрлэх	146	146
5	Задгай тэвштэй машин	1	Hyundai HD65 /өөрөө буулгагч/	3.5 тонн	Овор ихтэй хаягдал, барилгын хаягдал цуглуулах тээвэрлэх	158	158
6	Өөрөө буулгагч машин	1	Hyundai HD72 Garbage dump /өөрөө буулгагч/	4тонн	Органик хаягдал цуглуулах тээвэрлэх	180	180
<b>Аюултай хог хаягдал тээвэрлэх машин</b>							
7	Бүхээгтэй ачааны машин	1	Hyundai HD45 /Бүхээгтэй/	2.5тонн	Аюултай хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх	146	146
<b>Цэвэрлэгээ, үйлчилгээнд ашиглах техник хэрэгсэл</b>							
8	Тусгай зориулалтын зам талбайн цэвэрлэгээний автомашин /универсал бүх хошуу тоног төхөөрөмжийн хамт/	1	МК-2000 /замын цэвэрлэгээ/	Олон үйлдэлт	Орон сууцны хороолол дундах авто замын цэвэрлэгээ	396	396
9	Бага оврын цас цэвэрлэх машин (3195м <sup>3</sup> /цаг)	5	SP13T	2 үйлдэлт	Нийтийн эзэмшлийн зам талбай	5	25
<b>Хог хаягдлын төвлөрсөн цэг буюу ландфиллд ашиглах техник хэрэгсэл</b>							
10	Бульдозер	2	Komatsu	10м <sup>3</sup>	Хог хаягдал түрж дарж, булах	750	1500
11	Экскаватор	1	Hyundai	1.05м <sup>3</sup>	Хог хаягдлын цэгт	384	384
12	Ковш	2	Komatsu	2.5	Хог хаягдал ачиж тээвэрлэх түрж булах	300	600
<b>Бусад</b>							
13	Ажилчдын автобус	1	Hyundai county	24 хүний суудалтай	Ажилчдыг зөөвөрлөх	185	185
14	20х40 харьцаатай автограж	1			НААҮГ-ын засварын хашаанд байрлах	105.3	105.3
<b>нийт дүн</b>		<b>26</b>				<b>6158.1</b>	

Дээрх үнийн саналыг БНСУ-ын HYUNDAI motors компанийн албан ёсны гэрээт борлуулагч Хьюндай моторс Монгол ХХК болон БНХАУ-ын SHATUI, XCMG компаниудын гэрээт борлуулагчаас авсан болно.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 3.3. ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ, ЭРГҮҮЛЭН АШИГЛАХ ЗАМААР ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ, НОГООН АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХ, ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ

#### 3.3.1. Дархан сумын хог хаягдлын урсгалын төлөвлөлт

Дархан сумын хүн амын өсөлтийн 2050 он хүртэлх таамаглалыг шугаман тэгшитгэлийн аргаар тооцож үзэхэд 2030 онд 101.9 мянга, 2040 онд 116.1 мянга, 2050 онд 130.2 мянгад хүрэх тооцоо гарч байгаа бөгөөд харин өрхийн тоог экспоненциал тэгшрүүлэлтийн аргаар таамаглаж үзэхэд 2030 онд нийт 27.8 мянга, 2040 онд 30.2 мянга, 2050 онд 32.8 мянга болж тус тус нэмэгдэхээр байна (Хавсралт 9).

Хүснэгт 38. Дархан сумын хог хаягдлын урсгалын хандлага, 2020-2035

Ангилал	2020		2025		2030		2035			
	Өвөл	Зун	Өвөл	Зун	Өвөл	Зун	Өвөл	Зун		
Хүн ам	91216		94836		101920		109003			
Өрхийн тоо	Орон сууц		13792		14677		15385		16094	
	Гэр хороолол		11044		11742		12308		12875	
Өрхийн дүн	24836		26419		27693		28969			
Өрхийн хог хаягдал /тн/	Орон сууц		13950.7		14504.4		15587.7		16671.1	
	Гэр хороолол		7839.7   3934.9		8150.8   4091.1		8759.6   4396.7		9368.4   4702.3	
<b>Дүн</b>	<b>25725.3</b>		<b>26746.4</b>		<b>28744.0</b>		<b>30741.8</b>			
ААНБ-ын хог хаягдал /тн/	3455		9410		12296		16067			
Нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдал /тн/	20.0	58.0	21.3	64.0	23.0	69.0	24.5	74.0		
<b>Дүн</b>	<b>3533.0</b>		<b>9495.3</b>		<b>12388.0</b>		<b>16165.5</b>			
<b>Нийт дүн /тн/</b>	<b>29258.3</b>		<b>36241.7</b>		<b>41132.0</b>		<b>46907.3</b>			

Хүснэгт 39. Дархан сумын хог хаягдлын урсгалын хандлага, 2040-2050

Ангилал	2040		2045		2050			
	Өвөл	Зун	Өвөл	Зун	Өвөл	Зун		
Хүн ам	116086		123170		130253			
Өрхийн тоо	Орон сууц		16802		17510		18218	
	Гэр хороолол		13441		14008		14574	
Өрхийн дүн	30243		31518		32792			
Өрхийн хог хаягдал /тн/	Орон сууц		17754.4		18837.8		19921.1	
	Гэр хороолол		9977.2   5007.8		10586.0   5313.4		11194.8   5619.0	
<b>Дүн</b>	<b>32739.4</b>		<b>34737.2</b>		<b>36734.8</b>			
ААНБ-ын хог хаягдал /тн/	20995		27433		35847			
Нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдал /тн/	26.1	78.4	27.7	83.1	29.3	88.0		
<b>Дүн</b>	<b>21099.5</b>		<b>27543.8</b>		<b>35964.3</b>			
<b>Нийт дүн /тн/</b>	<b>53838.9</b>		<b>62281.0</b>		<b>72699.1</b>			

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээрх хүн амын болон өрхийн тооноос хамаарсан хог хаягдлын хэмжээг 1 хүнд ногдох хог хаягдлын хэмжээнд үндэслэн тооцож үзэхэд 2030 онд 28.7 мянган тонн, 2040 онд 32.7 мянган тонн, 2050 онд 36.7 мянган тонн болж нэмэгдэхээр байна.

Аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлын хэмжээг НААҮГ –аар хог хаягдлаа татан тээвэрлүүлэх үйлчилгээ авдаг ААНБ-ын сүүлийн 5 жилийн тоо мэдээнд үндэслэн тооцоход 2030 онд 12.3 мянган тонн, 2040 онд 21 мянган тонн, 2050 онд 35.8 мянган тонн хүрэхээр байна.

Нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлын хэмжээг хог хаягдлын хэмжээ нь бүртгэлтэй байгаа “Дархан -50” цогцолборын хогийн хэмжээг үндэслэн дүйцэхүйц 4 газрын “Миний монгол” цэцэрлэгт хүрээлэн, “Морин хуур” цогцолбор, “Бурхантай толгой” хогийн савны хэмжээгээр тооцон Дархан сумын хүн амын өсөлттэй уялдуулан төлөвлөхөд 2030 онд 92 тонн, 2040 онд 104.5 тонн, 2050 онд 117.3 тонн болох хандлагатай байна. Энэ дүн нь одоогийн байдлаар НААҮГ-ын хог татан зайлуулах үйлчилгээг авдаг ААНБ-ын дүнгээр бодож тооцож гаргасан болно.

Өсөн нэмэгдэж буй хүн ам, өрхийн хэрэглээ, мал аж ахуй, газар тариалангийн бодлоготой уялдуулан 2030 он хүртэлх зарим органик хог хаягдлын нөөцийг тооцоход дунджаар 109.69 мян.тн ба энэ нь 2020 оны дунджаас 37.72 %-аар нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 40. Дархан-Уул аймгийн зарим органик хог хаягдлын цаашдын хандлага, мян.тн

	Бод малын ялгадас	Бог малын ялгадас	Шувуун ы сангас	Гахайн ялгадас	Ногооны хаягдал	Хаягдал яс	Нийт
2021	47.73	36.73	0.23	0.88	3.91	2.12	<b>91.59</b>
2022	50.01	37.82	0.24	0.90	4.03	2.13	<b>95.14</b>
2023	52.41	38.96	0.24	0.93	4.15	2.15	<b>98.84</b>
2024	54.94	40.13	0.25	0.96	4.28	2.16	<b>102.72</b>
2025	57.61	41.34	0.26	0.99	4.41	2.18	<b>106.78</b>
2026	60.42	42.60	0.27	1.02	4.54	2.20	<b>111.03</b>
2027	63.38	43.89	0.27	1.05	4.67	2.21	<b>115.48</b>
2028	66.51	45.23	0.28	1.08	4.81	2.23	<b>120.14</b>
2029	69.81	46.62	0.29	1.11	4.96	2.25	<b>125.03</b>
2030	73.29	48.05	0.30	1.15	5.11	2.26	<b>130.15</b>
<b>Дундаж</b>	<b>59.61</b>	<b>42.14</b>	<b>0.26</b>	<b>1.01</b>	<b>4.49</b>	<b>2.19</b>	<b>109.69</b>



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Органик хог хаягдлын хэмжээг 2021-2025, 2026-2030 он хүртэл гэж 5 жилээр үечлэн үзэхэд дараах байдалтай байна

Хүснэгт 41. Дархан-Уул аймгийн зарим органик хаягдлын цаашдын хандлага, мян. тн (5 жилээр)

<b>Төрөл</b>	<b>2021-2025</b>	<b>2026-2030</b>
Бод малын ялгадас	52.54	66.68
Бог малын ялгадас	39.00	45.28
Шувууны сангас	0.24	0.28
Гахайн ялгадас	0.93	1.08
Ногооны хаягдал	4.16	4.82
Хаягдал яс	2.15	2.23
<b>Нийт</b>	<b>99.01</b>	<b>120.37</b>


Дархан-Уул аймгийн органик хог хаягдлын 2021-2025 оны таамагласан дундаж нөөц 2020 оныхоос 24.31%-аар, харин 2026-2030 оны таамагласан дундаж нөөц 51.12%-аар нэмэгдэх төлөвтэй байна. Иймд хэрэглээгээ багасгах, дадал зуршлаа өөрчлөх, ангилан ялгах, менежментийг сайжруулах зайлшгүй шаардлага тулгараад байна.

## 3.3.2. Хүний нөөцийн төлөвлөлт

НААҮГазар нь техник, үйлчилгээний хэлтэст, захиргаа, хүний нөөцийн хэлтэст, санхүү төлөвлөлтийн хэлтэс гэсэн 3 хэлтэстэйгээр үйл ажиллагаагаа явуулах болно.

Тус байгууллагын техник үйлчилгээний хэлтэс нь авто техникийн алба, тохижилт үйлчилгээний алба, цахилгаан гэрэлтүүлгийн алба, цэвэрлэгээ үйлчилгээний алба гэсэн 4 албанаас бүрдэнэ.

Цэвэрлэгээ, үйлчилгээний алба нь нийтийн эзэмшлийн зам талбайг болон Бараат хогийн цэгийг хариуцан ажиллахаар төлөвлөгөөнд тусгалаа. Харин бусад хог хаягдал болох айл өрх, ААН, барилга, аюултай хог хаягдлыг тусгайлсан ААН, байгууллага байгуулагдан ажиллахаар төлөвлөлөө. Тус байгууллагын ажиллагчдын орон тооны хувьд 150 орчим ажилтан, албан хаагч ажиллахаар төлөвлөгөөнд тусгав. Гэхдээ төлөвлөгөөний эхний 3 жилд дээрх хог хаягдлын төрөл тус бүрээр хариуцсан мэргэжилтэн ажиллах шаардлагатай болно.



Зураг 78. НААҮГ-ын удирдлага, зохион байгуулалтын бүтэц


### 3.3.3. Жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжих замаар хаягдал нөөцийг сэргээн ашиглах

Хог хаягдал гэж үзэгдэж буй хуучин зүйлсийг сэргээн засварлаж, дахин ашиглах нь хог хаягдлыг бууруулахад чухал нөлөө үзүүлэх бөгөөд хуучин тавилга, буйдан, цахилгаан бараа болон гутал, хувцас, цүнх зэргийг засварлан дахин хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж буй засвар, үйлчилгээний салбарт ажиллаж байгаа хүний нөөцийг чадавхжуулах, энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн аж ахуйн нэгжийг тогтвортой санхүүжилттэй байхад бодлогын дэмжлэг үзүүлэх үүднээс хөнгөлөлттэй зээлд хамруулах, хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй байна.

МУ-ын хог хаягдлын тухай хуулийн 4.1.5-т “овор хэмжээ ихтэй хог хаягдал” гэж 0.75 куб метрээс дээш эзлэхүүнтэй хог хаягдлыг хэлнэ хэмээн тусгасан байдаг. Цаашид сэргээн засварлах, дахин ашиглах дахивар нөөц бэлтгэх боломжтой овор хэмжээ ихтэй хог хаягдлыг цуглуулах тогтолцоог бий болгож засварын газруудыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Хүн төрөлхтөн өдгөө жил бүр 2.12 тэрбум тонн хог хаягдал бий болгож буй бөгөөд харамсалтай нь, бид тэр их хог хаягдлын 80 хувийг байгальд хаяж, дөнгөж 20 хувийг нь дахин боловсруулж буй юм. Дэлхийн банкнаас мэдээлснээр бид энэ асуудлыг шийдэх ямар нэгэн дорвитой арга хэмжээ авахгүй бол 2050 онд гэхэд хог хаягдлын хэмжээ 70 хувиар нэмэгдэх төлөвтэй байна. Уг нь хүн төрөлхтөн байгальд хаяж буй нийт хог хаягдлынхаа 80 хувийг дахин боловсруулах боломж бий. Энэ хүрээнд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудын хүрээнд болон Парисын хэлэлцээрт нэгдсэн улс орон бүр хог хаягдлыг бууруулах, эко орчныг бий болгохыг дэмжих амлалт өгч, дэлхийн өнцөг булан бүрд хаягдлын эсрэг төрөл бүрийн арга хэмжээ авч, аян, кампанит ажил өрнүүлж байна.

Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын эдийн засгийн хөгжлийн чиг хандлага нь эргэлтийн буюу хаягдалгүй эдийн засаг /circular economy/-т шилжихэд онцгойлон анхаарч байна.



Зураг 79. Хог хаягдлыг дахин боловсруулах, эргэлтэд оруулах эдийн засгийн хөгжлийн чиг хандлага

Хаягдалгүй эдийн засгийн үндсэн санаа нь ашиглаж дууссан зүйлсийг дахин боловсруулах, сэргээж ашигласнаар хог хаягдал нь цаашдын үйлдвэрлэлийн орц болдог систем юм. Ингэснээр шинэ ажлын байрууд нэмэгдэн тогтвортой амьжиргааг дэмжиж, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэн, түүхий эд, материал, эрчим хүчний

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

хомстол багассанаар байгаль орчинд учруулах хор хохирлыг төдий хэмжээнд бууруулах боломжтой.

Дархан сумын хувьд одоогийн суурь нөхцөл, нөөцөд тулгуурлан, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин ашиглах, дахин боловсруулах замаар хаягдалгүй эдийн засагт шилжих нь хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол, энергийн зарцуулалтыг бууруулахаас гадна хог хаягдлаас ялгарах нүүрс хүчлийн хий багассанаар Тогтвортой хөгжлийн бодлогод Монгол улсын оруулах хувь нэмрийг дэмжсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч эко хот болох юм.

Дархан сумын хог хаягдлыг дахин боловсруулахад баримтлах стратегийг дэлхий нийтийн өнөөгийн чиг хандлагатай уялдуулан хаягдал багатай арга ажиллагаанд шилжих, орон нутгийн нөөцөд тулгуурласан хүрээлэн буй орчинд ээлтэй мини технологийг нэвтрүүлэх, нутагшуулах, хог хаягдлыг эргүүлэн ашиглах замаар нийгэм, эдийн засаг, байгалийн нөөц, баялгийг хэмнэхэд чиглэгдэнэ.

Хог хаягдлыг дахин боловсруулахад дараах стратегиудыг баримтлан ажиллана.

Хүснэгт 42. Хог хаягдлыг дахин боловсруулахад баримтлах стратеги, хэрэгжүүлэх арга хэмжээ

	Баримтлах стратеги	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Оролцогч тал
1	Дахивар нөөц, дахин ашиглагдах, дахин боловсруулах, сэргээн ашиглагдах хог хаягдлыг бэлтгэн нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах	<ul style="list-style-type: none"> <li>- Дархан-Уул аймгийн хэмжээнд мөрдөх хог хаягдалтай холбоотой харилцааг зохицуулах цогц журам боловсруулах</li> <li>- Хог хаягдлын үнэ тарифыг шинэчлэн тогтоох /Бохирдуулагч төлөх зарчмыг баримтлах/</li> <li>- Урамшууллын бодлого боловсруулах, Хог хаягдлын менежмент, дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарт оролцогч талуудад тохирох урамшууллыг олгох (Хог хаягдлын тухай хуулийн 40.4-ыг баримтлах)</li> <li>- Дахин ашиглагдах болон боловсруулагдах хаягдлын жагсаалт гаргах</li> </ul>	Аймгийн ЗДТГ, бүх шатны засаг дарга нар, ИТХ, холбогдох газар, хэлтсийн дарга нар, судалгааны байгууллага, ТББ болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл
2	Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарт оролцогч талуудын хүний нөөцийг чадавхжуулах	<ul style="list-style-type: none"> <li>- НААҮГ, дахин боловсруулах аж ахуйн нэгжийн ажилтан, ажилчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд зориулсан богино хугацааны сургалтыг шат дараалалтай зохион байгуулах</li> <li>- Үйлдвэр, аж ахуйн нэгжийн захиалгаар инженер, техникийн ажилтнуудыг гадаад, дотоодын байгууллагуудад урт, богино хугацааны туршлага судлах сургалтад хамруулах</li> </ul>	Аймгийн ЗДТГ, НААҮГ, Үйлдвэрлэл, Аж ахуйн нэгжүүд, Их дээд сургууль, хүрээлэн, ТББ
3	Мини болон байгаль орчинд ээлтэй техник, технологийг нутагшуулан хог хаягдлыг дахин боловсруулж эдийн	<ul style="list-style-type: none"> <li>- Хог хаягдлыг дахин боловсруулах инновацийн санал, санаачлалыг дэмжих</li> <li>- Орон нутгийн нөөцөд тохирсон, хүрээлэн буй орчинд ээлтэй мини технологийг нутагшуулан хог хаягдлыг</li> </ul>	Аймгийн ЗДТГ, Хувийн хэвшил, Донор байгууллага, Судалгааны байгууллага, Иргэн, ААН

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

	засгийн эргэлтэд оруулах	<p>дахин боловсруулах үйлдвэрлэлд ашиглах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хуванцар боловсруулах үйлдвэр байгуулах</li> <li>- Органик хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах/ бордоо, яс, саван/</li> <li>- Барилгын хог хаягдал боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах</li> </ul>	
4	Хог хаягдлыг дахин боловсруулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэлийг тогтвортой санхүүжилт, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтаар дэмжлэг үзүүлэх</li> <li>- Тавилга, цахилгаан бараа, гутал хувцас засварын газруудыг чадавхжуулах</li> </ul>	Аймгийн ЗДТГ, Хувийн хэвшил, Донор байгууллага
5	Хяналт, судалгаа шинжилгээ, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Дахин боловсруулсан бүтээгдэхүүний чанар, стандартад хяналт тавин ажиллах</li> <li>- УЦУОШГ, МХЕГ-ын орчны шинжилгээний лабораторийн хүчин чадлыг сайжруулах</li> <li>- Дархан сумын хог хаягдлын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх</li> </ul>	Аймгийн ЗДТГ, МХЕГ, УЦУОШГ



### 3.3.4. Хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийн чиглэл, төлөвлөлт

Дархан Уул аймгийн хэмжээнд жилдээ 47.5 мянган тн хог хаягдал ялгардаг бөгөөд гэр хорооллоос гарч буй хог хаягдлын 80 гаруй хувь, нийт хог хаягдлын 56%-ийг тус тус дахин боловсруулах боломжтой. Дархан-Уул аймагт дахин боловсруулах үйлдвэр барих төсөл хэрэгжсэнээр 2019 оны байдлаар хог хаягдлын төвлөрсөн 1 цэгт 360 тонн хог хаягдал цугларсан бол 2017 оны байдлаар зориулалтын бус газарт хаягдсан 5671м үерийн далан, 11000 м2 эзэнгүй талбайн хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулна.

Арьс шир боловсруулах үйлдвэрээс хаягдаж байгаа идээлсэн зах, өөдөс, халим, хуулдас, зоргодос мэтийн хатуу хаягдал гарч байна. Энэ хаягдлын агууламжийн 30 орчим хувь нь коллагены уураг байдаг гэсэн судалгаа бий. Коллагены уургаар тэжээл, цавуу, бордоо, техникийн желатин, биотехнологиор хиамны хальс, уургийн гидролизат, дүүргэгч, арьс ширний тос, нанотехнологийн хүрээнд хүнсний нэмэлт тэжээл, эм бэлдмэл, гоо сайхны бүтээгдэхүүн, хиймэл эрхтэн үйлдвэрлэх боломжтой байдаг байна.

Дархан сумын хог хаягдлын хэмжээ, төрөлд үндэслэн дахин боловсруулах дараах үйлдвэрүүдийг байгуулах боломжтой байна. Үүнд:

Органик хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр:

- Компост бордооны үйлдвэр
- Яс боловсруулах үйлдвэр

Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр:

- Бортогын үйлдвэр
- Хогийн уутны үйлдвэр

Барилгын хог хаягдал дахин боловсруулах чиглэлээр:

- Үнс бэлтгэх цех
- Механик дайрга, элс бэлтгэх цех
- Бетон эдлэл үйлдвэрлэх цех
- Хуурай хольц үйлдвэрлэх цех

### 3.4. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХОГ ХАЯГДАЛ БОЛОН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛЖ, БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ АРГААР ЗАЙЛУУЛАХ ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХ

#### 3.4.1. Үйлдвэрийн болон аюултай хог хаягдлыг татан зайлуулах тогтолцоо

Аюултай хог хаягдлыг хүлээн авах, түүнтэй харьцах, урьдчилан боловсруулах ажиллагаанд хүлээн авч буй хаягдлын /ихэнхдээ бүтэц нь тодорхойгүй/ аюултай шинж чанараас шалтгаалж ахуйн болон үйлдвэрийн хатуу хог хаягдалд тавигддаг шаардлагаас илүү өндөр шаардлага тавигддаг. Тухайн хаягдлыг үүсгэсэн үүсгэгч нь аюултай хог хаягдлыг гарал үүсэл, холбогдох код, тайлбар, ямар аюултай материал агуулж буй мэдээлэл зэргийг багтаасан дагалдах бичиг баримтыг үйлдсэн байх шаардлагатай. Тээвэрлэлтийн үед гадагш алдагдах, нэвчих, уурших, урвалд орохоос сэргийлэх зорилгоор савлагаа, баглаа боодлыг зохих ёсоор хийсэн байх шаардлагатай.

Аюултай хог хаягдлыг зохих ёсоор нь ангилан ялгах шаардлагатай ба энэ нь хаягдлын аюултай шинжийг бууруулж өгдөг. Химийн найрлагын хувьд хоорондоо нийлэмжгүй материалуудыг ангилан ялгах шаардлагатай.

Аюултай хог хаягдлыг хүлээн авахдаа дараах аргачлалаар шалгах ба тодорхой нарийн зохицуулалтын журам шаардлагатай.

Үүнд:


- нүдээр үзлэг хийх
- дээж авах, шинжлэх
- торхтой хаягдлуудаас сонгож шалгах
- баглаа боодолтой ирсэн хаягдлуудаас задалж шалгах
- шаталтын параметруудийг тогтоох
- хаягдлын бүтцийг рентгенээр шалгах гэх мэт.

Аюултай хог хаягдлын төлбөрийг тооцох тухай 2006 онд гарсан аргачлалд бохирдуулагч нь төлөх зарчмыг баримтлах, улмаар аюултай хог хаягдлыг ердийн хог хаягдлаас ангилан ялгах, хог хаягдлын үүсгүүрийг бүртгэж байхыг зааж өгсөн.

Дархан сумын аж ахуйн нэгж, сургууль, эмнэлгийн байгууллагаас үүсч буй химийн бодис, түүнийг хадгалах, тээвэрлэх савны хаягдал, авто тээврийн хэрэгслээс үүсч буй хог хаягдал, цахилгаан хэрэгсэл болон ахуйн хэрэглээний батарейн хаягдал, эмнэлгийн хаягдал зэрэг хог хаягдлуудыг тусгайлан боловсруулах бага оврын цех, үйлдвэрүүдийг төслөн аймаг орон нутгийн эрх зүй, эдийн засгийн дэмжлэгээр үүсгэн байгуулах, үйл ажиллагааг нь тогтворжуулах шаардлагатай гэж үзэж байна.

Дархан сумд үүсч байгаа аюултай хог хаягдлын гол эх үүсвэр болох эмнэлэг, тээврийн хэрэгсэл, ахуйн хуурай батарей, үйлдвэр, лабораторийн үйл ажиллагаанаас үүсэлтэй химийн бодис агуулсан хаягдлуудыг татан зайлуулах менежментийн ерөнхий схемийг зургаар харуулав.

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ




Зураг 80. Аюултай хог хаягдлыг татан зайлуулах схем

Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулахын тулд үйлдвэр, ААНБ-ын аюултай хог хаягдлыг тодорхойлох, хэрхэн хадгалж боловсруулах, зайлуулах, устгах талаарх аргачлалыг нэвтрүүлэх хэрэгтэй байна. Мөн үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зарим аюултай хог хаягдлын дундын боловсруулалтын жижиг үйлдвэрүүдийг байгуулах шаардлагатай юм.

### 3.4.1.1. Эмнэлгийн хог хаягдал

Эрүүл мэндийн байгууллагаас үүссэн хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх үйл ажиллагаанд доорх схемд үзүүлсэн зарчмыг баримтална. 2020 оны байдлаар Дархан сумд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй ЭМБ-ийн тоо 120 байна. Эдгээр байгууллагууд өөрийн үйл ажиллагаанаас үүсч буй аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгахдаа ЭМ-ийн сайдын А/505 тоот тушаалыг баримтлан ажиллана. Энэхүү тушаалын дагуу эмнэлгийн аюултай хог хаягдлыг байгууллага бүр эх үүсвэр дээр нь ангилж, зориулалтын тэмдэг, тэмдэглэгээ бүхий уут, саванд хийн хаягласан байна. Эмнэлгийн хог хаягдалыг цуглуулах, ариутгах, устгах цехийн технологи нь дээр дурдагдсан “Элемент” ХХК жишиг технологи дээр суурилсан тээвэрлэлт, ариутгал, устгал, ландфилл гэсэн шат дамжлагатай байх ба эмнэлгийн хаягдал устгах бага хүчин чадалтай цехэд шаардлагатай тоног төхөөрөмж, машин техникийн жагсаалтыг хавсралтаар харуулсан болно. ЭМБ-ын аюултай хог хаягдлын эх үүсвэрийг хэрхэн ангилах, цуглуулах, тээвэрлэх, устгах талаарх схемийг зургаар харуулав. ЭМБ-аас гарч буй аюултай хог хаягдлын бүртгэлийг хог хаягдал хариуцсан мэргэжилтэн өдөр бүр бүртгэл хөтөлж, мэдээг холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэх болон мэдээллийн баазад тогтмол оруулж байна.

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ





Зураг 81. Эмнэлгийн аюултай хог хаягдлыг татан зайлуулах схем

Дархан сумд үүсэж буй эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах, устгах технологийг Элемент ХХК-ийн жишгээр хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ариутган халдваргүйжүүлэх, бутлах ба ландфиллийн булшлах технологиудын дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

Хүснэгт 43. Эмнэлгийн хог хаягдлыг устгах шат дамжлага, шаардлага

№	Шат дамжлага	Шаардлага
1	<p>Хог хаягдлыг цуглуулах</p> <p>Түр хадгалах байранд гадны хун орохыг хориглоно Халдвартай болон хурц үзүүртэй, иртэй хог хаягдлын био аюулгүйн таних тэмдэг Химийн бодис болон эмийн хог хаягдлын таних тэмдэг</p> <p>Зураг 1. Түр хадгалах байрны гадна талын таних тэмдэг</p>	<p>Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын тухай асуудлыг Эрүүл мэндийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2002 оны 249/201 тоот тушаалын хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 05 сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтад тусгагдсаны дагуу эмнэлгийн болон эрүүл мэндийн байгууллагын оношлогоо, эмчилгээ, үйлчилгээний явцад үүсэх хүн, амьтны бие, эрхтэн, эд, хэсэг, бичил биетийн өсгөвөр, цус бусад шингэн, ялгадас, эм эмийн бүтээгдэхүүн, био бэлдмэл, зүү тариур, хурц үзүүртэй, иртэй багаж хэрэгсэл, химийн болон цацраг идэвхт бодис зэрэг хаягдлыг үүссэн газарт нь тусгай зориулалтын био-аюулгүйн таних тэмдэг бүхий таних тэмдэгтэй уут, хогийн саванд хийж түр хадгалах байр эсвэл цэгт байршуулах.</p>
		<p>Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зориулалтын бат бэх, амархан цоорохооргүй, нүх</p>

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

<p>2</p>	<p>Тээвэрлэх</p>  <p>Аюултай хог хаягдал тээвэрлэх</p> 	<p>сүвгүй, шингэн нэвчихгүй, таглаатай хуванцар саванд хийж, замын хөдөлгөөнд оролцох шаардлага бүрэн хангасан, тусгай таних тэмдэгтэй, битүүмжлэгдсэн, тусгайлан тоноглогдсон авто машинаар өвлийн улиралд 72 цаг, дулааны улиралд 48 цагын дотор тээвэрлэнэ.</p> <p>Хог хаягдлын тээвэрлэх тээврийн хэрэгсэл дараах шаардлагыг хангасан байна</p> <ul style="list-style-type: none"> <li>- Жолоочийн кабин болон ачааны хэсэг хоорондоо тусгаарлагдсан байх</li> <li>- Машины дотор тал нь цэвэрлэж халдваргүйжүүлэх боломжтой байх</li> <li>- Стандартын шаардлага хангасан хувийн хамгаалах хэрэгсэлтэй байх</li> <li>- Шингэн зүйлс гоожиход авах арга хэмжээний заавар, цэвэрлэх хэрэгсэл, халдваргүйжүүлэгч бодис, хоосон нийлэг уут, бээлий, амны хаалт, шингээгч алчуур, хүрз зэрэг цэвэрлэгээний багажтай байх,</li> <li>- Хор саармагжуулах бодис, уусмал зэрэг байх</li> <li>- Тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх, хор уршгийг арилгах зориулалтын багаж, гал түймэр унтраах хэрэгсэл /галын хор, хүрз, шуудайтай элс, хувин г.м/</li> <li>- Яаралтай тохиолдолд хэрэглэх засварын хэрэгсэл</li> <li>- Машины хүндийн жин, дугуйны хэмжээнд тохирсон зогсоогч (механик тоормос)</li> <li>- Цахилгаанаас хамааралгүй асдаг 2 ширхэг шар гэрэл зэрэг болно.</li> </ul>
<p>3</p>	<p>Аюултай хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэх</p> 	<p>Эмнэлгийн аюултай хог хаягдлыг өндөр даралтад уур үүсгэгч Автоклавт халдваргүйжүүлнэ. Хог хаягдлын уут, савны бүрэн бүтэн байдлыг сайтар шалгаж автоклавын дотор хананд ямар нэгэн эд зүйлийг тулган тавихгүйгээр уут савтай хог хаягдлыг сийрэг байрлуулна. Овор ихтэй, хүнд жинтэй хог хаягдлыг доод хэсэгт байрлуулна. Автоклавт хог хаягдал материалын төрөл, хэмжээ зэргээс хамааран халдваргүйжүүлэх хугацаа, халууны хэм өөр өөр байна. Аюултай хог хаягдлыг автоклавт 121°С-ын хэмд 20 минут, 134°С-ын хэмд 10 минутын хугацаанд халдваргүйжүүлнэ. Автоклавын халдваргүйжүүлэлтийн чанарыг өндөр даралтат уурын өнгөний хувиралтай туузан индикатороор хяналт тавина.</p>
<p>4</p>	<p>Шатаах</p>	<p>Биологийн гаралтай эмгэг хог хаягдлыг өндөр температурт бүрэн устгалд оруулж ариутгана.</p>



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ


		<p>Шатаалтаас ялгарах утаа хийнд тавигдах стандартыг баримтална.</p> <p>Шатаах зуух 900-1100<sup>0</sup>С-д биологийн гаралтай хог хаягдлыг шатаах хүчин чадалтай. Нэмэлт үлээх болон сорох сэнстэй, температур ихэсгэх, утааг дахин шатаах зориулалтын 4 дезил буутай.</p>
5	<p>Бутлах</p> 	<p>Автоклавт ариутган халдваргүйжүүлсэн болон бусад хог хаягдлын овор хэмжээ, байгальд хурдан задрах процессыг нэмэгдүүлэх, эрсдэлийг багасгах зорилгоор буталж жижиглэн, тусгай бэлдсэн олон улсын стандарт шаардлагад нийцсэн, холбогдох хууль, журмын дагуу батлагдсан булаж устгахад зориулан бэлтгэсэн талбай зөөхөд бэлтгэнэ. Тус үйлдвэрийн хог хаягдлын бутлан жижиглэх зориулалттай бутлагч төхөөрөмж нь цагт 250кг, өдөрт 1.5-3тонн хог хаягдлыг бутлах хүчин чадалтай.</p>
6	<p>Ландфилл булшлах</p> 	<p>Эмнэлгийн хог хаягдлыг инженерийн орчин үеийн шийдлээр, олон улсын стандартын дагуу байгаль орчин болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй технологиор төлөвлөгөөт менежментийн дагуу хүч, техник тоног төхөөрөмж ашиглан газрын хөрсөнд булшлан устгаж, тухайн газрыг дахин ашиглах хүртэл авч хэрэгжүүлж буй инженерчлэлийн цогц байгууламжид булна.</p>

### 3.4.1.2. Тээврийн хэрэгслийн хог хаягдал

Манай улсад тээврийн хэрэгслээс хаягдаж байгаа аюултай хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй цөөхөн үйлдвэр байна. Үүнээс "Алтан оршихуй", "Хайби ойл" гэсэн хоёр компани нь ажилласан тос маслыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах үйл ажиллагаа явуулдаг. Байгальд ээлтэй, хаягдал гаргадаггүй технологиор үйл ажиллагаагаа явуулдаг "Хайби ойл" компани сард 1400 тонн орчим ажилласан тос дахин боловсруулж мазут үйлдвэрлэдэг бол, "Алтан оршихуй" компани нь хоногт 3-4 тонн дизель түлш, сард 30 тонн мазут үйлдвэрлэдэг байна. Ус холиогүй цэвэр ажилласан тос литрийг нь тодорхой үнээр худалдан авч түүхий эдийн нөөцөө бүрдүүлдэг байна. Мөн "Иннахис" компани суудлын автомашины хаягдал дугуйг дахин боловсруулж, резинэн хавтан үйлдвэрлэдэг. Харин хүнд даацын тээврийн хэрэгслийн дугуй, автомашины салон буюу хатуу хуванцар болон аккумулятор дахин боловсруулах үйлдвэр ховор байна. Аюултай хог хаягдлын тоонд орохгүй буюу автомашинаас гарах төмрийг боловсруулах үйлдвэр гурав, хөнгөн цагаан, хайлш зэргийг дахин боловсруулах үйлдвэр 10 орчим байдаг аж. Гэвч эдгээр үйлдвэрийн хүчин чадал нь автомашинаас жилд гарч буй нийт хаягдлын 30 хувийг ч дахин боловсруулахад хүрэлцдэггүй тул цаашид Дархан-Уул аймагт энэ чиглэлийн дахин боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах нь ач холбогдолтой байна. Дархан сумд тээврийн хэрэгслээс үүсч байгаа голлох аюултай хог хаягдал нь хэрэглэсэн хаягдал тос, аккумулятор, дугуй байна. Эдгээр хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, байгаль орчинд үзүүлж буй аюулын хэмжээг бууруулахын тулд хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгүүдийг байгуулж

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

цуглуулан, хуульд заасны дагуу аюулгүй хадгална. Дахин боловсруулах боломжтой аюултай хаягдлыг УБ хотын боловсруулах үйлдвэр рүү тусгай зөвшөөрөл бүхий ААНБ тээвэрлэнэ. Цуглуулсан болон тээвэрлэсэн аюултай хог хаягдлын мэдээллийг хөтөлж холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэх болон мэдээллийн санд тогтмол оруулж байна. Дахин боловсруулах боломжгүй аюултай хаягдлыг хуульд заасны дагуу зориулалтын газар, ландфиллд устгана.



Зураг 82. Тээврийн хэрэгслээс үүсэх аюултай хог хаягдлыг татан зайлуулах схем

Дархан-Уул аймгийн хэмжээнд тээврийн хэрэгслээс хаягдаж буй аюултай хаягдлын хэмжээ тодорхойгүй, хадгалах нэгдсэн цэг байхгүй, дахин боловсруулах үйлдвэр одоогоор байхгүй байна. Иймд тээврийн хэрэгслээс хаягдаж буй аюултай хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үүнд:


- Тээврийн хэрэгслээс хаягдах аюултай хаягдлыг ангилах, цуглуулах менежментийг хэрэгжүүлэх
  - Үүсвэр дээр нь ангилан ялгах
  - Үүсвэр дээр түр хадгалах
  - Хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгүүдээр дамжуулан цуглуулах
- Хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгүүдэд хадгалалт, тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны менежментийг хэрэгжүүлэх
  - Тээврийн хэрэгслийн хаягдлыг ангилан, төрөлжүүлэх
  - Хаягдал тос, аккумуляторыг тусгайлан зассан байгууламж болон талбайд түр хадгалж хөрсөнд нэвчихээс болгоомжлох
  - Цуглуулах, түр хадгалах, тээвэрлэхэд аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг баримтлах
  - Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэх

- Цуглуулсан болон дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлсэн хаягдлын талаар бүртгэл хөтөлж, холбогдох мэргэжлийн газарт мэдээлж байх
- Дархан-Уул аймгийн хэмжээнд тээврийн хэрэгслийн хаягдлыг боловсруулах байгальд ээлтэй дэвшилтэт технологийг нэвтрүүлэх

### 3.4.1.3. Хуурай зайн хаягдал

Манай оронд хамгийн түгээмэл хэрэглэгддэгт никель кадми (NiCd), никель металлын холимог (NiMH) никель цинк (NiZn), литиум ион (Li-ion), мөнгөн ус (Mercury), шүлтэн (Alkaline) батарей зайнууд өргөн хэрэглэж байна. Дархан-Уул аймагт үүсэж буй ахуйн болон автоматын хуурай зайг цуглуулах, аюулгүй хадгалах, тээвэрлэх, боловсруулах менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Аюултай хуурай зайг ахуйн хогоос ялгах менежментийг хэрэгжүүлэх,
  - Үүсвэр дээр нь ангилан ялгах
  - Үүсвэр дээр түр хадгалах
  - Хуурай зай борлуулагчаар дамжуулан цуглуулах, үйлчилгээ үзүүлэх,
- Борлуулагч дээр төвлөрсөн хуурай зайн хадгалалтын журам, менежментийг боловсруулах
  - Борлуулагч хэрэглэгчээс хаягдал хуурай зай цуглуулах менежментийг хэрэгжүүлэх
  - Хаягдал зайг ангилан ялган цуглуулах, түр хадгалах
  - Хаягдал зайг боловсруулах, хадгалах нэгдсэн цэгт хүргэх
- Хаягдал зайг Дархан-Уул аймагт ангилал, төрлөөр цуглуулах, хадгалах, боловсруулах журам, дүрмийг боловсруулах, хэрэгжүүлэх
  - Борлуулалтын цэгээс хаягдал хуурай зайг ангиллаар хүлээн авах, төрөлжүүлэн хадгалах
  - Хураан төвлөрүүлсэн хаягдал зайг хадгалах аюулгүй ажиллагааны дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэх
  - Хаягдал зайг боловсруулах байгальд хоргүй технологийг нэвтрүүлэх
  - Хураан төвлөрсөн хаягдал зайг боловсруулах туршилт, судалгааны ажлыг бодлогоор дэмжих



Зураг 83. Хаягдал зай цуглуулах, хадгалах схем

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 44. Нэг удаагийн хэрэглээний зайн төрөл, хадгалалт

Төрөл	Хэрэглээ ба тодорхойлолт	Хадгалалт
<p>Алкалин болон Цайрын карбидын зай</p> 	<p>Өдөр тутмын хэрэглээний ТВ удирдлага, цаг зэрэг өргөн хэрэглээнд зориулагдсан 9 Volt, AA, AAA, C, D төрлийн алкалин болон цайрын карбидын зай.</p>	<p>Гэрийн нөхцөлд энгийн зориулалттай хогийн саванд цуглуулан хатуу хаягдал боловсруулах газар луу илгээж дахин ашигладаг.</p>
<p>Дугуй зай</p> 	<p>Энэ төрлийн жижиг дугуй зай мөнгө, кадми, мөнгөн ус болон бусад төрлийн хүнд металлуудыг агуулдаг. Сүүлийн үед энэ төрлийн зайг литийн металаар сольсноор, машины түлхүүр, тооны машин, цаг, эмнэлгийн багаж, сонсголын аппарат зэрэг өргөн хэрэглээнд ашиглаж байна</p>	<p>Дугуй жижиг зай нь маш их аюулыг дагуулдаг ба бага насны хүүхдүүдэд хөнөөл ихтэйд тооцогддог. - Дугуй батареийг тусгай боловсруулах тусгай химийн менежмент дээр суурилан боловсруулдаг ба боловсруулагч газрын буцаан авах үйлчилгээ болон орон нутагт боловсруулах төвтэй байх шаардлага тавигддаг. - Түр хадгалалтыг хуванцар уут болон цахилгаан тусгаарлагч саванд хадгалдаг.</p>
<p>Нэг удаагийн лити зай</p> 	<p>Энгийн хэрэглээний нэг удаагийн зай (Li) нь камер, утаа мэдрэгч, удирдлага, цахилгаан тоглоом зэрэгт өргөн хэрэглэдэг.</p>	<p>- Түр хадгалалтыг хуванцар уут болон цахилгаан тусгаарлагч саванд хадгалдаг.</p>


Хүснэгт 45. Цэнэглэдэг зайн төрөл, хадгалалт

Төрөл	Хэрэглээ ба тодорхойлолт	Хадгалалт
<p>Никель-Кадмийн зай (Ni-Cd)</p>	<p>Энэ төрлийн зайнууд голдуу утасгүй төхөөрөмжид хэрэглэгддэг, Жнь: утас, дижитал камер, биохимийн төхөөрөмж болон видео камерт хэрэглэгддэг.</p>	<p>Салдаг зайг тусгай боловсруулах тусгай химийн менежмент дээр суурилан боловсруулдаг ба боловсруулагч газрын буцаан авах үйлчилгээ болон орон нутагт боловсруулах төвтэй байх шаардлага тавигддаг. Үйлдвэрлэгч байгууллага буцаан цуглуулах менежментийг хийдэг.</p>
<p>Литийн ион зай (Li-ion)</p>	<p>Хуучны утас, цахилгаан төхөөрөмж, дижитал камер, нотебүүк, хүүхдийн тоглоом, цахилгаан тамхи, таблет, e уншлагын төхөөрөмж зэрэгт ашиглаж байна.</p>	<p>Салдаг зайг тусгай боловсруулах тусгай химийн менежмент дээр суурилан боловсруулдаг ба боловсруулагч газрын буцаан авах үйлчилгээ болон орон нутагт боловсруулах төвтэй байх шаардлага тавигддаг. Үйлдвэрлэгч байгууллага буцаан цуглуулах менежментийг хийдэг.</p>

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

	<p>Зарим төрлийн литийн батарейг багажаас салгах боломжгүй хийснээс тэдгээр багаж нь шууд хор хөнөөлтэй хаягдалд тооцогддог.</p>	<p>Салдаггүй зайг тусгай боловсруулах хөтөлбөрөөр цахилгаан эдлэлийн хаягдал боловсруулах газарт боловсруулдаг ба эсвэл орон нутгийн аюултай хог хаягдал цуглуулах төвд өгч хадгалуулдаг.</p>
<p>Никель металл гидридний зай (Ni-MH)</p> 	<p>Гар утас, утасгүй цахилгаан төхөөрөмж, дижитал камер зэрэгт хэрэглэгддэг. Энэ төрлийн зай нь нэг удаагийн хэрэглээнд зориулагдсан байдаг.</p>	<p>Түр хадгалалтыг хуванцар уут болон цахилгаан тусгаарлагч саванд хадгалан зайн цуглуулах цэгт хуримтлуулна.</p>
<p>Никель-цайрын зай (Ni-Zn)</p>	<p>Энгийн хэрэглээний дижитал камер, виарласс хавтан, жижиг электроник төхөөрөмжүүдэд хэрэглэгдэн.</p>	
<p>Жижиг хар тугалгын батарей</p>	<p>Хөдөлгөөнт скүүтер, хүүхдийн машин, дохионы гэрэл, эмнэлгийн төхөөрөмж болон түүнчлэн компьютерын зай нөөцлүүр зэрэгт ашиглагддаг.</p>	

Хүснэгт 46. Автоматын зайн төрөл, хадгалалт

Төрөл	Хэрэглээ ба тодорхойлолт	Хадгалалт
<p>Дунд болон том хэмжээний Лити-ион зай</p> 	<p>Ихэнх цахилгаан машин болон цахилгаан хөдөлгүүрийг ажиллуулахад энэ төрлийн зайг ашиглаж байна. Тэрчлэн цахилгаан байшингийн энергийн үүсгэвэр болгон өргөн ашиглаж байна.</p>	<p>Дунд болон том хэмжээний Лити-ион зайг хэрэглэгч хүргэж өгөх, төвлөрсөн цэгт хаях том овор хэмжээ, хүнд зэрэг шалтгаанаас үүдэн хүндрэлтэй байдаг тул үйлдвэрлэгчийн зүгээс буцаан цуглуулах үйлчилгээг хийнэ. Борлуулагчаар дамжуулан татан авалтын ажлыг хийнэ.</p>




## 3.4.1.4. Химийн бодисын хаягдал

Дархан сумын хэмжээнд хугацаа нь дууссан, ашиглалтын шаардлага хангахгүй химийн бодис болон аюултай хог хаягдлын асуудал нь хамгийн тулгамдаж буй асуудлын нэг юм. Химийн бодисын хаягдал нь Үйлдвэр, ААНБ, сургалт, судалгаа, шинжилгээний лабораториуд, эмнэлгээс ихэвчлэн үүсч тэдгээрийг саармагжуулах, устгал хийх боломжгүй байна. Иймд Дархан сумд эх үүсвэр дээр хадгалагдаж байгаа устгалд орох химийн бодис, тэдгээрийн хаягдлыг зориулалтын түр хадгалах байр байгуулж цуглуулах шаардлагатай. Цуглуулсан химийн бодисын хаягдал, үлдэгдэл болон сав баглаа боодлыг хуульд заасны дагуу УБ хотод байгаа дахин боловсруулах, устгах зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж, байгууллагад хүлээлгэн өгнө.

Мөн химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг байгаль орчин, эрүүл ахуй болон гамшгаас урьдчилан сэргийлэх улсын байцаагч нарыг байлцуулж зориулалтын ландфиллын цэгт устгана.

Химийн бодисын хаягдал устгах цэг талбайн байршлыг тухайн орон нутгийн хөгжлийн хэтийн төлөв, төв суурин газрын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан нутаг дэвсгэрийн суурь нөхцөл байдлыг үндэслэн тогтоох ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байна. Химийн бодис түр хадгалах цэгт хүлээн авсан бодис, хаягдлын тоо хэмжээг тогтмол бүртгэж холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэх болон мэдээллийн санд тогтмол оруулж байна.



Зураг 84. Химийн бодисын хог хаягдлыг татан зайлуулах схем

Дархан сумын хэмжээнд аж ахуйн нэгж байгууллага, сургууль, эмнэлэг, шинжилгээний лабораториудад хадгалагдаж байгаа устгах шаардлагатай химийн бодисуудыг байгаль орчинд халгүйгээр аюулгүй цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Химийн бодисын хаягдал хадгалж байгаа эх үүсвэр дээр хэрэгжүүлэх
  - o Хадгалагдаж байгаа химийн бодисуудын хаягдлын мэдээг жил бүр холбогдох мэргэжлийн газарт гаргаж, хянуулдаг байх

- Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журамд заасан шаардлагуудыг биелүүлэх
- Химийн бодисын асгаралтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах хяналтыг тогтмол тавих
- Химийн бодис агуулсан бүтээгдэхүүнийг ил хаях, санамсаргүй алдагдах эрсдэлд хяналт тавих
- Химийн бодисын ашиглалт, хадгалалтын тайланг жил бүр гаргаж мэдээллийн сан бүрдүүлэх
- Дархан-Уул аймагт химийн бодисын хаягдлын талаар хэрэгжүүлэх
  - Аймгийн хэмжээнд аюултай хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах агуулах байгуулах
  - Агуулахын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хянах
  - Химийн бодисын сав баглаа, боодол зэргийг химийн материал дахин боловсруулдаг үйлдвэрт /Цэцүүх ХК-д/ хүргэх
  - ХАА-д хэрэглэгдэж байгаа пестицидийн мэдээлэл, хаягдлын талаар бүртгэлтэй болох
  - Химийн бодисын хаягдлыг боловсруулах, задлах, физик химийн дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх ажлыг дэмжих
  - Аюултай хог хаягдлыг устгах тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагуудыг бий болгох
  - Аюултай хог хаягдлыг устгах зориулалтын ландфиллын цэгтэй болох
  - Химийн бодисын ашиглалт, хаягдлын талаарх мэдээллийн системийг ажлуулж, хяналт тавих


### 3.4.1.5. Үйлдвэрийн хог хаягдал

Үйлдвэрийн хог хаягдлыг аюултай болон аюултай бус /энгийн/ гэж ангилдаг. Арьс шир, ноос, ноолуур, мах, сүүний гээд бараг бүх үйлдвэр олон төрлийн химийн бодис, будаг, ариутгалын бодис ашигладаг. Технологийн дамжлагаас нь ч олон төрлийн хаягдал үүсдэг. Иймд ямар төрлийн хог хаягдал гаргаж байна гэдгээ эхлээд тогтоох нь тухайн үйлдвэрийн хог хаягдлын менежментийн чухал асуудал байдаг. Дархан сумд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрийн газруудын хог хаягдлын (ангилах, цуглуулах, тээвэрлэх, ашиглах, устгах) менежментийн ерөнхий схемийг зургаар харуулав. Үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүд эх үүсвэр дээр нь хог хаягдлаа ангилж энгийн болон аюултай хаягдлыг холилтгүйгээр цуглуулна. Ангилж цуглуулсан энгийн хаягдлыг дахивар авах цэгүүдэд, боловсруулах боломжгүй хаягдлыг НААҮГ-тай хийсэн гэрээний дагуу ландфилл рүү зөөвөрлөнө. Үүсч буй аюултай хог хаягдлыг дахин боловсруулах боломжтой бол хуульд заасны дагуу зориулалтын зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид хүргэнэ. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд үйл ажиллагааны явцад үүсч байгаа завсрын болон эцсийн бүтээгдэхүүний хаягдлыг химийн аргаар саармагжуулах, дахин ашиглах технологиудыг нэвтрүүлж ашиглах боломжгүй хаягдлыг зориулалтын ландфилл цэгт хүлээлгэж өгнө. Энэ нь аюултай хог хаягдал үүсгэгчийн хувьд та хог хаягдлыг бий болгосон цагаас нь эхлэн зохих ёсоор боловсруулж, тээвэрлэх, устгах, эсвэл булшлах хүртэл хууль ёсны болон санхүүгийн хувьд хариуцлага хүлээнэ гэсэн үг юм. Үйлдвэрийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн хаягдлыг ангилал бүрээр бүртгэж холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэх болон мэдээллийн санд тогтмол оруулж байна.

- Үйлдвэрийн газрууд дээр хэрэгжүүлэх
  - Хог хаягдлаа ангилан ялгадаг байх

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Хог хаягдлын талаарх мэдээг (аюултай, аюулгүй) журамд заасны дагуу холбогдох мэргэжлийн газарт гаргаж, хянуулдаг байх
- НААҮГ-тай гэрээ байгуулж, хог хаягдлаа татан зайлуулдаг байх
- Хог хаягдал хариуцсан мэргэжилтэнтэй байх
- Үйл ажиллагааны явцад үүсч буй бүтээгдэхүүний хаягдлыг саармагжуулах, байгальд ээлтэй аргуудыг нэвтрүүлэх
- Хаягдлаа дахин ашиглах, дахин боловсруулах тал дээр бодлого боловсруулж ажиллах
- Үйлдвэрийн хогийн цэгт хаягдлаа ил задгай хаяхгүй байх
- Дархан-Уул аймагт үйлдвэрийн хаягдлын талаар хэрэгжүүлэх
  - Үйлдвэрийн хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах талын дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх ажлыг дэмжих
  - Аюултай хог хаягдал үүсгэдэг үйлдвэрүүдийн хаягдалд хяналт тавих
  - Үйлдвэрийн хэсэгт байгаа хогийн цэгийг хаах




Зураг 85. Үйлдвэрийн хог хаягдлыг татан зайлуулах схем

Дархан Нэхий ХК нь боловсруулах үйлдвэрээс гарах хаягдлыг дахин боловсруулах эдийн засгийн эргэлтэд оруулах тал дээр бодлого боловсруулж ажиллаж байгаа тул гол хаягдал болох бараат хогийн цэгт хаягдаж байгаа арьсны шар махны хаягдлыг боловсруулах талын судалгааг цаашид хийх шаардлагатай байна.

## 3.4.2. Барилгын хог хаягдлыг татан зайлуулах тогтолцоо

Дархан сумын барилгын хог хаягдлыг татан зайлуулах нэгдсэн тогтолцоог дараах байдлаар төлөвлөж байна.



Зураг 86. Барилгын хаягдлын схем

Барилгын хог хаягдлын үнэ тарифийг нарийвчлан тогтоож иргэд, ААН дуудлага өгч татан зайлуулалт хийгддэг системийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### 3.5. БУЛАЖ ЗАЙЛУУЛАХ ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭГ БУУРУУЛАХ, ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГИЙГ БАЙГАЛЬ ОРЧИНД ХАЛГҮЙГЭЭР ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ, ТЕХНИК ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ

#### 3.5.1. Бараат төвлөрсөн хогийн цэгийн дахин төлөвлөлт

Инженерчлэгдсэн орчин үеийн ландфиллийн цэгүүдийг зохион байгуулалт муутай ил задгай хог хаях цэгүүдтэй харьцуулахад хий болон шүлтийг хурааж авдаг, дахин ашиглах, дахин боловсруулж ашиглах боломжийг бүрдүүлдэг тул ил шаталтаас хамаагүй давуу талтай сонголт юм. “Хог хаягдлын тухай хуулийн 3.1.5-д “ландфиллийн арга” гэж байгаль орчинд нөлөөгүйгээр хог хаягдлыг хөрсөөр дарж устгах үйл ажиллагааг хэлнэ гэжээ . Харин олон улсад ландфилл нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр тусгай төхөөрөмжөөр төхөөрөмжлөн зохион байгуулсан талбайд дахин боловсруулж ашиглах боломжгүй хог хаягдлыг хүлээн авах, зөөх, хаях, ариутгах ажиллагааны цогц юм гэж тодорхойлжээ.

Бараат хогийн цэгийн шатсан хог хаягдлыг янзлах, булахын өмнө бүрэн унтраасан байх шаардлагатай. Үүнийг хийхгүй бол томоохон талбайг хамарсан хяналтгүй гал асах эсвэл уугилт үргэлжлэх боломжийг бий болгоно. Орчин үеийн ангилагдаж тусгаарлагдсан ландфиллийн цэгт тус газрын зөвхөн чийгшлийн агуулгыг бууруулах төдийгүй бас гэнэтийн гал гарахаас сэргийлэх зорилгоор өдөр бүр хог хаягдлыг шороо буюу шавраар бүрхэж, дарж байдаг.

2021 оны 02-р сарын 18-нд ДУА-ийн хот байгуулалт, дэд бүтцийн бодлогын асуудал хариуцсан хотын захирагчийн орлогч Б.Батболд, ДУА-ийн захирагчийн албаны дарга Э.Равжаадэлгэрэх нарын удирдлага дор хуучин хур хог хаягдлыг 2м зузаантай хөрсөөр дарж, урд жалганд булшлах, газрыг эрүүлжүүлэх ажлыг Гео Од ХХК зураг төслийг хийж, доорх зурагт үзүүлснээр газар шорооны ажил хийгдсэн.


**Талбай №1.** Бульдозероор түрэх талбай нь 6.0га дундаж өндөр нь  $h=2.5$ м-р бодоход эзлэхүүн нь  $150906\text{м}^3$  хог тархсан байна. Уг хогийг урд жалганд түрж дээр нь 2м зузаантай  $55302\text{м}^3$  хөрс /шороо/-р булсан.

**Талбай №2.** Өмнө нь жалганд хийгдсэн 1.4га талбайг 2м зузаантай хөрс шороогоор хучихад  $29768\text{м}^3$  газар шорооны ажил хийгдсэн.

**Талбай №3.** Бульдозероор 1.6га түрэх ба дундаж өндөр нь  $h=2.5$ м-ээр тооцоход эзлэхүүн нь  $32256\text{м}^3$  хог тархсан байна. Уг хогийг урд жалга руу түрж дээр нь 2м зузаантай  $8229\text{м}^3$  хөрс /шороо/-р булсан.

**Талбай №4.** Талбай 1,2,3,4 нийлээд нийт  $183162\text{м}^3$  хогийг жалга руу түрж  $933690\text{м}^3$  газар шорооны хучилтын ажил хийсэн.





Зураг 87. Хог түрэх чиглэлийн зураг

Техникийн нөхөн сэргээлт буюу газар шороог түрж тэгшлэх үйл ажиллагаа дууссаны газар ашиглалтын төлөвлөлт болон нөхөн сэргээлтийн ажил хийгдэнэ. Одоогийн Бараат хогийн цэгийн талбай нь зураг төслийн дагуу 14 га талбайг хөрсөөр хучиж техникийн нөхөн сэргээлт хийгдсэн тул биологийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Харин одоо ашиглагдаж буй хог буулгаж буй талбайд ирж буй хогийг цуглуулан, ангилан ялган ландфиллын үйл ажиллагаа явуулна.

Нөхөн сэргээлт нь эко тогтолцооны үйл ажиллагаа болон хөрсний үржил шимийг хуучин хивэнд нь буцаан оруулах зорилготой хэдий боловч анх байсан эко тогтолцооны үед газар нутгийн ашиглалтын зориулалт болон байгалийн төрөл зүйлийн бүтцээс арай өөр байна.

Тухайн газрыг ямар зорилгоор ашиглах гэж байгааг харгалзан нөхөн сэргээлтийн төрөл хэлбэрийг сонгох ба Бараат хогийн цэгийг өндөр мод бүхий ой болгох зорилт тавьснаар хангалттай хэмжээний модыг нөхөн сэргээлтийн газар тарих явдал юм.

Санал болгож буй Бараат хогийн цэг нь дараах байгууламжуудаас бүрдэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Нөхөн сэргээлтийн талбай
2. Авто пүү
3. Худаг
4. Ангилан ялгах хэсэг
5. Ажлын байрны барилга байгууламж
6. Хамгаалах далан
7. Зам
8. Гэрэлтүүлэг
9. Камер



Зураг 88. Бараат хогийн цэгийн газар ашиглалтын төлөвлөлт

Хүснэгт 47. Бараат хогийн цэгийн газар ашиглалтын төлөвлөлт

№	Төлөвлөж буй байгууламж	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төлөвлөж буй хугацаа	
1	Нөхөн сэргээлтийн талбай №1	га	14	2022-2025	
2	Нөхөн сэргээлтийн талбай №2	га	14	2025-2028	
3	Нөхөн сэргээлтийн талбай №3	га	14	2028-2030	
4	Авто пүү	ш	1	2022-2025	
5	Худаг	ш	4	2022-2030	
6	Ангилан ялгах хэсэг	Буулгах талбай	га	3	2022-2025
		Ялгах талбай	га	4	
		Цэвэрлэгээний талбай	га	3	
		Аюултай хог хаягдлын байгууламж	га	0.03	2022-2025
7	Зам	м	1515	2022-2025	
8	Гэрэлтүүлэг	ш	50	2022-2025	
9	Камер	ш	5	2022-2025	
10	Ажлын байрны барилга байгууламж	м <sup>2</sup>	4000	2022-2025	

## А. Нөхөн сэргээлтийн талбай

Нөхөн сэргээлтийн талбайд хог хаягдлыг түрж тэгшлэх болон үржил шимт хөрсөөр хучиж, хугацааны хувьд 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөв. Энд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг ургамалжуулах, мод, сөөг тарих, зарим мод, ургамлыг шилжүүлэн суулгах, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг хамгаалах, арчилгаа, тордолт хийх ажлууд хамаарна. Нөхөн сэргээлтийн талбайг 3 хэсэгт тус бүр 14 га хэмжээтэйгээр төлөвлөсөн ба сиймхий бүтэцтэй зурвас байгуулна.

Тарих мод: улиас, агч, чацаргана, хайлаас

Мод тарих зурвасын хэмжээ: Талбайг бүтэн тойруулж 1 эгнээ зурвас байгуулна.

2000 м талбайд дунджаар 175 м урттай 50 ш зурвас байгуулна.


Нийт зурвасын урт 10750 м

Зурвас хоорондын зай 6 м

### Тарих модны тоо, тарих зай:

Хүснэгт 48. Мод тарих хоорондын зай

Модны нэр	Улиас	Агч	Чацаргана	Хайлаас
Эгнээ хоорондох зай, метр	4	4	3	3
Ургамал хоорондох зай, метр	4	4	3	3
Модны тоо, ширхэг	2750	2750	3670	3670
1 га талбайд, мод/ширхэг	915			
<b>Нийт суулгац</b>	<b>12840</b>			



Зураг 89. Тарилтын схем

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

### Б. Авто пүү

Бетон дээр суурилуулах ачааллын элемент дээр авто пүү байрлана. Бүртгэлд орсон хогийн машины жингийн мэдээллийг ажлын байрны компьютерт дамжуулна. Авто пүүний хүчин чадал 40 тн байна. Автопүүг дараах зориулалтаар ашиглана.

Үүнд:

Хот суурингаас шууд ирж буй ахуйн хатуу хог хаягдал

Эмнэлгийн болон аюултай хог хаягдал

ААН байгууллагын энгийн хог хаягдал

### В. Худаг

Биологийн нөхөн сэргээлт хийх талбайн усалгаа тордлогоо хийх болон гүний усны чанарыг хянах мониторингийн /хяналтын/ худаг байна.

### Г. Ангилан ялгах хэсэг.

Ангилан ялгах талбай нь 3 ажлын талбайгаас бүрдэх бөгөөд хог хаягдал буулгах, ялгах болон цэвэрлэгээний үйл ажиллагаа гэсэн ажлын талбайг ээлжлүүлэх болно.

- Буулгах талбай: Энд зөвхөн хог хаягдал буулгахаар ашиглах бөгөөд ялгах үйл ажиллагаа хийхийг хориглоно.
- Ялгах талбай: Энд зөвхөн хог хаягдал ялгаж хоёрдогч түүхий эд цуглуулах үйл ажиллагаа явагдах бөгөөд аливаа машин механизмын үйл ажиллагаа хориглоно.
- Цэвэрлэгээний талбай: Энд талбайд ялгах үйл ажиллагааны дараа бий болсон үлдэгдэл хаягдлыг дарж булшлахад зориулсан
- Эмнэлгийн болон аюултай хог хаягдлыг булшлах байгууламж

Энэ хэсэгт дараах үндсэн зарчмуудыг баримтлах шаардлагатай.

- Хатуу хог хаягдлыг хангалттай түрж нягтруулах
- Хог хаягдлын замбраагүй тархах байдлыг багасгах
- Эвгүй үнэр тархах байдлыг багасгах
- Хог хаягдлыг аль болох богино хугацаанд тогтвортой болгох

Булшлах жалганы хэмжээг Гео Од ХХК-ны тооцооллоор авсан ба цэвэрлэгээний талбай нь 2,7 га талбай бүхий 246 491 м<sup>3</sup> хэмжээтэй гуу жалганд 2030 он хүртэл 246855,9 м<sup>3</sup> хог хаягдал булах тооцоо гарч байна. Бараат хогийн цэгийг 2022 оноос 2030 он хүртэл нийт 8 жилийн хугацаатай ашиглахаар нөөцтэй байгааг хүснэгтээр харуулав.

Булах хог хаягдлыг дарж булшлахад шаардагдах хүчин чадлын хэмжээг дараах тооцооллоор хийлээ.

$$V=V2+V3$$

V= Шаардагдах хэмжээ багтаамж

V1=Булах хогийн хэмжээ (хувийн жин 0,4тн/м<sup>3</sup>)

V2=Хогийн цэг дээр буусан хог хаягдлыг хучих хөрсний хэмжээ (Өдөр тутам хучих хөрсний хэмжээ хог хаягдлын 10%-тай тэнцэнэ)

V3=Аюулгүй тогтвортой байдалтай болсон хог хаягдлын хэмжээ (хувийн жин 1тн/м<sup>3</sup>)

Хүснэгт 49. Хог хаягдлыг булахад шаардагдах хүчин чадал

он	Булах хог хаягдлын жин	Булах хог хаягдлын эзлэхүүн хэмжээ	Хучилтын хөрс	Тогтвортой болсон хог хаягдлын эзлэхүүн хэмжээ	Нийт эзлэхүүн хэмжээ	Хуримтлуу лсан эзлэхүүн хэмжээ	Шаардагд ах хүчин чадал
	Wd	V1=Wd/0.4	V2= V1*0.08	V3=Wd/1.2	V=V2+V 3		
	тн/жил	м <sup>3</sup> /жил	м <sup>3</sup> /жил	м <sup>3</sup> /жил	м <sup>3</sup> /жил	м <sup>3</sup>	м <sup>3</sup>
2021.08	26080	65200	5216	21733.33	26949.33	26949.33	246855.9



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ


2022	33904	84760	6780.8	28253.33	35034.13	61983.46
2023	31296	78240	6259.2	26080	32339.2	94322.66
2024	28688	71720	5737.6	23906.67	29644.27	123966.9
2025	26080	65200	5216	21733.33	26949.33	150916.3
2026	23472	58680	4694.4	19560	24254.4	175170.7
2027	20864	52160	4172.8	17386.67	21559.47	196730.1
2028	18256	45640	3651.2	15213.33	18864.53	215594.7
2029	16691.2	41728	3338.24	13909.33	17247.57	232842.2
2030	13561.6	33904	2712.32	11301.33	14013.65	246855.9

### Д. Зам

Хөтөл хорооллын засмал замаас ландфиллын хаалга хүртэл замыг 12 жилийн турш ашиглахаар төлөвлөж байгаа тул асфальтан хучилттай зам тавьж улмаар хогийн машинууд хогийн цэг рүү нэвтрэхэд бэлэн болно.

Үндсэн замын өргөн: 6м

Замын хажуу: 0.5м /хоёр хажуу тал/



Зураг 90. Хогийн цэг рүү нэвтрэх замын бүтэц

### Е. Гэрэлтүүлэг

Асфальтан замын дагуу хоорондоо 30 м зайтай 80 квт-ын 50 ш гэрэлтүүлгийн шонгууд байрлана.

### Ё . Камержуулалт

Бараат хогийн цэгт хяналт тавих зорилгоор 5 цэгт гадна хяналтын камер суурилуулна. Техникийн үзүүлэлтэд:

- Гадна PTZ 360 IP камер
- Өдөр шөнийн тусгалтай
- Нягтрал: 2 megapixel
- Линз: 3.6мм
- Харах өнцөг: 180 градус
- Шөнийн тусгал: 50метр
- Оптик таталт: 18x
- Бичлэгийн өргөтгөл: H265+
- Гадаа камер
- Цахилгаангүй газар нарны панелаар ажиллана.
- Үүрэн телефоны операторуудын сим картыг хийж гар утас, компьютерээсээ дэлхийн хаанаас ч хянах боломжтой.



## Ж. Ажлын байрны байгууламж

Авто пүүний дэргэд ажилтны ажлын байр, дулаан граж, дугуй ариутгах цэг, аюулгүй байдлыг хангах, галын аюулаас сэргийлэх, агуулах болон хяналтын байгууламжууд байрлана. Ажлын байр нь авто пүүний хяналт болон ажилтан, ажилчдын байрнаас бүрдэнэ. Хогийн цэг дээр ирж буй хогийн машинуудыг хянах, бүртгэх бүрэн бололцоог хангасан шаардлагатай тоног төхөөрөмжтэй авто пүүний хяналтын өрөө байгуулна.


Хогийн цэгээс гарч буй машины хот руу явах ариун цэврийн шаардлагыг хангах зорилгоор дугуй ариутгах цэгийг байгуулна. Тухайн цэг нь бетонон бүтэцтэй байна.

## К. Хашаа

Хогийн цэг дээр дараах зорилгоор хашаа барих шаардлагатай.

- Хог түүгч иргэд, гаднын хүмүүс, амьтан орж гарах байдлыг хянах
- Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг хамгаалах
- Хууль бус хог хаяхаас сэргийлэх

Санал болгож буй хашааны загвар



Зураг 91. Ангилан ялгах талбайн хашааны бүтэц



Зураг 92. Нөхөн сэргээлтийн талбайн хашааны бүтэц

## Хүснэгт 50. Төлөвлөж буй нийт төсөвт зардал

№	Зардлын төрөл	Нийт үнэ сая.төг
1	Ногоон байгууламж	219.795
2	Худаг, усалгааны систем	237.710
3	Нөхөн сэргээх газрын хашаа	223.360
4	Хог хаягдлыг ангилан ялгах хашаа	74.760
5	Цахилгаан татах зардал	45.500
6	Хяналтын камерын зардал	14.750
7	Гэрэлтүүлгийн зардал	150.000
8	Авто механизмын зардал	2.484.000
9	Барилга байгууламжийн зардал	239.069
<b>Нийт зардал</b>		<b>3688.943</b>

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1. Зарим хөрөнгө оруулалтын болон зардлын задаргаа

#### 1.1 Нөхөн сэргээлтийн ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал

Хөрөнгө оруулалтын зардалд нөхөн сэргээлтийн ажилд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах, угсарч суурилуулах зардал, мөн тусгай зориулалтын тоног төхөөрөмж, холих, тээвэрлэх машин, усалгаа, арчилгааны машин зэргийг худалдан авах, шаардлагатай байгууламж, худаг, шугам сүлжээ байгуулах зардал багтана.

Тээврийн болон усалгааны машин гэх мэт цаашид нөхөн сэргээлтийн ажил хийгдсэний дараа газрын арчилгаа, тордолтын явцад шаардлагатай техник хангамж, хөрөнгийг НААҮГ-аас гаргана гэж тооцлоо.

#### А. Нөхөн сэргээлтийн 1-р талбайд хийх хамгаалалтын хашааны зардал

Хашаа 3 метр бүрт 150 см өндөртэй шон, 30 бүрт тулгууртай бөх бат 150 см өндөр шон 3 метр тулгуур (гадагшаа, дотогшоо налагаас хамгаална)-тай байна. Хашааны эргэлтийн цэг бүрт 2 тал руугаа 3 метр тулгууртай хүчирхэг шон байна.

Хашааны газраас 50 см-г жижиг амьтдаас хамгаалсан 4\*4см торон хаалт хийж өгнө. Автомашин орох 1, явган хүн орох 1 хаалгатай байна. Хаалга бүрт цоож хийж өгнө. Хашааны торны утас хоорондын зай газраас 50 см хүртэл зайд 10x10 см квадрат, түүнээс дээш 150 хүртэл 20x30 см тэгш өнцөгт бүхий нүднүүдтэй байна.

Нөхөн сэргээлт хийх газарт хашааны материалын зардлын төсөөлөл 1000м хашаа, бэлчээрийн хашааны хувилбараар /Төмөр хийцийн материалын үнэ 7 хоногоор өөрчлөгдөж байгаа тул 2021 оны 9 сарын зах зээлийн үнээр төсөөлөл гаргав./

Хүснэгт 51. Нөхөн сэргээлт хийх талбайн хашааны зардал

№	Материалын төрөл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт зарцуулах хөрөнгө
1	Тор	метр	5	195000	975000
2	Шон захын	ширхэг	4	23800	95200
3	Шон дундын	ширхэг	70	9350	654500
4	Шон голын	ширхэг	670	6500	4355000
5	Налуу тулгуур захын	ширхэг	10	1500	15000
6	Налуу тулгуур голын	ширхэг	100	6500	650000
7	Налуу тулгуур газарт бэхлэх шон	ширхэг	36	3300	118800
8	Шон болон налуу тулгуурыг бэхлэх боолт	ширхэг	420	900	378000
9	Бүжингийн тор	метр	55	119000	6545000
10	Хаалга	ширхэг	1	500000	500000
11	Электрод	ширхэг	1	170000	170000
12	Механик чангалагч, дэгээ	ширхэг	30	17000	510000
13	Бэхэлгээний утас	боодол	10	15000	150000
14	Шон тулгуурыг нүхлэх, үзүүрлэх зардал	ширхэг	1215	3000	3645000
15	Ситка	ширхэг	375	35000	13125000
16	Тээвэрлэлт				3000000
17	Ажлын хөлс				5000000
<b>1000 метр хашааны нийт зардал</b>					<b>39886500</b>
Нөхөн сэргээлтийн 1-р талбайд хийгдэх хашааны зардал /2000 м/					<b>79773000</b>
Нөхөн сэргээлтийн 2,3-р талбайд хийгдэх хашааны зардал /4000 м/					<b>143591400</b>
<b>Нийт</b>					<b>223364400</b>

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 52. Ногоон байгууламжийн зардал

№	Суулгацын төрөл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт зарцуулах хөрөнгө /төг/
1	Улиас	ширхэг	2750	4500	12375000
2	Агч	ширхэг	2750	5000	13750000
3	Чацаргана	ширхэг	3670	4000	14680000
4	Хайлаас	ширхэг	3670	3000	11010000
5	Бордоо	кг	7000	1000	7000000
6	Олон настын үр	кг	100	4500	450000
7	Тээвэрлэлт				1000000
8	Тарих ажлын хөлс				13000000
Нөхөн сэргээлтийн 1-р талбайд хийгдэх ногоон байгууламжийн зардал					<b>73265000</b>
Нөхөн сэргээлтийн 2, 3-р талбайд хийгдэх ногоон байгууламжийн зардал					<b>146530000</b>
<b>Нийт зардал</b>					<b>219795000</b>

### Худаг, усалгааны систем

Зурвасын талбай дахь 12840 мод тус бүрд 4 л/цаг ус дуслах дуслын усалгааны системийг ашиглахаар тооцлоо.

Хүснэгт 53. Худаг, усалгааны системийн зардал

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хуванцар хоолой	м	1700	8250	14025000
2	Хаалт	ш	60	28050	1683000
3	Дуслын хоолой	м	35000	935	32725000
4	Товчин дуслуур	ш	13000	715	9295000
5	Эмээл	ш	200	2750	550000
6	Эрвээхий хаалт	ш	200	2750	550000
7	Бэлб сокет	ш	200	10450	2090000
8	Тройник	ш	50	17050	852500
9	Булан	ш	50	18700	935000
10	Сокет	ш	20	1155	23100
11	Түлхүүр	ш	2	25000	50000
12	Дуслын хоолойн төгсгөгч таг	ш	200	220	44000
13	LD хоолой цоологч	ш	2	15400	30800
14	Насос	ш	2	4500000	9000000
15	Худаг		2	20000000	40000000
16	Материал тээвэрлэлт				2000000
17	Угсралтын ажлын хөлс				5000000
<b>Нөхөн сэргээлтийн 1-р талбайд хийгдэх 2 худгийн зардал</b>					<b>118853400</b>
<b>Нөхөн сэргээлтийн 2, 3-р талбайд хийгдэх худгийн зардал</b>					<b>118853400</b>
<b>Нийт</b>					<b>237706800</b>

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

### Хог хаягдлын ангилан ялгах талбайн хашааны зардал

Хог хаягдлыг ангилан ялгах газарт хашааны материалын зардлын төсөөлөл 3 м хашаа, квадрат төмрөөр хийхээр төлөвлөж гаргав.

#### Хүснэгт 54. Хог хаягдлын ангилан ялгах талбайн хашааны зардал

№	Материалын төрөл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт зарцуулах хөрөнгө
1	Квадрат төмөр 1.5*1.5 /1.5 м өндөртэй хашааны/	метр	30	2800	84000
2	Төмөр шон 5*5	метр	2.5	8900	22250
3	Дай төмөр 4*2	метр	6	6500	39000
4	Гагнуурын электрод	хайрцаг	1	17000	17000
5	Шонгийн хүчитгэл /цемент/	уут	1	11000	11000
6	Ажлын хөлс	метр	3	8000	24000
3 метр хашааны үнийн зардал					<b>197250</b>
Хог хаягдал ангилан ялгах хашааны нийт зардал 1137метр					<b>74757750</b>

#### Хүснэгт 55. Цахилгаан татах зардал

№	Материалын төрөл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт зарцуулах хөрөнгө
1	Цахилгаан татах зардал	м	1000	455000	45500000
<b>Нийт</b>					<b>45500000</b>

Нарны эрчим хүчээр ажилладаг аюулгүй байдлын камерууд нь алслагдмал газарзүйн байршил дахь эд хөрөнгийг хянах зориулалттай юм. Тус хогийн цэгийн орчимд 5 хэсэгт хяналтын камер байршуулахаа төлөвлөсөн болно.

#### Хүснэгт 56. Хяналтын камерын зардал

№	Материалын төрөл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт зарцуулах хөрөнгө
1	18X2MP Нарны панел, гар утасны сиймээр ажиллах хяналтын камер	ширхэг	5	2500000	12500000
2	Камер байрлуулах хөл	ширхэг	5	450000	2250000
<b>Нийт</b>					<b>14750000</b>

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 57. Дархан сумын хог хаягдал татан авалт гүйцэтгэх автомашин, механизмын үзүүлэлт, худалдан авах төсөв

№	Шаардлагатай машин механизмын нэр	Тоо ширхэг	Марк	Багтаамж	Зориулалт	Нэгж үнэ	Нийт үнэ
<b>Хог хаягдлын төвлөрсөн цэг буюу ландфиллд ашиглах техник хэрэгсэл</b>							
1	Бульдозер	2	Komatsu	10м <sup>3</sup>	Хог хаягдал түрж дарж, булах	750000000	1500000000
2	Экскаватор	1	Hyundai	1.05м <sup>3</sup>	Хог хаягдлын цэгт	384000000	384000000
3	Ковш	2	Komatsu	2.5	Хог хаягдал ачиж тээвэрлэх түрж булах	300000000	600000000
	<b>Нийт</b>	<b>9</b>					<b>2484000 000</b>

Хүснэгт 58. Бараат хогийн цэг дээр баригдах барилга байгууламжийн зардал

№	Зориулалт		Хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Автопүү Аналоги& Дижитал	1	Тавцангийн урт: /6-40/ метр Тавцангийн өргөн: /3-3,5/ метр Тавцангийн зузаан: 8мм, 10мм, 12мм, 14мм, 16мм Тавцангийн тулгуур зузаан: 5мм, 6мм, 8мм Даац/30-200/ тн Нарийвчлал: /10-50/ кг	9503000	9503000
2	Дугуй ариутгах төхөөрөмж			18000000	18000000
3	Ажилчдын байр	1	80 м <sup>2</sup>	35000000	35000000
4	Эмнэлгийн аюултай хог хаягдлыг булах байгууламж		100 м <sup>3</sup>	86000000	86000000
5	Автограж	1	20x30 харьцаатай	90566300	90566300
<b>Нийт</b>					<b>239069300</b>



### 3.5.2. Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилл байгуулах байршлын тохиромжтой байдлын үнэлгээ

Орчин үеийн ландфилл нь хог хаях цэгээс олон зүйлээр ялгаатай. Инженерчлэгдсэн байгууламж учраас тэд илүү аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг илүү хангасан, хүний үйл ажиллагаанаас үүдсэн шаталтад өртөх магадлал багатай байна. Тэдгээр нь мөн идэвхтэй менежмент болон зөвшөөрөлгүй хүмүүсийг (жишээ нь, хог түүгчид) нэвтрүүлэхгүй байх аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг шаардах бөгөөд технологи муутай хог хаях цэгийг бодвол харьцангуй өндөр үнэ өртөгтэй байж болох юм. Дархан сумын одоогийн хог хаягдал тархсан талбайн хэмжээг олон улсад хэрэглэж буй ландфиллын аргыг хэрэгжүүлбэл хог хаягдлыг 3-5 га талбайд багтаах боломжтой юм.

Хог хаягдлыг зайлуулахтай холбоотой янз бүрийн загвар, аргачлал байдаг бөгөөд эцсийн зорилго нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хамгийн бага нөлөөлөх тохиромжтой газрыг олох явдал юм. Хүрээлэн буй орчны мэдээллийн системийн хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгаа өнөө үед Газар зүйн мэдээллийн систем (ГМС) нь менежмент, шийдвэр гаргах үйл явцыг шинэ шатанд гаргах өөрчлөлтийг бий болгосон.

1950 оноос хойш ГМС бий болсноор олон шалгуурт шийдвэр гаргах (MCDM) аргыг шийдвэр гаргагчдад туслах чухал хэрэгсэл болгон ашиглаж ирсэн. Энэхүү судалгаанд ашигласан арга нь ландфиллын тохиромжтой байршлыг сонгох шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн параметр ангиллыг тодорхойлох, жигнэх, эрэмбэлэх, тодорхойлсон ангиудыг ашиглан хүчин зүйлийн газрын зураг боловсруулж, улмаар газрын зургийг нэгтгэн давхцуулах, эцэст нь ландфиллд тохиромжтой талбайг тодорхойлов. Газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхдээ газарзүйн мэдээллийн систем дээр суурилсан олон шалгуурт шийдвэр гаргалтын (Multi criteria decision analysis) аргыг эрэмбэлэлтийн матрицын аргатай хослуулан ашигласан.

Улс орны нөхцөл байдлаас хамаарч ландфиллийн байршлыг сонгох шалгуур үзүүлэлт янз бүр байдаг ба нийтлэг хэд хэдэн шалгуур байдаг. Эдгээр нь хүрээлэн буй орчны, улс төрийн, санхүү, эдийн засгийн, гидрологийн ба гидрогеологийн, байрзүйн, геологийн болон бусад шалгуур юм. Судалгаанд тооцож буй зарим шалгуур тус бүрийг авч үзвэл:

1. *Өндөржилт:* Судалгааны талбайн өндөрлөг газрын зургийг хоёр бүсэд хуваасан. 750 м-ээс 1000 м-ийн хоорондох өндөрлөг газруудыг тохиромжтой газар гэж тодорхойлсон болно.
2. *Суурьшлын бүсээс алслагдсан байдал:* Судлаач Аллений (2000) бичсэнээр ландфилийн газар нь сумын төвөөс 5 км зайд, тодорхой байшин барилгаас 500 м зайтай байх ёстой гэж үзсэн бол Кантвелл (1999) 500-аас дээш хүн амтай хот, тосгоны орчны зайг 1000 м, хүн амын бусад бүх тогтоосон төвүүдийн хувьд 500 м, хувийн орон сууц, аж ахуйн нэгж, нийгмийн болон олон нийтийн барилга байгууламжийн хувьд 250 м байх ёстой гэжээ. Судлаач Сиддики (1996) 10 болон түүнээс дээш барилга байгууламж үед шинэ хогийн цэгийг 0.4 км (0.25 миль) -аас холгүй газарт байрлуулах ёсгүй гэж зөвлөж байна. Нөгөөтээгүүр, Serwan, M.J.(1998) эдийн засгийн хувьд хогийн цэгийг хот суурин газраас 10 км дотор байрлуулах зүйтэй гэсэн байна. Харин манай оронд хог хаягдлыг булшлах буюу ландфилл байгуулах тодорхой стандарт байхгүй бөгөөд хүн амын суурьшлын хэтийн бусийн гадна орших (суурьшлын шинэ бүсээс улс, нийслэлийн зэрэглэлтэй хот бол 5 км-ээс багагүй, орон нутгийн зэрэглэлтэй хот, төвлөрсөн суурин газар бол 3 км-ээс доошгүй зайд байна) гэж үздэг. Эдгээр санал болгож буй аюулгүй зайг харгалзан үзэж хамгийн бага зайг суурьшлын бүсээс 3км, 5 км гэж тодорхойлов.

3. *Зам*: Замыг олон улсын чанартай зам ба хот доторх бусад жижиг зам гэсэн хоёр давхаргад хуваадаг. Учир нь авто замын ач холбогдлоос хамаарч орчны бүсийн ялгаатай зайг ашиглах шаардлагатай болсон. Замаас алслагдсан зайг судалгааны бүтээлд янз бүрээр дурьдсан байдаг. Тухайлбал Замаас эргэн тойрон 100 м бүсчлэл үүсгэх нь хамгийн тохиромжтой (Leao, S. et al., 2003) гэж үзсэн бол Кантвелл (1999) анхдагч, хоёрдогч, бүсийн, гуравдугаар зэрэглэлийн бүх замаас зайлсхийж, хоёр талдаа 30 м-ээс багагүй зайд байх ёстой гэжээ. Аллен (2000) -ын зөвлөснөөр төв зам, хурдны замаас 1 км-ээс хол зайд байх хэрэгтэй. Нөгөөтээгүүр, Lin, H.-Y (1999) хог хаягдал булах цэгийг одоо байгаа авто замын сүлжээнээс хол байрлуулж болохгүй, түүнийг холбосон зам барих зэргээр өртөг өндөр болохоос зайлсхийх хэрэгтэй Аллен (2000) –ы санал болгосноор гол замаас 3 км-ээс бага зайтай ба Серван (1998) –ын зөвлөснөөр гол замаас 0.2 км-ээс 10 км-ийн хооронд хамгийн тохиромжтой гэж үзжээ. Эдгээр санал болгож буй утгуудыг харгалзан алслагдах зайг замын зэрэглэлээс хамааруулан олон улсын чанартай зам, гол зам, туслах зам тус бүрд ялгаатай тодорхойлов.
4. *Налуу*: Ландфиллын тохиромжтой байршлыг сонгоход налууг хэрхэн тооцох талаар судлаачдын олон санал байдаг. Аллен (2000), Овейс (1990) нар 15 ° -аас дээш налуу бүхий газарт нь хогийн цэг байршуулахаас зайлсхийх хэрэгтэй гэж үзсэн бол Лин (1999) –ы зөвлөснөөр ландфилл барихад тохиромжтой налуу нь ойролцоогоор 8-12% байдаг, учир нь хэт налуу нь байгууламж барих, арчлахад бэрхшээлтэй байдаг бол хэт тэгш газар нь урсцын ус зайлуулалтад нөлөөлнө. Леао (2003) өндөр налуу нь ландфиллд хуримтлагдсан ус налуугийн дагуу урсах нөхцөлийг бүрдүүлснээр бохирдол үүсгэдэг тул налуу нь 20% -аас дээш байгаа газарт ландфилл байгуулахад тохиромжгүй.
5. *Гүний усны төвшин*: Ундны усыг хамгаалахын тулд газрын доорх усны өндөр чанарын нөөц дээр хогийн цэг байрлуулж болохгүй. Уст давхаргын гүнийг 15.24 м-ээс бага (50 фут) -аас 60.96 м (50-200 фут) хүртэлх гүний ус бүхий газрыг бага тохиромжтой гэж үзвэл зохино. (Bolton, 1995).
6. *Үерт автагдах байдал*: Хогийн цэгийн тохиромжтой байршлыг сонгоход бохирдсон урсгал ус урсах эрсдэлийг бууруулах үүднээс үерт автагдах газраас зайлсхийх хэрэгтэй гэсэн нийтлэг санал байдаг. Хэрэв газрын налуу нь 15% -иас бага, аллювийн хөрстэй бол үерт автагдах магадлалтай байдаг (Као et al., 1996). Багчи (1994) ын тэмдэглэснээр, хогийн цэгийг 100 жил дотор тохиолдсон үерт автагддаг газар байрлуулж болохгүй. Хэрэв ямар нэгэн далан барьсан бол хоёрдогч ус хагалбарын газарт далан дотор байрлуулж болно гэжээ. Дээрх судлаачдын дүгнэлт болон Монгол улсад баримталдаг норм дүрэмд үндэслэн ландфиллд тохиромжтой газрыг оновчтой сонгоход нөлөөлөх шалгуур, хүчин зүйлийг дараах байдлаар гаргав.


## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 59. Ландфиллийн тохиромжтой газрыг сонгох санал болгож буй хүчин зүйл, шалгуур

Үзүүлэлтүүд-ийн бүлэглэл	Бүлэгт хамаарагдах үзүүлэлтүүд		АНР жингийн коэффициент	Хэмжих нэгж	Тогтвортой байдлын үнэлгээний төвшин		
					Тохиромжтой	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжгүй
Физик газарзүйн нөхцөл	Өндөржилт		0.03	м	750-1000		>1000, <750
	Налуу		0.184	хувь	10-20	5-10	>20, <5
	Гадаргын ус		0.091	метр	>2000	1000-2000	<1000
	Гүний усны төвшин		0.103	метр	>60	15-60	<15
	Үерт автагдах байдал	Ус урсах шугам	0.07	метр	>500		<500
	Хөрсний төлөв байдал		0.051		Шаварлаг, шавранцар хөрс		Элсэн болон хайргархаг хөрс, нугат намгийн цэвдэгт хөрс, Аллювийн нугын хөрс
Нийгэм-Эдийн засгийн үзүүлэлт	Суурьшлын бүс		0.227	метр	>5000	3000-5000	<3000
	Зам	Улсын чанартай	0.072	метр	500-2000	>2000	<500
		Туслах зам			метр	100-500	>500
	Цахилгаан шугам		0.015	метр	>200		<200
	Тариалангийн газар		0.15	метр	>1000		<1000

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ


Дээрх шалгуур үзүүлэлт тус бүрээр хүчин зүйлийн зураглал гаргасныг дараах зургаар харуулав.



Зураг 93. Судалгааны талбайн хүчин зүйлийн зураг

Хогийн цэгийг сонгох санал болгож буй байршлыг хүчин зүйлийн газрын зургийг нэгтгэх замаар хэрэгжүүлсэн ба нэгтгэсэн үр дүнг зургаар харуулав. Үр дүнг харгалзан нэн тэргүүнд тавигдах шаардлагад нийцсэн маш тохиромжтой газарт байрлах хувилбаруудаас экологи, эдийн засгийн нөхцөлийг харгалзан ландфиллд тохиромжтой талбайн эцсийн сонголтыг хийсэн. Эцсийн сонголтыг хийхдээ газар ашиглалт болон салхины зонхилох чиглэлийг харгалзан Дархан сумын хэмжээнд 11 шалгуур хангасан 10 га –аас дээш талбайтай 8 газрыг хамгийн тохиромжтой гэж сонголоо.





Зураг 94. Дархан сумын ландфиллд тохиромжтой газрын байршил

Ландфиллд тохиромжтой байршлыг экологи, эдийн засгийн хувьд эрэмбэлэн эхний болон хоёр дахь тэргүүлэх чиглэлтэй сонгосон ба байршлын зургийг Зураг 3-д үзүүлснээр эхний ээлжийн байршлыг А1, А2, А3, А4 гэж заасан бол түүний дараагийнхыг В1, В2, В3, В4 гэж тодорхойлов. Сүүлийн шатанд бодит нөхцөл байдлыг загварчлалын үр дүнтэй харьцуулах зорилгоор хиймэл дагуулын зурагт буулган баталгаажуулсан болно.


А1, А2, А3, А4 бүхий байршлууд нь Бараат хогийн цэгээс зүүн зүгт 3,8 км орчимд байрлах ба Дархан сумаас 5 орчим км-т байрлана. Эдгээр нь 5.5-13.7 га талбайтай, газар ашиглалтын хувьд дунд зэргийн бэлчээрт хамаарагдаж байв.

Харин В1, В2, В3, В4 бүхий байршлууд нь 12.5-198 га талбайтай, Бараат хогийн цэгээс зүүн зүгт 6.9 км орчимд байрлах ба Дархан сумаас с 4.3 орчим км-т байрлана. Эдгээрийн аль нь ч хог хаягдлыг зайлуулахад хязгаарлалт тогтоогоогүй.


Ирээдүйд ашиглах боломжтой хамгийн тохиромжтой байршил бүхий төвлөрсөн хогийн цэгийн талбайд эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан ландфилл байгуулах шаардлагатай юм. Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан ландфилл нь дараах төшингүүдтэй байдаг ба аймгийн төвүүд 2, 3-р төвшний ландфилл байгуулахыг шаарддаг.




Ландфилл хаалтын 1-р түвшин




Ландфилл хаалтын 2-р түвшин



Ландфилл хаалтын 3-р түвшин



Ландфилл хаалтын 4-р түвшин



Зураг 95. Ландфиллын жишиг байгууламж

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

### Баримтлах үндсэн бодлого

Ландфилл хийх төлөвлөгөө боловсруулахад дараах үндсэн бодлого зарчмуудыг баримтлах шаардлагатай.

- Хатуу хог хаягдлыг хангалттай түрж нягтруулах.
- Хатуу хог хаягдлыг замбараагүй тархах байдлыг багасгах.
- Эвгүй үнэр тархах байдлыг багасгах.
- Хог хаягдлыг аль болох богино хугацаанд тогтвортой болгох.

Хатуу хог хаягдлыг нягтруулснаар ландфиллын ашиглалтын хугацааг уртасгах, ландфилл хийж дууссаны дараа газрын суултын хэмжээг багасгах сайн талтай юм. Түүнчлэн ландфиллын хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор хатуу хог хаягдал замбараагүй тархах, эвгүй үнэр тархах байдлаас сэргийлэх шаардлагатай. Дууссан ландфиллын цэгийг ирээдүйд амралтын бүс эсвэл хөдөө аж ахуйн зорилгоор ашиглах тохиолдолд ландфиллын үйл ажиллагааны үед хог хаягдлыг аль болох богино хугацаанд тогтвортой байдалд оруулах шаардлагатай.

### Ландфиллын бүтэц

Нүүрстөрөгчийн хагас хангамжтай сайжруулсан эрүүл ахуйн шаардлага хангах аргыг ландфилл дээр ашиглах болно.

### Ландфилл хийх арга

Ландфилл хийх аргачлалыг дараах гурван аргаар хийдэг. Үүнд: ил задгай хаях, хөрсөөр булах (сандвич арга), хэсэгчлэн хувааж булах (үүр хийх арга). Ил задгай хаях арга ашиглахад эвгүй үнэр, халдварт өвчин, хортон шавьж үүсэх байдлаас зайлсхийж чадахгүйн зэрэгцээ хог хаягдлыг дорвитой нягтруулах боломжгүй юм.

Сандвич аргыг ландфилл дээр хог хаягдлыг тэгшхэн хэвтээ байдалтай булаж хөрсөөр хучихад ашигладаг бөгөөд жижиг ландфилл дээр тохирох боловч том талбайтай тохиолдолд хог хаягдал ил задгай байдалтай тодорхой хугацаанд үлдэж улмаар эвгүй үнэр үүсгэх зэрэг байдал бий болгодог байна.

Үүр хийх аргачлалыг ашиглахад хог хаягдлыг өдөрт нь хөрсөөр булах ба ландфиллын хог хаягдлыг сайн нягтруулах боломжтой болж улмаар хатуу хог хаягдлыг замбараагүй хийсэх, эвгүй үнэр, хортон шавьж үүсэх байдлаас сэргийлнэ. Иймд энэхүү аргыг нэвтрүүлнэ.

Ландфиллын төлөвлөгөөг дараах байдлаар хийнэ.


1 шат: Хамгаалах болон хязгаарлагч далан баригдсаны дараа 1 дүгээр талбай (area) дээр ландфиллын үйл ажиллагаа эхэлнэ.

2 шат: 1 дүгээр талбай дээр ландфиллын ажил дууссаны дараа 2 дугаар талбай дээр ажил эхэлнэ.


3 шат: 2 дугаар талбай дээр ландфиллын үйл ажиллагаа дуусахаас өмнө хоёр дахь үе шатны хамгаалах даланг барина.

4 шат: 1-ээс 3 дугаар үе шатны ажлыг давтан хэрэгжүүлснээр хоёр дахь үе шатны ландфиллын үйл ажиллагааг зохион байгуулна.

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 96. Ландфиллын үйл ажиллагааны 1 болон 2-р алхам



Зураг 97. Ландфиллын үйл ажиллагааны үе шат 3-4

## Ландфиллын процедур

Ландфиллын үйл ажиллагаа дараах байдлаар явагдана.

- 1) Хогийн машин жолооч ландфиллын зохицуулагчийн удирдамжийн дагуу хог хаягдлыг ачсан ачаагаа буулгана.
- 2) Буусан хог хаягдлыг бульдозероор тарааж, буталж, тэгшилж нягтална.
- 3) Ландфиллын үйл ажиллагааны дараа хэсэгчлэн (үрэн хэлбэртэй) хувааж хөрсөөр булаах ажлыг өдөр тутам хийнэ.
- 4) Хязгаарлагч далан хүртэл хоёрдугаар үеийг нэгдүгээр үе дээрээ байгуулна. Булаах технологи нь нэгдүгээр үе дээр ашигласантай ижилхэн байна.
- 5) Ландфиллын хоёрдугаар үе дээр хөрс буюу хучилтын материалаар хучиж өгнө.
- 6) Хязгаарлагч, хий зайлуулах болон бохир шингэн цуглуулах байгууламжийг дараагийн буюу ландфиллын үйл ажиллагаа хийгдэж байгаа талбайн хажууд суурилуулна.


## Хөрс хучилт

Дээр дурьдсан аргачлалын дагуу хөрс хучилтын ажлыг хийх бөгөөд үе болгоны хөрсний зузааныг дараах байдлаар үзүүлэв:

Өдөр тутмын хөрс хучилт	:15см
Завсрын хөрс хучилт	:30см
Эцсийн байдлаар хөрс хучилт хийх	: 50см

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Эцсийн байдлаар хучилт хийхэд шаардагдах хөрсний хэмжээг оролцуулан хөрсний нийт хэмжээ хог хаягдлын хэмжээнд 8% эзэлнэ. Бараат хогийн төвлөрсөн цэгийн хөрс шорооны нөөц авах газартай тул тэндээс нь авахаар тооцов.



Зураг 98. Эцсийн байдлаар хийгдэх хучилтны жишиг загвар

Хогийн төвлөрсөн цэг дээр ландфиллын үе шаттай хийх төлөвлөгөөг хэрхэн хийх тухай дараах байдлаар үзүүлэв.

Хүснэгт 60. Ландфиллын үе шаттай хийх төлөвлөгөө

ЗҮЙЛ	ТАЙЛБАР		
НӨӨЦ ГАЗАР БА ГАЗАР АШИГЛАХ САНАЛ	НИЙТ ТАЛБАЙ : 24.6 га		
ЛАНДФИЛЛЫН ХҮЧИН ЧАДАЛ, ХЭМЖЭЭ	ҮЕ ШАТ	ХҮЧИН ЧАДАЛ	АШИГЛАХ ХУГАЦАА
	1 үе шат	84.981 м <sup>3</sup>	2025
	2 үе шат	164.298 м <sup>3</sup>	2025-2026
	3 үе шат	294.865 м <sup>3</sup>	2026-2027
	4 үе шат	433.090 м <sup>3</sup>	2027-2029
	5 үе шат	603.840 м <sup>3</sup>	2029-2031
	6 үе шат	805.650 м <sup>3</sup>	2031-2034
	7 үе шат	789.660 м <sup>3</sup>	2034-2036
	<b>Нийт</b>	<b>3.176.384 м<sup>3</sup></b>	<b>2025-2036</b>

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 3.6. ХОГ ХАЯГДЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ, ХЯНАЛТ БОЛОН УРАМШУУЛЛЫН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ, БОРЛУУЛАГЧ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭГЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ БАГАСГАХ, ДАХИН АШИГЛАХ, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ЗАМААР УРТ ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

#### 3.6.1. Хог хаягдлын хэмжээнд суурилсан үнийн системийг хэрэгжүүлэх

МУ-ын хог хаягдлын тухай хуулийн 41.5-д “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг үүсгэж байгаа хог хаягдлын хэмжээнээс хамааруулан тооцно” хэмээн заасан байдаг бөгөөд хог хаягдлын үнэ тарифийг тогтоох ерөнхий зарчим дэлхий нийтээрээ бохирдуулагч төлөх, хог хаягдлын хэмжээнд тохирсон төлбөр төлөх зарчмыг үндэс болгон хэрэгжүүлж байна. Иймд энэхүү төлөвлөгөөнд энэ зарчмыг ажил болгох, хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэх арга замыг тооцоолон оруулж байна.

Дархан сумын хэмжээнд нийт 2021 онд 25656 айл өрх бүртгэлтэй байна. Айл өрхийн хог тээврийн төлбөрийг оновчтой зохион байгуулахын тулд бид хог тээврийн төлбөрийг хогийн уут борлуулах замаар гарган авах арга замыг сонгон судалгаа хийсэн. Уг судалгаанд айл өрхийн буюу гэр хорооллын айл, орон сууцны айл, амины орон сууцны хорооллын айл өрхийн судалгааг, мөн эдгээр айл өрхийн хог хаягдлын хэмжээ, хогийн бүтцийн судалгаанд үндэслэлээ.

Хүснэгт 61. Дархан сумын айл өрхийн хог хаягдлын уутны өртөг, орлого, ашиг

Хогийн уут		Айл өрх хогийн уутны хэмжээ					Нийт хогийн уутны хэмжээ
		Хэмжээ	20*30	20*40	45*50	45*55	
2022	Орлого	63,435,024	67,166,496	195,902,280	251,874,360	363,818,520	942,196,680
	өртөг	28,863,608	30,787,849	75,045,381	86,590,824	98,136,268	319,423,930
	<b>Нийт ашиг</b>	<b>34,571,416</b>	<b>36,378,647</b>	<b>120,856,899</b>	<b>165,283,536</b>	<b>265,682,252</b>	<b>622,772,750</b>
2023	Орлого	64,066,608	67,835,232	197,852,760	254,382,120	367,440,840	951,577,560
	өртөг	29,964,153	31,961,764	77,906,799	89,892,460	101,878,122	331,603,298
	<b>Нийт ашиг</b>	<b>34,102,455</b>	<b>35,873,468</b>	<b>119,945,961</b>	<b>164,489,660</b>	<b>265,562,718</b>	<b>619,974,262</b>
2024	Орлого	64,695,744	68,501,376	199,795,680	256,880,160	371,049,120	960,922,080
	өртөг	31,009,265	33,076,549	80,624,089	93,027,795	105,431,501	343,169,198
	<b>Нийт ашиг</b>	<b>33,686,479</b>	<b>35,424,827</b>	<b>119,171,591</b>	<b>163,852,365</b>	<b>265,617,619</b>	<b>617,752,882</b>
2025	Орлого	65,327,328	69,170,112	201,746,160	259,387,920	374,671,440	970,302,960
	өртөг	32,003,203	34,136,750	83,208,328	96,009,610	108,810,891	354,168,782
	<b>Нийт ашиг</b>	<b>33,324,125</b>	<b>35,033,362</b>	<b>118,537,832</b>	<b>163,378,310</b>	<b>265,860,549</b>	<b>616,134,178</b>
2026	Орлого	67,896,360	71,776,152	206,598,924	267,705,648	384,099,408	998,076,492
	өртөг	32,945,931	35,142,326	85,659,420	98,837,793	112,016,165	364,601,635
	<b>Нийт ашиг</b>	<b>34,950,429</b>	<b>36,633,826</b>	<b>120,939,504</b>	<b>168,867,855</b>	<b>272,083,243</b>	<b>633,474,857</b>
2027	Орлого	68,546,520	72,463,464	208,577,268	270,269,136	387,777,456	1,007,633,844
	өртөг	33,842,469	36,098,634	87,990,420	101,527,408	115,064,396	374,523,328
	<b>Нийт ашиг</b>	<b>34,704,051</b>	<b>36,364,830</b>	<b>120,586,848</b>	<b>168,741,728</b>	<b>272,713,060</b>	<b>633,110,516</b>
2028	Орлого	69,194,160	73,148,112	210,547,944	272,822,688	391,441,248	1,017,154,152
	өртөг	34,693,117	37,005,991	90,202,104	104,079,350	117,956,597	383,937,159




## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

	<b>Нийт ашиг</b>	<b>34,501,043</b>	<b>36,142,121</b>	<b>120,345,840</b>	<b>168,743,338</b>	<b>273,484,651</b>	<b>633,216,993</b>
<b>2029</b>	Орлого	69,844,320	73,835,424	212,526,288	275,386,176	395,119,296	1,026,711,504
	өртөг	35,503,224	37,870,105	92,308,382	106,509,671	120,710,961	392,902,344
	<b>Нийт ашиг</b>	<b>34,341,096</b>	<b>35,965,319</b>	<b>120,217,906</b>	<b>168,876,505</b>	<b>274,408,335</b>	<b>633,809,160</b>
<b>2030</b>	Орлого	70,491,960	74,520,072	214,496,964	277,939,728	398,783,088	1,036,231,812
	өртөг	36,273,104	38,691,311	94,310,071	108,819,313	123,328,555	401,422,356
	<b>Нийт ашиг</b>	<b>34,218,856</b>	<b>35,828,761</b>	<b>120,186,893</b>	<b>169,120,415</b>	<b>275,454,533</b>	<b>634,809,456</b>
<b>2031</b>	Орлого	71,142,120	75,207,384	216,475,308	280,503,216	402,461,136	1,045,789,164
	өртөг	37,008,155	39,475,365	96,221,202	111,024,464	125,827,726	409,556,913
	<b>Нийт ашиг</b>	<b>34,133,965</b>	<b>35,732,019</b>	<b>120,254,106</b>	<b>169,478,752</b>	<b>276,633,410</b>	<b>636,232,251</b>
<b>2032</b>	Орлого	71,789,760	75,892,032	218,445,984	283,056,768	406,124,928	1,055,309,472
	өртөг	37,708,510	40,222,411	98,042,126	113,125,530	128,208,934	417,307,512
	<b>Нийт ашиг</b>	<b>34,081,250</b>	<b>35,669,621</b>	<b>120,403,858</b>	<b>169,931,238</b>	<b>277,915,994</b>	<b>638,001,960</b>

Айл өрхийн хэрэгцээнд гарган ашиглагдах хог хаягдлын уутны 20\*30 хэмжээс нь 2 кг, 20\*40 хэмжээс нь 3кг хүнсний хог хаягдлыг бор уутанд, 45\*50 хэмжээс нь 5кг, 45\*55 хэмжээс нь 7 кг, 55\*70 хэмжээс нь 15 кг-ийн багтаамжтай ахуйн хог хаягдлын хар, шар уут байх болно (Хавсралт 10).

Уутны үнийн тогтоохдоо хог хаягдлын уут үйлдвэрлэдэг 6 үйлдвэрээс үнийн санал ба мөн инфляцийн хандлагад (Хавсралт 9) үндэслэн тооцсон.

Уг уутыг хэрэглээнд ашигласнаар айл өрхийн хог тээврийн төлбөрийг байцаагч хураах биш борлуулж буй хог хаягдлын уутнаас хураамжийн төлбөр шингээгдэн борлогдох болно.



Зураг 99. Хог хаягдлын орлого зарлагын тооцоолол

2022 оны байдлаар айл өрхөд шаардлагатай нийт хогийн уутны хэмжээ хамгийн багадаа 3.638.185 ширхэг уут буюу 240.140 багц уутны хэрэгцээг хангахын тулд 319.423.930 төгрөг шаардагдаж байна.

2022 онд борлуулалтын орлогын хэмжээ 942.196.680 төгрөг болж хог хаягдлын уут борлуулснаас олох ашиг 622.772.750 төгрөг байна.

Хүснэгт 62. Дархан сумд үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ААН-н хог хаягдлын уутны өртөг, орлого, ашиг

Хогийн уут	ААН-н хогийн уутны хэмжээ			Нийт
	20*40	55*70	60*80	
Хэмжээ				
Багцын тоо	15	15	15	

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022	Шаардлагатай хэмжээ	26.412	26.412	26.412	79.236
	Өртөг	800	1.700	2.000	
	Нийт өртөг	21.129.600	44.900.400	52.824.000	<b>118.854.000</b>
	Борлуулах үнэ	1.600	6.500	7.800	
	Нийт орлого	42.259.200	171.678.000	206.013.600	<b>419.950.800</b>
	нийт ашиг	21.129.600	126.777.600	153.189.600	<b>301.096.800</b>

ААН-ийн хувьд 20\*40, 55\*70, 60\*80 гэсэн хэмжээтэй хог хаягдлын уутыг ашиглана гэж тооцсон.


2022 оны байдлаар ААН -д 79.236 багц хогийн уут шаардлагатай гэсэн үндсэн дээр 118.854.000 төгрөг бүхий өртөгтэй, 301.096.800 төгрөгийн ашиг олно гэж тоосон.

2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн Дархан сумын ИТХ-ын ээлжит хуралдаанаар хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 2020 оны нийт хураамжийн орлого 592.100.000 төгрөг байна.

### Хүснэгт 63. 2020 он 2021 оны нийт орлогын харьцуулалт

№	Орлогын бүтэц	2020	2022
1	Айл өрхүүдээр	334.536.500	622.772.750
2	ААН байгууллагаар	257.563.500	301.096.800
3	Томоохон ААН		23.400.000
<b>Нийт</b>		<b>592.100.000</b>	<b>947.269.550</b>

2022 оноос хогийн уут борлуулж олох орлогын 947.269.550 төгрөг гэж тооцоолж байна. Хогийн уут борлуулж хогийн хураамжийн орлогыг бүрдүүлснээр 2020 оныхоос 37.5% -аар нэмэгдэхээр байна.



Зураг 100. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого ба зарцуулалт

Үүнээс харахад 2020 онд хог тээвэртэй холбоотой гарсан зардал орлогоосоо 217.9 сая төгрөгөөр давсан үзүүлэлттэй байсан бол 2022 онд хогийн уут борлуулсан орлого нь зардлаас 96.6 сая төгрөгөөр давахаар байна.

### 3.6.2. Үйлдвэрлэгч хариуцлага хүлээх системийг хэрэгжүүлэх

Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын систем (Extended Producer Responsibility) нь үйлдвэрлэгчдэд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийхээ ашиглалтын болон амьдралын мөчлөг дуусах хүртэлх дахин ашиглах, боловсруулах, устгах хариуцлагыг хүлээлгэдэг бодлогын үзэл баримтлал юм. Энэ систем нь үйлдвэрлэгчдэд бүтээгдэхүүнээ зохион бүтээхдээ байгаль орчинд гарах үр дагаврыг анхаарч үзэх шаардлагыг зүй ёсоор тавьдаг. Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын системийг Япон, Солонгос, АНУ, Канад, Австрали болон Европын 30 гаруй оронд амжилттай хэрэгжүүлдэг сайн туршлагууд бий. Эдгээр улс орнуудын туршлагаас харахад үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчид нэгдэн холбоо байгуулан хамтран ажилладаг ба төлбөрт суурилсан бизнесийн загвар хэлбэрээр хөгжсөн байдаг. Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын системийг сайн дурын хэлбэрээр бус төрөөс зохион байгуулалттайгаар эрх зүйн орчныг бүрдүүлж, бүртгэл мэдээллийн системийг сайжруулан, хяналт болон урамшууллын системийг оновчтой болгон нэвтрүүлэх нь хамгийн тогтвортой хэрэгжих үндэс болдог.

МУ-ын хог хаягдлын тухай хуулийн 10 болон 40 дүгээр зүйлээр үйлдвэрлэгч болон ААН үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг дахин ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах, устгахад хүлээх хариуцлагыг тодорхойлон тусгасан байдаг.

Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 13-ний өдрийн А-429/257 дугаар тушаалаар батлагдсан “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт” нь үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын системийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс болно. Уг тушаалд үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагааг хариуцна гэж заасан бөгөөд дараах 11 төрлийн хог хаягдлыг хамруулсан байдаг. Үүнд:

1. Хуванцар сав суулга, түүхий эд;
2. Нийлэг уут түүний түүхий эд;
3. Бүх төрлийн зай хураагуур, аккумулятор;
4. Хими цэвэрлэгээний бодис;
5. Шилэн лонх сав;
6. Өндөр даралтат сав;
7. Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол;
8. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн сэлбэг хэрэгсэл, дугуй;
9. Бүх төрлийн машин механизмын тос, тосолгооны бүтээгдэхүүн;
10. Мөнгөн ус агуулсан бараа бүтээгдэхүүн;
11. Аюултай хог хаягдал

Дархан сумын нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ААН байгууллагуудын хүрээнд 28 холбоод, ТББ болон 117 хоршоод үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд зарим чиглэлийн бизнес эрхлэгчдийг зохион байгуулалтад оруулж мэргэжлийн холбоонуудаар дамжуулан үйлдвэрлэгч хариуцлага хүлээх системийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Энэ бодлогын хүрээнд Дархан сумын засаг дарга холбоодын тэргүүнтэй “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч, борлуулагч хариуцах” гэрээг байгуулан ажиллах ба тухайн холбооны тэргүүн холбооны бусад гишүүн байгууллагуудтай хамтран ажиллах хариуцлагын гэрээг байгуулан ажиллана.

### 3.6.3. Төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх

Нийгмийн суурь үйлчилгээг тогтвортой үзүүлэх чадавхыг сайжруулах зорилгоор төр хувийн хэвшлийн түншлэлийг дараах нийтлэг загваруудаар хэрэгжүүлдэг.



Зураг 101. Төр хувийн хэвшлийн түншлэлийн загварууд

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татсанаар төслийг хэрэгжүүлэхээс өмнө эрсдэлийг нарийвчлан тодорхойлох чадавхыг нэмэгдүүлэх боломжтой юм. Ашиг нь амжилттай хэрэгжих төслөөс хамаарах учир хөрөнгө оруулагч нь ТХХТ-ийн төслийн гэрээний бүх талын шинжилгээг нухацтай хийж, эрсдэлийг тодорхойлон, зохистой хуваарилж, боломжтой тохиолдолд бууруулахыг эрмэлздэгээрээ давуу талтай. Ингэснээр нийт зардлыг бууруулахаас гадна ТХХТ нь төрөөс үзүүлж буй үйлчилгээний зардлын хэлбэлзлийг багасгаж, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах ба гэнэтийн хямралыг даван туулах төсвийн чадварыг сайжруулдаг. Энэхүү өгөөж нь үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрсдэлийг талуудад зохистой хуваарилснаар бий болох боловч ТХХТ-ийн гэрээгээр хуваарилсан эрсдэлийг удирдан зохицуулах хувийн хэвшил талын чадвараас хамаардаг.


Олон улсын хэмжээнд “ТХХТ” хэмээх нэр томъёог төрийн болон хувийн секторын аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулдаг олон төрлийн гэрээний талаар ярихдаа ашигладаг бөгөөд ТХХТ-ийн хөтөлбөр нь өргөжин хөгжихийн хэрээр улс орнууд ТХХТ-ийн өөр өөр тодорхойлолтуудыг бий болгон ашиглаж ирсэн байдаг. Гэсэн хэдий ч “ТХХТ-ийн гэрээ гэдэг нь төрийн хийх ёстой нийтийн зориулалттай ажил үйлчилгээг төрийн ба хувийн аж ахуйн нэгж хамтарч хийхээр тэдгээрийн хооронд байгуулдаг удаан хугацааны гэрээ” хэмээн ойлгодог нийтлэг ойлголт дээр тэдгээр тодорхойлолтууд төвлөрч байдаг. Энд гол зүйл нь хамтарч хийх ажиллагаа нь төрийн хийх ажил юм. ТХХТ-ийг тодорхойлох хамгийн энгийн арга нь олон улсын тодорхойлолтуудад нийтлэг тохиолддог гол үндсэн шинжүүдийг сонгон авах юм. Тэдгээр үндсэн шинжүүд нь:

- Төрийн байгууллага болон хувийн компанийн хооронд байгуулах урт хугацааны гэрээгээр хувийн хэвшил нийгмийн тухайн суурь үйлчилгээг үзүүлэх эсвэл энэхүү үйлчилгээний тодорхой хэсгийг үзүүлэхэд хувь нэмэр оруулна
- Хувийн компани үзүүлсэн үйлчилгээний төлбөрөө төслийн орлогоор нөхнө. Орлогын эх үүсвэр нь улс, орон нутгийн төсвөөс, эсвэл хэрэглэгчийн тарифаас

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

санхүүжсэн эсвэл хосолсон хэлбэртэй байж болох бөгөөд орлогын хэмжээ нь үзүүлсэн үйлчилгээний чанар ба хэмжээнээс хамаарна. Тиймээс ТХХТ-ийн гэрээгээр эрсдэлийг, үүний дотор эрэлтийн болон үйлчилгээний боломжит байдлын эрсдэлийг төрөөс хувийн талд шилжүүлнэ. Ингэснээрээ хувийн хэвшил илүү их орлого олохын тулд өмнө нь төрийн үзүүлж байсан үйлчилгээний тоо хэмжээ, чанар, нь илүү сайн болох бололцоотой.

- Хувийн компанид ТХХТ-ийн хүрээнд хөрөнгө оруулалт хийх шаардлага тавих нь түгээмэл бөгөөд наад зах нь ажлын капиталыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлнэ.
- Улс, орон нутгийн төсвөөс зохих эх үүсвэр хуваарилахаас гадна тамгын газар нь төслийг газраар хангах, байршилд нэвтрэх эрх олгох, одоо байгаа эд хөрөнгийг ашиглуулах, зээлийн болон өөрийн хөрөнгийн эх үүсвэрийн зарим хэсгийг санхүүжүүлэх зэрэг тусламж үзүүлж болно. Түүнчлэн тамгын газар нь төслийн эрсдэлийг төр болон хувийн талд зохистой хуваарилахын тулд төрөл бүрийн баталгааг гаргаж болно.
- ТХХТ-ийн гэрээ дуусгавар болоход төслийн эд хөрөнгө нь гэрээнд заасан нөхцөл шаардлагын дагуу төрийн мэдэлд шилжинэ.



Зураг 102. Хог хаягдлын менежментийн ТХХТ-ийн загвар

Дээрх загварын дагуу хог хаягдлын цуглуулалт, татан зайлуулалт, тээвэрлэлт зэрэг үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрсдэлийг хувийн талд шилжүүлснээр ТХХТ нь төсвийн зардлын хариуцлага хүлээх чадварыг сайжруулна. Өөрөөр хэлбэл төсвийн төлбөрийг зөвхөн гэрээний хугацаанд, зохих чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд хийнэ. ТХХТ-ийн төслийн өгөөж нь эрсдэлийг төрийн болон хувийн талд зохистой хуваарилснаас бий болдог. Эрсдэлийг зохистой хуваарилахын тулд төслийн үргэлжлэх хугацаанд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлагыг тодорхой болгосон байх шаардлагатайг анхаарах хэрэгтэй юм. Дархан сумын тухайд эх үүсвэр дээр ангилах, устгах булшлах үйл ажиллагаанаас бусад үйлчилгээг ТХХТ-ээр хэрэгжүүлэх боломжтой юм.




## 3.7. ХОГ ХАЯГДАЛ, ХОРТ БОДИСЫН ЯЛГАРЛААС ҮҮДЭЛТЭЙ ОРЧНЫ БОХИРДЛЫГ ХЯНАХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭГ ӨРГӨЖҮҮЛЖ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ, ХОГ ХАЯГДЛЫН НАРИЙВЧИЛСАН ТОО БҮРТГЭЛ, СУДАЛГАА ХИЙХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗАМААР ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЧАНАРЫН БОДИТ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ

### 3.7.1. Судалгаа шинжилгээ мониторингийн орчныг сайжруулах

Төвлөрсөн хог хаягдлын цэгийн орчим дахь хүрээлэн буй орчны аюулгүй байдал, бохирдол, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг зайлшгүй хянаж, үнэлгээ өгч байх шаардлагатай бөгөөд мониторингийн хяналтын харуулын цэг байгуулах хэрэгтэй. Энэхүү цэг дээр агаар, ус, хөрсний чанарын мониторингийг тогтмол хийх зорилгоор тогтмол дээжлэх, сорьц авах, түүний тодорхойлолт шинжилгээ, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардалыг тусгав. Мөн хогийн цэг орчмын усны төвшин, химийн найрлагад ажиглалт хийж, үр дүнг мэдээллийн сан байгуулж оруулах, хэрэглэгчдэд нээлттэй байлгах хэрэгтэй.

Энэхүү мониторинг нь Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Монгол Улсын бусад холбогдох хуулиудын дагуу хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэх, хэмжилт хийх, холбогдох нарийвчлалыг хангасан багаж тоног төхөөрөмжөөр хяналт шинжилгээг гүйцэтгэнэ.

Хяналт шинжилгээний ажлын хүрээнд агаар, ус, хөрсний чанар, бохирдлын төвшинг дотоод хяналт шалгалтаараа хянах бөгөөд шаардлагатай үед хөндлөнгийн хяналт оруулж, хянуулж байх шаардлагатай.



Зураг 103. Хүрээлэн буй орчны судалгааны төрөл

#### Агаарын чанарын шинжилгээ:

Орчны агаарын чанар муудах, тоосжилт үүсэхэд шороон шуурганы нөлөө их бөгөөд энэ нь тухайн газар нутгийн хөрсний гадаргуу, хог хаягдал, ургамлан бүрхэвч, орон нутгийн цаг уур, салхины горимоос нэлээд хамаардаг. Шороон шуурах үед хуурай хөрсний өчүүхэн жижиг ширхэгтэй тоос, шороо, элс, биологийн гаралтай эгэл хэсгүүд, хог хаягдал газрын гадаргаас агаарт хөөрөх ба энэ нь агаар мандалд хэдхэн нанометрээс хэдэн зуун микрометрийн хэмжээтэй байдаг. Иймд хогийн цэгийн ойролцоох агаар

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

мандлын доод хилийн давхаргад үүсч байгаа тоосжилтыг (PM10, PM2.5) хэмжиж суурь мэдээлэл бүрдүүлэх шаардлагатай. Энэ ажлыг хээрийн хэмжилтийн Dust Trak™ Aerosol Monitor багажийг ашиглан тодорхой заасан хугацаанд хийж агаарын чанарын бусад цэгүүдтэй харьцуулж мониторинг хийнэ. Хэмжилт хийх үеийн цаг агаарын төлөв байдал, агаар, хөрсний температур, салхины хурд, чиглэл, агаарын харьцангуй чийг зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлж тэмдэглэл хамт хөтөлнө. Мөн хаягдлаас орчинд үүсэх бусад хий байдалтай бохирдуулагчдын (SO<sub>2</sub>, NO<sub>x</sub>, CO, O<sub>3</sub>, CO<sub>2</sub>, CH<sub>4</sub>, бенз-а-пирен, диоксин, фуран гэх мэт) шинжилгээг зориулалтын лабораторид болон магадлан итгэмжлэгдсэн лабораторид хийлгэх, үр дүнг бүртгэлжүүлэн мэдээллийн санд оруулж, хадгалж байх шаардлагатай.

### Усны чанарын шинжилгээ:

Усны төвшингийн хэмжилтийг “плоппер” буюу усны төвшинг хэмжигчээр хэмжинэ. Усны статик төвшинг ямагт хэмжилт хийх байнгын хатуу цэгээс хэмжиж метрээр илэрхийлнэ. Хогийн цэгийн ойролцоох 5 худаг, Хөтөл хорооллын айл өрхийн 3 худаг зэрэг нийт 8 цэгийн химийн шинжилгээ болон худгын усны төвшинг хэмжиж өөрчлөлтийг хянана (Бараатын худгийн GIS цэгүүд).

Усны шинжилгээний дээжийг хогийн цэгийн ойролцоох цооног эсвэл худгаас авна. Усны чанарын үзүүлэлтийг улиралд нэг удаа хийх бөгөөд усны физик, химийн шинжилгээ хийх автомат багажуудыг ашиглан хийнэ. Дээжийг зориулалтын ариутгасан нэг удаагийн саванд авах ба (500мл) нэг цэгээс 1 л-ээс доошгүй дээж авна. Дээжийн дугаар, дээж авсан он, сар, өдөр, дээж авсан цэгийн дугаар, нэрийг дээжийн саван дээр бичнэ. Дээжийг авахдаа дээжний савны амсарыг дүүргэж, аль болох хий оруулалгүй авч битүүмжлэнэ.

Гүний усны хяналт шинжилгээнд хамрагдаж байгаа хогийн цэгийн ойролцоох цооног эсвэл худгуудын усны дээжинд физик үзүүлэлт болох усны орчин (pH), цахилгаан дамжуулах чадвар (E.C), жигнэгдэх бодис (TDS), исэлдэн ангижрах потенциал (ORP) болон температурыг хээрийн багаж ашиглан хэмжинэ. Химийн шинжилгээг зориулалтын лабораторид шинжлэх бөгөөд гол ионууд, ууссан хүчилтөрөгч, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, химийн хэрэгцээт хүчилтөрөгч, биогений элементүүд, шим бохирдол үүсгэгчид, гол бохирдуулагч хүнд металлыг тодорхойлно.

### Хөрсний чанарын шинжилгээ:

Хөрс нь агаарт цацагдсан хорт бодис, утаа тортог, газар дээрх хуурай нойтон хог хаягдлаар бохирддог. Ялангуяа хүн, амьтны хатуу ба шингэн хаягдал, ургамлын үлдэгдэл, ахуйн ба үйлдвэрийн бохир ус зэрэг нь бохирдуулагч эх үүсвэр болдог. Хөрсний гол бохирдол нь химийн (хүнд металлууд, цацраг идэвхт бодисууд, нефтийн нүүрс ус, хуванцар болон органик материал, эрдэс бордоо гэх мэт) болон биологийн (мал амьтны сэг, хөдөө аж ахуйн, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлууд гэх мэт) бохирдол байдаг. Иймд төвлөрсөн хогийн цэгийн ойролцоох хөрсний өнгөн хэсгийн 3 цэгээс болон тодорхой гүний дээжээс агрохимийн шинж чанар pH, CaCO<sub>3</sub>, ялзмаг, механик бүрэлдэхүүн, хүнд металлын агуулгыг тодорхойлж экологийн эрсдэлийн үнэлгээ хийнэ. Мөн микро биологийн шинжилгээг зориулалтын лабораторид хийлгэж нянгийн бохирдлыг тодорхойлуулна.





### Хүснэгт 64. Орчны шинжилгээний үзүүлэлт, давтамж

№	Агуулга	Хаана	Үзүүлэлт	Давтамж
1	Агаарын	Төвлөрсөн хогийн цэг орчмын 3 цэгт	Тоосжилт (PM10, PM2.5)	Өдөр бүр тодорхой цагт
2			Хорт хийнүүд SO <sub>2</sub> , NO <sub>x</sub> , CO, CO <sub>2</sub> , O <sub>3</sub> ,	
4			Органик дэгдэмхий хий CH <sub>4</sub> (C <sub>20</sub> H <sub>12</sub> )	

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

5	Усны	Төвлөрсөн хогийн цэг орчмын 5 худаг, айл өрхийн 3 худагт	Усны орчин (pH), Цахилгаан дамжуулах чадвар (E.C), жигнэгдэх бодис (TDS), Исэлдэн ангижрах потенциал (ORP) болон температур зэрэг физик үзүүлэлтүүд	Улиралд 1 удаа
6			Гол ионууд, УХ, БХХ, ХХХ, биогений элементүүд, шим бохирдол үүсгэгчид	
7			Хүнд металлууд	
8			Нефтийн бүтээгдэхүүн	
9			Микро биологийн шинжилгээ	
10	Хөрсний	Хогийн цэг орчмын 3 цэгээс	Агрохимийн шинж чанар pH, CaCO <sub>3</sub> , ялзмаг, механик бүрэлдэхүүн	Жилд 2 удаа
11			Хүнд металлын агуулга	
12			Микробиологийн шинжилгээ	

Хүснэгт 65. Орчны шинжилгээнд хэрэглэгдэх багаж, төхөөрөмж

№	Агуулга	Үзүүлэлт	Багаж	Зориулалт	Үнэ /сая/
1		Тоосжилт (PM10, PM2.5)		Dust Truck II- Aerosel Monitor 8530 Тоосны хэмжилтийн багаж	26.0
		Хорт хийнүүд, CO, CO <sub>2</sub> , H <sub>2</sub> S		Portable Internal Gas Pump Co, CO <sub>2</sub> , H <sub>2</sub> S, Ex Toxic Gas Detector	1.9
		O <sub>3</sub> , SF <sub>6</sub> , CH <sub>2</sub> O, TVOC, CO, H <sub>2</sub> S, NO <sub>2</sub> , NO, SO <sub>2</sub> , CL <sub>2</sub> , NH <sub>3</sub> зэрэг хийнүүд		Handheld gas detector ZA-XM-E-03	3.5
	Агаар	CO, NO <sub>x</sub> , SO <sub>2</sub> , тоос, тоосонцор		Determination of CO, NO <sub>x</sub> , SO <sub>2</sub> , PM <sub>2.5</sub> and PM <sub>10</sub> by automatic analyzers	280.0

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Агаарын чанарын мэдээг олон нийтэд хүргэх LCD дэлгэц		wall mounted lcd screen signage outdoor advertising player with android or windows system	12.0
2	Ус	Усны физик шинж чанар тодорхойлох: Температур, Цахилгаан дамжуулах чадвар, Давслаг, Усны орчин		Extech EC500 Waterproof ExStik II pH/Conductivity/TDS/Salinity/Temperature Meter	0.6
		рН, УХ, ЕС, Жигнэгдэх бодис (TDS), Исэлдэн ангижрах потенциал (ORP), NO3, Cl, NH4		Hanna HI9829 Multiparameter	25.0
		Зарим эрдэс элемент, био гений элементүүд, шим бохирдол үүсгэгчид		Hanna HI83308 Photometer	6,0
		Хүнд металлууд		Atomic Absorption Spectrometer--Aas	300.0
		Нефтийн бүтээгдэхүүн, бусад анализид		UV/VIS Spectrophotometer	15.0
		Микробиологийн шинжилгээ		Тарьж өсгөвөрлөх аргаар /зориулалтын лабораторит/	5
3	Хөрс	Агрохимийн шинж чанар рН, CaCO <sub>3</sub> , ялзмаг,		УЦУОШТ-д тодорхойлж байгаа аргачлалаар	5

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

	механик бүрэлдэхүүн			
	Хүнд металлын агуулга		Atomic Absorption Spectrometer-- Aas	Усны хүнд металлын багажийг ашиглана
	Хөрсний элементийн шинжилгээ хийх		Skraray Explorer 9000 XRF Хөрсөнд олон элемент тодорхойлох Германы багаж GPS, WIFI, Bluetooth системтэй	85.0
	Микробиологийн шинжилгээ		Тарьж, өсгөвөрлөх аргаар /зориулалтын лабораторит/	Устай ижил
	Урвалж, химийн бодис			5
	<b>Нийт дүн</b>			<b>770.0</b>

Хогийн цэгийн орчны хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй химийн хорт болон бусад бодисын тоо мэдээ, агуулгын хэмжээ мэдээллийг байгаль орчны болон төрийн захиргааны төв байгууллага, нийтэд нээлттэй болгож, тухайн мэдээллийг цахим хэлбэрээр түгээж байх хэрэгтэй.

Олон нийт ч амьдарч буй орчных нь агаар, ус, хөрсний чанар, бохирдлын хэмжээ үзүүлэлтүүд ямар төвшинд байгааг мэдээллийн хэрэгслээр шууд харах, мэдэх эрхтэй тул энэ чиглэлээрх үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгах үүднээс нэгдсэн мэдээллийн санг ажиллуулж үр дүнг хотын төвд LCD дэлгэцээр мэдээлэх, веб сайт, ухаалаг гар утас, аппликат ашиглан түгээх ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

Энэхүү мэдээллийн санд зөвхөн хогийн цэг орчмын орчны чанар бус Дархан сумын байгаль орчны мониторингийн үр дүнг бүхэлд нь харуулж байх цогц мэдээллийн үйлчилгээ багтана. Үүнд дараах агуулгуудыг багтаавал ач холбогдол өндөртэй байх болно.

- Агаарын чанарын үзүүлэлтийг өдөр, сар, жилээр харуулсан график;
- Төрөөс үзүүлж байгаа цахилгааны үнийн хөнгөлөлтийн талаарх мэдээлэл, хөнгөлөлтөд хамрагдах зааварчилга;
- Тээврийн хэрэгслийн оношилгооны дүн мэдээлэл, экологид ээлтэй хэрэглээг дэмжсэн бодлого зохицуулалт;
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, түүний хэрэгжилтийн үр дүн, тайлан;
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээрх бодлого, шийдвэр, эрх зүйн баримт бичгүүд,
- Агаар, ус, хөрсний бохирдолтой холбоотой цаг үеийн үйл ажиллагааны мэдээлэл;



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Агаар, ус, хөрсний бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс хамгаалах эрүүл мэндийн зөвлөгөө
- Цэвэр усны зөв хэрэглээ, ус хэмнэлтийн талаарх мэдээлэл
- Усны нөөц, ус бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн үр дүн, тайлан
- Хөрсний судалгаа, бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн, тайлан
- Цаг уурын үзүүлэлтүүд болон бусад мэдээллийг нэмэх боломжтой

Мэргэжлийн энэ мэдээллийн системийг хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээллийн эх сурвалжаа болгон ашиглаж болно.

Дээрх хяналт шинжилгээг хэвийн явуулахад шаардлагатай лабораторийн чадавхыг сайжруулахад 525.2 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай.

## 3.7.2. Хяналт, мэдээллийн орчныг сайжруулах

Хог хаягдлын үйлчилгээтэй холбоотой зөрчлүүдийг багасгах цаашид бүрэн арилгах зорилгоор "Хог хаягдлын хяналтын төв" байгуулах шаардлагатай. Энэ нь нийтийн эзэмшлийн гудамж талбайд хог ихээр үүсдэг байршлыг сонгон эрүүл ахуйн шаардлага хангасан өнгө үзэмж, багтаамж сайтай, битүү хогийн савыг байрлуулж, гэрэлтүүлэг, камер бүхий орчныг бий болгож нэгтгэн хянах удирдлагын төв юм. Тус төв нь хог хаягдлын цэвэрлэгээ, үйлчилгээ, тээвэрлэлтийг бүрэн хянах, мөн ил задгай хог үүсэх, зөрчил гаргаж буй иргэн байгууллага, аж ахуйн нэгжийг илрүүлэх, цаашлаад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон талын ач холбогдолтой юм.



Зураг 104. УБ хотын Сүхбаатар дүүргийн "Хог хаягдлын ухаалаг систем

Хяналтын төв нь Дархан сумын хог ихээр төвлөрсөн болон хууль бус хог хаягддаг байршлууд мөн орон сууц, гэр хорооллын хог ангилан хаях цэгүүдэд байршина.

Дархан сумыг тойрсон тог цахилгаан байхгүй алслагдмал 5 байршилд нарны эрчим хүчээр ажилладаг камерууд суурилуулна.

Хүснэгт 66. Тоног төхөөрөмжийн төсөв /Хяналтын төв/


№	Бараа бүтээгдэхүүний нэр	Марк үзүүлэлт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	UNIVIEW 2MP 4MM / POE / шөнө өнгөтөөр хардаг гадаа IP камер	Брэнд: UNV Зориулалт: Гадна IP камер Нягтрал: 2MP Линз: 4 мм Харах өнцөг: 90 градус харна Шөнийн харалт: 30метр Видео шахалтын формат: H.265+	32	180.000	5.760.000
2	Бичигч төхөөрөмж UNIVIEW NVR 16ch Up to 6MP	UNIVIEW NVR 16 сувагтай бичигч төхөөрөмж Модель: NVR301-16E Оролт/ Гаралт : HDMI болон VGA гаралттай Суваг: 16 порттой 16 камер холбох боломжтой Бичлэг : 8мр хүртэл хэмжээний	4	350.000	1.400.000

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

		бичлэг хүлээж авна. Орчны температурт: -10с -аас +55с			
3	18X2MP Нарны панел, хяналтын камер	Гадна PTZ 360 IP камер Өдөр шөнийн тусгалтай Нягтрал: 2 megapixel Линз: 3.6мм Харах өнцөг: 180 градус Шөнийн тусгал: 50метр Оптик таталт: 18х Бичлэгийн өргөтгөл: H265+	5	2.500.000	12.500.000
4	Камер суурилуулах хөл	Бетон шон	5	450.000	2.250.000
3	PTZ удирдлага	Brand:SKU: VK KB1100 Barcode: UNIVIEW брендийн PTZ камерын удирдлагын төхөөрөмж	1	650.000	650.000
4	Свитч:	Brand:SKU: TD TEG1024D Barcode: -24port 100/1000 Rack -Хяналтын камер цуглуулагч төхөөрөмж	3	260.000	780.000
5	ХАРД ДИСК:	Төрөл: Дотоод Модель: HDD Хатуу дискний багтаамж: 2ТВ	1	220.000	220.000
6	Гадна камерын утас:	STP CAT6	10000	900	9.000.000
7	Хяналтын дэлгэц	Brand: SKU: TV-50 H2800 Barcode: -HPP 50inch -Хяналтын камер хянах зориулалттай	4	880.000	3.520.000
8	Зөөврийн компьютер	Brand: SKU: DELL INSPIRON 5593 Barcode: CPU: INTEL I7-1065G7H RAM: 8GB HARD: 500GB SSD	1	2.365.000	2.365.000
9	Принтер	Brand: SKU: M-130FW Barcode: Функц: Хэвлэх, хувилах, сканнер, факс Хэвлэх, хувилах нягтрал: 600 х 600dpi Сканнер нягтрал: 1200 х 1200dpi ADF Автомат цаас татагч - 35 хуудас Дэлгэц: 2.7 in touch screen, LCD (color graphics)	1	627.000	627.000
10	Бусад				1.000.000
<b>Нийт</b>					<b>40.072.000</b>


## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дархан сумын хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд эх үүсвэрээс гарч байгаа хог хаягдлын ангилал бүрээр судалгаа, тооцоо хийхэд шаардлагатай мэдээллийн нэгдсэн санг байгуулна.



Зураг 105. Хог хаягдлын мэдээллийн сангийн тогтолцоо

Мэдээллийн сангийн хэвийн ажиллагаа, тоо баримтын үнэн байдлыг хангах үүднээс хаягдал үүсгэгчид болон хамрагдах аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргаж, бодит мэдээлэл цуглуулах шаардлагатай.



Зураг 106. Хог хаягдлын мэдээллийн сангийн бүтэц

Хаягдал үүсгэгч бүрд бүртгэлийн дугаар олгох бөгөөд хог хаягдлын мэдээг батлагдсан маягтын дагуу мэдээллийн санд байршуулна.

Мэдээллийн сангийн бүртгэл, судалгааны ажлыг БОАЖГ-ын хог хаягдал хариуцсан мэргэжилтэн хариуцан ажиллана. Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг зөвхөн албан хэрэгцээнд ашиглах ба байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад холбогдох хугацаанд мэдээлж байна.

## 4. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 4.1. САНХҮҮГИЙН ТООЦОО

Хүснэгт 67. Нийт зардал /сая.төг/

Зардлын төрөл		Зардал	Эзлэх хувь	Хэрэгжүүлэлтийн үе шат		
				᠒᠐᠒᠒	᠒᠐᠒᠓	᠒᠐᠒᠔
<b>Үйл ажиллагааны зардал:</b>		<b>36,685.15</b>	<b>64.22</b>	<b>8,672.52</b>	<b>13,560.91</b>	<b>14,451.72</b>
1	Хөдөлмөр, хүний нөөц	28,334.75	49.60	6,446.20	10,492.24	11,396.31
2	Хогийн уут	4,094.20	7.17	994.24	1,477.23	1,622.73
3	Хог татан авалт, тээвэрлэлт, ложистик	1,474.88	2.58	402.24	536.32	536.32
4	Нийтийн эзэмшлийн зам, талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ	573.11	1.00	198.31	187.40	187.40
6	Дахивар авах төвийн үйл ажиллагаа	1,017.68	1.78	272.88	372.40	372.40
7	Овор хэмжээ ихтэй болон электрон хаягдал цуглуулах төвийн үйл ажиллагаа	456.35	0.80	119.79	168.28	168.28
8	Хяналтын төвийн үйл ажиллагаа	734.18	1.29	238.86	327.04	168.28
<b>Удирдлагын зардал:</b>		<b>1,373.50</b>	<b>2.40</b>	<b>912.10</b>	<b>336.05</b>	<b>125.35</b>
1	Иргэд, олон нийтийн сургалт, нөлөөллийн ажил	1,003.50	1.76	602.10	301.05	100.35
2	Хог хаягдлын мэдээллийн сан байгуулах	200.00	0.35	200.00		
4	Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах үйл ажиллагааны хэвлэлийн зардал	50.00	0.09	30.00	15.00	5.00
5	Мониторинг, үнэлгээ	60.00	0.11	20.00	20.00	20.00
6	Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфиллын ТЭЗҮ боловсруулах	60.00	0.11	60.00		
<b>Хөрөнгө оруулалтын зардал:</b>		<b>19,066.63</b>	<b>33.38</b>	<b>14,904.90</b>	<b>3,570.06</b>	<b>591.67</b>
1	Нэмж байгуулах дахивар авах төв	39.00	0.07	39.00		
2	Сэргээн засварлах төв	525.00	0.92	262.50	262.50	
3	Овор хэмжээ ихтэй болон электрон хаягдал авах төв	117.89	0.21	58.94	58.94	
4	Гэр хорооллын айлуудын хог түр хадгалах сав	5,033.00	8.81	5,033.00		
5	Орон сууцны хорооллын хог түр хадгалах сав	783.00	1.37	783.00		
6	Судалгаа, шинжилгээний орчныг сайжруулах	770.00	1.35	490.00	280.00	
7	Хяналтын тоног төхөөрөмж	40.10	0.07	40.10		
8	Хог тээвэрлэлтийн техник болон парк шинэчлэл	3,674.10	6.43	1,783.80	1,371.90	518.40
9	Бараат хогийн цэгийн дахин төлөвлөлтийн хөрөнгө оруулалт	3,688.94	6.46	3,423.56	192.12	73.27
10	Хуванцар боловсруулах үйлдвэр	1,981.00	3.47	1,981.00		
11	Компост бордооны үйлдвэр	855.00	1.50	855.00		
12	Яс боловсруулах үйлдвэр	445.00	0.78		445.00	
13	Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр	959.60	1.68		959.60	
14	Эмнэлгийн хог татан зайлуулах, устгах үйл ажиллагаа	155.00	0.27	155.00		
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>57,125.29</b>	<b>100.00</b>	<b>24,489.53</b>	<b>17,467.02</b>	<b>15,168.74</b>
Эзлэх хувь				42.87	30.58	26.55



## САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 4.2. САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР

Хүснэгт 68. Санхүүгийн эх үүсвэр

№	ЗОРИЛТУУД	Нийт төсөв	Үүнээс: /сая төгрөг/				
			Орон нутгийн төсөв	Улсын төсөв	Хог хаягдлын төлбөр, хураамж	ОУ-ын төсөл, хөтөлбөр	Иргэн, аж ахуйн нэгж
1	Иргэд, олон нийтэд ногоон хэрэглээний соёл, эх үүсвэр дээр бууруулах, хог хаягдлыг ангилан ялгах, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх	14,068.4	18,483.3		7,841.0	3,726.5	1,017.7
2	Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэд оруулах, ногоон ажлын байр бий болгох, жижиг дунд бизнесийг дэмжих, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх	33,674.6	11,760.7			1,983.2	8,170.2
3	Үйлдвэрлэлийн хог хаягдал болон Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулж байгаль орчинд ээлтэй аргаар зайлуулах чадавхыг бий болгох	155.0		155.0			
4	Булж зайлуулах хог хаягдлын хэмжээг бууруулах, хогийн төвлөрсөн цэгийн байгаль орчинд халгүйгээр тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, техник хангамжыг сайжруулах	7,423.0	60.0	6,082.2		987.7	293.1
5	Хог хаягдлын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгож хэрэгжилтийг сайжруулах, хяналт болон урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, борлуулагч болон үйлдвэрлэгч үйлдвэрлэлийн нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, дахин ашиглах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгох	834.3	60	7743			
6	Хог хаягдал, хорт бодисын ялгарлаас үүдэлтэй орчны бохирдлыг хянах хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, судалгаа шинжилгээний лабораторийн чадавхыг бэхжүүлэх, хог хаягдлын нарийвчилсан тоо бүртгэл, судалгаа хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх замаар хүрээлэн буй орчны чанарын бодит мэдээллээр хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах	970.0				970	
<b>НИЙТ</b>		<b>57,125.3</b>	<b>13,363.9</b>	<b>12,689.9</b>	<b>7,841.0</b>	<b>13,749.5</b>	<b>9,480.9</b>
<i>Төсөвт эзлэх хувь</i>		100.0	23.4	22.2	13.7	24.1	16.6

## САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 69. Санхүүгийн эх үүсвэр (Зардлын төрлөөр)

Орон нутгийн төсөв	Улсын төсөв	Хог хаягдлын төлбөр, хураамж	ОУ-ын төсөл, хөтөлбөр	Иргэн, аж ахуйн нэгж
Нийтийн эзэмшлийн зам, талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ	Эмнэлгийн хог татан зайлуулах, устгах үйл ажиллагаа	Орон сууцны хорооллын хог түр хадгалах сав	Гэр хорооллын айлуудын хог түр хадгалах сав	Дахивар авах төвийн үйл ажиллагааны зардал
Нэмж байгуулах дахивар авах төв	Хөдөлмөр, хүний нөөц	Гэр хорооллын айлуудын хог түр хадгалах сав	Иргэд, олон нийтийн сургалт, нөлөөллийн ажил /50%/	Хуванцар боловсруулах үйлдвэр /ҮА-ны зардал/
Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах үйл ажиллагааны хэвлэлийн зардал	Хяналтын тоног төхөөрөмж	Хогийн уут	Хуванцар боловсруулах үйлдвэр /хөрөнгө оруулалт/	Компост бордооны үйлдвэр /ҮА-ны зардал/
Хогийн уут /Эхний 1 жилийн зардал/	Хяналтын төвийн үйл ажиллагааны зардал	Хог татан авалт, тээвэрлэлт, ложистик	Компост бордооны үйлдвэр /хөрөнгө оруулалт/	Яс боловсруулах үйлдвэр /ҮА-ны зардал/
Иргэд, олон нийтийн сургалт, нөлөөллийн ажил /50%/			Яс боловсруулах үйлдвэр /хөрөнгө оруулалт/	Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр /ҮА-ны зардал/
Хөдөлмөр, хүний нөөц			Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр /хөрөнгө оруулалт/	Овор хэмжээ ихтэй болон электрон хаягдал цуглуулах төвийн үйл ажиллагааны зардал
Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфиллын ТЭЗҮ боловсруулах			Овор хэмжээ ихтэй электрон хаягдал цуглуулах төв	Сэргээн засварлах төв
Мониторинг үнэлгээ			Бараат хогийн цэгийн дахин төлөвлөлт /худаг, усалгааны систем, бульдозер-1/	Хөдөлмөр, хүний нөөц /хог татан зайлуулах/
			Судалгаа, шинжилгээний орчныг сайжруулах	Бараат хогийн цэгийн дахин төлөвлөлт /ногоон байгууламж/
			Бараат хогийн цэгийн дахин төлөвлөлт	
			Хог тээвэрлэлтийн парк шинэчлэл	
			Хог хаягдлын мэдээллийн сан байгуулах	

# САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 4.2.1. Санхүүгийн боломжит эх үүсвэр

Хүснэгт 70. Санхүүгийн боломжит эх үүсвэр

Зардлын төрөл		Зардал /сая.төг/	Хэрэгжүүлэлтийн үе шат			Хариуцах байгууллага
			2022- 2024	2025- 2028	2029- 2032	
<b>Үйл ажиллагааны зардал:</b>		<b>36,685.2</b>	<b>8,672.5</b>	<b>13,560.9</b>	<b>14,451.7</b>	
1	Хөдөлмөр, хүний нөөц	23,521.3	5,556.5	8,623.8	9,341.0	НААҮГ, төсөв
	Хөдөлмөр, хүний нөөц	4,813.5	889.7	1,868.4	2,055.3	Хувийн хэвшил
2	Хогийн уут	4,094.2	994.2	1,477.2	1,622.7	Айл өрх, ААН
3	Хог татан авалт, тээвэрлэлт	1,474.9	402.2	536.3	536.3	НААҮГ, төсөв
4	Нийтийн эзэмшлийн зам, талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ	573.1	198.3	187.4	187.4	НААҮГ, төсөв
6	Дахивар авах төвийн үйл ажиллагаа	1,017.7	272.9	372.4	372.4	Хувийн хэвшил
7	Овор хэмжээ ихтэй болон электрон хаягдал цуглуулах төвийн ҮАЗ	456.4	119.8	168.3	168.3	Хувийн хэвшил
8	Хяналтын төвийн үйл ажиллагаа	734.2	238.9	327.0	168.3	НААҮГ, төсөв
<b>Хөрөнгө оруулалтын зардал:</b>		<b>8,949.6</b>	<b>7,052.6</b>	<b>1,823.7</b>	<b>73.3</b>	
1	Нэмж байгуулах дахивар авах төв	39.0	39.0			Хувийн хэвшил
2	Сэргээн засварлах төв	525.0	262.5	262.5		Хувийн хэвшил
3	Овор хэмжээ ихтэй болон электрон хаягдал авах төв	117.9	58.9	58.9		Хувийн хэвшил
4	Гэр хорооллын айлуудын хог түр хадгалах сав	1,808.3	1,808.3			Айл, өрх
5	Орон сууцны хорооллын хог түр хадгалах сав	783.0	783.0			Айл, өрх
6	Бараат хогийн цэгийн хөрөнгө оруулалт: Үүнээс	1,280.8	1,109.8	97.7	73.3	
	- Ногоон байгууламжийн зардал	293.1	122.1	97.7	73.3	Албан байгууллага, ААН
	- Худаг ус, усалгааны систем	237.7	237.7			ЕХ -ны төсөл
	- Бульдозер	750.0	750.0			АХБ -ны төсөл
7	Хуванцар боловсруулах үйлдвэр	1,981.0	1,981.0			Хувийн хэвшил
8	Компост бордооны үйлдвэр	855.0	855.0			Хувийн хэвшил
9	Яс боловсруулах үйлдвэр	445.0		445.0		Хувийн хэвшил
10	Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр	959.6		959.6		Хувийн хэвшил
11	Эмнэлгийн хог татан зайлуулах, устгах үйл ажиллагаа	155.0	155.0			Нэгдсэн эмнэлэг, улсын төсөв
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>45,634.8</b>	<b>15,725.1</b>	<b>15,384.7</b>	<b>14,525.0</b>	

## САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь 11 жилийн хугацаанд 3 үе шатыг дамжин хэрэгжих ба нийт 57,125.3 сая төгрөгийн зардал шаардагдаж байгаагаас санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхой зардлаар ялган харуулбал нийт төсвийн 80 хувийг буюу 45,634.8 сая төгрөг болж байна.

Дээрх тооцоонд Бараат хогийн цэгийн дахин төлөвлөлтийн зардлаас 987.7 сая төгрөгийг Европын холбооны төслөөс санхүүжүүлэхээр, мөн ногоон байгууламж хийх зардлыг “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ААН, албан байгууллагуудаар гүйцэтгүүлэх боломжтой гэж үзсэн ба хувийн хэвшлийн ААН-үүдтэй концессын гэрээгээр гүйцэтгүүлэх ажлуудыг оруулсан болно.

Харин улсын төсвөөр буюу НААҮГ-ын зардлыг тусгахдаа зөвхөн хүний нөөцийн зардал болон нийтийн эзэмшил талбайн хог цэвэрлэгээ, татан зайлуулах үйл ажиллагааны зардлыг тусгасан бөгөөд нийт 25,730.4 сая төгрөг буюу дунджаар жилд 2.3 тэрбум төгрөг болж байна.

Орон сууц болон гэр хорооллын хог түр хадгалах савны зардал 5,816.0 сая төгрөг болох бөгөөд үүний 45% буюу 2,591.3 сая төгрөгийг өрх бүрээс 100,000 төгрөг хураамж байдлаар нэг удаа татан төвлөрүүлэхээр тооцсон.

Мөн түүнчлэн айл өрх албан байгууллагад хог ангилан ялгах уут борлуулснаар төлөвлөгөөний 1-р шатанд 1,860.5 сая төгрөг, 2-р шатанд 2,515.9 сая төгрөг, 3-р шатанд 2,542.9 сая төгрөг буюу 11 жилийн хугацаанд нийт 6.9 тэрбум төгрөгийн ашиг олж хөрөнгө оруулалтад ашиглах боломжтой юм.

2020 оны байдлаар НААҮГ –ын нийт зардал 4.7 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 26 хувь буюу 1.24 тэрбум (1241,384,588 төг) төгрөг нь хог тээврийн үйлчилгээний зардал байна.

Хог тээврийн үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэх менежментийг хийснээр ажиллах хүчний тоо цөөрч 25 болох бөгөөд ЭХШ, засвар үйлчилгээ, шатахуун болон бусад зардлууд буурч дээрх үйлчилгээнд зарцуулах төсвийн ачаалал 59 хувиар багасах боломжтой байна.

### Хүснэгт 71. Хог тээврийн үйлчилгээний зардлын төлөвлөлт. /НААҮГ/

№	Зардлын төрөл	Бүгд сая.төг	Хувь	2022 -2024	2025 - 2028	2029 - 2032
1	Үндсэн цалин	4278.62	46.93	790.87	1660.83	1826.92
2	НДШ	534.83	5.87	98.86	207.60	228.36
3	Бичиг хэрэг	12.35	0.14	2.28	4.79	5.27
4	Тээвэр, шатахуун	1886.31	20.69	348.67	732.21	805.43
5	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4.91	0.05	0.91	1.91	2.10
6	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	96.00	1.05	17.74	37.26	40.99
7	Урсгал засвар	275.75	3.02	50.97	107.04	117.74
8	Даатгалын үйлчилгээ	16.95	0.19	3.13	6.58	7.24
9	Тээврийн хэрэгслийн татвар	16.40	0.18	3.03	6.37	7.00
10	Тээврийн хэрэгслийн оношлогоо	5.15	0.06	0.95	2.00	2.20
11	Мэдээлэл, технологийн зардал	50.48	0.55	9.33	19.59	21.55
12	Газрын төлбөр	28.18	0.31	5.21	10.94	12.03
13	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1248.17	13.69	230.72	484.50	532.95
14	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	662.46	7.27	122.45	257.15	282.86
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>9116.55</b>	<b>100.00</b>	<b>1685.13</b>	<b>3538.77</b>	<b>3892.65</b>

## САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 4.2.2. Санхүүгийн дутагдалтай эх үүсвэр

Хүснэгт 72. Санхүүгийн дутагдалтай эх үүсвэр

Зардлын төрөл		Зардал /сая.төг/	Хэрэгжүүлэлтийн үе шат			Хариуцах байгууллага
			2022- 2024	2025- 2028	2029- 2032	
<b>Удирдлагын зардал:</b>		<b>1,373.50</b>	<b>912.1</b>	<b>336.1</b>	<b>125.3</b>	
1	Иргэд, олон нийтийн сургалт, нөлөөллийн ажил	1,003.50	602.1	301.1	100.3	ЗДТГ, / Их, дээд сургуулиуд төсөл/
2	Хог хаягдлын мэдээллийн сан байгуулах	200	200			АЗДТГ, БОАЖГ /төсөл/
3	Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах үйл ажиллагааны хэвлэлийн зардал	50	30	15	5	Сумын ЗДТГ
4	Мониторинг, үнэлгээ	60	20	20	20	АЗДТГ
5	Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфиллын ТЭЗҮ боловсруулах	60	60			АЗДТГ, /төсөл/
<b>Хөрөнгө оруулалтын зардал:</b>		<b>10,117.00</b>	<b>7,852.30</b>	<b>1,746.30</b>	<b>518.4</b>	
4	Гэр хорооллын айлуудын хог түр хадгалах сав	3,224.70	3,224.70			Сумын ЗДТГ /төсөл/
5	Судалгаа, шинжилгээний орчныг сайжруулах	770	490	280		АЗДТГ, /төсөл/
6	Хяналтын тоног төхөөрөмж	40.1	40.1			Сумын ЗДТГ
7	Хог тээвэрлэлтийн техник болон парк шинэчлэл	3,674.10	1,783.80	1,371.90	518.4	Аймаг, сумын ЗДТГ /төсөл, гэрээ/
8	Бараат хогийн цэгийн дахин төлөвлөлтийн хөрөнгө оруулалт	2,408.10	2,313.70	94.4		Аймаг, сумын ЗДТГ /Улсын төсөв төсөл/
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>11,490.50</b>	<b>8,764.40</b>	<b>2,082.40</b>	<b>643.7</b>	


Нийт зардлын 20 хувь буюу 11,490.50 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдалтай байгаа бөгөөд үүнд хог хаягдлын ангилан ялгах болон тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд шаардагдах техник, тоног төхөөрөмжүүдийн хөрөнгө оруулалт, мөн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлагын зардлууд багтаж байна.



## 5. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ

### 5.1. ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ УДИРДЛАГА, МАНЛАЙЛАЛ

Энэхүү стратегийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэхэд бодлого боловсруулах, гүйцэтгэх, хяналт тавьж мониторинг хийх 3 төвшинд дараах институцүүд оролцож байна.



Зураг 107. Хэрэгжилтийг зохицуулах удирдлага, манлайллын бүдүүвч

Дархан сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг Дархан-Уул аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн суурь бодлогуудтай уялдуулан хог хаягдлын бүтэц, нөөцөд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1. Дархан-Уул аймгийн засаг даргын тамгын газрын үүрэг, хариуцлага, манлайлал нь төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодлого, нэгдсэн удирдлагын суурь нөхцөл болно. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Төлөвлөгөөгөөр дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх талаар тууштай байр суурь баримтлах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дутагдах санхүүжилтийг гадаад эх үүсвэрээр бүрдүүлэх;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар оролцогч талуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, орон нутгийн төвшинд нэгдмэл удирдлага, зохион байгуулалтыг бий болгох;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дотоод, гадаадын хандивлагч бүх талын оролцоог хангах, тэдгээрийн үйл ажиллагааг манлайлан удирдах, уялдуулан зохицуулах;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх дунд, богино хугацааны, жил бүрийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх;
- Орон нутгийн төвшинд хог хаягдлын менежментийн удирдлага, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхыг бэхжүүлэх;

## ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ

- Хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр хувийн хэвшилтэй концессын гэрээ байгуулах, хамтран ажиллах;
2. Захирагчийн ажлын албаны үүрэг хариуцлага нь төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын суурь нөхцөл болно. ЗАА нь төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Төлөвлөгөөний биелэлтийн явц, олсон амжилт, хүрсэн төвшин, санхүүгийн нөөцийн зарцуулалтын тухай илтгэлийг бэлтгэж, жил бүрийн 11 дүгээр сард багтаан ИТХ-д оруулж хэлэлцүүлэхээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж байх;
  - Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих;
  - Төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж харьцангуй бие даасан салбар болгон хөгжүүлэх;
  - Зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт, тодотгол оруулах, хэрэгжүүлэх хугацааг сунгах, эсхүл хэрэгжүүлэх ажлыг зогсоох тухай санал боловсруулан ИТХ-д оруулах;
  - Төлөвлөгөөний зорилго зорилтуудыг иргэн аж ахуйн нэгж байгууллагад сурталчлах, аймгийн БСУГ болон их дээд сургуулиудтай хамтран олон нийтийн мэдлэг, хандлагыг өөрчлөх сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх
  - Төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох бүх талуудтай хамтран үе шат бүрд нь үнэлэх, олон нийт, холбогдох бүх талуудад тайлагнах зэрэг болно.
3. Дархан сумын засаг даргын тамгын газрын үүрэг хариуцлага нь хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих;
  - Хог татан зайлуулах, цуглуулах, тээвэрлэх чиглэлээр хувийн хэвшилтэй үйл ажиллагааны гэрээ байгуулах;
  - Төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийн хураамжаас олох эх үүсвэрийг бүрдүүлэх;
  - Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд өдөр тутмын удирдлага зохион байгуулалтыг хангаж ажиллах
  - НААҮГ болон хувийн хэвшлүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллах
  - Төлөвлөгөөний гүйцэтгэгчдийн саналыг үндэслэн ээлжит онд төлөвлөж байгаа арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн төслийг боловсруулан зохих журмын дагуу өргөн мэдүүлэх;

# ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ

## 5.2. ЭРХ, ҮҮРГИЙН ХУВААРИЛАЛТ

Оролцогчдын хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль болон “Хог хаягдлын тухай” хуульд зааснаар дараах байдлаар тоймлон харуулав.

Монгол Улсын Их Хурал	<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих; Засгийн газраас өргөн мэдүүлснээр хог хаягдлын тухай хуулийн хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг баталж, зарцуулалтад хяналт тавих;</li> <li>Хууль тогтоомжид заасан бусад</li> </ul>
Монгол Улсын Засгийн Газар	<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах;</li> <li>Хог хаягдлын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах;</li> <li>Хууль тогтоомжоор заасан заавар журам, аргачлал, жагсаалтуудыг батлан гаргах, мөрдүүлэх, хэрэгжилтийг хангах</li> <li>Хууль тогтоомжид заасан бусад</li> </ul>
Аймгийн Захирагчийн Алба, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	<ul style="list-style-type: none"> <li>Нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;</li> <li>Хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавих;</li> <li>Хог хаягдлын менежментийн цогц журам баталж, биелэлтэд хяналт тавих</li> <li>Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахинашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгох журам батлах;</li> <li>Нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам батлах, нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг тогтоох;</li> </ul>
Сумын ЗДТГ, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	<ul style="list-style-type: none"> <li>Нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;</li> <li>Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох;</li> <li>Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлүүлэх, нийтийн эдэлбэр газарт хогийн савыг хүртээмжтэй тоогоор байрлуулах;</li> <li>Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</li> <li>Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, хог хаягдлын олон нийтийн байцаагчийн урамшууллыг жил бүрийн төсөвт тусгаж, батлуулах, зарцуулалтад хяналт тавих.</li> <li>Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих, хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төвлөрсөн орлогыг хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хог хаягдлыг булшлах үйл ажиллагаанд, хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлсэн тохиолдолд үйлчилгээний шимтгэл төлөхөд зарцуулах, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</li> <li>Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг шийдвэрлэх;</li> <li>Хог хаягдлын талаархи боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг санаачлах, дэмжлэг, тусалцаа үзүүлэх;</li> </ul>
Мэргэжлийн газар, хэлтэс	<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдлын талаар баримтлах хууль, дүрэм, журам, стандартын мөрдөлтийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих</li> <li>- Орон нутгийн хог хаягдлын мэдээллийн дэд сан үүсгэх, мэдээллийг шинэчлэх, үйл ажиллагаанд хяналт тавих</li> <li>- Хог хаягдлын мэргэжлийн зөвлөл байгуулан, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх</li> <li>- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол, хүний эрүүл мэндэд учир болох эрсдэлт нөхцөл байдлын талаар шинжилгээ хийн, бууруулах боломжит арга хэмжээг авах,</li> <li>- Олон нийтэд хог хаягдлын боловсрол олгох сургалт, аян, хөдөлгөөн өрнүүлэх зэргээр нөлөөллийн ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах</li> </ul>
Судалгааны байгууллага, хүрээлэн	<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийн, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ, мэдээлэлээр иргэд, олон нийт, шийдвэр гаргах түвшинд үйлчилгээ үзүүлэх</li> <li>- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг орон нутгийн засаг захиргаа, холбогдох мэргэжлийн газар, хэлтэстэй хамтран зохион байгуулах</li> <li>- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, бууруулах зааварчилгаа, нас сэтгэхүйн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөрийн модулиудыг холбогдох бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулах</li> <li>- Олон нийтэд хог хаягдлыг ангилан ялгах, эх үүсвэр дээр нь бууруулах зөв дадал төлөвшүүлэх нөлөөллийн ажлыг холбогдох бусад мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах</li> </ul>
Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдлыг эрх үүсвэр дээр нь бууруулах, ангилах чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй үнэн бодит мэдээ, мэдээлэлээр олон нийтэд үйлчилгээ үзүүлэх</li> <li>- Хог хаягдлыг эрх үүсвэр дээр нь бууруулах, ангилах чиглэлээр нас, сэтгэхүйн онцлогт тохирсон цуврал видео контент, нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд эерэг хандлагыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллах</li> <li>- Хог хаягдлын менежментийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг цаг алдалгүй олон нийтийн хүртээл болгох, олон нийтийн оролцоог дэмжин уриалахад идэвхтэй ажиллах</li> </ul>
Иргэн, аж ахуйн нэгж	<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага идэвхтэй оролцох, хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих;</li> <li>Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;</li> <li>Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж ажиллуулах</li> <li>Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</li> <li>Хог хаягдлын талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага идэвхтэй оролцох;</li> <li>Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн буюу галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн савтай байх;</li> <li>Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;</li> <li>Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;</li> <li>Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;</li> <li>Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох;</li> <li>Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх</li> </ul>
Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>Холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран олон нийтийг идэвхжүүлэх, нөлөөллийн ажил зохион байгуулах</li> <li>Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэнд иргэний нийгмийн оролцоотой хяналт тавих</li> </ul>



### 5.3. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙХ БАЙГУУЛЛАГА, ХУГАЦАА

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт - шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлд хяналт тавихдаа дор дурдсан зарчмуудыг баримтална:

- Төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг зохион байгуулахдаа арга зүйн болон мэдээллийн нэгдсэн байдлыг хангах;
- Төлөвлөгөөний зорилтуудын хэрэгжилтийг зохион байгуулахдаа оролцох байгууллага (Аймаг сумын засаг дарга, тамгын газар, хэлтэс албад, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, бизнесийн байгууллага, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, ААН, айл өрх, иргэн гэх мэт)-ын хэрэгжүүлэх чиг үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой зааглах;
- Удирдлагын аливаа шийдвэр, дүгнэлтийг хөндлөнгийн бие даасан шинжээчдийн үнэлгээний дүнд үндэслэн гаргах;

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тодорхой хугацаанд үнэлж, доголдож байгаа асуудлын талаар шийдвэр гаргахад туслахад оршино. Төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг үнэлэх хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтүүдийн дагуу статистик мэдээллийн системд тулгуурлан мэдээллийг цуглуулах, мэдээллийн өгөгдлийн бааз байгуулах, бодлогын дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээ гаргаж аймаг сумдын засаг даргын зөвлөлд танилцуулах чиг үүргийг Хог хаягдлын мэргэжлийн зөвлөл хариуцна. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр хийнэ. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шат бүрийн төгсгөлд тухайн үе шатанд тавьсан зорилт, арга хэмжээг бүхэлд нь хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Дархан сумын засаг дарга төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээний дүнг, цаашид авах арга хэмжээний саналын хамт жил бүр 11 дүгээр сарын 2 дахь долоо хоногт багтаан аймаг сумын ИТХ, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Ингэхдээ төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, хүрэх эцсийн үр дүн, хуваарилагдсан хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан эсэх, санхүүжилтийн төсвийн бус эх үүсвэрийг татан ашигласан байдалд түлхүү анхаарна.

# ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ

## 5.4. ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Оноо: хэрэгждэггүй 0, сул хэрэгждэг 5, дундаж 10, дундаж/сайн хэрэгждэг 15, сайн хэрэгждэг 20

№	Шалгуур үзүүлэлт	Тодорхойлолт	Оноо
<b>Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, гудамж талбайн цэвэрлэгээний чанарын үнэлгээ</b>			
1	Эх үүсвэр дээр цуглуулах цэгийн нөхцөл байдал	Байршил оновчтой эсэх, стандарт мөрдөгддөг эсэх, савны бүрэн бүтэн болон үзэмжтэй байдал, ил задгай хог хаягдсан эсэх	
2	Гудамж талбайн цэвэрлэгээний үр дүн	Хогийн сав хүрэлцээтэй эсэх, хогийн сав дүүрсэн эсэх, зам талбайд ил задгай хог хаягдсан эсэх	
3	Гэр хорооллын хогийг цуглуулах байдал	Хур хог байгаа эсэх, хууль бус хогийн цэг үүссэн эсэх, ил задгай шатааж байгаа эсэх	
4	Хог тээвэрлэлтийн бүтээмж, үр дүн	Стандарт хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг эсэх, ангилсан хаягдлыг зориулалт бүрээр тээвэрлэдэг эсэх, тээвэрлэлтийн давтамж, хүртээмж	
5	Үйлчилгээний төлөвлөлт ба хяналтын оновчтой байдал	Тогтсон хуваарийн дагуу тээвэрлэлт хийгдэж байгаа эсэх, тээвэрлэгдэж буй бүх хог хаягдал бүртгэл, хяналтад хамрагддаг эсэх	
6	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ажилчдын эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал	Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийн хангалт, бодлогын дэмжлэг, төсөв	
7	Гудамж талбайн цэвэрлэгээний менежментийн нөхцөл байдал	Ажилчдын хөдөлмөрийн багаж, техникийн хангалт, шинэчлэл, хөдөлмөрийг хөнгөвчилсөн байдал, ажилчдын цалин хөлс, нийгмийн халамж үйлчилгээ, хөдөлмөрийн норм нормативын мөрдөлт	
8	Хог тээвэрлэлтийн машин техникийн шинэчлэл	Тухайн жилд шинээр авсан машин техникийн тоо, төсөв, хөрөнгө оруулалт	
9	Хог хаягдлын үйлчилгээний хүрээнд тээвэрлэгдсэн нийт хогийн хэмжээ	Нийт хог хаягдлын хэмжээнд харьцуулж тогтооно	
<b>Хог хаягдлын үйлчилгээний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ</b>			
1	Хүлээн авч буй нийт хог хаягдалд тавих хяналт, талбайн зохион байгуулалт	Энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй бүх газарт энэ шалгуур үзүүлэлтийг хэрэглэнэ. Хүлээн авч буй бүх хог хаягдалд бүртгэл, судалгаа хөтлөх, устгах булшлах үйл ажиллагаа явуулдаг бол хяналтын худаг, хийн болон нэвчдэс зайлуулах хоолой, ариутгах цэг бий эсэх	
2	Хог хаягдал боловсруулах, устгахад тавих хяналт	Хог хаягдлыг боловсруулах, устгах үйл ажиллагаа явуулдаг бүх газар ялгаруулах хийг хэрхэн шийдвэрлэсэн нь чухал бөгөөд	

## ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ

		шаардлагатай технологи, үйл ажиллагааны зохистой ашиглалт хамаарна.	
3	Байгаль орчны хяналт шинжилгээ, баталгаажуулалт	Байгаль орчны зөвшөөрөл/лиценз олголт, бүртгэл тайлан хөтлөлт, дотоод хяналт, дүрэм журмын мөрдөлт, хөндлөнгийн болон эрх бүхий байгууллагын хяналт мониторинг (Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ) тогтмол эсэх хамаарна.	
4	Эрчим хүч үйлдвэрлэх болон ашиглалтын үр ашиг	Хог хаягдлаас зөвхөн эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар ажилладаг байгууламжийн бүтээмжийг үнэлэхэд хамаарна.	
5	Хог хаягдал боловсруулах, устгах байгууламжийн төлөвлөлт, менежмент, ашиглалтын мэргэжлийн чадамж	Мэргэжлийн чадамжийг үнэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг авч үзнэ: (i) үйлчилгээ үзүүлж буй байгууллагын статус; Тусгай зөвшөөрөл, хөрөнгө санхүү, техникийн чадамж (ii) боловсруулах, устгах байгууламжийн менежмент; Стандарт мөрдөх, дэд бүтэц, инженерийн байгууламжийн техник ашиглалт (iii) үйлчилгээний ажилчид: Ажилчдын цалин хөлс, нийгмийн халамж үйлчилгээ, хөдөлмөр эрүүл ахуйн аюулгүй байдал	
6	Ажилчдын эрүүл ахуй ба хөдөлмөрийн аюулгүй байдал	Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, хангалт	
7	Аюултын болон эмнэлгийн хог хаягдалд тавих хяналт	Аюултай хог хаягдлын чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн байдаг эсэх, аюултай хог хаягдлын бүртгэл судалгаа тайлан тогтмол гаргадаг эсэх	
<b>Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах үйл ажиллагааны үнэлгээ</b>			
1	Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилдаг байдал	Эх үүсвэр дээр нь дахин боловсруулалтад зориулж ангилан цуглуулсан цэвэр дахиварын эзлэх хэмжээнд үндэслэнэ. Хэт бохирдолтой “холимог” хаягдлаас ялгаатай цэвэр дахиварын хувь хэмжээгээр тогтооно. Хэрэглэгчийн гарын авлагад эх үүсвэр дээр ангилах тодорхой зааварчилга тусгагдсан эсэх	
2	Органик хаягдлын дахин боловсруулалтын чанар	Дахин боловсруулсан бүтээгдэхүүний (тухайлбал малын тэжээл, бордоо) болон органик бүтээгдэхүүний (агааргүй задралын бүтээгдэхүүн био хий) эх үүсвэр дээрх ангилж буй байдал, зааварчилга, татан авалт, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ	
3	Хог хаягдлын шатлалын дээд төвшинд анхаардаг байдал	Эх үүсвэр дээр бууруулах талаарх бодлого стратеги бий эсэх, 9R буюу 9 дахин зарчим түүнийг хэрэгжүүлэх бодлого, хэрэгжилтийн үнэлгээ	



## ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ

4	Хог хаягдлын менежментэд олон нийтийн болон албан бус салбарын оролцооны интеграц	Олон нийтийн хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах байдлыг хэрхэн үр дүнтэй явуулж буй үнэлгээ, албан бус дахин боловсруулалтыг татан оролцуулсан байдал	
5	Дахин боловсруулах үйл ажиллагааны байгаль орчинд халгүй байдал	Ангилан ялгасан дахиварыг цуглуулах, тээвэрлэх, боловсруулах хүртэлх бүх шатан дахь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ	
6	Ажилчдын эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал	Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийн хангалт, хүрэлцээ, төсөв	
7	Сэргээн засварлах үйлчилгээний тогтвортой байдал	Сэргээн засварлагдсан нийт дахиварын тоо хэмжээ, төрөл, сум хөгжүүлэх сангийн төсөл хөтөлбөрт хамрагдсан ААН, өрх, иргэний тоо	
8	Дахиварын төвүүдийн үйл ажиллагааны тогтвортой байдал	Нийт цуглуулсан хаягдлын тоо хэмжээ, төрөл, нийлүүлэлтийн гэрээ, ажилчдын цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл,	
9	Овор хэмжээ ихтэй болон ахуйн цахилгаан хог хаягдал цуглуулах төвийн үйл ажиллагааны тогтвортой байдал	Нийт цуглуулсан хаягдлын тоо хэмжээ, төрөл, нийлүүлэлтийн гэрээ, ажилчдын цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл,	
10	Хатуу хог хаягдлын дахин боловсруулалтын чанар	Дахин боловсруулсан бүтээгдэхүүний эх үүсвэр дээрх ангилж буй байдал, зааварчилга, татан авалт, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ	
<b>Олон нийтийн оролцооны үнэлгээ</b>			
1	Үйлчилгээний тэгш байдал	Орлогын төвшингээс үл хамааран бүх иргэд хог хаягдлын менежментийн үйлчилгээ авах боломжтой эсэх	
2	Үзэл бодлыг харгалзан үзэх	Эрх баригчид хууль журмын шийдвэр гаргахдаа иргэдтэй зөвлөж саналыг авдаг эсэх, иргэдийн санал шийдвэрт нөлөөлдөг эсэх	
3	Олон нийтийн оролцооны төвшин	Хог хаягдлын менежментийн шийдвэр гаргах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцын зохих үе шатанд олон нийтийн оролцоог нотлох баримт дээр үндэслэн дүгнэнэ	
4	Олон нийтийн санал хүсэлтийн механизм	Хог хаягдлын менежментийн үйлчилгээний талаарх олон нийтийн санал хүсэлтийн механизм, тогтолцоо байгаа эсэх	
5	Олон нийтийн боловсрол ба мэдлэг	Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааг явуулахад анхаарч олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг эсэх, сургалт нөлөөллийн ажилд хамрагдсан иргэдийн тоо	
6	Хандлага үр дүнтэйгээр өөрчлөгдөх байдал	Дараах үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулан дүгнэх: Хог тээврийн болон булшлах үйлчилгээ авч буй айл өрх, ААНБ-ын тоо, хогийн төлбөр	

## ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ

		хураамж төлж буй айл өрх ААНБ-ын тоо, дахин ашиглагдахаар сэргээн засварлалтад орсон хаягдлын тоо, дахин боловсруулагдсан хог хаягдлын тоо хэмжээ, дарж булшлагдсан хогийн тоо хэмжээ	
<b>Төр хувийн хэвшлийн түншлэлийн тогтвортой байдлын үнэлгээ</b>			
1	Хууль эрх зүйн орчин	Төрийн ба хувийн хэвшилд хатуу хог хаягдлын менежментийн үйлчилгээг тогтвортой явуулах боломжийг олгодог хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг үндэсний ба орон нутгийн төвшинд хэрэгжүүлж буй байдал	
2	Хувийн хэвшлийн төлөөлөл	Хувийн хог хаягдлын секторыг төлөөлдөг байгууллага, холбоодын тоо, хог хаягдлын менежментийн чиглэлээр зохион байгуулагдаж буй арга хэмжээ, хурал уулзалт, ажлын хэсэг, удирдах бүлэгт идэвхтэй оролцдог байгууллагын тоо	
3	“Албан бус” ба олон нийтийн секторын үүрэг	Хог хаягдлын менежментийн үйлчилгээ үзүүлдэг хуулийн хүрээнд баталгаажсан “албан бус” болон олон нийтийн байгууллага, төлөөллийн тоо	
4	Үйлчилгээ үзүүлэх төрийн болон хувийн хэвшлийн ашиг сонирхлын тэнцвэр	Хог хаягдлын үйлчилгээг төрийн болон хувийн хэвшлийн аль алианаар нь хангаж буй байдал, үр дүн, харилцан ашигтай ажиллах зарчим хэрхэн хангагдсан, мониторингийн үнэлгээ	
5	Тендерийн процесс	Нээлттэй, ил тод байдлын зэрэг тендерийн үйл явц, үр дүн	
<b>Санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээ</b>			
1	Зардлын бүртгэл	Хог хаягдлын менежментийн зардалд үйл ажиллагааны болон бусад холбогдох зардлууд бүрэн зөв тусгагдсан байдал, данс тооцоо олон нийтэд нээлттэй хяналттай эсэх	
2	Төсвийн чадамж	Жилийн төсөв нь үйлчилгээний зардлыг бүрэн нөхдөг эсэх	
3	Орон нутгийн төсөв бүрдүүлэлт – айл өрхийн төлбөр хураамж	Хог тээвэрлэх үйлчилгээг авч байгаа болон хогийн төлбөр төлдөг нийт айл өрхийн эзлэх хувь Нийт зардлын хувьд биш өрхийн тоонд харьцуулна	
4	Орон нутгийн төсөв бүрдүүлэлт – ААНБ-ын төлбөр хураамж	Хог тээвэрлэх, булшлах үйлчилгээг авч байгаа болон хогийн төлбөр төлдөг нийт ААНБ-ын эзлэх хувь Нийт зардлын хувьд биш ААНБ-ын тоонд харьцуулна	
5	Төлбөрийн уян хатан, оновчтой байдал	Хог хаягдлын хэмжээнд суурилсан төлбөрийн бодлого бий эсэх, төлбөрийн чадвар доогуур хэрэглэгчдэд татаас өгөх, хөнгөлөлт үзүүлэх журам, бодлого, шийдвэр бий эсэх	

## ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ

6	Хог хаягдлыг устгах, булшлах зардал	Хог хаягдал боловсруулах болон устгах эцсийн цэгт ирэх хүртэлх бүх зардал, ядаж үйл ажиллагааны зардал нөхөгдөхөөр тусгагдсан эсэх, хог хаягдлын хэмжээнд суурилсан төлбөрийн бодлого бий эсэх	
7	Хөрөнгө оруулалтын зардал	Үйлчилгээнд хамрагддаггүй айл өрх, ААНБ-ыг нэмсэн, стандартын шинэчлэл хийх, парк шинэчлэл хийх, техник тоног төхөөрөмж авах гэх мэт шаардлагатай хөрөнгө оруулалт хангалттай тусгагддаг эсэх	
<b>Хог хаягдлын менежментийн засаглалын чанарын үнэлгээ</b>			
1	Хууль тогтоомж, дүрэм журам	Хог хаягдлын менежментэд тавигдах шаардлагыг шийдвэрлэх үндэсний хэмжээний хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журам, бодлого шийдвэр байгаа эсэх	
2	Стратеги /Бодлого	Хог хаягдлын менежментийн үндэсний хэмжээний бодлого стратегийн хүрээнд орон нутагт тодорхой бодлого хэрэгжүүлж байгаа эсэх	
3	Удирдамж, хэрэгжүүлэх дүрэм журам	Орон нутгийн удирдлагуудад хууль тогтоомж, стратегийг хэрэгжүүлэх талаар тодорхой удирдамж чиглэл байдаг эсэх, бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх үр дүнтэй механизм байдаг эсэх	
4	Хог хаягдлын менежментийн бодлого стратегийг хэрэгжүүлэх төрийн байгууллага	Хог хаягдлын менежментийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага байдаг эсэх	
5	Хууль тогтоомжийн хэрэгжилт ба хяналт	Байгаль орчны асуудлаар тогтмол хяналт тавих, хүний нөөц болон чиг үүргийн менежмент тодорхой байгууллага агентлагийн мэдээ тайлан байгаа эсэх, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам бүх хүмүүст хүрч, тэгш үйлчилдэг эсэх	
6	Үйлдвэрлэгчийн хариуцлага (EPR) ба бараа бүтээгдэхүүний менежмент (PS)	Сав баглаа боодол, электрон бараа болон бусад бүтээгдэхүүний хаягдлыг хариуцах талаар гадаад дотоодын компани, ААН-тэй байгуулсан гэрээний тоо, Эдгээр ААНБ-тай хог хаягдлын менежментийн үйлчилгээ болон дахин боловсруулах зардлыг хуваалцдаг эсэх	
<b>Хог хаягдлын менежментийн орон нутгийн тогтолцооны чанарын үнэлгээ</b>			
1	Байгууллагын бүтэц, уялдаа холбоо	Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй байгууллагуудын тоо, оролцогч талуудын эрх үүрэг хэр тодорхой оновчтой байгаа эсэх	
2	Байгууллагын чадавх	Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааг хариуцдаг байгууллагын хүний нөөц, техник, санхүү, менежментийн чадавх	

## ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ

3	Орон нутгийн хог хаягдлын менежментийн стратеги ба төлөвлөгөө	Орчин үеийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан стратеги төлөвлөлттэй байна уу эсвэл хуучин стратеги төлөвлөгөө шинэчлэгдээгүй байгаа эсэх, хог хаягдлын менежментийг орон нутгийн төвшинд хэрэгжүүлдэг эсэх	
4	Хог хаягдлын тоо хэмжээ, бүртгэлийн чанар, хүртээмж	Хог хаягдлын өгөгдлийн сан бүхий мэдээллийн систем бий эсэх, мэдээлэл судалгаа, тайлан тогтмол гаргадаг эсэх, хяналттай эсэх	
5	Менежмент, үйлчилгээ, хяналт	Хог хаягдлын үйлчилгээг хэр шуурхай чанартай үзүүлдэг байдал, үйлчилгээг төр болон хувийн хэвшил хамтран үзүүлдэг байх, Хог хаягдлын менежментийн үйлчлүүлэгч болох хотын хяналт хэр хүчтэй байгаа,	
6	Орон нутгийн төвшинд хог хаягдлын менежментийн салбарын хамтын ажиллагаа	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ажлыг сумын төвшинд, боловсруулах болон устгах ажлыг аймгийн төвшинд хийдэг эсэх, дахин боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийг аймгийн хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд хамран цуглуулдаг эсэх	

Хог хаягдлын менежмент (SWM) нь нийтийн үйлчилгээний гол үйлчилгээ боловч мэдээлэл ихэвчлэн дутагдалтай байдаг

- Хог хаягдлын менежментийн гүйцэтгэлийг хэмжих нь хотын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тогтооход тусалдаг
- Wasteaware жишиг үзүүлэлтүүд: Техникийн болон засаглалын хүчин зүйлсийг аль алиныг нь хэмждэг

5 жилийн турш боловсруулагдсан 6 тивийн 50 гаруй хотод туршигдсан энэ аргад тулгуурлан боловсруулав.

### АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

---

1. Азийн сан. (2019). Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлын бүтцийн судалгаа. Хог хаягдал уур амьсгалын өөрчлөлт төсөл. Улаанбаатар
2. Азийн Хөгжлийн банк. (2019). Орон нутгийн хотуудын хог хаягдлын менежментийг сайжруулах нь төсөл. НААҮГ, Дархан-Уул аймаг
3. Байгаль орчин аялал жуулчлалын яам. (2019). Хог хаягдлын менежментийн үндэсний чуулганаас гаргасан зөвлөмж. Улаанбаатар
4. Гео од ХХК. (2021). “Бараат” хогийн цэгийн газар шорооны ажлын тооцоо, төсөв. Дархан-Уул аймаг
5. Гурван тулгуурт хөгжлийн бодлого (2018 он). Монгол улсын засгийн газар. Улаанбаатар
6. Дархан-Уул аймгийн Нийтийн ахуй үйлчилгээний газрын тайлан 2019. Улаанбаатар
7. Дархан-Уул аймгийн Нийтийн ахуй үйлчилгээний газрын тайлан (2020). Дархан-Уул аймаг
8. Дархан-Уул аймгийн ЗДТГ (2009). Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого 2009-2021
9. ЖАЙКА КОКУСАЙ КООГЁО ХХК. (2007). Монгол улсын Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөө боловсруулах судалгаа. Улаанбаатар
10. Жанчивдорж.Л, Цогтбаатар.Ж.(2008).Томоохон хот суурингийн хатуу хог, хаягдлын цэгийн менежментийг боловсронгуй болгох арга. Улаанбаатар.
11. Монгол улсын засгийн газар. (2020 он), Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Улаанбаатар
12. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2016 он). Улаанбаатар
13. Монгол орны байгаль орчин. (2017). Хүн ба байгаль орчин. V боть. Улаанбаатар
14. Монгол улсын “Ногоон хөгжлийн бодлого” (2014 он). Улаанбаатар
15. Монгол улсын Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамны сайдын тушаал А/445. (2018.11.19). Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах, аргачилсан заавар. Улаанбаатар
16. Монгол Улсын БОАЖ-ын сайдын А/349 тоот тушаал (2017). Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл
17. Монгол Улсын БОАЖ-ын сайдын А/18 тоот журам. (2018). Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох
18. Монгол Улсын Засгийн газрын 116 дугаар тогтоол.(2018). Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
19. Монгол Улсын Засгийн газрын 2006 оны Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
20. Монгол улсын хууль, Хог хаягдлын тухай. (2017)



21. Монгол Улсын Шадар Сайд, БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан 2017оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 тушаалын хавсралт. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
22. Монгол Улсын ЭМ-ийн сайдын А/505 тушаал. (2017). Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай
23. Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо. (2018). Ажлын тайлан. Улаанбаатар
24. Монгол Улсын БОНХАЖ, ЭМС-ын сайдын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн А/356/396 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт. Химийн хорт болон аюултай бодисын ангилал
25. Монгол Улсын БОАЖЯ. (2018-2019). Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан
26. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль Орчны Хөтөлбөр. (2007). Хамгийн боломжтой технологи ба байгаль орчинд хамгийн ээлтэй арга ажиллагааны аргачлал. Байгаль орчныг бохирдуулагч удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын Конвенцийн 5-р зүйл, Хавсралт В. Женев, Швейцар
27. Онцгой байдлын газрын статистик мэдээ. (2019). Дархан-Уул аймаг
28. СХҮТ. (2015). MNS6501:2015. Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрийн хаягдлын ерөнхий ангилал, код. Монгол Улсын стандарт. Улаанбаатар
29. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого (2015 он),
30. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги 2015-2020 он (2015 он)
31. Устгах шаардлагатай буюу чанарын шаардлага хангахгүй болсон химийн хорт болон аюултай бодис хадгалдаг аж ахуйн нэгж байгууллагуудын бүртгэл. (2019). Дархан хот
32. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр (2014 он)
33. Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-01-04). (2004). Улаанбаатар
34. ЭМБ-ын жилийн эцсийн хог хаягдлын тоо мэдээ. (2020). Дархан хот
35. Япон ОУХАБ Жайка Кокусай Коогёо ХХК. (2007). Монгол Улсын Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөө боловсруулах судалгааны тайлан
36. Başak Sener, Mehmet Lutfisuzen. Landfill site selection by using geographic information systems. (November 2006) Environmental Geology 49(3):376-388; DOI:10.1007/s00254-005-0075-2
37. Chabuk, A.; Al-Ansari, N.; Hussain, H.M.; Knutsson, S.; Pusch, R.; Laue, J.(2017). Combining GIS Applications and Method of Multi-Criteria Decision-Making (AHP) for Landfill Siting in Al-Hashimiyah Qadhaa, Babylon, Iraq. Sustainability, 9, 1932. [Google Scholar] [CrossRef]
38. David C Wilson et al. (2014). Wasteaware Benchmark Indicators for Integrated Sustainable Waste Management in Cities, Waste Management as doi: 10.1016/j.wasman.
39. Katarzyna Fela.(2011). Present and prospective leather industry waste disposal Pol. J. Chem. Tech., Vol. 13, No. 3

40. Moghaddas, N.H.; Namaghi, H.H. (2011) Hazardous waste landfill site selection in Khorasan Razavi Province, Northeastern Iran. Arab. J. Geosci. , 4, 103–113. [Google Scholar] [CrossRef]
41. Namkhainyam, B., Tseyen-Oidov, J., Byambatsogt, P. (2014). Studies on country-specific Greenhouse Gas emission and removal factors for Mongolia, Mongolia's initial biennial update report.
42. O.B. Delgado et al. (2007). Comparative analysis of hazardous household waste in two Mexican regions. Elsevier Science Direct. Waste Management 27.792–801
43. Pandey, P.C.; Sharma, L.K.; Nathawat, M.S. (2011). Geospatial strategy for sustainable management of municipal solid waste for growing urban environment. Environ. Monit. Assess. , 184, 2419–2431. [Google Scholar] [CrossRef] [PubMed]
44. United States environmental protection agency: <https://www.epa.gov/recycle/used-household-batteries>
45. Hossein Yousefi, Zahra Javadzadeh, Younes Noorollahi, Amin Yousefi-Sahzabi (2018). Landfill Site Selection Using a Multi-Criteria Decision-Making Method: A Case Study of the Salafcheghan Special Economic Zone. Iran, Sustainability, 10(4), 1107; <https://doi.org/10.3390/su10041107>
46. <http://1212.mn/>
47. <https://element.mn/>
48. <https://www.terbuntan.com/>
49. <https://www.truckpaper.com/listings/trucks/for-sale/list/category/224/heavy-duty-trucks-plow-trucks-spreader-trucks>
50. <https://www.unicef.org/>
51. <https://www.theworldcounts.com/>
52. <https://www.theworldcounts.com/challenges/planet-earth/state-of-the-planet/world-waste-facts/story>
53. <https://www.worldbank.org/en/news/press-release/2018/09/20/global-waste-to-grow-by-70-percent-by-2050-unless-urgent-action-is-taken-world-bank-report>
54. <https://www.rubicon.com/blog/statistics-trash-recycling/>

# ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

## ХАВСРАЛТ

### ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, удирдлага болгоход оршино.
- 1.2. Энэхүү журмыг аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, байнга болон түр оршин суугч иргэн бүр дагаж мөрдөнө.
- 1.3. Журмыг Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын алба, сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар шууд хариуцан зохион байгуулж хэрэгжүүлнэ.
- 1.4. Журмаар зохицуулагдаагүй харилцааг “Хог хаягдлын тухай” хуулийг удирдлага болгон зохицуулна. Хуульд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд журамд зохих нэмэлт өөрчлөлтийг оруулна.
- 1.5. Журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, цагдаа, хог хаягдлын байцаагч, хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан, гэрээгээр эрх олгосон төрийн бус байгууллага болон олон нийтийн хяналтыг иргэдийн бүлэг, иргэн тавина.
- 1.6. Энэхүү журамд заасан хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллага Захирагчийн ажлын албанд бүртгүүлж, хог хаягдлын хяналт удирдлагын нэгдсэн цахим системд орсноор сонгон шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах эрх нээгдэнэ.

#### ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 2.1. Хог хаягдал үүсгэгч болон эрх бүхий этгээд үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.
  - 2.1.1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, минималист хэв загварыг хэвшүүлэх
  - 2.1.2. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, эдийн засгийн эргэлтэд оруулах
  - 2.1.3. Хамгийн бага хэмжээгээр булах
  - 2.1.4. Байгаль орчинд ээлтэй, нийгмийн эрүүл мэндэд харшлахгүй байх
  - 2.1.5. Дэвшилтэт технологи, шинэлэг санаачлагыг нэвтрүүлэх
  - 2.1.6. Оролцооны зарчмыг баримтлах
- 2.2. Ерөнхий шаардлага
  - 2.2.1. Хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах, устгах үйл ажиллагааг сумын Засаг даргатай гэрээ байгуулж бүртгүүлсэн эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага гүйцэтгэнэ.
  - 2.2.2. Сумын Засаг даргатай гэрээ байгуулсан эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ чиглэлийн үйл ажиллагаандаа холбогдох хууль, журам энэ чиглэлээр батлагдан гарсан Монгол Улсын стандартыг мөрдөн ажиллана.
  - 2.2.3. Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх.
  - 2.2.4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй, зааварчилга авсан байна.

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

- 2.2.5. Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, дүрэмт хувцас, ялгах тэмдэгтэй байх.
- 2.2.6. Харилцааны соёлд суралцсан, байгаль хамгаалах, хог хаягдлын талаар нийгмийн хариуцлагаа ухамсарласан ажиллах хүчин байна.
- 2.2.7. Стандартын шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгсэл ашиглана.
- 2.2.8. Эрх бүхий этгээд нь үйл ажиллагааны тайлан, мэдээг тоо, хэмжээ, нэр төрөл тус бүрээр гаргаж сар бүрийн 25-ны дотор сумын Засаг даргад хүргүүлж байна.

### **ГУРАВ. ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ХАДГАЛАХ**

- 3.1. Хог хаягдлыг ангилах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.7 дахь заалтад заасныг ойлгоно.
- 3.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үүсгэж буй хог хаягдлыг эх үүсвэр дээр нь болон үйл ажиллагааны явцад “дахин ашиглах, органик, үнс, овор хэмжээтэй, электрон, барилгын, аюултай болон бусад” гэсэн төрлөөр ангилж зориулалтын ангилсан хог цуглуулах цэгт эсхүл дахивар нөөц авах, татан зайлуулах, сэргээн ашиглах болон дахин боловсруулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүлээлгэн өгнө.
- 3.3. Дахин ашиглах боломжтой хог хаягдалд дараах хаягдал нөөц хамаарна:
  - 3.3.1. Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савалгаа гэх мэт/
  - 3.3.2. Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, кетчуп, ургамлын тос, угаалга, цэвэрлэгээний нунтаг, шингэний хуванцар сав, авто машины тос, тослогооны шингэний хуванцар сав, нэг удаагийн хуванцар сав, 0.025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол гэх мэт/
  - 3.3.3. Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, эдлэл, таглаа гэх мэт/
  - 3.3.4. Лааз /бүх төрлийн лаазалсан бүтээгдэхүүний сав, таглаа, тугалган цаас гэх мэт/
  - 3.3.5. Хөнгөн цагаан, төмөр, металл, зэс, гууль тэдгээрээр хийсэн зүйл
  - 3.3.6. Мод, модон эдлэлийн хаягдал
  - 3.3.7. Сэргээн ашиглах боломжтой хувцас, даавуун эдлэл, савхи, резин
- 3.4. Органик хог хаягдалд амархан муудаж гэмтдэг хоол хүнсний үлдэгдэл хог хаягдал хамаарна: /бүх төрлийн жимс, хүнсний ногооны хальс болон үлдэгдэл, хоолны үлдэгдэл, яс, өндөгний хальс, хэрэглэсэн хүнсний тос гэх мэт/
- 3.5. Үнс /айл өрхийн ердийн зуух, пийшингийн үнс, халаалтын болон нам даралтын зуухны үнс, цахилгаан болон дулааны станцын зуухны үнс гэх мэт/
- 3.6. Овор хэмжээ ихтэй хаягдалд 0.75 куб метрээс дээш эзлэхүүнтэй эвдэрч, хуучирсан ахуйн болон албаны хэрэгцээнд ашиглагдахгүй болсон тавилга хэрэгсэл хамаарна: /Бүх төрлийн тавилга, буйдан, орны матрас гэх мэт/
- 3.7. Электрон хог хаягдалд бүх төрлийн цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн дагалдах хэрэгслүүд хамаарна: /Компьютер түүний дагалдах хэрэгслүүд, гар утас түүний дагалдах хэрэгслүүд, будаа агшаагч, хөргөгч, хөлдөөгч, угаалгын машин гэх мэт ахуйн цахилгаан хэрэгслүүд, телевиз түүний дагалдах хэрэгслүүд/
- 3.8. Барилгын хог хаягдалд барилга, байгууламж, явган хүний зам талбай, ногоон байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах, тоноглох, буулгахад үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарсан хог хаягдал хамаарна: /мод, модон эдлэлийн хаягдал, дуу дулаан тусгаарлах материалууд, хөөсөнцрийн хаягдал, тоосго, чулуу, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал, суурийн блок, бүх төрлийн ялуу, ханын блок, ханын материалууд, барилгын суурь ба талбайн тэгшилгээ, цэвэрлэгээнээс гарсан хөрс шороо зэрэг барилгын хаягдал материалууд, бүх төрлийн бетон, төмөр бетон эдлэл, шилэн хийцүүд, цахилгаан монтажны кабелиуд, хуванцар хийц бүтээгдэхүүнүүд гэх мэт/

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

3.9. Аюултай хог хаягдалд тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлууд хамаарна: /бүх төрлийн батарей, химийн хортой бодис түүнийг агуулсан сав, барилгаас гарсан дахин ашиглах, дахин боловсруулах боломжгүй хаягдал, асбест болон хортой бодис агуулсан, хортой бодисоор бохирдсон, мөнгөн ус агуулсан агуулсан хөрс, шороо, чулуу, нунтаг шороо, бетон, тоосго, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал, мод, шил, хуванцар зэрэг хаягдлууд болон биологийн шингэн, цус агуулсан хаягдал, зүү, тариур, цацраг идэвх, хүний эд эрхтэн, тайрдас, эмийн хаягдал, урвалж, химийн бодис зэрэг эрүүл ахуйн хувьд эрсдэл бүхий эмнэлгийн хаягдал гэх мэт/

3.10. Бусад хог хаягдалд дахин ашиглагдах болон боловсруулагдах боломжгүй хог хаягдал хамаарна: /Ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, номын хавтас, сэтгүүл, фото цаас, дахин ашиглагдахгүй урагдаж хуучирсан хувцас, хэрэглэл, дахин ашиглагдах боломжгүй бохирлогдсон нэг удаагийн аяга таваг хэрэгсэл, шаржигнасан гялгар уут (талх, нарийн боов, чихрийн уут), хагарсан шаазан эдлэл, паалантай сав суулга гэх мэт/

3.11. Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилахдаа дараах өнгөний кодыг стандарт болгон мөрдөнө. (Хавсралт 1)

- а. Дахин ашиглагдах боломжтой хаягдал
- б. Шил, лааз – Улбар шар
- в. Хуванцар – Ногоон
- г. Бусад хог – Хар
- д. Органик хаягдал - Бор
- е. Аюултай хаягдал – Шар

3.12. Орон сууцны хорооллын айл өрх хог хаягдлыг хамгийн багадаа дараах төрлөөр ангилна.

- а. Цаас
- б. Шил, лааз
- в. Хуванцар
- г. Органик хаягдал
- д. Бусад хог

3.13. Гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг хамгийн багадаа дараах төрлөөр ангилна.

- а. Дахин ашиглагдах хог хаягдал
- б. Үнс
- в. Органик хаягдал
- г. Бусад хог

3.14. Аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг хамгийн багадаа

- а. Цаас
- б. Шил, лааз
- в. Хуванцар
- г. Органик хаягдал
- д. Бусад хог
- е. Аюултай хог хаягдал

3.15. Энэхүү журамд заасан хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах төрлийг хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлтэй уялдуулан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, өөрсдийн санаачлалаар нэмэгдүүлж болно.



## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

- 3.16. Хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах цэг, хогийн уут нь хаягдлын төрлийн дагуу өнгөөр ялгасан, ангилах, ялгах зориулалтын тэмдэг, тэмдэглэгээтэй, тайлбартай, бүрэн бүтэн өнгө үзэмж бүхий стандарт хангасан байна.
- 3.17. Орон сууцны хорооллын айл өрхүүдийн ахуйн хатуу хог хаягдал цуглуулах савны стандарт 4000x2000x2000 мм хэмжээтэй байх ба бусад хог хаягдал хийх тасалгаа нь хар өнгөтэй өргөний хэмжээ нь 1,5м, цаасны хаягдал хийх тасалгаа нь цэнхэр өнгөтэй өргөний хэмжээ нь 0,5м, бүх төрлийн шил лаазны хаягдал хийх тасалгаа нь улбар шар өнгөтэй өргөний хэмжээ нь 1 метр, бүх төрлийн хуванцар хаягдал, гялгар уут хийх тасалгаа нь ногоон өнгөтэй өргөний хэмжээ нь 1м урттай байна (Хавсралт 2).
- 3.18. Орон сууцны хорооллын айл өрхүүдийн органик хаягдал хийх савны стандарт 1200x1000x1200 мм хэмжээтэй, халдаггүй, зэвэрдэггүй, цинкэн материалаар хийгдсэн, яс болон хүнсний хаягдал хийх зориулалт бүхий 2 тасалгаатай байна (Хавсралт 3).
- 3.19. Орон сууцны хорооллын айл өрхүүдийн бусад болон органик хогийг зориулалтын хогийн уутанд савлан түр хадгалах хогийн саванд хийнэ. Органик хаягдлын уут нь бор өнгөтэй хэмжээний хувьд сонголттой, таних тэмдэг, тайлбар бичигтэй байна (Хавсралт 4).
- 3.20. Гэр хорооллын айл өрхүүдийн ахуйн хог хаягдал цуглуулах, хадгалах савны стандарт 2000x1000x1300 мм хэмжээтэй бусад хог, үнс хийх зориулалт бүхий 2 тасалгаатай байх бөгөөд 3 мм-ийн зузаантай лист төмрөөр хийгдэж гаднаас ачих зориулалттайгаар хашаанд суурилагдсан байна (Хавсралт 5).
- 3.21. Бусад хогийн уут нь хар өнгөтэй, 8л, 10л, 15л хэмжээтэй, таних тэмдэг, тайлбар бичигтэй байна (Хавсралт 6).
- 3.22. Гэр хорооллын айл өрхүүд дахин ашиглагдах хог хаягдлыг энэхүү журамд заасны дагуу өөрсдийн эзэмшил хашаандаа ангилан цуглуулж хамгийн ойр байрлах дахиварын төв болон сэргээн засварлах газар, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулна.
- 3.23. Гэр хорооллын айл өрхүүд органик хаягдлыг зориулалтын бокаши саванд зааврын дагуу хийж бордоо болгон хашаа, хорооныхоо ногоон байгууламжид ашиглана (Хавсралт 7).
- 3.24. Гэр хорооллын айл өрхүүдийн үнсний уут нь 520x1200 мм хэмжээтэй, таних тэмдэг, тайлбар бичиг бүхий дулаанд тэсвэртэй, шатамхай биш, ус нэвтэрдэггүй шилэн даавуун материалаар хийгдсэн байна (Хавсралт 8).
- 3.25. Ахуйн нөхцөлд аюултай хог хаягдал бий болсон тохиолдолд айл өрхүүд зориулалтын уутанд хийж ангилна. Аюултай хог хаягдлын уут шар өнгөтэй, хэмжээний хувьд сонголттой, таних тэмдэг, тайлбар бичигтэй байна (Хавсралт 9).
- 3.26. ААНБ-ын хог хаягдлыг энгийн ба аюултай хог хаягдал гэж 2 ангилна.
- 3.27. Үйлдвэрлэлийн явцад үүсч байгаа хог хаягдал аюултай эсэхийг тогтооно. Хог хаягдлын аюулын шинж чанар болон аюултай, хортой, идэмхий, цочроомтгой, шатамхай зэрэг шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг агуулсан болохыг тодруулах бол итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулна.
- 3.28. Үйлдвэрлэл болон үйлчилгээний гаралтай аюултай хог хаягдал үүсгэгч нь тухайн хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх, устгах эрх бүхий ААНБ-д шилжүүлэх хүртэл зориулалтын саванд савлаж байгууллага дээрээ түр байршуулан хадгална.
- 3.29. Өөрийн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлын төрөл, кодыг хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтооно.
- 3.30. Аюултай хог хаягдлын хэмжээ 1 сард 1000 килограммтай тэнцүү буюу түүнээс бага үүсч байвал 180 хоног, 1000 килограммаас их хэмжээтэй үүсч байвал 90 хоног хадгална

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

3.31. Аюултай хог хаягдлын шинж чанар, онцлогоос нь хамааруулж, төрөлжүүлэн тухайн онцлогт тохирсон зориулалтын саванд савлаж битүүмжлэн, журмын 3.25-д заасан стандартын дагуу хадгална.

3.32. ААНБ-ын энгийн хатуу хог хаях зориулалтын хогийн сав нь үүсгэж буй хог хаягдлын төрөл хэмжээнээс хамааран (харилцан адилгүй) хэмжээтэй байж болох ба энэ журмын 3.11, 3.14-д заасан ангилал, өнгөний код, таних тэмдэг, тайлбар зэргийг мөрдлөг болгоно (Хавсралт 10).

3.33. Айл өрх, иргэн ААН, байгууллагууд нь дахин боловсруулагдах хаягдлыг эх үүсвэр дээр нь энэхүү журмын хавсралтад дурдсан зааврын дагуу ангилан ялгаж хэвшинэ (Хавсралт 11).

3.34. Дахин боловсруулагдах дахивар нөөцийг энэ журмын хавсралтаар баталсан тарифаар бодож авна (Хавсралт 12).

### **ДӨРӨВ. НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗАР, ХОТЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙГ ЦЭВЭРЛЭХ**

4.1. Нийтийн эдэлбэр газар, хотын гудамж, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг энэхүү журмын 1.6-д заасны дагуу Дархан сумын хог хаягдлын менежментийн бүртгэл, хяналтын нэгдсэн цахим санд бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

4.2. Зам талбайн цэвэрлэгээний өдөр тутмын хөндлөнгийн хяналтыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох ба цэвэрлэгээний ажлын зардлын 2 хувиар санхүүжүүлнэ.

4.3. Нийтийн эдэлбэр газар, хотын гудамж, зам талбайн цэвэрлэгээг зам, талбайн онцлог, улирлын байдлаас шалтгаалан гараар болон тусгай зориулалтын машин техникээр гүйцэтгэнэ.

4.4. Нийтийн эдэлбэр газар, хотын гудамж, зам талбайн цэвэрлэгээг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

4.4.1. Нийтийн эдэлбэр газарт хамаарах гудамж, зам талбайн хог хаягдлыг механикаар цэвэрлэгч жижиг оврын тусгай зориулалтын авто машинтай байх;

4.4.2. Ажилчдын ажлын хувцас солих өрөө, бие засах газар, халуун усанд орох нөхцөлийг бүрдүүлсэн түрээсийн болон өөрийн ажлын байртай байх;

4.4.3. Зам талбайн цэвэрлэгээнд ажиллах шүүрт болон давс бодис цацах тусгай зориулалтын автомашинтай байх ба автомашин нь стандарт шаардлага хангаж, тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоонд хамрагдсан, байгаль орчин, агаарын чанарт сөрөг нөлөөгүй байх;

4.4.4. Зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд ажиллах автомашин нь 5-аас дээш жилийн насжилттай бол агаарын бохирдлоос сэргийлэх зорилгоор автомашины түлш, яндангийн системд тусгай зориулалтын шүүлтүүр, тоног төхөөрөмж суурилуулсан байх;

4.4.5. Цас мөс хайлуулах зориулалт бүхий бодис нөөцлөх шаардлага хангасан агуулахтай байх;

4.4.6. Санхүүгийн чадавхтай байх, нийгмийн даатгал, татварын хугацаа хэтэрсэн өр зээлгүй байх;

4.4.7. Нийтийн эдэлбэр газар, хотын гудамж, зам талбайн цэвэрлэгээнд ажиллах машин техник нь газар зүйн мэдээллийн (GPS) систем бүхий тоног төхөөрөмжтэй байх;

4.5. Нийтийн эдэлбэр газар, хотын гудамж, зам талбайд дараах зам, талбайг хамруулна.

4.5.1. Олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж, гүүр, гүүрэн гарц, явган хүний зам, ногоон байгууламж, хайс, хашлага;

4.5.2. Цэцэрлэгт хүрээлэн, зорчих хэсгийн тусгаарлах зурвас, нийтийн талбай, хөшөө баримал, түүхийн дурсгалт газар;

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

- 4.5.3. Орон сууц, гэр хороолол доторх гол болон туслах авто зам, замын байгууламж, явган хүний зам, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, нийтийн талбай, авто зогсоол;
- 4.5.4. Дархан сумын ногоон бүсийн авто болон явган зам, голын эрэг, гольдрол, амралт, зугаалгын бүсийн ой мод, амралтын талбай, авто болон явган зам.
- 4.6. Нийтийн эдэлбэр газар, зам талбайн цэвэрлэгээний үйл ажиллагаанд тавигдах шаардлага.
- 4.6.1. Нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайн цэвэрлэгээ хийх аж ахуйн нэгж, байгууллагын зам талбайн үйлчлэгч нь улбар шар өнгийн хантаазтай байх;
- 4.6.2. Хотын гол гудамж, зам, талбай, туслах зам, хорооллын доторх зам талбайн цэвэрлэгээг өдөр бүр, хотоос алслагдсан зам, замын байгууламжийн цэвэрлэгээг долоо хоногт хоёроос доошгүй удаагийн давтамжтайгаар цэвэрлэх;
- 4.6.3. Зам талбайн үйлчлэгчийн нэг удаагийн цэвэрлэх талбай 10000 м<sup>2</sup>-аас ихгүй байх;
- 4.6.4. Авто зам, автобусны буудал, авто зогсоолын цэвэрлэгээг зуны улиралд өглөөний цэвэрлэгээг 05:00-07:00 цаг, өвлийн улиралд 06:00-08.00 цагийн хооронд бүрэн хийж авто машин, явган зорчигч саадгүй зорчих нөхцөлийг хангах;
- 4.6.5. Гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед ажлын цаг харгалзахгүй ээлжээр цэвэрлэгээг хийх;
- 4.6.6. Авто замын зорчих хэсгийн цэвэрлэгээг гүйцэтгэхдээ ослоос сэргийлсэн цацруулагч бүхий түмбийг цэвэрлэгээний талбайгаас 10 хүртэлх метрийн зайд байрлуулан аюулгүй ажиллагааг хангаж ажиллах;
- 4.6.7. Нийтийн эдэлбэр газар, авто замын цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг авто замын борооны ус зайлуулах ил болон далд шугам сүлжээ, шүүрт худаг, үерийн хамгаалалтын далан сувагт хаяж болохгүй ба ил задгай овоолж салхиар тархах, хийсэхээс сэргийлэн зориулалтын хогийн саванд хадгалж, тээвэрлэгчид хүлээлгэн өгөх;
- 4.6.8. Нийтийн эдэлбэр газар, зам, талбайд байрлуулсан хогийн савны хог хаягдлыг хогийн сав дүүрч, халихаас өмнө давтамж харгалзахгүй суллаж цэвэрлэх;
- 4.6.9. Өвлийн улиралд цас, мөсийг хайлуулах зориулалтаар цацсан давс, тусгай зориулалтын бодис бүхий цас, мөсийг ногоон байгууламжид хийхгүй байх ба хариуцсан гудамж, зам, талбайн цас мөсийг цас орсон өдрөөс хойш 72 цагийн дотор бүрэн цэвэрлэх;
- 4.6.10. Авто болон явган хүний замын хайс, хашлага, нийтийн эдэлбэр газар, зам талбайн хогийн сав, сандал бусад архитектурын байгууламжийг 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 9 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд сард хоёроос доошгүй, 10 дугаар сарын 1-ний өдрөөс 3 дугаар сарын 31-ний өдрийн хооронд сард нэгээс доошгүй удаа цэвэрлэх;
- 4.6.11. Хатуу хучилттай авто болон явган хүний замыг 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 9 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд гар болон механикаар чийгшүүлэн цэвэрлэх.
- 4.7. Нийтийн эдэлбэр газар, хотын гудамж, зам талбайн цэвэрлэгээг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 4.7.1. Нийтийн эдэлбэр газар, зам, талбайн үйлчлэгчид болон жолооч, ачигчдад энэхүү журмын 4.6.1-д заасан өнгө бүхий өвөл, зуны ажлын хувцас, хэрэгсэл, багаж, материалаар хангах;
- 4.7.2. Зам талбайн цэвэрлэгээний дараалал, хуваарь, аргачлалыг батлуулж ажиллах;
- 4.7.3. Өвлийн улиралд хариуцсан авто зам болон зам талбайн халтиргаа гулгааг цас орсон даруйд дагтаршиж, мөстөхөөс өмнө халтираа, гулгаа арилгах тусгай зориулалтын бодис, давсыг цацаж, замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- 4.7.4. Гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлс болох цас, зуд, үер усны аюулын үед ажиллах шуурхай ажиллагааны төлөвлөгөө, нөөц авто машин, багаж, тоног

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

- төхөөрөмж, материалын тоо, хэмжээг гарган байгууллагын даргаар батлуулж, аймаг, сумын онцгой комисст жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлэх;
- 4.7.5. Ажилд гарахын өмнө хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгыг тогтмол танилцуулан, ажлын хувцас, хэрэглэлийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тухайн өдрийн ажил гүйцэтгэх даалгаврыг өгч, ажилтан бүрээр гарын үсэг зуруулж, тэмдэглэл хөтлөх;
- 4.7.6. Хууль, журам, ажил үүргийн тодорхойлолт, хуваарь, цэвэрлэгээний арга зүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, харилцаа, ёс зүйн хэм хэмжээг багтаасан чиглүүлэх сургалтад хамрагдсан зам талбайн үйлчлэгч, жолооч, ачигч, ажилтнуудыг ажиллуулах;
- 4.7.7. Зам талбайн үйлчлэгч, жолооч, ачигчийг өвчтэй, хэт ядарсан болон согтууруулах ундаа хэрэглэсэн үед ажилд гаргахгүй байх;
- 4.7.8. Цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг зориулалтын саванд хийж нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал тээвэрлэх авто машинд ачуулах;
- 4.7.9. Журмын 3.1.2-д заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбооны орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал, шарилж, лууль зэрэг ургамал, цас мөсийг төлбөртэйгээр цэвэрлэж, зардлыг гаргуулах.
- 4.8. Сар бүрийн эхний долоо хоногийн Бямба гарагт бүх нийтийн цэвэрлэгээг хийнэ.
- 4.9. Бүх нийтийн их цэвэрлэгээнд дараах нийтийн эдэлбэр газар, гудамж, талбай, ногоон бүсийг хамруулна. Үүнд:
- 4.9.1. Олон улсын болон улс, орон нутгийн чанартай авто зам, явган замын дагуух 50 хүртэлх метрийн өргөн зурвас;
- 4.9.2. Төмөр замын хамгаалалтын бүс болон бүсээс гадагш 50 хүртэлх метрийн өргөн зурвас;
- 4.9.3. Голын гольдрол, эрэг түүний хамгаалалтын бүс;
- 4.9.4. Хотын ногоон бүс;
- 4.9.5. Орон сууцны хороолол, гэр хорооны доторх авто болон явган зам, ногоон байгууламж, бичил цэцэрлэг, гудамж, амралт, тоглоомын талбай, жалга, суваг, үерийн усны далан, шуудуу;
- 4.9.6. Нийтийн эдэлбэр газар, зам талбайн цэвэрлэгээнд тогтмол хамрагддаггүй авто болон явган хүний зам, замын байгууламж, гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэн, амралт, зугаалгын бүс, бичил тохижилт.
- 4.10. Нийтийн их цэвэрлэгээнд тавигдах шаардлага
- 4.10.1. Цэвэрлэсэн хог хаягдлыг ил задгай овоолон орхихгүй болон шатаахгүй байх;
- 4.10.2. Цэвэрлэгээнээс гарсан хог, хаягдлыг зориулалтын уутанд хийж, уутны амыг боон хог хаягдал ачихаар тодорхойлсон байршилд хүргэх;
- 4.10.3. Хөдөлмөр, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааг ханган цэвэрлэгээнд оролцож байгаа иргэд амны хаалт, бээлий хэрэглэх;
- 4.10.4. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг багш, эцэг эхийн хараа, хяналтын дор бүх нийтийн цэвэрлэгээнд оролцуулах.
- 4.11. Бүх нийтийн их цэвэрлэгээг улирлын онцлогийг харгалзан дараах төрлөөр гүйцэтгэнэ.
- 4.11.1. Хур хог цэвэрлэх, ачиж, тээвэрлэх;
- 4.11.2. Цас, мөс цэвэрлэх, халтиргаа гулгаа арилгах;
- 4.11.3. Шарилж, лууль зэрэг ургамлыг цэвэрлэх;
- 4.11.4. Нийтийн эдэлбэр газар, гудамж талбайн хайс хашлага, архитектурын жижиг байгууламжийг угааж, цэвэрлэх, будаж, өнгийг сэргээх;
- 4.11.5. Авто зам, төмөр зам дагуух хог хаягдлын түүвэр цэвэрлэгээ;
- 4.11.6. Орон сууц, нийтийн байрны орц, шатны хонгил, цонх, хаалгыг угааж цэвэрлэх;

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

4.11.7. Гэр хорооллын гудамж, жалга, далан сувагт үүссэн хог хаягдлыг цэвэрлэж, ачиж, тээвэрлэх;

4.11.8. Зуслан, ногоон бүсийн ой мод, голын эрэг, гольдролд үүссэн хог хаягдлыг цэвэрлэж, ачиж тээвэрлэх.

### **ТАВ. ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ**

5.1. Энгийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах

5.1.1. Хог хаягдал цуглуулах, хадгалах зориулалт бүхий савыг гэр байшин, хүнс боловсруулах хадгалах газар, хүүхдийн тоглоомын талбайгаас 20-30 метрт салхины доод талд нь хөрсийг нь нягтаршуулж бэлдсэн зориулалтын талбайд тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэхээр байршуулсан байна.

5.1.2. Хог хаягдал цуглуулах, хадгалах зориулалт бүхий саванд ангилсан хог хаягдлыг хийхдээ бусад хогийг зориулалтын уутанд хийж битүүмжилж хаяна. Дахин боловсруулагдах боломжтой хаягдлууд болох цаас, шил лааз, хуванцар хаягдлуудыг харгалзах өнгө бүхий тасалгаанд задгай хэлбэрээр хийнэ.

5.1.3. Цаасны хогийг хаяхдаа цааснаас бусад зүйлийг салгаж тус тусад нь төрөлжүүлж боож хаяна.

5.1.4. Бүх төрлийн шил, лаазыг хаяхдаа доторхыг нь зайлж, тагийг нь авч (шилнээс салахгүй тагийг хамтад нь хаяж болно) хаяна. Лаазыг базаж хэмжээг багасгаж хаяна.

5.1.5. Бүх төрлийн хуванцар хог хаягдлыг хаяхдаа доторхыг нь зайлж, шошго хаягийг арилган цэвэрлэж, базаж хэмжээг нь багасгаж хаяна.

5.1.6. Хүнсний хогийг хаяхдаа шингэнийг шүүж авсан байна. Ясыг бусад шингэн хогтой холихгүй.

5.1.7. Хүнсний хогийг зориулалтын хог хадгалах саванд 3 хоногоос илүү хугацаагаар хадгалахгүй.

5.1.8. Айл өрх, ААН, байгууллагууд сэргээн ашиглах болон дахин боловсруулагдах боломжгүй “бусад хог хаягдал” болон хүнсний хог хаягдлыг зориулалтын уутыг худалдан авч гэртээ болон ААН, байгууллага дээрээ савлан хадгалж байгаад ангилсан хогийн цэгт зайлуулна.

5.1.9. Айл өрх, ААН, байгууллагууд сэргээн ашиглах болон дахин боловсруулагдах боломжтой хог хаягдлыг энэхүү журамд заасны дагуу ангилан гэртээ болон ААН, байгууллага дээрээ цуглуулан хадгалж байгаад гэрийн ойролцоох болон байгууллагын ангилсан хогийн цэгт зайлуулна.

5.1.10. Аюултай хог хаягдал

- Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журамд заасан шаардлагуудын хэрэгжилтийг жилд 1 удаа байнга хянан, шалгах
- Аймгийн хэмжээнд химийн бодис хэрэглэдэг албан газар, аж ахуйн нэгжийн химийн бодисын ашиглалт, хадгалалтын тайланг жил бүр гаргаж холбогдох эрх бүхий байгууллага мэдээллийн сан бүрдүүлнэ
- Мэдээллийн сангийн тоон материалд байнга шинэчлэл хийж, үнэн зөв байдалд үнэлгээ өгч байх
- Химийн бодистой харьцдаг ажиллагсдыг жил бүр сургалтад хамруулж мэдлэг, чадвар, дадлыг нэмэгдүүлж байна
- Устгах зорилгоор байгууллагууд дээр хадгалагдаж байгаа химийн бодисын хор аюулын эрсдэлийг бууруулахын тулд тэдгээрийг зориулалтын төвлөрсөн агуулахад цуглуулж, хадгалалт, хамгаалалтыг сахих

5.1.11. Эмнэлгийн хог хаягдал



## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

- Эмнэлгийн хаягдлыг үүссэн газарт нь тусгай зориулалтын био-аюулгүйн таних тэмдэг бүхий таних тэмдэгтэй уут, хогийн саванд хийж түр хадгалах байр эсвэл хадгалах цэгт аюулгүй байршуулна

### 5.2. Хог хаягдлыг тээвэрлэх

5.2.1. Сумын нутаг дэвсгэрт айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг ачиж, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг төрийн болон хувийн хэвшлийн ААНБ-аар гүйцэтгүүлж болно. Уг ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн баримт бичигт журамд заасан шаардлага, хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх байгууллагын сар бүр ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тусгана.

5.2.2. “Хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээний гэрээ”-г Захирагчийн алба, сумын Засаг дарга, тухайн хог хаягдлын үйлчилгээний байгууллага хамтран байгуулна.

5.2.3. Сумын нутаг дэвсгэрт хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээ эрхлэх гэрээний үүргийг аль нэг тал зөрчсөн эсхүл ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамаарч гэрээ цуцлах дүгнэлт гарсан тохиолдолд гэрээг нэг талын санаачлагаар хэдийд ч цуцална.

5.2.4. Хөндлөнгийн хяналтыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ба уг байгууллага нь “Хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээ эрхлэх гэрээ”-нд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хог хаягдлын үйлчилгээний байгууллагад хяналт тавьж, сар бүрийн ажлын гүйцэтгэлд үнэлгээ өгнө.

5.2.5. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага дараах шалгуурыг хангасан байна:

- Энгийн хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь зориулалтын битүүмжлэлтэй, технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, задгай тэвштэй тээврийн хэрэгслээр тээвэрлэх бол хог хаягдал хийсэхгүй, асгахгүй байх нөхцөлийг хангасан байна.

- Тээвэрлэх хог хаягдлын төрөл, ангиллыг заасан тэмдэг тэмдэглэгээтэй байна.

- Хотын өнгө үзэмжид нийцсэн цэвэрхэн, зориулалтын байх.

- Дуудлагаар хог хаягдал тээвэрлэж болох ба энэ талаар журмын 2.2.1 дэх заалтад заасан гэрээнд тодорхой тусгана.

- Батлагдсан маршрут, хуваарийн дагуу тээвэрлэнэ.

5.2.6. Хог хаягдлыг тээвэрлэх график, маршрутыг жил, улирал, сараар гаргаж хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулснаас хойш 5 хоногт багтаан сумын Засаг даргаар батлуулна.

5.2.7. Иргэн, ААН, байгууллага нь сэргээн ашиглагдах болон дахин боловсруулагдах хаягдлаа ангилан ялгаж холбогдох дахивар авах төвлөрсөн цэгүүд, засварын төвүүд, боловсруулах үйлдвэрүүдэд өөрсдөө хүргэж өгсөн тохиолдолд энэхүү журамд заасан үнэлгээний дагуу үнэ төлбөр авна.

5.2.8. Орон сууцны хорооллын “Бусад хог” ангиллын хогийг долоо хоногт нэг удаа тогтмол хуваарийн дагуу “Бараат” төвлөрсөн хогийн цэг рүү тээвэрлэнэ.

5.2.9. Цаасны хаягдлыг долоо хоног бүрийн Даваа гарагт, шил лаазны хаягдлыг Мягмар, хуванцар хаягдлыг Пүрэв гарагт тээвэрлэнэ.

5.2.10. Хүнсний хаягдлыг долоо хоног бүрийн Лхагва, Ням гарагуудад тээвэрлэнэ.

5.2.11. Гэр хорооллын “Бусад хог” ангиллын хогийг сард хоёр удаа тогтмол хуваарийн дагуу “Бараат” төвлөрсөн хогийн цэг рүү тээвэрлэнэ.

5.3. Барилгын хог хаягдлыг тээвэрлэх

5.4. Эмнэлгийн хог хаягдлыг тээвэрлэх

- Шаардлагын дагуу тоноглон битүүмжилсэн бага оврын ачааны машиныг ашиглан эмнэлгийн аюултай хаягдлыг халдваргүйжүүлэгч газар луу тээвэрлэнэ

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

- Автоклавт ариутган халдваргүйжүүлсэн хог хаягдлын овор хэмжээ, байгальд хурдан задрах процессыг нэмэгдүүлэх, эрсдэлийг багасгах зорилгоор буталж жижиглэнэ

5.5. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх

- Тээвэрлэгч тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, бүрэн бүтэн байхаас гадна “химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг” тэмдэглэгээг байрлуулсан байх
- Тээвэр хийж буй ачааны онцлогт тохирсон ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардагдах материал, багаж хэрэгслээр хангасан байна

### **ЗУРГАА. ХОГ ХАЯГДЛЫГ СЭРГЭЭН АШИГЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ**

6.1. Хог хаягдлыг сэргээн ашиглах

6.1.1. Хог хаягдлыг сэргээн ашиглах үйл ажиллагааг дэмжих зорилгоор гутал засвар, цаг засвар, электрон барааны засвар, хувцас засвар, цүнх засвар, буйдан засвар, хуучин тавилга засвар, утас засвар, компьютер засвар гэх мэт засварын газрууд ажиллуулах иргэн, ААН-ийг татвараас чөлөөлөх, хөнгөлөлттэй зээлд хамруулах, төсөл хөтөлбөрт хамруулах бодлого баримталж ажиллана.

6.1.2. Хог хаягдал сэргээн ашиглах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 9.3.2 дахь заалтад заасан зөвшөөрөл авсан, 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, журмын 2.2 дахь заалтад заасан шаардлага хангасан хуулийн этгээд гүйцэтгэнэ.

6.1.3. Хог хаягдал сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч Хог хаягдлын тухай хуулийн 8.1.3-д заасан журмын дагуу дахин боловсруулсан болон сэргээн ашигласан хог хаягдлын мэдээ, тайланг тогтоосон хугацаанд Дархан-Уул аймгийн Захирагчийн албанд ирүүлнэ.

6.1.4. Хог хаягдал сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч нь Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтад заасан ерөнхий шаардлагыг удирдлага болгоно.

6.1.5. Хог хаягдлыг сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч нь сэргээн ашиглах хог хаягдлаа төрөлжүүлэн цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын гэрээ болон журмын 2.2.1. -д заасны дагуу сумын Засаг даргатай гэрээ байгуулан гүйцэтгэж болно.

6.1.6. Хог хаягдлыг сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгчид тавигдах нэмэлт шаардлага:

- Хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах технологи хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байх;

- Хог хаягдлыг сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч Хог хаягдлын тухай хууль, тогтоомж, стандарт, шаардлага, хөдөлмөр хамгаалал, эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, сэргээн ашиглах технологи, арга ажиллагааны талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах;

- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээ хийх заавар, дүрэм, аргачлал боловсруулах;

- Сэргээн засварлах үйл ажиллагааны явцад үүссэн хаягдлыг энэхүү журмын 3.2-д заасны дагуу дахин боловсруулагдах болон дахин боловсруулагдахгүй төрлүүдээр нь ангилан эрх бүхий байгууллагад нийлүүлэх

6.1.7. Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр, үйлчилгээний газрууд бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотойгоор үүсэж буй хаягдлыг сэргээн ашиглах зорилгоор үйлдвэр дээрээ өөрийн бүтээгдэхүүний шил сав, баглаа боодлыг эргүүлэн авах цэг ажиллуулна.

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

- 6.1.8. Дархан сумд байрлалтай хүнсний дэлгүүрүүд худалдаалдаг бүтээгдэхүүний хуванцар, лааз болон шилэн савыг эргүүлэн авах, үйлдвэрлэгчдэд болон дахиварын төв, дахин боловсруулах үйлдвэрүүдэд буцаан нийлүүлэх үүрэг хүлээж ажиллана.
- 6.1.9. Иргэн, ААН-ийн хэрэглэхгүй болон илүүдэл эд зүйлсээ солилцох, хэмнэлт бий болгох, хямд үнээр худалдаж эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжих зорилгоор Дархан сумд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Бямба гарагт “Нээлттэй зах”-ыг Захирагчийн Албанаас зохион байгуулан ажиллуулна.
- 6.2. Хог хаягдлыг дахин боловсруулах
- 6.2.1. Дархан-Уул аймагт хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй технологиор зориулалтын байгууламж, тоног төхөөрөмжид зөвшөөрсөн газарт шатааж, эрчим хүч /цахилгаан, дулаан, халуун ус/ үйлдвэрлэх болон зөвшөөрсөн арга технологиор хог хаягдлыг нэрэх, угаах, халдваргүйжүүлэх, цэвэрлэх, сэргээх анхны хэлбэрт оруулах зэрэг арга замаар эдийн засгийн хувьд ашигтай чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн бий болгох, үйлдвэрлэх үйл явцыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 6.2.2. Хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 9.3.2 дахь заалтад заасан зөвшөөрөл авсан, 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, журмын 2.2 дахь заалтад заасан шаардлага хангасан хуулийн этгээд гүйцэтгэнэ.
- 6.2.3. Хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэнэ.
- 6.2.4. Хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтад заасан ерөнхий шаардлагыг удирдлага болгоно.
- 6.2.5. Хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч Хог хаягдлын тухай хуулийн 8.1.3-д заасан журмын дагуу дахин боловсруулсан болон сэргээн ашигласан хог хаягдлын мэдээ, тайланг тогтоосон хугацаанд Дархан-Уул аймгийн Захирагчийн албанд ирүүлнэ.
- 6.2.6. Хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь сэргээн ашиглах хог хаягдлаа төрөлжүүлэн цуглуулах, тэвэрлэх үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын гэрээ болон журмын 2.2.1. -д заасны дагуу сумын Засаг даргатай гэрээ байгуулан гүйцэтгэж болно.
- 6.2.7. Хог хаягдал дахин боловсруулсан бүтээгдэхүүн байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн, мал, амьтан, ургамал, байгаль орчинд аюулгүй, Монгол Улсын болон олон улсын стандартад нийцсэн, хүний хэрэгцээ шаардлагыг хангасан байх;
- 6.2.8. Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрт гамшгийн эрсдэлийн нөлөөллийн үнэлгээ хийлгэж, аймгийн онцгой байдлын газраар батлуулан, менежментийн төлөвлөгөөг боловсруулан үе шаттай хэрэгжүүлэх;
- 6.2.9. Дахин боловсруулах, сэргээн ашиглах хог хаягдлын үйлдвэрлэлийн процесс, технологийг харуулсан зураглал, схемийг гаргаж олон нийтэд нээлттэй байршуулах;
- 6.2.10. Дахин боловсруулах хаягдал хүлээн авах талбай хатуу хучилттай, дээвэртэй, хог хаягдал салхиар тархах, хийсэхээс сэргийлсэн хашаатай байх ба хог хаягдлын бүтэц, найрлагыг тогтоох, хэмжих, ачиж буулгах, шахаж нягтруулах техник, тоног төхөөрөмжтэй байх;
- 6.2.11. Эрүүл ахуйн шаардлага хангасан, лабораторийн шинжилгээгээр хүлээн зөвшөөрөгдсөн хог хаягдлаар дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх;
- 6.2.12. Хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь 30 хоногийн хугацаанд туршилтын үйлдвэрлэлийг явуулан, үйл ажиллагааны горим, технологийн үзүүлэлт,

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

агаарт ялгарах ялгарлын хэмжээг тогтоож стандарт, шаардлага хангасан тохиолдолд үйл ажиллагааг эхлэх;

6.2.13. Хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь Хог хаягдлын тухай хууль, тогтоомж, стандарт, шаардлага, хөдөлмөр хамгаалал, эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, сэргээн ашиглах технологи, арга ажиллагааны талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, ажилтан ажилчиддаа тогтмол сургалт зохион байгуулах;

6.2.14. Хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь техник, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээ хийх заавар, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах дүрэм, аргачлал боловсруулан мөрдөж ажиллах;

### **ДОЛОО. ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ, БУЛШЛАХ**

7.1. Эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь сэргээн ашиглах, дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга технологиор устгаж булшилна.

7.2. Сэргээн ашиглах, дахин боловсруулагдах боломжгүй энгийн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт буулгаж дахин ангилал хийгдсэний дараа ландфиллийн зориулалттай талбайд түрж булна.

7.3. Ашиглах боломжгүй болон дахин боловсруулах үйлдвэрлэлүүдийн хаягдал хогийг тухайн үйлдвэрүүд энэхүү журмын 2.2.1-д заасан гэрээнд тусгасны дагуу төвлөрсөн хогийн цэгт буулгаж булшлуулна.

7.4. Хог хаягдлыг зөвхөн төлөвлөж, батлагдсан талбайд хүлээж авах бөгөөд байгалийн гамшигт үзэгдэл, давагдашгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Захирагчийн ажлын албатай зөвшилцөн нөөц талбайд хог хаягдлыг хүлээн авна

7.5. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдлыг хүлээн авах, дарж, нягтруулах үйл ажиллагааг шөнийн цагт явуулах тохиолдолд хангалттай гэрэлтүүлэгтэй орчинд талбайн чиглүүлэгчийн удирдлага дор гүйцэтгэж, осол, аваар гарахаас сэргийлэх арга хэмжээг авч ажиллана

7.6. Биологийн болон хими, физикийн аргаар хог хаягдлыг устгахдаа ашиглах бодис, технологийн талаарх мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж, дүгнэлт гаргуулан Захирагчийн ажлын албанаас зөвшөөрөл авсны дараа гүйцэтгэнэ

7.7. Хог хаягдал хүлээн авах ажлын талбайд хог хаягдлыг дахин ангилан ялгах үйл ажиллагааг тусгай хуваарийн дагуу аюулгүй ажиллагааг ханган эрхэлнэ.

7.8. Хэт хуурайшилттай, халуун, салхи, шуургатай үед хог хаягдал хийсэх, агаарт тоосонцор үүсэхээс сэргийлэн хог хаягдал хүлээн авч байгаа талбайг усаар норгож чийглэх, хог хаягдал шатаж, гал гарсан тохиолдолд шуурхай унтраах зорилгоор усан сан болон ус шүрших төхөөрөмж бүхий усны машинтай байх бөгөөд гал унтраах ажиллагаанд оролцох ажилтнууд гал унтраах сургалтад хамрагдсан байна

7.9. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдлыг шороон хөрсөөр хучиж нягтаршуулбал хөрсний зузаан 15 см багагүй байх бөгөөд хог хаягдал хучих хөрсийг шаардлагатай хэмжээгээр нөөцөлж хадгалсан байна

7.10. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдал тээвэрлэж ирсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухай хог хаягдлыг ландфилдд дарж булах зардлыг Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.2 дэх заалтад заасны дагуу тогтоон тооцож авна

7.11. Хог хаягдлын төвлөрсөн цэгт ажиллах машин, техникүүд нь олон улсын болон үндэсний стандарт шаардлагыг хангасан байна

7.12. Хог хаягдлын төвлөрсөн цэг дээр ажиллаж байгаа хүнд даацын техник хэрэгсэл болон авто машинууд үйл ажиллагаанд хяналт, мониторинг хийх боломжтой газар зүйн мэдээллийн (GPS) систем суурилуулсан байна

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

- 7.13. Хог хаягдал тээвэрлэн ирж байгаа авто машиныг ачаатай үед хог хаягдлын төвлөрсөн цэгт орох пүүн дээр жигнэж, бүртгэн, хэмжилт хийн, ачиж, тээвэрлэсэн хог хаягдлын эх үүсвэр, хог хаягдлын төрлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд хяналтын ажилтан ачиж, тээвэрлэсэн хог хаягдлыг шалгаж, нягтлан биологийн, химийн болон аюултай, шатах, дэлбэрэх эрсдэлтэй хог хаягдал илэрвэл хог хаягдлын төвлөрсөн цэгт нэвтрүүлэхийг хориглоно
- 7.14. Хог хаягдал асгаж, буулгасны дараа хог хаягдлын төвлөрсөн цэгээс авто машин гарахад ачаагүй үеийн авто машины жинг хэмжиж пүүлэх бөгөөд ачаатай үеийн жингийн зөрөөгөөр хог хаягдлын төвлөрсөн цэгт тээвэрлэгдэн ирсэн хог хаягдлын хэмжээг тооцон бүртгэж, баталгаажуулна
- 7.15. Хог хаягдлын төвлөрсөн цэгт шингэн хог хаягдал, хүний шарил, эд эрхтэн, тэсэрч дэлбэрэх, химийн, аюултай хог хаягдал булшлахыг хориглоно
- 7.16. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаанаас үүсэх агаар, хөрс, усанд ялгарах ялгаралд жилд нэг удаа хяналт, шинжилгээ хийх, ялгарал нь стандарт шаардлагаас өндөр болсон тохиолдолд шалтгаан нөхцөлийг тогтоон, засварлаж ялгарлыг хэвийн хэмжээнд хүргэх ба давтан шинжилгээгээр ялгарал нь дахин стандарт, шаардлагаас өндөр байвал, ялгарал стандарт хэмжээнд хүртэл хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг Захирагчийн ажлын албанаас түр хаана
- 7.17. Хаалтын хучилт хийгдсэн болон нөхөн сэргээлт хийгдсэн талбайг эргүүлэн ухаж, хог хаягдлыг гаргаж тараахыг хориглох ба зайлшгүй тохиолдолд Захирагчийн ажлын албанаас зөвшөөрөл авч ухаж болох бөгөөд эргүүлэн нөхөн сэргээлтийг хийнэ
- 7.18. Хяналттай төвлөрсөн хогийн цэг нь дараах шаардлагыг хангасан байна
- Хог хаягдал булшлах, устгах байгууламж уруу орох замыг хөрсөөр хучиж, нягтруулан хог тээврийн авто машин саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;
  - Хамгаалалтын хашаа;
  - Гадна гэрэлтүүлэг;
  - Хяналтын камер, дэлгэц болон бусад шаардлагатай тоног төхөөрөмж бүхий бүртгэлийн байр;
  - Авто пүү;
  - Тээвэрлэх, түрэх, ус шүрших, булж устгах тоноглол бүхий зориулалтын машин техник;
  - Гал унтраах иж бүрэн тоног, төхөөрөмж, хувцас, хэрэгсэл;
  - Автограж;
  - Харуулын байр;
- 7.19. Хог хаягдлын төвлөрсөн цэгт ажиллагсад нь хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг нарийн чанд мөрдөж ажиллана
- 7.20. Хог хаягдлын төвлөрсөн цэг нь эмнэлгийн болон аюултай хог хаягдлыг булшлах хөрс, газрын доорхи болон гадаргын ус бохирдохоос болон хур тунадас, нарны шууд тусгалаас хамгаалсан битүүмж сайтай зориулалтын байгууламжтай байна
- 7.21. Хог хаягдлын төвлөрсөн цэгт аюултай болон эмнэлгийн хог хаягдлыг булшлахын өмнө шатах боломжтой хаягдлыг пиролизийн шатаах зууханд буюу 900-1100<sup>0</sup>С-д шатаах болон хоргүйжүүлж саармагжуулсан байна
- 7.22. Хог хаягдлын төвлөрсөн цэгт булшлах эмнэлгийн болон аюултай хог хаягдлын зөвшөөрлийг мэргэжлийн хяналтын дүгнэлтийг үндэслэн Захирагчийн ажлын албанаас олгоно
- 7.23. Хог хаягдлын төвлөрсөн цэгт булшилсан эмнэлгийн болон аюултай хог хаягдлын тодорхойлолт, тоо хэмжээ, устгасан арга, огноог тэмдэглэсэн бүртгэл хөтөлнө



## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

7.24. Хог хаягдлын төвлөрсөн цэгт зөвшөөрөгдсөн эмнэлгийн болон аюултай хог хаягдлыг булшлахдаа битүүмжлэлийг чанд сахина

### **НАЙМ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

8.1. Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг:

8.1.1. Журмын хэрэгжилтийг хангах, үр дүнг тооцох, аймгийн ИТХ-д тайлагнах;

8.1.2. Журмыг хэрэгжүүлэхэд сум, багийн Засаг дарга болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллах;

8.1.3. Хог хаягдал булшлах, устгах үйл ажиллагаа эрхлэх байгууллагатай гэрээ байгуулах, зөвшөөрөл олгох;

8.1.4. Гэнэтийн болон Байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон үед хуваарьт бус бүх нийтийн их цэвэрлэгээг зарлах;

8.1.5. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, булшлахад шаардагдах төсөв, техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

8.1.6. Орон тооны бус хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийг байгуулж ажиллах

8.1.7. Хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжид Газрын тухай хууль, бусад хууль тогтоомжид заасны дагуу газар олголт болон дэд бүтцээр дэмжлэг үзүүлэх

8.2. Хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийн хүлээх үүрэг:

8.2.1. Хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах, устгах байгууллагын үйл ажиллагааны хүчин чадал, менежментийг үнэлэх аргачлалыг боловсруулах

8.2.2. Хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгааны нэгдсэн арга зүйг боловсруулах;

8.2.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх аргачлал, зөвлөмжөөр хангаж ажиллах

8.2.4. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, мониторинг үнэлгээ хийх

8.3. Захирагчийн ажлын албаны хүлээх үүрэг

8.3.1. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр дэх хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих, бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах;

8.3.2. Сумдын хилийн цэс харгалзахгүйгээр нэгдсэн удирдлага зохион байгуулалттайгаар цэвэрлэгээ хийх нийтийн эдэлбэр газарт хамаарах гудамж, зам талбай, хотоос алслагдсан зам, замын байгууламжийн жагсаалтыг батлах;

8.3.3. Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох ба хяналтын төрийн бус байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж ажиллуулах;

8.3.4. Аймгийн хэмжээнд хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах

8.3.5. ААН, байгууллагуудын хог хаягдал хариуцсан ажилтнуудад жилд 2-оос доошгүй мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, тухайн байгууллагын хог хаягдлын нарийвчилсан тайлан мэдээг нэгтгэн гаргах

Аймгийн нутаг дэвсгэрт хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээний гэрээ"-г сумын Засаг даргатай хамтран байгуулах;

8.3.6. Аймгийн хог хаягдлын менежментийн хяналт, удирдлагын нэгдсэн цахим системийг ажиллуулах;

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

- 8.3.7. Хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх байгууллагын үйл ажиллагааны хүчин чадал, үйл ажиллагаанд улирал бүр хяналт тавьж, дүгнэлт гаргах
- 8.3.8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө, олон улсын зээл, тусламжаар байгуулах хог хаягдал булшлах, устгах байгууламжийн газар Захирагчийн ажлын албаны эзэмшилд байх ба хог хаягдлын төвлөрсөн цэгийг хаасны дараа арван жилийн турш байгаль орчны хяналт, мониторинг хийх;
- 8.4. Сумын Засаг даргын хүлээх үүрэг:
- 8.4.1. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, иргэн аж ахуйн нэгж байгууллагад сурталчлах, боловсролын байгууллагууд болон ТББ-тай хамтран олон нийтийн мэдлэг, хандлагыг өөрчлөх сургалт, нөлөөллийн ажлуудыг хамтран зохион байгуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх.
- 8.4.2. Хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулах, сэргээн ашиглах, дахин боловсруулах цэгийг байгуулах, хог хаягдлыг устгах булшлахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгах.
- 8.4.3. Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх график, маршрутыг батлах, хяналт тавих.
- 8.4.4. Анхан шатанд ахуйн хог хаягдлыг ангилан ялгасан, бусдад үлгэр дуурайл болсон айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, олон нийтэд сурталчлах.
- 8.4.5. Хог хаягдлыг бууруулах, төвлөрсөн цэгийг тохижуулах, устгах, булшлах үйл ажиллагаанд тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын техник хэрэгслийг ашиглах.
- 8.4.6. Эрүүл мэнд, барилга, зам тээвэр, батлан хамгаалахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудыг хог хаягдлаа тухайн чиглэлийн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан журмын дагуу тээвэрлэх, устгах, булшлахыг шаардах, хяналт тавих.
- 8.4.7. Аюултай хог хаягдлыг түр байршуулах газрыг байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллагуудын үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн тогтоож, түр хадгалах байр, түүнийг тээвэрлэх, зам, маршрут гарган батлах.
- 8.4.8. Хог хаягдлын тайлан, мэдээг холбогдох иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас хугацаанд нь авч 6, 12 дугаар сарын 10-ны дотор Байгаль орчин, аялал жуулчлалын газарт болон Захирагчийн ажлын албанд хүргүүлэх
- 8.4.9. Журмын 8.3.2-д зааснаас бусад сумын хилийн цэс доторх нийтийн эдэлбэр газарт хамаарах гудамж, зам талбайн жагсаалтыг батлах;
- 8.4.10. Хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх байгууллагын үйл ажиллагааны хүчин чадал, үйл ажиллагаанд улирал бүр хяналт тавьж, үнэлгээг улирал тутамд хийж, үр дүнг Захирагчийн ажлын албанд тайлагнах;
- 8.4.11. Бүх нийтийн их цэвэрлэгээнд хамрагдах сумын нутаг дэвсгэрийн гудамж, зам, талбай, ногоон бүсийн зураглалыг гаргаж төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, их, дээд сургууль, коллеж, ерөнхий боловсролын сургуульд зураглалаар хариуцуулан, хуваарь гарган батлах;
- 8.4.12. Сумын нутаг дэвсгэр дэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбоодод хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгааг журмын 8.2.2-д заасан арга зүйн дагуу тогтмол зохион байгуулах;
- 8.4.13. Нийтийн эдэлбэр газар, гудамж талбайд журамд заасан стандартын дагуу байршуулах ба шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусгуулах;
- 8.4.14. Сумын нутаг дэвсгэрт журмын хэрэгжилтийг хангах, нийтийн эдэлбэр газарт ил задгай хог хаягдал үүсгэхгүй байх арга хэмжээг авч ажиллах;
- 8.4.15. Сумын нийт айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын ачилт, цуглуулалт, тээвэрлэлтийн үйлчилгээг өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр Хог

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2-т заасны дагуу Захирагчийн албатай хамтран нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, шалгарсан байгууллагатай “Хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээ эрхлэх гэрээ” байгуулан гүйцэтгүүлэх;

8.4.16. Сумын нутаг дэвсгэр хог ачиж, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх хог хаягдлын үйлчилгээний байгууллагыг журмын 8.2.1-т заасан сар бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 41.10 дахь хэсэгт заасны дагуу санхүүжүүлэх ба чанаргүй гүйцэтгэсэн ажлын хувь хэмжээгээр санхүүжилтийг хасаж олгоно.

8.4.17. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлөх хог хаягдлын үйлчилгээний хураамжид хяналт тавих;

8.4.18. Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.7, 9.4.14-д заасны дагуу хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хог хаягдлын олон нийтийн байцаагчийг ажиллуулж, шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусгаж батлуулах;

8.4.19. Сумын газар нутгийн онцлогоос хамаарч ангилсан хог хаягдлыг худалдан авах, түр хадгалах цэгийн байршлыг тогтоох;

8.4.20. Зам талбайн цэвэрлэгээг аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас баталсан тарифыг үндэслэн цэвэрлэгээний зардлыг сумын төсөвт тусгаж, Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулах.

8.5. Багийн Засаг даргын хүлээх үүрэг:

8.5.1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, аймаг сумаас зохион байгуулж буй хог хаягдлыг бууруулах, ангилах, сэргээн ашиглах, дахин боловсруулах талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, олон нийтийн ажилд багийн иргэд, айл өрх болон багийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулах;

8.5.2. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн аж ахуйн нэгж байгууллагын тээвэрлэлтийн график, хугацаа давтамжид хяналт тавьж хамтран ажиллах;

8.5.3. Хог хаягдлын олон нийтийн байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

8.5.4. Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг ангилуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, бүртгэл хөтлөх;

8.5.5. Нийтийг хамарсан цэвэрлэгээ зохион байгуулахад гэр хорооллын хэсэг, орон сууцны хорооллын СӨХ -тэй хамтран айл өрх, иргэдийг татан оролцуулах, бүртгэл тэмдэглэл хөтлөх;

8.5.6. Тухайн багийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг ААН, байгууллагын хогийн бүртгэл судалгааг нэгтгэн хөтлөх, хяналт тавих, холбогдох тайлан мэдээг гаргах;

8.5.7. Баг хороодод сайн дурын идэвхтэн ажиллуулах, чиглэл өгөх, хамтран ажиллах;

8.5.8. Байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хог, зэм, хаягдлыг цэвэрлэх, устгах ажилд зохион байгуулалттай оролцох, хяналт тавьж ажиллах.

8.6. Хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах, устгах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгж байгууллагын хүлээх үүрэг:

8.6.1 НААҮГ болон гэрээгээр хог цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, устгах, булшлах үүрэг хүлээсэн ААН нь энэхүү журмын 2.2-т заасан ерөнхий шаардлагыг ханган ажиллах ба хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах, булшлах үйлчилгээг батлагдсан хуваарийн дагуу тогтмол чанартай үзүүлэх;

8.6.2. Цэвэрлэж, цуглуулж, тээвэрлэж, устгаж, булшилсан хог хаягдлын дэлгэрэнгүй бүртгэл бүхий мэдээллийн сантай байх бөгөөд холбогдох тайлан мэдээг цаг тухайд нь Захирагчийн ажлын алба, сумын Засаг даргын тамгын газарт нэгтгэн гаргаж өгч байх;

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

- 8.6.3. НААҮГ болон гэрээгээр хог цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, устгах, булшлах үүрэг хүлээсэн ААН нь энэхүү журмын 4.4-д заасан шаардлагыг хангахаас гадна хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг ажилтнуудыг ажилд гарахын өмнө өдөр бүр өгч, хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийн бүрэн, бүтэн байдлыг шалгах зэрэг аюулгүй ажиллагааг хангаж ажиллах;
- 8.6.4. НААҮГ болон гэрээгээр хог цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, устгах, булшлах үүрэг хүлээсэн ААН нь ажилтан, албан хаагчдыг өвөл болон зуны улирлын хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл, ажлын хувцас, гутлаар хангах;
- 8.6.5. Ажилтан, албан хаагчдыг хог хаягдлын хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, шаардлага болон хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, устгах, булшлахтай холбоотой мэргэжлийн сургалтад хамруулан мэргэшүүлж ажиллуулах;
- 8.6.6. Ажилтан, албан хаагчдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалд хамруулах;
- 8.6.7. Өвчтэй буюу ядарсан үед техник, хэрэгслийн жолооч, туслах ажилтнууд, чиглүүлэгчийг ажиллуулахгүй байх; журам зөрчсөн болон ажлын хариуцлага алдсан ажилтанд хариуцлага тооцох;
- 8.6.8. Үйл ажиллагаанд ашиглах хүнд даацын машин, механизмуудыг засах, үйлчилгээ хийх засварын төвийг байгуулах ба дугуй солих, нөхөх төхөөрөмж, агаарын шүүр цэвэрлэх компрессор болон шаардлагатай сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хог хаягдлыг ачиж, тээвэрлэсний дараа тээврийн хэрэгсэл болон тэвшийг тогтмол цэвэрлэж, сард хоёроос доошгүй удаа ариутгал, халдваргүйжүүлэлт хийх;
- 8.6.9. Ажлын байр болон хог хаягдал хүлээн авч буй талбайд ил гал гаргах, тамхи татах болон шатах, тослох материал агуулахгүй байх;
- 8.6.10. Төвлөрсөн хогийн цэгийн харуул, хамгаалалтыг мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх;
- 8.6.11. Хог хаягдлын төвлөрсөн цэгт мал, амьтан оруулах, бэлчээх, тэжээхгүй байх;
- 8.6.12. Иргэдийн санал, гомдлыг шийдвэрлэж, шуурхай байдлыг ханган ажиллах;
- 8.6.13. Зориулалтын бус газарт хог хаясан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, зөрчил гомдлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд үнэн зөв мэдээлэх, зөрчлийг арилгахад хамтран ажиллах;
- 8.6.14. НААҮГ болон гэрээгээр хог цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, устгах, булшлах үүрэг хүлээсэн ААН нь энэхүү журамд үндэслэн үйл ажиллагааны зохион байгуулалт, аюулгүй ажиллагааг нарийвчлан заасан журмыг боловсруулан мөрдөх
- 8.7. СӨХ, ГӨХ-ны хүлээх үүрэг:
- 8.7.1. Сууц өмчлөгчдийн холбоо нь Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.10-т заасны дагуу орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал, шарилж, лууль зэрэг ургамал, цас мөсийг өдөр бүр тогтмол цэвэрлэх;
- 8.7.2. Журмын 8.7.1-д заасан үүргийг гүйцэтгэхгүй тохиолдолд багийн Засаг дарга мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд гарсан зардлыг сууц өмчлөгчдийн холбоо хариуцах;
- 8.7.3. Харьяалж буй орон сууцныхаа оршин суугчдад энэхүү журмын хавсралт 11-д тусгасан зааврын дагуу ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь хэрхэн ангилан ялгах болон хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх өдөр, хуваарийн талаарх мэдээллээр хангах;
- 8.7.4. СӨХ-ны харьяаллын орон сууцны дундах хог хаягдал түр хадгалах ангилан ялгах савны ашиглалт хамгаалалт ариутгал халдваргүйжилтийг хариуцаж ажиллах
- Багийн Засаг дарга болон сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэнтэй хамтран оршин суугчдад сургалт, сурталчилгаа явуулах, нийтийн цэвэрлэгээнд татан оролцуулах;

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

- 8.7.5. Оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж орц, байрны орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг хийх хугацааг тодорхой гаргаж тогтмолжуулах;
- 8.7.6. Орон сууцны нэг давхарт байрлах ААН, байгууллагуудын хогийн судалгааг гаргаж хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах, зориулалтын хогийн савтай байх, нийтийн ангилсан хогийн цэгт хаях, хогийн төлбөр барагдуулах зэрэгт хяналт тавьж ажиллахаас гадна нийтийн цэвэрлэгээ болон бусад олон нийтийн чанартай үйл ажиллагаанд татан оролцуулах;
- 8.7.7. Энэ журмын 4.10-д заасан бүх нийтийн цэвэрлэгээнд харьяа орон сууцны оршин суугчид болон орон сууцны нэг давхарт байрлах ААН, байгууллагуудыг хамруулах
- 8.7.8. Хог хаягдал ачиж цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллага хуваарийн дагуу ангиллын төрөл тус бүрээр хогоо ачаагүй тохиолдолд Захирагчийн ажлын алба, баг сумын Засаг даргад мэдээлж уг байгууллагын үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах, 3-аас дээш удаа хуваарийн дагуу хогоо ачаагүй тохиолдолд гэрээг нь цуцлуулах, шаардлага хангасан хүчин чадал бүхий өөр байгууллагаар тээвэрлэлт хийлгүүлэхийг шаардах;
- 8.7.9. Гудамж Өмчлөгчдийн Холбоо (ГӨХ) нь өөрийн харьяалалд хамрагдах гудамж, талбайн цэвэрлэгээ, тохижилтод хяналт тавьж ажиллах
- 8.7.10. .Харьяалж буй гудамжныхаа оршин суугчдад энэхүү журмын хавсралт 11-д тусгасан зааврын дагуу ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь хэрхэн ангилан ялгах болон хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх өдөр, хуваарийн талаарх мэдээллээр хангах;
- 8.8. Аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг:
- 8.8.1. ААН, байгууллага нь эрчим хүч, усны хэрэглээг багасгаж хамгийн бага хэмжээгээр хог үүсгэх, эх үүсвэр дээр хог хаягдлыг бууруулах бодлого, дадал хандлагыг үйл ажиллагаандаа хэвшүүлж ажиллах;
- 8.8.2. ААН, байгууллага нь стандартад нийцсэн ангилан ялгах хогийн савыг энэхүү журмын 3.27-д заасан шаардлагад нийцүүлэн байршуулсан байх;
- 8.8.3. ААН, байгууллага нь хог хаягдлаа энэхүү журмын хавсралт 11-д заасны дагуу эх үүсвэр дээр нь ангилж, цуглуулан, татан зайлуулах батлагдсан хуваарьт нийцүүлэн зориулалтын ангилсан хогийн цэгт хадгалах;
- 8.8.4. ААН, байгууллага нь дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж эсхүл ажилтантай байх бөгөөд хог хаягдал хариуцсан ажилтан нь хог хаягдлын талаар сургалтад тогтмол хамрагддаг байх ба байгууллагын ажиллагсдыг хог хаягдлын менежментийн талаарх мэдлэг ойлголт, мэдээллээр хангах, байгууллагын хог хаягдлын төрөл, хэмжээ бүхий судалгаа тайланг нэгтгэн гаргаж холбогдох байгууллагуудад цаг тухайд нь хүргэж ажиллах;
- 8.8.5. ААН, байгууллага нь Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.10-г заасны дагуу орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал, шарилж, лууль зэрэг ургамал, цас мөсийг өдөр бүр тогтмол цэвэрлэх;
- 8.8.6. Журмын 8.8.5-д заасан үүргийг гүйцэтгэхгүй тохиолдолд сумын Засаг дарга мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд гарсан зардлыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага хариуцах;
- 8.8.7. ААН, байгууллага нь хог хаягдлын тооллогыг төрөл, хэмжээгээр нь нарийвчлан бүртгэдэг судалгаатай байх, мэдээ тайланг цаг хугацаанд нь гаргах, төсөв хөрөнгө төлөвлөх, нийтийг хамарсан цэвэрлэгээнд ажилтан, албан хаагчдыг хамруулах, холбогдох зардлыг гаргаж цэвэрлэгээний багаж хэрэгслээр хангах;
- 8.8.8. Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гаргах хог хаягдлыг цуглуулж барилгын хог хаягдал тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах



## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

эрх бүхий иргэн аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлэх, үйлчилгээний хөлсийг хариуцах, шаардлагатай тохиолдолд эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

8.8.9. Эмнэлгийн хог хаягдлыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу ангилах, цуглуулах, нэгдсэн эмнэлгийн зориулалтын хог тээвэрлэх, устгах нэгжид хүлээлгэн өгөх;

8.8.10. Аюултай болон химийн гаралтай хог хаягдлыг Аюултай хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх, устгах журмын дагуу хадгалж ашиглалтын хугацаа дуусмагц Дархан-Уул аймгийн аюултай хог хаягдал төвлөрүүлэн хадгалах газарт хүлээлгэн өгөх;

8.8.11. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй сүлжээний бизнес эрхлэгч иргэн, ААН нь тухайн сүлжээний бүтээгдэхүүний сав баглаа, боодлыг эргүүлэн цуглуулж холбогдох дахивар авах цэгүүд болон дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгөх, эргэлтэнд оруулах үүрэг хүлээх;

8.8.12. Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр, үйлчилгээний газрууд үйлдвэрлэж байгаа болон борлуулж буй бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотойгоор үүсэж буй дараах хаягдлыг эргэн цуглуулж сэргээн ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах болон аюулгүй устгалд оруулах үүрэг хүлээх:

- РЕТ төрлийн хуванцар сав;
- Шилэн лонх, сав;
- Авто тээврийн хэрэгсэл болон өөрөө явагч хэрэгслийн дугуй;
- Хөнгөн цагаан болон металл лааз, сав;
- Гар утас болон түүний дагалдах хэрэгсэл;
- Хуурай зай;
- Хугацаа дууссан эм, тариа;

8.8.13. Хог хаягдлыг үүсгэгч нь журмын 8.8.11 болон 8.8.12 дахь заалтыг дангаар болон хамтран хэрэгжүүлж болно.

8.8.14. Хүнсний зах, супермаркет, худалдаа үйлчилгээний төвүүд иргэдэд авсан бараагаа савлах цэгийг байгуулж, цаасан хайрцгаар хангах, дахивар авах дэвшилтэт технологи бүхий автомат машинуудыг байршуулан ажиллах

8.8.15. Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд аймаг сумаас зураглалаар хариуцуулсан нийтийн эдэлбэр газар, гудамж, зам, талбайн хог хаягдлыг журмын 4.10-д заасан шаардлагыг дагуу цэвэрлэж ачуулах, холбогдох байгууллагад мэдээ тайлан гаргаж өгөх;

8.8.16. ААН, байгууллага нь 0.75м.кубээс дээш эзлэхүүнтэй овор хэмжээ их энгийн болон барилгын хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-д заасны дагуу нэмэлт үйлчилгээний хөлс төлж эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэх;

8.8.17. Барилга, байгууламжийг өргөтгөх, шинээр барихдаа түүний зориулалт, хүн амын нягтрал, хог хаягдлын үүсэх хэмжээ, ангиллын төрлөөс хамаарч хог хаягдал хадгалах байр, талбайн байршлыг барилга, байгууламжийн зураг, төсөлд тусгасан байх;

8.8.18. Бүх шатны боловсролын байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн ААН, байгууллага, компаниуд хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, ангилан ялгах соёл, дадлыг төлөвшүүлэх зорилгоор жилд 1 удаа олон нийтийн арга хэмжээг хамтран болон дангаараа санаачлан зохион байгуулж ажлын үр дүнгийн тайланг Захирагчийн Албанд ирүүлэх

8.8.19. Судалгааны байгууллага, их дээд сургууль, ТББ-ууд энэхүү журмын хэрэгжилтэд гүйцэтгэх үүрэгтэй оролцохоос гадна олон нийтийн хог хаягдлын талаарх мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалт,

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах, хогийн төрөл ангилал, хэмжээний талаар мэдээлэл судалгаа бэлтгэх, түгээн дэлгэрүүлэх үүргийг хүлээх

8.8.20. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой, хувийн хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжүүд бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа хог хаягдлыг дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг нэн тэргүүнд сонгоно.

8.9. Орон сууцны хорооллын айл өрх, иргэдийн хүлээх үүрэг:

8.9.1. Эрчим хүч, усны хэрэглээг багасгаж хамгийн бага хэмжээгээр хог үүсгэх, эх үүсвэр дээр хог хаягдлыг бууруулахад чиглэсэн минималист амьдралын хэв загварыг ажил амьдралдаа хэвшүүлэх

8.9.2. Ахуйн хог хаягдлаа энэхүү журмын 3.2 заалтын дагуу хавсралт 11-ээр баталсан зааврын дагуу эх үүсвэр дээрээ ангилах

8.9.3. Эх үүсвэр дээр ангилсан хог хаягдлаа нийтийн ангилсан хогийн цэгт зааврын дагуу хаях

8.9.4. Ахуйн хог хаягдлаа эх үүсвэр дээр журмын дагуу ангилан ялгаад дахин боловсруулах хаягдлаа дахиварын төвүүдэд хүргэж өгсөн иргэн, айл өрхүүд энэ журмын хавсралт 12-д заасан тарифаар бодож үнэ төлбөрийг авна

8.9.5. Хүнсний хогийг зааврын дагуу ангилж зориулалтын органик хаягдал авах саванд энэ журмын 3.19д заасан стандарт уутанд савлан хаях

8.9.6. Овор хэмжээ ихтэй хаягдал, ахуйн электрон бүтээгдэхүүний хаягдал болон барилгын хаягдлуудыг дахивар цуглуулах цэг, засварын газрууд болон дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүлээлгэн өгч энэ журмын хавсралт 12-д заасан тарифаар бодож үнэ төлбөрийг авна, дуудлага өгч ачуулсан тохиолдолд ачилтын төлбөрийг хариуцах

8.9.7. Хугацаа дууссан эм тариа, халдвар бүхий боолт тариур зэрэг ахуйн орчинд үүссэн эмнэлгийн хаягдлыг журмын 3.25-д заасны дагуу стандарт уутанд хийж сайн битүүмжлэн харьяа өрхийн эмнэлэгт болон гэрийн ойр эмийн санд хүлээлгэн өгөх

8.9.8. Ахуйн орчинд үүссэн энэ журмын 3.9-д заасан аюултай хог хаягдлыг журмын 3.25-д заасны дагуу стандарт уутанд хийж сайн битүүмжлэн аюултай хог тээвэрлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагад дуудлага өгөн зайлуулах ба тээвэрлэлтийн зардлыг хариуцах

8.9.9. Хог хаягдлыг орц болон зориулалтын бус цэгт журамд заасан зааврын дагуу бус хаясан, айл өрх, иргэнд шаардлага тавих, энэ талаар үнэн зөв баримттай мэдээлэх, Хог хаягдлын тухай хуулийн 41.13 заалтын дагуу урамшуулал авах

8.9.10. Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд хариуцсан нийтийн эдэлбэр газар, гудамж, зам, талбай, орц, байр орчмын хог хаягдлыг журмын 4.10-д заасан шаардлагыг дагуу цэвэрлэж ачуулах, хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, ангилахад чиглэсэн орон нутгийн хөтөлбөр, компанит ажлуудад идэвхтэй оролцох;

8.9.11. Иргэн, айл өрх нь журамд заасан аймаг сумаас зохион байгуулж буй хог хаягдлын талаарх сургалтад хамрагдах;

8.10. Гэр хорооллын айл өрх, иргэдийн хүлээх үүрэг:

8.10.1. Эрчим хүч, усны хэрэглээг багасгаж хамгийн бага хэмжээгээр хог үүсгэх, эх үүсвэр дээр хог хаягдлыг бууруулахад чиглэсэн минималист амьдралын хэв загварыг ажил амьдралдаа хэвшүүлэх

8.10.2. Ахуйн хог хаягдлаа энэхүү журмын 3.2 заалтын дагуу хавсралт 11-ээр баталсан зааврын дагуу эх үүсвэр дээрээ ангилах

8.10.3. Айл бүр энэхүү журмын 3.20 заалтад заасан стандартын дагуу хийгдсэн хогийн цэгтэй байна.

8.10.4. Үнснийг журмын 3.23 заалтад заасан стандарт уутанд савлан, бусад хогийг журмын 3.21 заалтад заасан зориулалтын уутанд савлаж журмын 8.10.3-д заасан хогийн цэгт

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

хадгалж, батлагдсан хуваарийн дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэн өгч ачуулах

8.10.5. Хүнсний болон мал амьтны гаралтай органик хог хаягдлыг журмын 3.23-т заасны дагуу дахин боловсруулах замаар компост бордоо бэлтгэж хашаа хорооныхоо ногоон байгууламжийг бордож ашиглах

8.10.6. Яс болон бусад дахин боловсруулах хог хаягдлыг энэхүү журмын хавсралт 11-ээр баталсан зааврын дагуу ангилж хашаандаа хадгалж байгаад хамгийн ойр байршилд байх дахивар авах цэг болон эрх бүхий иргэн ААН, байгууллагад хүлээлгэн өгч журмын хавсралт 12-д заасан тарифаар бодож үнэ төлбөрийг авна, дуудлага өгч ачуулсан тохиолдолд ачилтын төлбөрийг хариуцах

8.10.7. Овор хэмжээ ихтэй хаягдал, ахуйн электрон бүтээгдэхүүний хаягдал болон барилгын хаягдлуудыг дахивар цуглуулах цэг, засварын газрууд болон дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүлээлгэн өгч энэ журмын хавсралт 12-д заасан тарифаар бодож үнэ төлбөрийг авна, дуудлага өгч ачуулсан тохиолдолд ачилтын төлбөрийг хариуцах

8.10.8. Хугацаа дууссан эм тариа, халдвар бүхий боолт тариур зэрэг ахуйн орчинд үүссэн эмнэлгийн хаягдлыг журмын 3.25-д заасны дагуу стандарт уутанд хийж сайн битүүмжлэн харьяа өрхийн эмнэлэгт болон гэрийн ойр эмийн санд хүлээлгэн өгөх

8.10.9. Ахуйн орчинд үүссэн энэ журмын 3.9-д заасан аюултай хог хаягдлыг журмын 3.25-д заасны дагуу стандарт уутанд хийж сайн битүүмжлэн аюултай хог тээвэрлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагад дуудлага өгөн зайлуулах ба тээвэрлэлтийн зардлыг хариуцах

8.10.10. Хог хаягдлыг зориулалтын бус цэгт хаясан, журамд тавигдсан стандарт шаардлагыг мөрдөөгүй айл өрх, иргэнд шаардлага тавих, энэ талаар үнэн зөв баримттай мэдээлэх, Хог хаягдлын тухай хуулийн 41.13 заалтын дагуу урамшуулал авах

8.10.11. Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд хариуцсан нийтийн эдэлбэр газар, гудамж, зам, талбай, хашаа орчмын хог хаягдлыг журмын 4.10-д заасан шаардлагыг дагуу цэвэрлэж ачуулах, хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, ангилахад чиглэсэн орон нутгийн хөтөлбөр, компанит ажлуудад идэвхтэй оролцох;

8.10.12. Иргэн, айл өрх нь журамд заасан аймаг сумаас зохион байгуулж буй хог хаягдлын талаарх сургалтад хамрагдах;

### **ЕС. ХЯНАЛТ ТАВИХ, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ**

9.1. Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаанд дараах этгээд хяналт тавина:

9.1.1. Аймаг, сумын ИТХ, аймаг, сум, багийн Засаг дарга

9.1.2. Мэргэжлийн хяналтын газар

9.1.3. Байгаль орчин аялал жуулчлалын газар

9.1.4. Онцгой байдлын газар

9.1.5. Экологийн цагдаагийн алба

9.1.6. НААҮГ

9.1.7. Төрийн бус байгууллага

9.1.8. ААН

9.1.9. СӨХ

9.1.10. Иргэдийн бүлэг, иргэн

### **9.2. Хариуцлага хүлээлгэх:**

9.2.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Улсын байцаагч, Цагдаа, аймаг, сум, багийн Засаг дарга нь Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

9.2.2. Журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.3. Хог хаягдлын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой маргааныг хоёр тал харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **АРАВ. УРАМШУУЛАЛ**

10.1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан, ялгаж хэвшсэн, хог хаягдлыг дахин ашиглах шинэ санал санаачилгыг гаргасан, мөн хоёрдогч түүхий эдийг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулахад бусдад үлгэр дуурайл болсон айл өрх, иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулж, олон нийтэд сурталчлан, бүх талаар дэмжиж ажиллана.

10.2. Дээрх дэмжлэг, урамшууллын арга хэмжээг тухайн иргэн аж ахуйн нэгжийн хүсэлт, багийн Засаг даргын тодорхойлолтыг үндэслэн аймаг, сумын Засаг дарга зохион байгуулна.

10.3. Энэхүү журмыг зөрчсөн тухай мэдээлэл өгсөн иргэн, ААН-д уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгуулийн 15 хувиар тооцож Хог хаягдлын тухай хуулийн 41.13 заалтын дагуу аймаг, сумын Засаг дарга мөнгөн урамшуулал олгоно.

10.4. Урамшууллын механизмыг хэрэгжүүлэхдээ Монгол улсын Засгийн газрын 2015 оны 263 дугаар тогтоол /Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилж, урамшуулал олгох журам/-ийг мөрдлөг болгоно.


# ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

## Журмын хавсралтууд

Хавсралт 1. Хог хаягдлын өнгөний кодын стандарт

 <ul style="list-style-type: none"> <li>✓ Хэт богиногүй сонин, сэтгүүл дэлгэр, бичгийн цаас</li> <li>✓ Төрөл бүрийн боодлын цаас</li> <li>✓ Картон цаас</li> <li>✓ Сүү, жүжсний тетрапак саяалгаа</li> </ul> <p>Өнгөний код: ЦЭНХЭР</p>	 <ul style="list-style-type: none"> <li>✓ Арда, пиво, ундаа, дарсны шил</li> <li>✓ Бүх төрлийн шилэн сав, хэдлэл</li> <li>✓ Ундаа, шавоны лаал</li> <li>✓ Бүх төрлийн давдсан бүтээгдэхүүний сав.</li> <li>✓ Шал, лаазны таглаа</li> <li>✓ Тугалган цаас</li> </ul> <p>Өнгөний код: УЛЪАР ШАР</p>	 <ul style="list-style-type: none"> <li>✓ Төрөл бүрийн ус, услагны хувицар сав</li> <li>✓ Кечүүц, уургасан тос, утгага, цэвэрстгэлийн нунтаг, шингний хувицар сав</li> <li>✓ Авто машины тос, тослогооны шингний хувицар сав</li> <li>✓ Нэг удаагийн хувицар сав</li> <li>✓ 0.025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, бяглаа боодол</li> </ul> <p>Өнгөний код: НОГООН</p>	 <ul style="list-style-type: none"> <li>✓ Аравн цэврийн хэрэгслийн хаягдал</li> <li>✓ Номын хавтас</li> <li>✓ Сигуур, фото цаас</li> <li>✓ Давин ашиглагдахгүй урагдаж зууцисан хувица, хэрэгсэл</li> <li>✓ Нэг удаагийн аяга тавь хэрэгсэл</li> <li>✓ Шаралгаасан гялгар (уут талх, нарийн боос, чөсрийн уут)</li> <li>✓ Хягарсан шалан хэдлэл, пазантай сав</li> </ul> <p>Өнгөний код: ХАР</p>	 <ul style="list-style-type: none"> <li>✓ Бүх төрлийн жимс, хүнсний ногооны халдас болон үлдэгдэл</li> <li>✓ Хоолны үлдэгдэл</li> <li>✓ Ял</li> <li>✓ Өндөгний халдас.</li> <li>✓ Хэрэгдсэн хүнсний тос</li> </ul> <p>Өнгөний код: БОР</p>	 <ul style="list-style-type: none"> <li>✓ Бүх төрлийн батерей</li> <li>✓ Химийн хортой бодис түүнийг агуулсан сав</li> <li>✓ Эмгэгдлийн халдварбүхийн хаягдал</li> <li>✓ Эсийн хаягдал</li> <li>✓ Хортой бодис агуулсан, хортой бодисоор болирсон, мөнгөн ус агуулсан хаягдлууд</li> </ul> <p>Өнгөний код: ШАР</p>
--	--	--	---	---	---

Хавсралт 2. Орон сууцны хорооллын айл өрхүүдийн ахуйн хатуу хог хаягдал цуглуулах савны стандарт





# ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Хавсралт 3. Орон сууцны хорооллын айл өрхүүдийн органик хаягдал хийх савны стандарт



Хавсралт 4. Орон сууцны хорооллын айл өрхүүдийн органик хаягдлын уутны стандарт



Хавсралт 5. Гэр хорооллын айл өрхүүдийн ахуйн хог хаягдал цуглуулах, хадгалах савны стандарт



# ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Хавсралт 6. Бусад хогийн уутны стандарт



Хавсралт 7. Гэр хорооллын айл өрхүүдийн органик хаягдлын бокаши савны стандарт



Хавсралт 8. Гэр хорооллын айл өрхүүдийн үнсний уутны стандарт



# ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Хавсралт 9. Аюултай хог хаягдлын уутны стандарт



Хавсралт 10. ААНБ-ын энгийн хатуу хогийн савны жишиг



Хавсралт 11. Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах зааварчилгаа

Энгийн хатуу хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах зааварчилгаа:

- Цаас
  - o Скотчгүй байх
  - o Хавтасгүй байх
  - o Наалтгүй байх
  - o Лакан бүрээсгүй байх
  - o Хоол хүнсний бохирдолгүй байх
  - o Цавуугүй байх
  - o Чихэр болон фото цаасны хаягдлыг бусад хогтой хаях
- Ус, ундааны сав, лааз
  - o Угааж цэвэрлэсэн байх
  - o Овор хэмжээг багасгасан байх
- Шил
  - o Угааж цэвэрлэсэн байх
  - o Шошгыг салгасан байх
  - o Тагийг авсан байх
- Гялгар уут

## ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

- o Овор хэмжээг багасгасан байх
- o Уутыг шошгоноос нь салгасан байх
- o Мөнгөлөг гялгар уут авахгүй

Шаардлага хангасан дахиварыг урьдчилж бэлдсэн уутанд тус бүрд нь хийж цуглуулж, хадгална.

Цуглуулсан дахиварыг батлагдсан хуваарийн дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх иргэн, ААН, байгууллагад хүлээлгэн өгч, хамтран ажиллана.

Эсвэл дахивар авах цэгт тушаана.

Органик хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах зааварчилгаа:

- Ясны хаягдлыг бусад хүнсний хаягдалтай холихгүй байх
- Хоолны үлдэгдлийн шингэнийг шүүж уутанд хийх
- Хүнсний ногооны хаягдалтай сонгино, сармисны хаягдлыг холихгүй байх
- Жимс, жимсгэнийн хаягдалтай хаягдалтай холихгүй байх
- Сонгино, сармис, цитрусын төрлийн хаягдлыг бусад хогтой хаях

Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах зааварчилгаа:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр, хурдны хайрцаг, тослогооны хаягдал, тоормосны шингэн, хөлддөггүй шингэн зэргийг хөрсөнд нэвчүүлэхгүйгээр сайтар битүүмжилсэн саванд хурааж түүхий эд цуглуулах цэг болон хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх
- Ашиглалтын хугацаа дууссан аккумулятор, машины дугуй, бусад эд ангийг түүхий эд цуглуулах цэгт хүргэх
- Хэрэглэсэн батарейгаа томоохон тагтай шил болон хуванцар саванд цуглуулж батарей цуглуулдаг цэгүүд /сургууль, дэлгүүр, үйлчилгээний газрууд гэх мэт/ дээр хүргэж өгөх
- Мөнгөн ус агуулсан хаягдлыг бага насны хүүхэд хүрэхээс болгоомжлон уут саванд хийж битүүмжлэн, дээр нь хаягдлын нэрийг тодорхой бичих
- Хугацаа нь дуусаагүй хэрэглэхгүй байгаа эм тариа, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг эмийн сангуудад хүргэж өгөх, хугацаа нь дууссан бол сайн битүүмжилж, дээр нь хаягдлын нэрийг бичих
- Биологийн хаягдлыг хатуу саванд цуглуулж, дээр нь хаягдлын нэрийг тодорхой бичих
- Электрон хог хаягдлыг хуучин эд зүйл худалдаж авдаг цэг, түүхий эд цуглуулах цэгт хүргэх
- Гоо сайхны бүтээгдэхүүний хаягдлыг сайн битүүмжилж, дээр нь хаягдлын нэрийг бичиж шар өнгийн уутанд хийж хаяна.

Аюултай хог хаягдал үүсгэгч бүтээгдэхүүнийг гэртээ аюулгүйгээр хадгалах зааварчилгаа:

- Хэрэв савнаас гоожиж, асгарсан бол шинэ сав ашиглах, хүнсний савыг ашиглахгүй байх
- Хадгалах явцад өөр зүйл нэмэхгүй байх
- Сав баглаа боодол дээр анхааруулах шошго, үйлдвэрлэгчийн заавар зэрэг нь хэвээр байгаа эсэхийг шалгах
- Бага насны хүүхдээс хол байлгах
- Чүдэнз гэх мэт гал өдөөх эх үүсвэрийг хадгалах газраас хол байлгах
- Хадгалах газрыг сэрүүн, хуурай байлгах

## ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Хавсралт 12. Үнийн судалгаа

№	Төрөл	Хэмжих нэгж	Үнэ
1	Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, шүүсний тетрапак савалгаа/		
	Сонин	кг	50
	Сэтгүүл		
	Дэвтэр		
	Боодлын цаас		
	Картон цаас		
Сүү, шүүсний тетрапак савалгаа			
2	Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав		
	Ус, ундааны (PET)	кг	200
	Бор (PET)		50
	Ахуйн хэрэглээний (HDPE)		400
	Авдар, подоон (PP)		100
	Вакуум, цонхны (PVC)		300
	Хөөсөнцөр		500
3	0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол		
	Зөөлөн (LDPE)	кг	500
	Багцлагч пакет		800
4	Хөнгөн цагаан, төмөр, металл, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл;		
	Зэс /гялгар/	кг	12000
	Зэс /бохир/		11000
	Гууль		3500
	Радиатор		4000
	Хайлш, хөнгөн цагаан		2300
	Тугалга		1000
	Аккумулятор		600
	Төмөр /зузаан/		180
	Төмөр /нимгэн/		130
	Төмөр /ган/		80
	Төмөр /ширмэн/		130
5	Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/;		
	550 гр	ш	50
	720 гр		20
	980 гр		20
	1-1,5 л		20
	300-350 гр		20
	350 гр /шоколадны крем/		20
	500-530 гр /урбаник/		40
	Сок /тагтай/		20
	Үлэмж тарагны шил /1 л/		200
	Үлэмж тарагны шил /0.5 л/		100
	Үлэмж тарагны шил /0.2 л/		50
	Ээдэм		50
	Хужирт/0.3, 073/		20



## **ХАВСРАЛТ-1. ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХОГ ХАЯГДЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

	Вакусны шил		10
	Шар Чингис/0.3-0.7/		250
	Соёрхол/0.5, 0.7/		100
	Сэржим /0.5, 0.7/		100
	Стандарт /0.7л/		150
	Стандарт /0.5л/		50
	Стандарт /0.3л/		30
	Соёмбо /0.5, 0.7/		100
	Их монгол /0.5, 0.7/		50
	Морьт хангай		40
	АПУ, хараа пиво		30
	Хараа /0.5,0.7/		40
	Хараа /0.3/		10
	Ерөөл /0.7/		50
	Ерөөл /0,3, 0,5/		30
	Export /0.7/		50
	Export /0.3, 0.5/		30
	Вино /эргэдэг тагтай/		30
6	Лааз;	кг	900
7	Газ /тагтай/	ш	50
	Газ /таггүй/	ш	25
8	Мод, модон эдлэлийн хаягдал;		
9	Хувцас, даавуун эдлэл;		
10	Савхи, резин;		
11	Өвс, мод.		

Эх сурвалж: Төвшин Сайхан төв

## **ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

### **ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

#### **Үндэслэл**

Монгол улсын хүн амын өсөлт, хотын хэт тэлэлтээс үүдэлтэй их хэмжээний хог хаягдал үүсэж байгаа нь хүн амын эрүүл мэнд төдийгүй байгаль орчин, экологи, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлсөн томоохон тулгамдсан асуудал болж, хяналт зохицуулалт, үйлчилгээний хүртээмжгүй байдлыг бий болгож байна.

Өнөөгийн байдлаар хот, аймаг, сум, суурин газрын орчим болон уул уурхайн бохирдуулсан газрыг оролцуулбал 10 мянга гаруй га газар хог хаягдлаар 4000 га газар химийн бодисоор, нийт 111154.4 га газар хатуу хог хаягдлаар, 4093.6 га газар химийн хог хаягдлаар бохирдсон байна.

Манай улсын хот суурин газраас хаягддаг хог хаягдлын 35-40% нь хаягдал гялгар уут хуванцар байдаг. Полиэтилен, полимер, PP, PVC хэмээн нэрлэгддэг нүүрстөрөгч, устөрөгчийн химийн нэгдэл (C<sub>2</sub>H<sub>4</sub>) нь өнөөгийн хүн төрөлхтний амьдралд чухал хэрэгцээ болсон ч хаягдахаараа маш удаан хугацааны турш буюу 100 – 400 жилд задарч, байгаль орчинд үл шингэдэг байна. Энэ хугацаандаа химийн хорт хий ялгаруулж хөрс, ус, агаарыг бохирдуулсаар байдаг.

Мөн гялгар уут, хуванцар нь тодорхой хугацаанд хүнсний бүтээгдэхүүнтэй урвалд орж формалдегид, бензол, тлоул зэрэг олон уусгагч ялгаруулж, тэр нь эргээд хүнсэндээ шингэдэг. Гялгар уутан савлагаатай байсан хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэл нь уутандаа ялзарч, гэдэсний савханцар, сальмонеллэз, стафилококк зэрэг маш олон зүйлийн халдварт өвчин үүсгэгч нян бактери үржиж, дамжих хөрс суурь болж өгдөг. Ямар ч төрлөөр хэрэглэх гялгар уут нэг удаагийн хэрэглээ. Түүнчлэн эдгээр хатуу хог хаягдлыг манай улсад зөвхөн булшлах ландфиллийн аргаар л дарж булж байгаа нь газрын хөрсөн дор маш удаан оршиж, хөрснөөс гадна гүний усыг ч бохирдуулах чадвартай хорыг үүсгэж, газар дор шатан хүлэмжийн хий ялгаруулж орчны агаар бохирдуулж байгаа юм.

Сүүлийн 35-40 жилд дэлхий нийтээрээ хог хаягдлыг ангилан ялгаж, боломжтой хэсгийг нь дахин боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр ихээхэн хэмжээний байгалийн нөхөн сэргээгддэггүй ашигт малтмал, ой модыг хамгаалж, хөрс ус агаарыг бохирдуулахаас сэргийлж байгаа шинэ төрлийн бизнес бий болон өргөжин тэлж байгаа билээ.

Монголын үндэсний хог хаягдлыг дахин боловсруулах холбоо ТББ-аас гаргасан албан бус судалгаагаар дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг нийт хог хаягдлын 80 хувь гэж үзвэл бид жилд 78 тэрбум төгрөгийг шууд хаядаг бөгөөд тэрхүү хаягдлаа дарж булшилж устгахын тулд төсвөөс илүү их хэмжээний үргүй зардал гаргадаг гэсэн дүгнэлтийг өгсөн байна. 2018 оны байдлаар Дархан уул аймагт 2 хогийн цэгүүд дээр жилдээ 30000 тн хатуу хог хаягдал буулгаж булдаг бол Улаанбаатар хотод байгаа Цагаан даваа, Нарангийн энгэр, Морингийн даваа гэсэн нийт 3 нэгдсэн хогийн цэгүүд дээр өдөртөө 2000 шахам тонн хатуу хог хаягдал буулгаж булдаг гэж Нийслэлийн болон Дархан Уул аймгийн Захирагчийн Ажлын Албаны харъяа Хот тохижуулах газрын мэдээнд дурдагдаж байгаа нь тэдгээрийг тээвэрлэх, булахад асар их эдийн засгийн зардал гарч байгаагийн илрэл юм.

#### **Төслийн зорилго**

Төслийн зорилго нь дахин боловсруулах боломжтой эдийн засгийн эргэлтэд оруулж болох дахивар хог хаягдлыг цуглуулж, хүрээлэн буй орчны эрүүл мэндийг хамгаалах, байгаль орчныг бохирдуулж буй хуванцар хог хаягдлыг дахин боловсруулан байгалийн шахагдах нөөц баялгийг хамгаалах, хуванцар, төмөр бетон, цаасан үйлдвэрлэлийг орлох, импортоор орж ирж буй бүтээгдэхүүнийг орлох, дотоодын зах

## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

зээлийг хангах болон стратегийн ач холбогдолтой түүхий эдийг орлуулж бат бөх, өнгө үзэмжтэй бүтээгдэхүүн хийцийг үйлдвэрлэж, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулан шинээр ажлын байрыг бий болгоход оршино.

Хуванцар савны хор хөнөөл:

1. Хуванцар сав бисфенол, хар тугалга, миламин зэрэг хор ялгаруулдаг.
2. Хамгийн аюултай нь хуванцар савны хор удаан хугацааны дараа дархлаа бууруулж, цус багадалт, элэгний хатуурал, чихрийн шижин, үргүйдэл, хөхний болоод савны хавдар, эр бэлгийн эсийн цөөрөл, арьсны өвчин, мэдрэлийн саажилт, ургийн гажиг үүсгэдэг.
3. Хуванцар савны хэрэглээтэй айлын хүүхдүүдийн цусанд хар тугалга хэвийн хэмжээнээс өндөр гарч, тухайн хүүхдүүдийн оюуны чадавх мэдэгдэхүйц буурч, ядаргаанд орсныг баталсан судалгаа байна.
4. Хоолыг хуванцар сав, гялгар уутанд хийж халаах маш осолтой бөгөөд хуванцар савны хортой бодис хоолонд шингэж хорт хавдар үүсгэх нөхцөл бүрдүүлдэг.
5. Хуванцар сав, гялгар уутны хог хаягдал хөрсөнд уусаж шингэдэггүй тул байгаль бохирдуулан хордуулах сөрөг нөлөөтэй.
6. Хуванцрын төрлүүд:
7. №1 PEТЕ полиэтилентерефталат. Хуванцрын хамгийн өргөн тархсан хэлбэр. Минерал ус, жимсний шүүсний сав, кетчуп, ургамлын тосны сав зэрэг бүтээгдэхүүн хийдэг. Ийм савнуудыг дахин ашиглах бүрэн боломжтой. Европын холбооны улсууд болон Америкт хүүхдийн тоглоом хийхэд ашигладаг.
8. №2 HDPE өндөр нягттай полиэтилен . Нам даралтын полиэтилен. Энэ төрлийн хуванцраар нэг удаагийн сав, хуванцар уут сав, сүүний сав, хүнсний ногооны уут сав зэргийг хийдэг.
9. №3 PVC поливинилхлорид . Энэ төрлийн хуванцрыг техникийн зориулалтаар ашигладаг. Хуванцар хоолой, мебель, техникийн шингэн хадгалах сав зэргийг хийхэд ашигладаг. Хуванцрын хамгийн аюултай төрөлд ордог.
10. №4 LDPE бага нягттай полиэтилен. Энэ төрлийн хуванцрыг CD, шугам зэрэг хатуу эдлэлийг хийхэд ашигладаг.
11. №5 PP полипропилен. Бат бөх, дулааны тэсвэртэй. Хүүхдийн тоглоом, хүнсний ногооны сав, тариур зэргийг хийхэд ашигладаг.
12. №6 PS полистирол. Энэ төрлийн хуванцар нь мах болон сүүний зориулалттай гэж ангилагддаг. Тарагны сав, хүнсний ногоо, жимсний сав, сэндвичний дулаан тусгаарлах хавтан, мах хадгалах сав зэргийг хийдэг.
13. №7 бусад поликарбонат, полиамид ба бусад төрөл. Дээрх төрөлд хамаарагдахгүй хуванцрууд ордог. Усны сав, тоглоом, хүүхдийн угж, гэх мэт хуванцар эдлэлийг хийхэд ашигладаг.
14. Хуванцар нь полившил (PVC гэгддэг) болон поли этиленээс тогтоно. Энэ төрлийн сав, лонхнууд маш өргөн хэрэглэгдэж байна. Яагаад гэвэл үйлдвэрлэхэд хялбар, задарч ялзралгүй маш удаг. Хэрэв чийг, дулаан үйлчлэхгүй бол хөрсөнд хаягдсан хуванцар сав хэдэн зууны турш тэндээ хадгалагддаг. Хуванцрыг шатаах нь асуудлыг шийдэх тохиромжтой арга биш. Харин сүүлийн үед бичил биетүүдийн тусламжтайгаар хялбар задардаг цардуулыг хуванцрын бүтцэд нэмснээр хуванцар нь байгалийн бүтээгдэхүүн гэгдэх тал уруугаа илүү ойртож байна.
15. Хуванцар карт мөн хуванцар савны адил PVC -ээс тогтоно. Энэ нь утасны карт, кредит карт гэх зэргээр бидний өдөр тутмын амьдралд хэрэглэгдэж байна. Түүний хөрсөнд маш удаан хугацаагаар хадгалагддаг чанар нь

## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

ирээдүйн археологичдод бидний өнөөгийн амьдралын тухай мэдэхэд сайн “олдвор-баримт” болж магадгүй юм.

Хүснэгт 73. Монгол улсын хэмжээнд айл өрхийн жилийн хуванцар хаягдлын бүтэц /тн/

	Хатуу хуванцар /HDPE, LDPE, PVC/	Гялгар уут	Хуванцар сав /PET /
Гэр хороолол	221.3	27.7	138.3
Орон сууц	236.2	29.5	147.7

### Дархан-Уул аймгийн хуванцар хог хаягдлын өнөөгийн байдал

Дархан Уул аймгийн хэмжээнд жилдээ 47.5 мянган тн хог хаягдал ялгардаг бөгөөд гэр хорооллоос гарч буй хог хаягдлын 80 гаруй хувь, нийт хог хаягдлын 56%-ийг тус тус дахин боловсруулах боломжтой. 2019 оны байдлаар хог хаягдлын төвлөрсөн 1 цэгт 360 тонн хог хаягдал цугларсан бол 2017 оны байдлаар зориулалтын бус газарт хаягдсан 5671м үерийн далан, 11000 м2 эзэнгүй талбайн хог хаягдлыг энэхүү төсөл эдийн засгийн эргэлтэд оруулна. Дахин боловсруулах боломжтой /бүх төрлийн хуванцар сав (PET), хатуу хуванцар(HDP,LDPE, PP), гялгар уут зэрэг/ хог хаягдал орон сууцанд амьдарч байгаа иргэдийн хувьд /зун болон өвлийн улиралд/ нийт хог хаягдлын дунджаар 40% орчим хувийг, гэр хорооллын хувьд зуны улиралд нийт хог хаягдлын 30 орчим хувийг эзэлж байна гэж тогтоосон

### Нөөцийн судалгаа

Дархан-Уул аймгийн хэмжээнд жижиг1600 орчим дунд бизнес эрхлэгч болон хувиараа үйлдвэр эрхлэгч байдаг гэсэн судалгаа байдаг. Эндээс зориулалтын төрлөөс хамааруулан томоохон үйлдвэрлэлүүдээс жилд гардаг хуванцар хог хаягдлын хэмжээг тооцож үзэхэд гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь жилд дунджаар 750 орчим кг хаягдал гаргадаг бөгөөд одоогийн байдлаар Дархан-Уул аймгийн хэмжээнд нийт 100 орчим хүнсний үйлдвэрлэл байна. Энэ үйлдвэрүүдээс жилд нийт 42 орчим тонн хуванцар хог хаягдал гардаг судалгаа харагдаж байна.

Хүснэгт 74. Дархан-Уул аймгийн хүнсний үйлдвэрээс гарах хуванцар хог хаягдлын хэмжээ

Хүнсний үйлдвэр	Зориулалт	Нийт	Жилд нэг үйлдвэрийн гаргаж байгаа дундаж пластик хаягдал /кг/	Жилд гарах хуванцар хог хаягдал /кг/	Пластик хаягдлын төрөл
	Мал төхөөрөх үйлдвэр	2	568	1,136	Төрөл бүрийн
	Мах боловсруулах үйлдвэр	31	23	713	Төрөл бүрийн
	Сүү боловсруулах үйлдвэр	8	105	840	Төрөл бүрийн

## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

	Гурилын үйлдвэр	7	139	973	урагдсан шуудай
	Гурилан бүтээгдэхүүний үйлдвэр	51	750	38,250	шуудай, гялгар уут, хуванцар сав
	<b>Нийт</b>	<b>99</b>	<b>1585</b>	<b>41.912.00</b>	

Нийтийн хоолны үйлчилгээний салбарын хувьд Дархан-Уул аймгийн хэмжээнд 236 хоолны үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, хувь хүн байдаг бөгөөд хуванцар хог хаягдлын хэмжээ зочид буудлын дэргэдэх ресторанд жилд дунджаар 312 кг гардаг нь хамгийн их бөгөөд харин хувь хүн эрхэлдэг цайны газрын хувьд олон байдаг учир жилд гарч байгаа хуванцар хаягдлын хэмжээ нийтдээ 26 гаруй тонныг эзэлж байна. Нийтийн хоолны салбараас жилд нийт 44 гаруй тонн хуванцар хаягдал гардаг гэсэн судалгаа харагдаж байна.

Хүснэгт 75. Дархан-Уул аймгийн нийтийн хоол үйлдвэрлэлээс гарах хуванцар хог хаягдлын хэмжээ

	Зориулалт	Нийт	Нэг үйлдвэрийн гаргаж байгаа дундаж пластик хаягдал /кг/	жилд гарах хуванцар хог хаягдал /кг/	Пластик хаягдлын төрөл
Нийтийн хоол үйлдвэрлэл	зочид буудлын дэргэдэх ресторан	8	312	2.496	Төрөл бүрийн
	зоогийн газар	23	260	5.980	Төрөл бүрийн
	кафе	30	276	8.268	Төрөл бүрийн
	түргэн хоолны газар	5	208	1.040	Төрөл бүрийн
	цайны газар	170	156	26.520	Төрөл бүрийн
	<b>НИЙТ</b>	<b>236</b>	<b>1.212</b>	<b>44.304</b>	

Хүнсний дэлгүүр болон худалдаа эрхлэгч нарын хувьд хуванцар хог хаягдлыг нарийвчлан тодорхойлох боломжгүй боловч хүнсний худалдаа эрхлэгч тодорхой тооны дэлгүүрээс нарийвчлан судалгаа хийхэд жилд дунджаар 400 гаруй кг хуванцар гардаг болохыг тооцож гаргасан байна. Эндээс жилд нийт 150 гаруй тонн хуванцар хог хаягдал гардаг гэдэг судалгаа гарсан байна.



## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Хүснэгт 76. Дархан-Уул аймгийн хүнсний худалдаанаас гарах хуванцар хог хаягдлын хэмжээ

Хүнсний худалдаа үйлчилгээ	Зориулалт	Нийт	Нэг дэлгүүр, лангууны гаргаж байгаа дундаж пластик хаягдал /кг/	жилд гарах хуванцар хог хаягдал /кг/	Пластик хаягдлын төрөл
	Хүнсний дэлгүүр, лангуу		365	415	151.475
	<b>нийт</b>	<b>365</b>	<b>415</b>	<b>151.475</b>	

Айл өрхийн судалгааны үр дүнгээс харахад хуванцар сав 1 сая 800 орчим мянган кг хуванцар гардаг бөгөөд 70 орчим хувийг худалдаж авна гэж тооцоол гарсан байна.

Хүснэгт 77. Дархан-Уул аймгийн айл өрхөөс гарах хуванцар хог хаягдлын хэмжээ

Айл өрх	Зориулалт	Нэг өрхийн гаргаж байгаа дундаж пластик хаягдал /кг/	жилд гарах хуванцар хог хаягдал /кг/	Пластик хаягдлын төрөл
	Хатуу хуванцар PET		35.4	864.000
Хатуу хуванцар HDPE, LDPE, PVC		17.7	432.000	Төрөл бүрийн
Гялгар уут		23.6	576.000	Төрөл бүрийн
	<b>нийт</b>	<b>76.7</b>	<b>1.872.000</b>	

Хүснэгт 78. Монгол улсад Хуванцар хаягдлаар хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компани

№	Компанийн нэр	Байршил	Үйл ажиллагааны чиглэл	Бүтээгдэхүүний нэр төрөл
1	Пластик центр ХХК	БЗД	Хуванцар хаягдал, гялгар уут дахин боловсруулах	Хуванцар хаягдал, гялгар уутыг дахин боловсруулан ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч
Хуванцар болон цаас дахин боловсруулан өөр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч				

## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ


2	Хэв хашмал хуванцар ХХК	Налайх дүүрэг	Хуванцар дахин боловсруулах	Хуванцар дахин боловсруулан барилгын төрөл бүрийн хэв хашмал үйлдвэрлэгч
3	Од пластик	БГД	Хуванцар, гялгар уут дахин боловсруулах	Хуванцар дахин боловсруулан үрлэн түүхий эд, гялгар уут үйлдвэрлэгч
4	Мог пластик	СХД	Дулааны аргаар боловсруулалт	Хуванцар дахин боловсруулан үрлэн түүхий эд үйлдвэрлэгч
5	Сан Оргиу	Дархан-Уул аймаг	Хуванцар, гялгар уут дахин боловсруулах	Хуванцар хаягдал, гялгар уутыг дахин боловсруулан ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч

### 20x40 метрийн хэмжээтэй үйлдвэрлэлийн зориулалттай барилгын зардал

Архитектур төлөвлөлтийн хувьд 20x40 харьцаатай барилга нь үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж багтах тулаасгүй орон зайтай нэгдсэн талбай төлөвлөв. Авто машины 1, явган хүний 1 хаалгатай төмөр карказан сендвичин барилга байна.

Суурийн барилга нь төмөр бетон аяган болон шугаман суурьтай байна. Хучилт болон дээвэр нь металл дам нуруун дээр  $b=150\text{мм}$  зузаантай сэндвичэн хавтангаар 2 налуу дээвэр маягаар угсарна. Шалыг ургамлан хөрсийг хуулж,  $b=300\text{мм}$  зузаантай нягтруулсан хайрган дэвсгэр дээр БМ-150 маркийн бетоноор  $b=150$  зузаантай цутгана.

Хаалгыг  $b=150$  зузаантай сэндвичин хавтангаар хийх ба вакуум цонхтой байна. Халаалтыг төвийн холболтод холбохоор төлөвлөсөн ба агаар сорох ердийн салхивчтай байна.



Зураг 109. Үйлдвэрийн барилгын загвар

## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Хүснэгт 79. 20x40 метрийн хэмжээтэй үйлдвэрийн барилгын

№	Материалын нэр	марк	хаана хэрэглэх	хэмжих нэгж	хэмжээ	нэгжийн үнэ	нийт үнэ
1	Хананы хавтан	150мм 18кг/м <sup>3</sup>	Хана	м	600	33000	19800000
2	Таазны хавтан	150мм 18кг/м <sup>3</sup>	Дээвэр	м	1030	36000	37080000
3	Хананы хавтан	150мм 18кг/м <sup>3</sup>	Хаалга	м	27	33000	891000
4	Төмөр	Квадрат 60x60	Карказ	м	652	12000	7824000
5	Төмөр	Квадрат 20x20	Карказ холболт	м	360	2500	900000
6	Цонх	Вакум	Цонх	м	72	180000	12960000
7	Дайраг	0-5 мм	Шал	м <sup>3</sup>	240	16000	3840000
8	Бетон зуурмаг	БМ-150	Шал	м <sup>3</sup>	120	175000	21000000
9	Бусад	Холболт		ш	1	1000000 0	10000000
10	Халаалтын зардал	Цахилгаан халаагуур	Шал хана	м	800	80000	64000000
<b>Нийт</b>						<b>179.295.000</b>	


Хүснэгт 80. Түүхий эдийн бүтээгдэхүүний үнэ

Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав		
Ус, ундааны (PET)	кг	200
Бор (PET)	кг	50
Ахуйн хэрэглээний (HDPE)	кг	400
Авдар, подоон (PP)	кг	100
Вакум цонхны (PVC)	кг	300
Хөөсөнцөр	кг	500
0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол		
Зөөлөн (LDPE)	кг	500
Багцлагч пакет	кг	800

Энэхүү бүтээгдэхүүний судалгааны үр дүнгээс харахад хуванцар савны үнэ дунджаар 1кг үнэ 300 орчим төгрөг байгаа бөгөөд нийт аж ахуйн нэгж болон байгууллагуудаас жилд ойролцоогоор 250 мянга орчим кг хаягдал, айл өрхөөс 1 сая 800 орчим мянган кг хуванцар гардаг бөгөөд 70 орчим хувийг худалдаж авна гэж тооцох юм бол энэ нь зах зээлийн үнээр жилд 600 орчим сая төгрөгөөр худалдаж авах тооцоо байна.

## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

*Хуванцар хог хаягдлыг дахин ашиглаж үйлдвэрлэх үйл ажиллагааны горим*




Зураг 110. Үйл ажиллагааны горим



Зураг 111. Пластик хог хаягдлыг дахин бутлан боловсруулах үрлэн технологийн үйлдвэр

КСР цуврал шахмал үрлэн боловсруулах машин нь БНХАУ-ын улсын үйлдвэрийнх бөгөөд зах зээлийн ханшаар 60,000 доллар үнэтэй байдаг. /Тээврийн зардал болон гаалийн зардал ороогүй./ Хуванцар эдлэлд зориулагдсан гурван дамжлагатай дахин боловсруулах машин юм. Үрлэн хийх машин нь PE, PP, CPP, BOPP, PS, PPS, EPS, ABS, PA, PLA, PET хаягдал хуванцар материалыг дахин боловсруулах чадвартай. Үйлдвэрлэлийн хүчин чадал жилд 30-50 багц гаргах хүчин чадалтай.



Зураг 112. Бутлагч машины бүтэц

## **ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**



Зураг 113. Түүхий эд

Бүх төрлийн хатуу зөөлөн пластик болон хөвөн даавуу зэрэг материалуудыг дахин боловсруулах боломжтой.

Хүснэгт 81. КСР пластик дахин боловсруулах машины техник үзүүлэлт /КСР180/

Төрөл	Хэмжээ	Цах.Зарц уулалт	Урт	Өргөн	Өндөр	Нягтруул агч	Моторын чадал	Бутлагч	Моторын чадал	2 дахь нягтруула гч
	кг/цаг	кв.кг/ цаг								
КСР180	1000	0.2	1480	685	485	1400	160-180	180	315-355	200

### **HDPE LDPE PE Био задрах бариултай дахин боловсруулсан уут хийх машин**

Энэ хурдан задралтай био задрах машин нь БНХАУ-ын улсын үйлдвэрийнх бөгөөд зах зээлийн ханшаар 36,000 доллар үнэтэй байдаг. /Тээврийн зардал болон гаалийн зардал ороогүй./ Гялгар уутанд зориулагдсан дахин боловсруулах машин нь HDPE LDPE PE хаягдал хуванцар материалыг дахин боловсруулах чадвартай. Үйлдвэрлэлийн хүчин чадал жилд 300 орчим багц гаргах хүчин чадалтай.

## **ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**



Зураг 114. HDPE LDPE PE Био задрах бариултай дахин боловсруулсан уут хийх машин

Хүснэгт 82. Үйлдвэрлэлтийн машины хэмжээ

Ангилал	CW-400V2
Урт	250mm-750mm
Өргөн	400*2lines
Хэрчих хурд	250-300pcs per min
Хальслах зузаан	0.01-0.04mm

Хүснэгт 83. Био задрах гялгар уутны дахин боловсруулах машины техник үзүүлэлт

Техник үзүүлэлт	жин	Хурд	Урт	Өргөн	Өндөр	Улс
	кг	1 мин	см			
	2000	6000	600	200	130	Тайван

### **Ningbo HAICHEN эрчим хүч хэмнэх хуванцар цэцгийн бортого хийх машин**

Эрчим хүчний хэмнэлттэй хуванцар цэцгийн сав хийх машин нь БНХАУ-ын улсын үйлдвэрийнх бөгөөд 33000 орчим доллар үнэтэй байна. /Тээврийн зардал болон гаалийн зардал ороогүй./ Энэхүү цэцгийн савны машин нь 1 цагт 1000 ширхэг үйлдвэрлэх хүчин чадалтай.



Зураг 115. Ningbo HAICHEN эрчим хүч хэмнэх хуванцар цэцгийн бортого хийх машин



## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Хүснэгт 84. Хуванцар бортогын хэмжээ төрөл

	Хэмжээ	96*96*82
	Материал	ABS/PP/PC/PET/HDPE
	Жин	34гр
	Төрөл	followerpot /plant pot /plastic follower container/box

Хүснэгт 85. Техник үзүүлэлт

Төрөл	Боловсруулах хуванцрын төрөл	Жин	Моторын хүчин чадал	Өдөрт дунджаар
HCS290	PP, PC, ABS, PET, PVC, PPR, EVA HDPE, MLLDPE	9300 кг	30 kw	3000 ш

Хүснэгт 86. Цахилгаан зардлын тооцоо

Зарцуулалтын төрөл	Тариф	Хэрэглээ/цаг	Ашиглалтын зардлын дүн	
			Өдөрт	Сард
Цахилгааны хэрэглээ /кВт.ц	141.35	562.7	79.545	1.750.000
Дулааны хэрэглээ /гДж	7276.5	3.43	25.000	550.000
<b>Нийт</b>			<b>104.545</b>	<b>2.300.000</b>

Хүснэгт 87. Туслах багаж хэрэгсэл

№	Нэр Монгол	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Будагч бодис	20 тн	10.000.000	200.000.000
2	Бусад туслах багаж хэрэгсэл			12.000.000
3	Ачааны машин	2	20.000.000	40.000.000
<b>Нийт</b>				<b>93.000.000</b>

Хүснэгт 88. Хүний нөөцийн жагсаалт, цалин

Албан тушаал	Орон тоо	Сарын цалин
Удирдлагын баг		
Ерөнхий захирал	1	1.500.000
Гүйцэтгэх удирдлагын баг		

## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Маркетинг, борлуулалтын менежер	1	1.200.000
Тоног, төхөөрөмжийн инженер	1	1.200.000
Үйлдвэрлэлийн алба		
Ээлжийн ахлах	2	900.000
Үйлдвэрийн ажилчид	21	800.000
<b>Бүгд</b>	<b>26</b>	<b>22.500.000</b>

### Сургалт хөгжил

Ажилтнуудыг сүүлийн үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжтэй танилцуулах, ашиглаж сургах үүднээс тоног төхөөрөмж нийлүүлсэн байгууллагын албан ёсны сургалтанд хамруулна. Мөн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс мэргэжилтэн ирж угсралт ба тохиргоо, туршилт, сургалт хийх үед мэргэжлийн ажилчдыг дагалдуулан тоног төхөөрөмжийн хүчин чадал, бүтэц, ажиллуулах зарчим болон техникийн үзүүлэлтийн талаар мэдлэгийг эзэмшүүлэх, сургах ажлуудыг зохион байгуулна.

Ажилчдад өдөр бүр ажил эхлэхийн өмнө тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа болон үйлдвэрлэлийн соёл холбогдох дүрэм журмын талаар зааварчилгаа сургалтыг өгч ажиллуулна. Мөн ажилчдын дунд техник аюулгүй ажиллагааны талаар тогтмол шалгалт авч, хяналт тавьж байна.

Компанийн бизнесийн ёс зүйн журмыг боловсруулан мөрдүүлнэ.

Компанийн бизнесийн ёс зүйн журам нь тус компанийн ажилтнууд харилцагч, хэрэглэгч байгууллагуудын болон хамтран ажилладаг хүмүүстэй албан болон албан бус тохиолдолд ажил төрлийн харилцаанд хэрхэн орох, биеэ зөв авч явах, ёс суртахууны өндөр соёл, хүмүүжилтэй байх талаар баримтлан мөрдөх зарчим, хэм хэмжээг тодорхойлно. Ажилтнууд компанийн нүүр царай гэдгээ ямагт санаж өөрийн компанийн бүтээгдэхүүн бүрийн онцлог, давуу талын мэдлэг, мэргэжлийн дадлага, туршлагыг илэрхийлсэн ажил хэргийн чадвар, найрсаг зан чанар, гадаад төрхийн стандартыг баримталсан, харилцагчдад чин сэтгэлээсээ ханддаг харилцааны болон сэтгэл татах чадваруудыг бүрэн дүүрэн эзэмшсэн байна.

Нийт ажиллагсад хувийн ариун цэврийг сахиж үргэлж цэвэр, цэмцгэр биеэ авч явна.

Хувцаслалт: Компанийн ажилтнууд ажил хэрэгч загвараар хувцаслана. Хувцас нь цэвэр үзэмжтэй, толбо, үрчлээсгүй байхаас гадна товч тасарсан, оёдол ханзарсан эсэхэд анхаарч сайтар индүүдлэгтэй байна. Сайтар тосолсон гутлыг өмсөнө.

Үс засалт: Компанийн ажилтнууд үсээ хэт маяггүйгээр цэвэр, үзэмжтэй засаж янзалсан байх бөгөөд үсийг зөвхөн байгалийн өнгөөр будна. Эмэгтэй үс мөрнөөс урт тохиолдолд үсийг боох, овоолж шуух, хавчаар зүүлт зүүх зэргээр янзална.

### Идэвхжүүлэлт, урамшуулал

Ажиллах хүчний нийгмийн асуудалд маш сайн анхаарна. Нийт ажиллагсдын нийгмийн асуудалд доорх үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Бүх ажилчдыг нийгмийн даатгалд хамруулна.
- Нийтийн болон ажилчдын цайны газар ажиллуулна.
- Ажилчдыг тогтмол хувиараа нэгдсэн журмаар эмнэлгийн үзлэгт хамруулж байна.
- Үйлдвэрийн хүнд нөхцөлд ажилладаг ажилчдад хордлого тайлах болон нэмэлт амин дэмтэй хүнс өгч байна.
- Ажиллагсдыг идэвхжүүлэх бусад арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.
- Гүйцэтгэлийн төвшнөөс хамаарсан улирлын бонус олгоно.

## **ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

- Ажиллагсдыг идэвхжүүлэх бусад арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ. Гүйцэтгэлийн төвшнөөс хамаарсан улирлын бонус олгоно.

### **Хөдөлмөр хамгаалал**

Байгууллагын үйл ажиллагаанд тохируулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын дотооддоо ашиглах тогтолцоог бүрдүүлж ажилчдынхаа эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын асуудлуудыг зохицуулан ажиллана. Манай компани нь:

Ажилчдаа эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах ба үйлдвэрлэлийн орчны хүчин зүйлийн сөрөг нөлөөллийг бууруулж, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнийг багасган үйлдвэрлэлээ явуулна.

Ажилчдаа жилд хоёр удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамааруулна.

Ажилчдаа хамгаалах техник хэрэгсэл болон хөдөлмөр хамгааллын хувцас /халаад, цамц, өмд, усны гутал, хормогч, малгай, бээлий/ хэрэгслээр хангана.

Ажлын хувцсыг угаах нөхцөлийг бүрдүүлэн /тоног хэрэгсэл эсвэл угаалгын гэрээт газарт/ тогтмол угааж, хэрэглэнэ.

Хүснэгт 89. Нэг ажилтны хувцас

Нэг ажилтны хэрэгцээт хувцас хэрэглэл			
1	Халаад	15.000 ₮	"Ажлын гутал импорт"ХХК
2	Цамц	45.000 ₮	"Их газрын чулуу"ХХК
3	Өмд		
4	Усны гутал	30.000 ₮	"Абсолют чойс"ХХК
5	Хормогч	20.000 ₮	"Ажлын гутал импорт"ХХК
6	Малгай	5.000 ₮	
7	Бээлий	5.000 ₮	
	Нийт	120.000 ₮	




Хүснэгт 90. Хөдөлмөр хамгааллын зардал

		Зардлын дүн	
		Сард	Жилд
Орон тоо	26		
Жилийн норм /1 хүнд/	2		
Хувцас, хэрэглэлийн зардал	120.000	1.000.000 ₮	12.000.000 ₮
Угаалгын бодисын зардал		50.000 ₮	600.000 ₮
Эрүүл мэндийн үзлэг	30.000	250.000 ₮	3.000.000 ₮
Нийт		1.300.000 ₮	15.600.000 ₮

## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

### Хуваарилалтын бодлого

Зах зээлийн эрэлт хэрэгцээ, бизнесийн зорилго, зардал зэрэг олон хүчин зүйлсийг харгалзан үзсэний үндсэн дээр компанийн бэлэн бүтээгдэхүүний хуваарилалтын бодлого нь дараах байдлаар хэрэгжих нь үр дүнтэй гэж үзэж байна.



Хүснэгт 91. Баримтлах стратеги

	Нэвтрэлт	Өсөлт	Тогтворжилт	Уналт
Зорилго	Бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд таниулах	Зах зээлд эзлэх хувиа өсгөх буюу зах зээлд гүн нэвтрэн стратеги	Зал зээлд эдлэх хувь хэмжээг аль болох урт хугацаагаар хамгаалах	Брэндийн нэр хүндийг алдахгүй байх
Өрсөлдөгч	Өрсөлдөгчдийн бүтээгдэхүүн зах зээлд хоногшсон тул таслах стратеги баримтлан ажиллана.	Өсөлтийн үед манай бүтээгдэхүүн зах зээлд хоногшсон байх тул булаан эзлэх стратеги баримтлан ажиллана	Хамгаалах стратеги баримтлана	Шинэ бүтээгдэхүүний стратеги
Бүтээгдэхүүн	Бүтээгдэхүүний чанарын тогтвортой өсөлтийн стратеги баримтална.			Брэндийг шинэчлэх стратеги баримтална.
Үнэ	Бүтээгдэхүүний үнэт чанараар баримжаалсан үнийн min стратеги баримтална	Бүтээгдэхүүний үнэт чанараар баримжаалсан үнийн стратеги	Үнийг тах болгож бүтээгдэхүүний үнийг тогтвортой барих стратеги баримтална	Үнэт чанараар баримжаалсан үнийн стратеги

## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Хуваарилалт	Сонгомол хуваарилалтын стратеги баримтална	Эрчимжүүлсэн хуваарилалтын стратеги баримтална	Эрчимжүүлсэн хуваарилалтын стратеги баримтална	Хуваарилалтын сувгийн түлхэх стратеги баримтална
Идэвхжүүлэлт	PR болон зар сурталчилгааг хослуулсан татах стратегийг баримтлан ажиллана	Эрчимжүүлсэн хуваарилалтын сувагтаа тулгуурлан түлхэх стратеги баримтлан ажиллана	Эрчимжүүлсэн хуваарилалтын сувагтаа тулгуурлан түлхэх стратеги баримтлан ажиллана	Уналтын үеийн бусад маркетингийн хольцуудтай уялдуулж идэвхжүүлэлтийн страгийг тодорхойлох

Хүснэгт 92. Нийт хөрөнгө оруулалтын зардлын хураангуй /төгрөгөөр/

№	Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ
1	Барилгын зардал	1	ш	179.295.000
2	Хашааны зардал	1	багц	30.000.000
3	Пластик хог хаягдлыг дахин бутлан боловсруулах үрлэн технологийн үйлдвэр	1	ш	188.100.000
4	HDPE LDPE PE Био задрах бариултай дахин боловсруулсан уут хийх машин	1	ш	112.860.000
5	Ningbo HAICHEN эрчим хүч хэмнэх хуванцар цэцгийн бортого хийх машин	1	ш	103.455.000
6	Ачааны машин	2	ш	40.000.000
	<b>Нийт</b>			<b>613.750.000</b>

## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Хүснэгт 93. Үйл ажиллагааны шууд зардлын хураангуй /төгрөгөөр/

№	Зардлын төрөл	1 сард	Жилийн зардал	Тайлбар
1	Цалингийн зардал	18.600.000	223.200.000	-
2	Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	2.325.000	27.900.000	-
3	Цахилгаан эрчим хүчний хэрэглээний зардал	13.998.626	167.983.506	-
4	Тээвэрлэлтийн зардлын тооцоо	3.450.000	41.400.000	-
5	Бичиг хэргийн зардал	1.260.000	15.120.000	-
8	Хөдөлмөр хамгааллын зардал	1.300.000	15.600.000	-
9	Болзошгүй гарах зардал	250.000	3.000.000	-
10	Тоног төхөөрөмжийн элэгдлийн зардал	5.114.513	61.374.156	-
11	Түүхий эдийн зардал	67.666.670	812.000.040	Түүхий эд материалын үнэ сар бүр хэлбэлздэг тул жилийн хугацааны хэлбэлзэл тооцох аргачлалаар тооцоолов
	<b>Нийт</b>	<b>113.964.809</b>	<b>1.367.577.702</b>	

Хүснэгт 94. Бүтээгдэхүүн борлуулалтын тооцоо /төгрөг/

№	Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /50%/	Нэг бүрийн үнэ	Борлуулалтын орлого
1	Үрсэлгээний бортого	Ширхэг	1.056.000	400	422.400.000
2	Нэг удаагийн гялгар уут	Ширхэг	15.840.000	80	1.267.200.000
	<b>Нийт</b>				<b>1.689.600.000</b>



## ХАВСРАЛТ-2. ХУВАНЦАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Хүснэгт 95. Орлогын үр дүнгийн тооцоо

№	Үзүүлэлт	Сард	Жилд
1	Борлуулалтын орлого	140.800.000	1.689.600.000
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	113.964.809	1.367.577.702
3	Нийт ашиг	26.835.191	322.022.298
4	Үйл ажиллагааны зардал	19.371.848	206.106.105
5	Удирдлагын зардал	4.387.500	52.650.000
6	Борлуулалтын зардал	6.500.000	78.000.000
7	Халаалтын зардал	4.392.678	26.356.065
8	Зээлийн хүүний зардал	4.091.670	49.100.040
9	Татвар төлөхийн өмнөх ашиг	7.463.344	115.916.193
10	Татварын хэмжээ 10%	746.334	11.591.619
11	Цэвэр ашиг	6.717.010	104.324.573

Нийт хөрөнгө оруулалтын зардал барилга болон үйлдвэрийн тоног төхөөрөмж нийт 613 сая төгрөг болж байгаа бөгөөд энэ дээр мөн үйл ажиллагааны зардал 1.3 тэрбум төгрөгийн зардал бас гарна. Харин бүтээгдэхүүн борлуулалтын ашиг тухайн үйлдвэрийн 50%-ийн хүчин чадлаар ажиллуулах тохиолдолд 1.6 орчим тэрбум төгрөгийн борлуулалт хийх боломжтой. Эндээс орлогын үр дүнгээс жилд 104 сая төгрөгийн цэвэр ашиг харж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын зардлыг 6 жилийн хугацаанд нөхөх боломжтой гэж үзэж байна.

## ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

### ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

#### НЭГ. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Төслийн нэр:	Органик хог хаягдлыг бордооны үйлдвэрлэлд ашиглах боломж
Төслийн зорилго:	Органик хог хаягдлыг дахин боловсруулах замаар газар тариалан, цэцэрлэгжүүлэлт, мөн түүнчлэн цаашлаад малын тэжээл гэх мэт өргөн хүрээтэй хэрэглээнд нэвтрүүлж ашиглан хөрсний үржил шимийг хамгаалан сайжруулж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах замаар Дархан-уул аймгийн хүрээлэн буй орчны экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах, ногоон технологийг нэвтрүүлэх
Төсөл хэрэгжүүлэх салбар:	Органик бордоо үйлдвэрлэл
Төслийн зориулалт, хэрэгцээ:	Органик хог хаягдлыг дахин ашиглах төсөл нь Дархан-Уул аймгийн Дархан сумын органик хог хаягдлыг ашиглах боломжийг тогтоосноор Дархан сумын иргэдийн эрүүл, цэвэр, тухтай орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхээс гадна газар тариаланд органик бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж экологийн хувьд ач холбогдолтойгоос гадна тэжээлийн бодисын хангамж өндөртэй, эрүүл хүнсээр хангагдах боломжийг дээшлүүлнэ.
Төслөөс гарах үр дүн:	Орон нутаг нь эрүүл хөрстэй, цэвэр орчинтой болохын зэрэгцээ хог хаягдлыг ашиглан органик бордоо үйлдвэрлэснээр үнэ өртөг өндөр импортын бордооны хэрэглээг бууруулах
Бүтээгдэхүүний нэр, төрөл:	Бууц, сангас, бүх төрлийн ургамлын ногоон масс, бүх төрлийн ургамлын хатсан масс, элдэв хүнсний бүтээгдэхүүний тэр дундаа ногооны хаягдал, өндөгний хальс, жимс, хүнсний ногооны ялзарсан, муудсан хаягдлууд, модны үртэс, иш мөчир, гишүү, яс гэх мэт
Төслийн тоног төхөөрөмжийн төсөвт өртөг	Компост бордооны үйлдвэр 447.505.710 ₮ Яс боловсруулах үйлдвэр 259.185.489 ₮

## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

### **ХОЁР. ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улс жилд 150-200 мянган тонн бордоог газар тариалангийн салбарт хэрэглэдэг хэрэглээтэй улс юм. Эдгээр нийт хэрэглээний 80 гаруй хувийг хөрш орнуудаасаа импортоор худалдан авч газар тариалангийн салбарт бордоо болгон ашигладаг. Энэ нь бид өөрсдийн түүхий эд нөөц боломжоо хангалттай ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.

Монгол Улсад энэ чиглэлд сүүлийн жилүүдэд бордоог үйлдвэрлэх цөөн тооны үйлдвэр ашиглалтанд орж байгаа хэдий ч Монгол Улсын нийт хэрэглээний 20 орчим хувийг л хангаж байна.

Иймд энэ чиглэлийн дотоодоо үйлдвэрлэх үйлдвэр байгуулах нь дотоодын зах зээлд эзлэх хувь хэмжээ багтаамж өндөр байгаа нь судалгаагаар тогтоодсон. Монгол Улс 60 гаруй сая тоо толгой малын Хонь, Ямааны өтөг бууц хөрзөн, Үхрийн аргал хорголыг олон улсын дэвшилтэт технологийн тусламжтайгаар боловсруулан органик компост бордоо болгон зах зээлд борлуулах боломжтой.

Компост бордоо үйлдвэрлэл бол маш хямд төсөр үйлдвэрлэл юм. Манай орон шиг ус чийг дутагдалтай оронд хөрсний ус барих чадварыг сайжруулдаг ганцхан бордоо бол яах аргагүй Компост Бордоо юм. Компостлох гэдэг нь амьтан болон ургамлын гаралтай органик хаягдал хогийг микрооргоанизмууд задалж боловсруулан органик бордоо болгох процессыг хэлнэ. Микрооргоанизмуудын амьдралын үйл ажиллагааны явцад дулаан (+40С - +70С) үүсэх бөгөөд биотермийн дулаан гэнэ. Биотермийн дулааны үйлчлэлээр компост бордоонд байгаа хог ургамлын үр болон бичил биетнүүд үхдэг учир зөв боловсруулсан компост бордоо нь ариутгагдсан байдаг. Хялбархан, ажиллагаа багатай мөртлөө байгаль орчинд асар их эерэг нөлөө үзүүлдэг. Энэ бол бид байгаль дэлхийдээ буцаан өгч чадах **НОГООН БУЯН** гэж ойлгож болно.

Компост нь ургамал ургах эрүүл орчинг бүрдүүлэх бөгөөд ургамлын ялзмаг, чийгийн хорхой, бактери, мөөгөнцөрөөр дүүрэн цоо шинэ экосистем бүхий орчныг бүрдүүлнэ. Цоо шинэ, эрүүл, нялх ургамал ургахад шаардлагатай амин чухал микроэлементүүдийг агуулсан органик бодис юм.

Компостлох аргаар органик бордоо үйлдвэрлэх боломжтой органик хаягдлууд:

- 1) Бүх төрлийн малын баас, шээс
- 2) Бүх төрлийн шувууны сангас
- 3) Модны үртэс
- 4) Өндөгний хальс
- 5) Жимс, хүнсний ногооны ялзарсан, муудсан хаягдлууд
- 6) Хүнсний ногооны талбай ба хүнсний зах дээр хаягддаг навч, иш гм хаягдлууд
- 7) Хоолны давс, сода бүрэлдэхүүнд нь ороогүй бүх төрлийн ургамлын гаралтай хүнс, хоолны хаягдлууд
- 8) Хотын ногоон байгууламжийн хаягдлууд
- 9) Зөөлөн, нимгэн цаасан хаягдлууд

Компостлох боломжгүй органик хаягдлууд:

- a) Махан бүтээгдэхүүний хаягдлууд
- с) Малын улаан яс
- d) Амьтны ба ургамлын гаралтай тосны хаягдлууд
- e) Хоолны давс, сода агуулсан хүнс, хоолны хаягдлууд

## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

Хоолны давстай хүнс, хоолны хаягдлыг компостлох аргаар боловсруулж органик бордоо үйлдвэрлэх үед хоолны давс нь хэвээр хадгалагдан үлдэж газар тариалангийн хөрсөнд хуримтлагдан үлдэж бусад давсыг өөртөө татан хужир “ургаж” эхэлдэг.

Монгол оронд маань хамгийн их хаягдал болдог үнэт түүхий эдүүдийн нэг бол яс юм. Бид Монголдоо ясыг дахин боловсруулан экспортонд гаргах, органик бордоо үйлдвэрлэх, тэжээвэр амьтад болон үслэг ангийн аж ахуйн тэжээл үйлдвэрлэж болно. “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын 6.2, 6.2.1-а дахин боловсруулах боломжтой хог, 6.2.1-г-д хүнсний органик хог хаягдал ангилана гэж тусгасан байдаг.

Дээр дурьдан органик хог хаягдлын нэр төрөл болон эх үүсвэрийн нөөцийн боломжийг харгалзан үзээд Дархан-Уул аймгийн хувьд дахин боловсруулах боломжит эх үүсвэрээр нь компост бордоо болон яс боловсруулах үйлдвэрлэлийг жижиг дунд үйлдвэрлэлийн түвшинд байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

### **ГУРАВ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

#### **Төслийн зорилго, зорилт**

Дархан сумын иргэдийн эрүүл, цэвэр, тухтай орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхээс гадна газар тариаланд органик бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж экологийн хувьд ач холбогдолтойгоос гадна тэжээлийн бодисын хангамж өндөртэй, эрүүл хүнсээр хангагдах боломжийг дээшлүүлэх явдал юм.

Төслийн үр дүнд Дархан-Уул аймгийн органик гаралтай хог хаягдал ашиглан компост бордоо үйлдвэрлэх мөн махны үйлдвэрүүд болон зах худалдааны төв, хоолны газруудаас гарсан ясыг дахин боловсруулан органик бордоо үйлдвэрлэх, тэжээвэр амьтад болон үслэг ангийн аж ахуйн тэжээл үйлдвэрлэх боломжтой.

Энэхүү төсөл хэрэгжсэнээр дараах давуу талууд гарна.

- Дархан сумын нутаг дэвсгэр органик хог хаягдлаар бохирдохгүй байх
- Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах.
- Хямд үнэ өртөг бүхий шим тэжээлийн агууламж өндөр бордооны нийлүүлэлт нэмэгдэх
- Импортын бордоо худалдан авахад зарцуулагдах гадагшаа мөнгөний урсгал буурах.
- Мал бүхий иргэд малаас гарах хаягдал болох бууцаа зарж борлуулан орлогын эх үүсвэх нэмэгдэх

## ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ



Зураг 116. Органик хог хаягдлыг дахин ашиглах менежментийн ерөнхий схем

### Нөөцийн судалгаа

Дархан-Уул аймгийн айл, өрхийн тоо хүн хүн амын цэвэр өсөлт болон механик шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан цаашид нэмэгдэх хандлагатай байгаа тул хаягдал ясны хэмжээ мөн нэмэгдэх төлөвтэй байна.

Дархан-Уул аймгийн газар тариалан, мал аж ахуйгаас гарах зарим органик хог хаягдлын нөөцийг тооцон үзэхэд жилд дунджаар 79.65 мян тн хаягдал гардаг байна. Өсөн нэмэгдэж буй хүн ам, өрхийн хэрэглээ, мал аж ахуй, газар тариалангийн бодлоготой уялдуулан 2030 он хүртэлх зарим органик хог хаягдлын нөөцийг тооцоход дунджаар 109.69 мян тн ба 2020 оны дундаж хэмжээнээс 37.72 %-аар нэмэгдэх хандлагатай байна.

Органик хог хаягдлыг ашиглах боломж нь эдгээрийг ашиглан бордоо гарган авах явдал юм. Компост бордоо болон ясны бордоо үйлдвэрлэхэд механикжсан ажиллагаатай бага оврын үйлдвэр төлөвлөх зайлшгүй шаардлагатай. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтвортой явуулахын тулд түүхий эдийн нөөц хангалттай байх нь чухал үзүүлэлт юм. Манай Дархан-Уул аймгийн хувьд тариалангийн төв бүсэд харьяалагддаг тул төмс, хүнсний ногооны аж ахуй эрхэлдэг 70 аж ахуй нэгж, 301 иргэний 300-500 тонны багтаамжтай 10 гаран зоорь болон жижиг хэмжээний зоорьнууд байдагаас гадна мал төхөөрөх 2 үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр, цех 18, нийтийн хоол үйлдвэрлэлийн 66 аж ахуй нэгж мөн хүнсний ногоо, жимс, жимсгэний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч дэлгүүр болон хувь хүмүүс үйл ажиллагаа явуулж байна.

Хэрэв малын баасны 20%, шувууны сангас, гахайн баасны 80%, ногооны хаягдлын 40%, хаягдал ясны 80%-ийг тус тус цуглуулж чадвал 2021-2030 оны таамагласан дунджаар 24.91 мян тн органик хог хаягдлын нөөцийг цуглуулах боломжтой юм.

Хүснэгт 73. Цуглуулах боломжтой органик хог хаягдлын нөөцийн хэмжээ

Төрөл /мян.тн/	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	Дундаж
Бод малын баас	9.55	10.00	10.48	10.99	11.52	12.08	12.68	13.30	13.96	14.66	11.92
Бог малын баас	7.35	7.56	7.79	8.03	8.27	8.52	8.78	9.05	9.32	9.61	8.43
Шувууны сангас	0.18	0.19	0.19	0.20	0.21	0.21	0.22	0.23	0.23	0.24	0.21
Гахайн баас	0.70	0.72	0.75	0.77	0.79	0.81	0.84	0.86	0.89	0.92	0.81

## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

Ногооны хаягдал	1.57	1.61	1.66	1.71	1.76	1.82	1.87	1.93	1.98	2.04	1.80
Хаягдал яс	1.69	1.71	1.72	1.73	1.74	1.76	1.77	1.78	1.80	1.81	1.75
Нийт	21.04	21.80	22.59	23.42	24.29	25.20	26.15	27.15	28.19	29.28	24.91
Бордоо /40%/	8.41	8.72	9.04	9.37	9.72	10.08	10.46	10.86	11.27	11.71	9.96

Органик бордоо үйлдвэрлэхэд үйлдвэрлэлийн явцад 60% нь ашиглагдан 40% нь л эцсийн бүтээгдэхүүн болдог байна.

Дархан-Уул аймгийн 2021-2030 оны таамагласан цуглуулах боломжтой органик хог хаягдлын нөөцөөр 8.41-11.71 мян тн буюу жилд дунджаар 9.96 мян тн бордоо үйлдвэрлэх боломжтой байна.

### **ДӨРӨВ. БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**


Ерөнхий ойлголт

Түүхий эдийн нөөц, бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг үндэслэн мал бүхий иргэд, фермерүүд, мах бэлтгэлийн үйлдвэрүүд, зах худалдааны төв, айл өрхүүдээс гарах органик гаралтай хог хаягдлыг ашиглан дараах хоёр үйлдвэрийг байгуулах боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- Компост бордооны үйлдвэр
- Ясны гурил хийх үйлдвэр

Органик хог хаягдал дахин ашиглаж компост бордоо үйлдвэрлэх үйлдвэр дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Органик хог хаягдал нийлүүлэгч нэгжүүд
- Бүтээгдэхүүн хуримтлуулах
- Боловсруулалт, арчилгаа
- Эцсийн бүтээгдэхүүн



Зураг 117. Органик хаягдлыг дахин боловсруулж компост бордоо үйлдвэрлэх төлөвлөлт



## ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

### 1. КОМПОСТ БОРДООНЫ ҮЙЛДВЭР

Манай орны малчид тариаланчдын хувьд хамгийн их хаягдалыг дахин боловсруулж, орон нутагтаа төрөл бүрийн хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалангийн аж ахуй, эрчимжсэн мал аж ахуйн фермерийн аж ахуй, мал бордох газар, саалийн үнээний ферм зэргийн түшиглэн өрхийн хэмжээнд ихээхэн орлоготой жижиг дунд үйлдвэр байгуулах боломжыг бүрдүүлнэ.

Компост бордооны үйлдвэрлэл явуулах талбайн хэмжээ: 3 га

Үйлдвэрийн барилгын хэмжээ: 600м<sup>2</sup>

Цахилгаан эрчим хүч бага зарцуулах энэ үйлдвэр нь хүчин чадал сайтай бөгөөд цагт 1-3 тонн органик бордоо үйлдвэрлэнэ.

**Бордооны үйлдвэрлэлд ашиглагдах тоног төхөөрөмжийн танилцуулга:**



Зураг 118. Бордооны түүхий эдийг овоолох, холих дугуйт ковш

Хүснэгт 74. Дугуйт ковшийн хүчин чадал

Үндсэн жин	1500кг	Эргэлтийн радиус	3700мм
Шанагны багтаамж	0.7 м <sup>3</sup>	Дугуйн зай	2100мм
Зүтгэх дээд чадал	48KN	Мөр хоорндын зай	1400мм
Хутгуурын өргөх өндөр	2700мм	Хөдөлгүүрийн модел	4DW91-45(xichai)
Хутгуурын сунгах урт	780мм	Хөдөлгүүрийн чадал	37KW, 2300RPS
Хутгуурын өргөх хугацаа	≤4.5 сек	Дугуй	12-16.5
Бүтэн циклийн хугацаа	≤9 сек	Хүч дамжуулах систем	Статик гидрийн даралт-механик хэлбэрийн
Хурд	8-19 км/цаг	Нийт хэмжээ	5185*1750*2650(мм)

## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**



Зураг 119. Органик бордооны хэвжүүлэгчтэй машин

Хүснэгт 75. Техникийн үзүүлэлт:

Загвар	OF15	OF18.5	OF30
Бордооны хэмжээ (мм)	Φ3-10	Φ3-16	Φ3-20
Чадал (квт)	15	18.5	30
Хүчин чадал (тонн/цаг)	1-1.5	1.5-2.5	2.5-4

### **Тоног төхөөрөмжийн тайлбар**

Ороож шахах аргаар хэвжүүлэгч машин нь ямар нэгэн тусгай хэв үл шаардах бөгөөд заавал тасалгааны температурт хатаах шаардлагагүй. Эрчим хүч хэмнэхээс гадна хаягдал бага гаргана. Ажиллуулахад амархан бөгөөд засвар үйлчилгээ хийхэд хялбар.

Бордоо, эмийн үйлдвэр, химийн үйлдвэр, малын тэжээлийн үйлдвэр, барилгын материалын үйлдвэрт жижиг мөхлөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд өргөн хэрэглэнэ.

Төрөл бүрийн түүхий эдийг тогтоосон орц норм, жорын дагуу хэлбэржүүлэн гаргана. Ялангуяа органик бордоо, био бордоо, соронзонт бордоо гэх мэт олон төрлийн бордоо хийх ба ховор хөрс, техникийн сод, бикарбонатын серийн аммони зэрэг химийн бүтээгдэхүүнийг хэвжүүлнэ.



Зураг 120. Органик бордооны дискэн машин

Хүснэгт 76. Техникийн үзүүлэлт

Загвар	Дискийн диаметр	Хашлагын өндөр	Багтаамж	Эргэлтийн хурд	Чадал	Хүчин чадал
DG-1.0	1000мм	300мм		13.6 эрг/мин	3квт	0.1-0.2тн/цаг
DG-1.5	1500мм	350мм		13.6 эрг/мин	3квт	0.2-0.3тн/цаг

## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

DG-1.8	1800мм	380мм		13.6 эрг/мин	3квт	0.3-05тн/цаг
DG-2.0	2000мм	450мм		13.6 эрг/мин	4квт	0.5-1тн/цаг
DG-2.5	2500мм	500мм	2.5м <sup>3</sup>	13.6 эрг/мин	7.5квт	1-1.5тн/цаг
DG-2.8	2800мм	600мм	3.7м <sup>3</sup>	13.6 эрг/мин	11квт	1-2.5тн/цаг
DG-3.0	3000мм	600мм	4.2м <sup>3</sup>	13.6 эрг/мин	11квт	2-3тн/цаг
DG-3.2	3200мм	600мм	4.8м <sup>3</sup>	13.6 эрг/мин	11квт	2-3.5тн/цаг

### **Тоног төхөөрөмжийн тайлбар**

Дискэн машин нь ташуу байрлалтай тогоо хэлбэртэй бөгөөд бордоо хийх бүтээмж 93 хувьтай. Гурван цорго бүхий тогоотой, үйлдвэрлэлийн процесс найдвартай, хөдөлмөр хүч ихээхэн хэмнэсэн. Хөдөлгүүртэй холбогдсон редуктор машины үйл ажиллагааг тогтвортой явуулж, зөөлөн эхлүүлэх, аажим зогсоох зэрэг эргэлтийн хурдыг тохируулж өгнө. Энэ нь машиныг урт удаан жилийн хугацаанд эвдрэл гэмтэлгүй ажиллах техникийн нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.



Зураг 121. Холигч болон туузан дамжуулагч

Түүхий эдийг холигч машинд өөрсдийн бэлтгэсэн жорын дагуу хийж, сайтар хутгаж боловсруулна. Үүний дараа туузан дамжуулагчаар үндсэн бордоо хэвлэгч машинд оруулна.



Зураг 122. Туузан дамжуулагчын хувилбарууд

## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

Дээд талд нь зөөврийн туузан дамжуулагч, доод талд нь суурин туузан дамжуулагч. Захиалагч өөрийн сонголтоор аль нэгэн хувилбарыг сонгоно. Стандарт хэмжээ: 7500 х 500 х 50мм.

Эцсийн бүтээгдэхүүн: том жижиг хэмжээтэй цилиндр болон бөөрөнхий хэлбэрийн органик бордоо, био бордоо, холимог бордоо үйлдвэрлэнэ. Эцсийн бүтээгдэхүүний хэмжээ хэвнээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд жижигхэн хийхэд цагт үйлдвэрлэх тоо хэмжээ буурна.

Хүснэгт 77. Хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн судалгаа /Монгол банкны 2021.06.21 ханшаар/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ, ширхэг	Нэгжийн үнэ, төгрөг	Нийт үнэ, төгрөг
1	Үйлдвэрийн барилга /20*30 сэндвич/	600м2	500.000	300.000.000
2	Холигч ковш	1	22.657.500	22.657.500
3	Туузан зөөгүүр	1	1.400.000	1.400.000
4	Хэвлүүлэгчтэй машин	1	18.003.630	18.003.630
5	Дискэн машин	1	21.686.580	21.686.580
6	Доргиурт шигшүүр	1	7.358.000	7.358.000
7	Ачигч	1	8.900.000	8.900.000
8	Тээвэрлэх машин	1	4.500.000	4.500.000
9	Бутлагч машин	1	50.000.000	50.000.000
10	Тоног төхөөрөмжийн угсралтын зардал	1	13.000.000	13.000.000
Нийт /төг/				447.505.710

Хүснэгт 78. Үйлдвэрийн ажиллах горим

№	Үйлдвэрийн нэр	Хоногт ажиллах цаг	Сард ажиллах хоног	Жилд ажиллах хоног
1	Компост бордоо	8	22	264

Хүснэгт 79. Цехийн хүчин чадлын хуваарилалт

№	Үйлдвэрийн нэр	Цагийн хүчин чадал, тн	Хоногийн хүчин чадал, тн	Сарын хүчин чадал, тн	Жилийн хүчин чадал, тн
1	Компост бордоо	1.5-5	12-40	264-880	3168-10560

Компост бордооны 10 тонн хүртэл компост бордоо бэлтгэх хүчин чадалтай байхаар төлөвлөв.

## ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Хүснэгт 80. Цалин хөлсний фонд

№	Зардлын төрөл	1 сарын дундаж цалин	Ажиллах хүчний тоо	Нийт цалин	Жилийн нийт цалин
1	Цалин	1125000	8	9.000.000	108.000.000
2	НДШ /12.5%/	140625		1.125.000	13.500.000
<b>НИЙТ</b>					<b>12.1500.000</b>

Хүснэгт 81. Цахилгааны зардлын тооцоо

	Хэрэглээ /к.Вт/		Нэгж үнэ /төг/	Нийт зардал /жилээр/
	1 цагт	Сард		
Хэвжүүлэгч OF30	30.00	5.280.00	141.35	8.955.936
Дискэн машин DG-3.0	11	1.936.00	141.35	3.283.843
Холигч. туузан дамжуурга	15	2.640.00	141.35	4.477.968
Бусад хэрэглээ		850	141.35	1.441.770
<b>НИЙТ</b>				<b>8.159.517</b>

Хүснэгт 82. Үйлдвэрлэлийн шууд зардлын тооцоо

№	Зардлын нэр	1 сард зардал	Жилийн зардал	Тайлбар
1	Цалингийн зардал	9.000.000	108.000.000	6 ажилтны цалин
2	Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	1.125.000	13.500.000	-
3	Цахилгаан эрчим хүчний хэрэглээний зардал	1.513.293	18.159.517.20	-
4	Тээвэрлэлтийн зардлын тооцоо	403.200	4.838.400	-
5	Хөдөлмөр хамгааллын зардал	900.000	10.800.000	-
6	Сав. баглаа боодол	13.333.333	160.000.000	
7	Тоног төхөөрөмжийн элэгдлийн зардал	3.729.214	44.750.571	-
8	Бусад зардал	5.000.000	45.000.000	-
9	Түүхий эдийн зардал	204.167	2.450.000	Нийт түүхий эдийн 10% -ийг худалдан авахаар тооцов.
<b>НИЙТ</b>		<b>35.208.207</b>	<b>407.498.488</b>	

## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

Хүснэгт 83. Борлуулалтын орлогын тооцоо

№	Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /70%/	Сав /20кг/	Нэг бүрийн үнэ	Борлуулалтын орлого
1	Органик бордоо	тн	2.450	122.500	10.000	1.225.000.000
	<b>НИЙТ</b>					1.225.000.000

Үйлдвэрийн үндсэн хүчин чадлын 70 хувийг ашиглахаар тооцлоо.

Хүснэгт 84. Үйлдвэрлэлийн үр ашгийн тооцоо

№	Үзүүлэлт	Сард	Жилд
1	Борлуулалтын орлого	102.083.333	1.225.000.000
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	35.208.207	407.498.488
3	Нийт ашиг	66.875.126	817.501.512
4	Үйл ажиллагааны зардал	34.108.371	399.700.457
5	Удирдлагын зардал	2.925.000	35.100.000
6	Борлуулалтын зардал	25.000.000	300.000.000
7	Халаалтын зардал	3.200.000	28.800.000
8	Зээлийн хүүний зардал	2.983.371	35.800.457
9	Татвар төлөхийн өмнөх ашиг	32.766.755	417.801.055
10	Татварын хэмжээ 10%	3.276.675	41.780.106
11	Цэвэр ашиг	29.490.079	376.020.950

Дээрх тооцоогоор нийт хөрөнгө оруулалтын өгөөж 84% бөгөөд анхны хөрөнгө оруулалтыг 1.2 жилийн хугацаанд нөхөх боломжтой байна. Үр ашгийн тооцоонд хөрөнгө оруулалтын зээлийн хүүг оруулан үндсэн зээлийн эргэн төлөлтийг оруулаагүй болно.



## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

### **2. ЯС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР**

Монгол улсад яс цуглуулах, ясаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх зах зээл нь төдийлөн хөгжөөгүй салбар бөгөөд маш бага хэмжээний, нийт хаягдал ясны 10-15 хувь орчмыг дахин боловсруулж, түүгээр кальцын бүтээгдэхүүн үйлдвэрлэж, илүүдэл буюу эмийн найрлагад ордоггүй хэсгийг экспортолдог байна. Мал амьтны ясаар олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой бөгөөд түүхий эдийн нөөц нь харьцангуй тогтвортой байдаг. Гол асуудал нь нийт хаягдал ясны дийлэнх хувийг эзэлдэг өрхийн хэрэглээнээс гарч буй ясны цуглуулалтыг хэрхэн хийх асуудал манай улсын хувьд шийдэхэд төвөгтэй асуудал юм. Энэ нь иргэдийн хог ангилан хаях сэтгэхүй, нөхцөл боломж бүрдээгүй, хоёрдогч түүхий эдийн бүтээгдэхүүний ложистик, нэгжийн зардал өндөр байх зэрэгтэй холбоотой байх нь дамжиггүй. Иймд одоо үйл ажиллагаа явуулж буй хаягдал яс дахин боловсруулах чиглэлийн үйлдвэрүүд түүхий эдээ зөвхөн Хүчит шонхор, Хархорин зах болон зарим боловсруулах үйлдвэрүүдээс гэрээ байгуулан авч байна.

Малын гаралтай түүхий эд, тэр дундаа хаягдал ясыг дотооддоо бүрэн ашиглан боловсруулж тэжээлийн уураг болон малын гаралтай тос гарган савангийн үйлдвэрүүдэд түүхий эдий нийлүүлэх боломжтой.

Монголчууд бид хог хаягдал болох яснаасаа салж, буянт малынхаа үр шимийг үйлдвэрлэн шувуу, гахай, эргээд малаа тэжээх бүтээгдэхүүн гаргаж, мөн хөрсөнд фосфорын гуриалан бордоо болгон хэрэглэмнээр хөрсний үржил таримлын чанарт сайнаар нөлөөлж улмаар хүн ам экологийн эрүүл хүнс хэрэглэх боломжийг нэмэгдүүлнэ. Тэжээлийн уураг буюу витаминьг хэрэглэсэн амьтны ашиг шим нэмэгдэж гарц сайжирдаг бол таримал ургамлын ургалтын эхний хугацаанд фосфороор сайн хангагдсан таримал нь ган болон өвчин тэсвэрлэх чадвар сайтай байдаг байна.

Яс боловсруулах үйлдвэрлэл явуулах талбайн хэмжээ: 1 га

Үйлдвэрийн барилгын хэмжээ: 400м<sup>2</sup>

**Яс боловсруулах үйлдвэрт ашиглагдах тоног төхөөрөмжийн танилцуулга:**



Зураг 123. Яс хөрөөдөх машин

## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

Хүснэгт 85. Техник үзүүлэлт

Чадал:	1500 ватт
Хүчдэл:	220V
Жин:	55 кг
Хурд:	18 м/сек
Хөрөөдөх зузаан:	0-20см
Хэмжээ: 6	1*61*110см
Баталгаа:	13 сар



Зураг 124. Уурын даралттай битүү чанагч цахилгаан тогоо

Энэхүү тогоо нь халаалтын температурын автоматаар болон механик тохиргоотой бөгөөд хэрэглэхэд хялбар. Тос болон усанд хүнсний бүтээгдэхүүнийг чанаж боловсруулах зориулалттай бөгөөд хэрэглэж дууссаны дараа тогоог тонгойлгож доторхи шөл болон тосыг авч болно. Сайн чанарын зэвэрдэггүй гангаар үйлдвэрлэсэн тул арчиж цэвэрлэхэд хялбар, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан.

Нийтийн хоолны газар болон хагас бэлэн боловсруулсан хүнсний үйлдвэр өргөн хэрэглэнэ.

Автомат температур тохируулагчтай энэ тогоонд малын яс, толгой зэрэг удаан хугацаагаар ялз болгох шаардлага бүхий хүнсний бүтээгдэхүүнийг өндөр даралтаар чанана. Тогоон доторхи уурын даралт 0.35 МРа хэмжээнд хүрмэгц тогооны автомат систем цахилгаан хэрэглээг таслан зогсооно. Тогооны доторхи уурын даралтыг хянах боломжтой бөгөөд хэрэв даралтын хэмжээ эрс нэмэгдвэл халаагчыг автоматаар салгана.

## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

Хүснэгт 86. Техник үзүүлэлт

Модель	CMDJ-100	CMDJ-200	CMDJ-300	CMDJ-400	CMDJ-500	CMDJ-600
Багтаамж	100 литр	200 литр	300 литр	400 литр	500 литр	600 литр
Тогооны амсарын диаметр	700 мм	800 мм	900 мм	1000 мм	1100 мм	1200 мм
Чадал	12 кВт	18 кВт	24 кВт	30 кВт	36 кВт	42 кВт
Материал	SUS304/Q2358 маркийн сайн чанарын зэвэрдэггүй ган төмөр					
Халах температур	1450С хэм					
Стандарт даралтын хэмжээ	0,44 МПа Үйлдвэр дээр хийсэн туршилтаас хийсэн дүгнэлтээр хамгийн дээд тал нь ийм үзүүлэлтийг дааж байсан.					
Ажлын даралтын хэмжээ	0,35 МПа Үйлдвэрлэлийн хэрэглээнд энэ үзүүлэлттэй байхад аюулгүй гэсэн дүгнэлтэнд хүрсэн.					

Энэ тогоо энгийн тогоотой харьцуулбал цахилгаан хэмнэх тал дээр гайхамшигтай. Ясыг 24 цаг буцалгасаны дараа жинхэнэ кальциар баялаг шөл болдог. Тийм шөл гаргахын тулд маш их эрчим хүч шаардагдах нь мэдээж. Тэгвэл энэ тогоо гадуураа давхар дулаалгатай тул доторхи халуунаа гадагшаа алдах нь бага байдаг. Нэгэнт буцалсан бол цахилгаан тэжээлийг таслан 3-4 цаг халуун ууранд нь ясаа болгоно. Тогооны дулаан алдагдал бага тул яс удаан хугацаагаар халуун ууранд задарч, кальци болон бусад тэжээлийн элементүүд шөлөнд шингэнэ.



**Яс бутлагч машин**

Зураг 125. Яс бутлах машин

## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

Хүснэгт 87. Техник үзүүлэлт

Загвар	BC600
Цахилгаан хүчдэл	380V
Цахилгаан хэрэглээ(квт/цаг)	15
Бутлагч хайрцгийн хэмжээ(мм)	340×600
Ир (ширхэг)	18
Хутга (ширхэг)	2
Хүчин чадал (кг/цаг)	600~800
Торны нүхний диаметр (мм)	10
Машины хэмжээ (см)	145×125×172
Машины жин (кг)	950

Яс бутлагч машиныг улаан буудай, эмийн ургамал, химийн бодис, уурхайн баяжмал, полистирол, полипрофолин, нилон, хаягдал хуванцар, PVC материал гэх зэрэг хэт хатуу биш төрөл бүрийн бүтээгдэхүүнийг бутлах зориулалтаар ашиглаж болно. Өөрөөр хэлбэр универсаль бутлагч машин гэж ойлгож болно.



Зураг 126. Туузан зөөгүүр



Зураг 127. Яс гурил тээрэмдэгч

## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

Хүснэгт 88. Техник үзүүлэлт

Марк	3000S
Зориулалт	Үйлдвэрлэл
Цахилгаан хэрэглээ	220V/380V, 50Hz
Хөдөлгүүрийн чадал	3 квт
Эргэлтийн хурд	1400 эрг/мин
Хүчин чадал	70 кг/цаг
Хэмжээ	620*320*460мм
Жин	65 кг

Хүснэгт 89. Үйлдвэрт шаардлагатай тоног төхөөрөмжүүд /Монгол банкны 2021.06.21 ханшаар/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ, ширхэг	Нэгжийн үнэ, төгрөг	Нийт үнэ, төгрөг
1	Үйлдвэрийн барилга /20м*20м Сэндвич/	400м2	500.000	15.000.0000
2	Холигч ковш	1	22.657.500	2.2657.500
3	Уурын даралттай битүү чанагч цахилгаан тогоо	1	12.400.970	1.2400.970
4	Яс бутлах машин	1	5.262.894	5.262.894
5	Яс гурил тээрэмдэгч	1	2.764.125	2.764.125
6	Туузан зөөгүүр	2	1.800.000	3.600.000
7	Тээвэрлэх машин	1	4.500.000	4.500.000
8	Тоног төхөөрөмжийн угсралтын зардал	1	8.000.000	8.000.000
<b>Нийт</b>				<b>25.9185.489</b>

Хүснэгт 90. Үйлдвэрийн ажиллах горим

№	Үйлдвэрийн нэр	Хоногт ажиллах цаг	Сард ажиллах хоног	Жилд ажиллах хоног
1	Яс боловсруулах үйлдвэр	8	22	264

## ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Хүснэгт 91. Үйлдвэрийн хүчин чадлын хуваарилалт

№	Үйлдвэрийн нэр	Цагийн хүчин чадал, кг	Хоногийн хүчин чадал, тн	Сарын хүчин чадал, тн	Жилийн хүчин чадал, тн
1	Яс боловсруулах	70	0.56	12.32	147.84

Хүснэгт 92. Цалин хөлс

№	Зардлын төрөл	1 сарын дундаж цалин	Ажиллах хүчний тоо	Нийт цалин	Жилийн нийт цалин
1	Цалин	1.125.000	8	9.000.000	108.000.000
2	НДШ /12.5%/	140.625		1.125.000	13.500.000
<b>НИЙТ</b>					<b>121.500.000</b>

Хүснэгт 93. Цахилгааны зардлын тооцоо

	Хэрэглээ /квт/		Нэгж үнэ /төг/	Нийт зардал /жилээр/
	1 цагт	Сард		
Яс хөрөөдөгч машин	5	880.00	141.35	1.492.656
Битүү чанагч	12	2.112	141.35	3.582.374
Яс бутлагч	15	2.640	141.35	4.477.968
Туузан зөөгүүр	11	1.936.00	141.35	3.283.843
Яс гурил тээрэмдэгч	3	528	141.35	895.594
Бусад хэрэглээ		850	141.35	1.441.770
<b>НИЙТ</b>				<b>15.174.205</b>

Хүснэгт 94. Үйлдвэрлэлийн шууд зардлын тооцоо

№	Зардлын нэр	1 сард зардал	Жилийн зардал	Тайлбар
1	Цалингийн зардал	9.000.000	108.000.000	6 ажилтны цалин
2	Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	1.125.000	13.500.000	-
3	Цахилгаан эрчим хүчний хэрэглээний зардал	1.264.517	15.174.205	-
4	Тээвэрлэлтийн зардлын тооцоо	115.920	1.391.040	-
5	Хөдөлмөр хамгааллын зардал	720.000	2.880.000	-



## **ХАВСРАЛТ-3. ОРГАНИК ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

6	Сав, баглаа боодол	65.707	591.360	
7	Тоног төхөөрөмжийн элэгдлийн зардал	2.159.879	25.918.549	-
8	Бусад зардал	2.000.000	18.000.000	-
9	Түүхий эдийн зардал	18.480	221.760	Нийт түүхий эдийн 10% -ийг худалдан авахаар тооцов.
	<b>НИЙТ</b>	16.469.503	185.676.914	

Хүснэгт 95. Борлуулалтын орлогын тооцоо

№	Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Сав /25кг/	Нэг бүрийн үнэ	Борлуулалтын орлого
1	Ясны гэжээл	тн	147.84	5.914	60.000	354.816.000
	<b>НИЙТ</b>					354.816.000

Хүснэгт 96. Үр ашгийн тооцоо /төг/

№	Үзүүлэлт	Сард	Жилд
1	Борлуулалтын орлого	39.424.000	354.816.000
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	16.469.503	185.676.914
3	Нийт ашиг	22.954.497	169.139.086
4	Үйл ажиллагааны зардал	11.772.964	107.075.565
5	Удирдлагын зардал	2.925.000	35.100.000
6	Борлуулалтын зардал	5.000.000	45.000.000
7	Халаалтын зардал	3.200.000	19.200.000
8	Зээлийн хүүний зардал	647.964	7.775.565
9	Татвар төлөхийн өмнөх ашиг	11.181.533	62.063.521
10	Татварын хэмжээ 10%	1.118.153	6.206.352
11	Цэвэр ашиг	10.063.380	55.857.169

Дээрх тооцоогоор нийт хөрөнгө оруулалтын өгөөж 22% бөгөөд анхны хөрөнгө оруулалтыг 4.6 жилийн хугацаанд нөхөх боломжтой байна. Үр ашгийн тооцоонд хөрөнгө оруулалтын зээлийн хүүг оруулан үндсэн зээлийн эргэн төлөлтийг оруулаагүй болно.

## **ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

### **ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

#### **Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах**

Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 48 дугаартай тушаалаар Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журмыг баталсан байдаг. Тус журмаар барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, явган хүний зам талбай, ногоон байгууламж шинээр барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах, буулгахад үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэлээс гарах хог хаягдлыг цуглуулах, ангилах, цэвэрлэх, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг зохицуулахаар журамласан.

Уг журамд барилгын хог хаягдлуудын жагсаалтыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Дахин боловсруулах боломжтой барилгын хог хаягдалд:

- цаас /ханын цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, хаягдал цаас/;
- хуванцар /төрөл бүрийн гялгар уут, баглаа боодол, бүх төрлийн шингэн материалын сав, сантехникийн шугам хоолой, цахилгааны тоноглол, кабел, хаалга, цонхны хүрээ/;
- хөнгөн цагаан, төмөр, металл, зэс, гууль, тэдгээрээр хийсэн бүх төрлийн бүтээгдэхүүн;
- шил /бүх төрлийн шилэн сав, хийц, эдлэл, шилэн бүтээгдэхүүн/;
- мод, модон эдлэлийн хаягдал;
- төрөл бүрийн шуудай, даавуун материалын хаягдал;
- дуу дулаан тусгаарлах материалууд, хөөсөнцрийн хаягдал;
- резин, уур, ус, чийгээс хамгаалах бүх төрлийн хуйлмал материалууд;
- өвс, ургаа мод, байгалийн чулуу;
- бүх төрлийн бетон, төмөр бетон эдлэл;
- тоосго, чулуу, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал;
- авто замын асфальт бетон, битумын холимог, замын хайрга, шороо;
- хаягдал арматур, бүх төрлийн төмөр эдлэл;
- бүх төрлийн цахилгаан, холбооны кабелин утас;
- бүх төрлийн сав, баглаа, боодол;
- барилгын суурь ба талбайн тэгшилгээ, цэвэрлэгээнээс гарсан хөрс шороо.

Дахин ашиглах боломжтой барилгын хог хаягдалд:

- суурийн блок;
- бүх төрлийн ялуу;
- хучилтын хавтан, татанга, төмөр бетон дам нуруу;
- тоосго, ханын блок, угсармал барилгын ханын хавтгайлж;
- модон эдлэл, эдлэхүүн;
- бүх төрлийн сав, баглаа, боодол;
- барилгын суурь ба талбайн тэгшилгээ, цэвэрлэгээнээс гарсан хөрс шороо.

Устгах, булшлах барилгын хог хаягдалд:

- Барилгаас гарсан дахин ашиглах, дахин боловсруулах боломжгүй хаягдал, асбест болон хортой бодис агуулсан, хортой бодисоор бохирдсон, мөнгөн ус агуулсан хаягдлууд;
- Бохирдсон буюу хортой бодис агуулсан хөрс, шороо, чулуу, нунтаг шороо, бетон, тоосго, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал, мод, шил, хуванцар.

## **ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

“Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын 2.2.1.3-т үнс үүсэх эх үүсвэрийг дараах байдлаар ангилан тусгасан байдаг. Үүнд:

- Өрх
- Халаалтын болон нам даралтын зуух
- Цахилгаан болон дулааны станцын зуух

Дээр дурдан барилгын хог хаягдлын нэр төрөл болон эх үүсвэрийн нөөцийн боломжийг харгалзан үзээд Дархан-Уул аймгийн хувьд дахин боловсруулах боломжит эх үүсвэрээр ҮНС болон БАРИЛГЫН БУУЛГАЛТААС ҮҮСЭХ БЕТОНЫ хаягдлыг сонгох нь зүйтэй гэж үзэж байна. Уг 2 төрлийн барилгын хог хаягдлыг сонгох болсон үндэслэлийг дараах байдлаар тоймлож болно. Үүнд:

Барилгын хог хаягдлын 80%-иас илүү хэсгийг Дархан-Уул аймгийн Дулааны цахилгаан станцын хаягдал үнс эзэлдэг тул нөөц хангалттай бөгөөд тасралтгүй гарсаар байх болно.

Үнс нь цемент, хуурай хольц, бага маркийн бетон гэх мэт барилгын үндсэн материалуудад нэмэлт түүхий эд болгон хэрэглэгдэх боломжтой.

Барилгын буулгалтаас үүсэх хог хаягдлыг механик боловсруулалтад оруулж жижиглэх замаар дайрга болон элс бэлтгэх боломжтой бөгөөд уг дүүргэгчийг хуурай хольц, бага маркийн бетонд хэрэглэх бүрэн боломжтой.

Үнсэн нэмэлттэй цемент болон барилгын хаягдлаас гарган авсан дүүргэгчийг ашиглан бетон эдлэл (замын тоосго, явган хүний замын хавтан, хашаа болон хашлага хийх блок гэх мэт) хийх боломжтой.

Манай аймгийн ДЦС-ын хаягдал үнс нь үйлдвэрлэлийн түүхий эдээр ашиглах хэмжээнд хүртэл хуримтлагдсан. Жилд 58000-65000 тн хаягдал үнс гаргадаг гэсэн тоо баримт байдаг. Энэ их хаягдал үнсийг барилгын материалд ашиглах боломжтойг гадаадын олон эрдэмтэд төдийгүй манай орны эрдэмтэн судлаачид ч тогтоосон байдаг. Айл өрхүүдээс гарч байгаа нүүрсний үнсний хувьд шатаалтын температур багатай учраас дутуу шаталт ихтэй, бохирдолттой байдаг тул механик болон химийн идэвхжүүлэлт хийж зарим нэг барилгын материалд идэвхгүй дүүргэгчээр ашиглах боломжтой. Барилгын материалын үйлдвэрлэлээс гарч байгаа хаягдал тухайлбал шохойн үйлдвэрлэлийн хаягдлыг дахин ашиглан хуурай хольцын үйлдвэрлэлд (замаск), барилга байгууламжийн нураалтаас үүсэх хаягдал, дайрганы бутлалтаас үүссэн хаягдлыг механик дайрга, элс болгон ашиглах бүрэн боломжтой.

### **Төслийн зорилго, зорилт**

Энэхүү төслийн зорилго нь барилгын хог хаягдлыг дахин ашиглаж Дархан-Уул аймгийн хөгжил, бүтээн байгуулалтад түлхэц үзүүлэх барилгын материал үйлдвэрлэх явдал юм.

Төслийн үр дүнд Дархан-Уул аймгийн Дулааны цахилгаан станцын хаягдал үнс, барилгын хаягдлаас гарган авсан дүүргэгч материал дээр цементийг нэмж хуурай хольц, бага маркийн бетон эдлэл (замын тоосго, явган хүний замын хавтан, хашаа болон хашлага хийх блок гэх мэт) үйлдвэрлэх боломжтой.

Энэхүү төсөл хэрэгжсэнээр дараах давуу талууд гарна.

Дархан сумын нутаг дэвсгэр барилгын хог хаягдлаар бохирдохгүй байх


Олон жил хуримтлагдсан үнсэн сангийн үнсийг бодитоор, тасралтгүй ашиглах боломж бүрдэнэ.

## **ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

Хаягдал үнс болон барилгын буулгалтаас гарах хатуу хог хаягдал (бетон, тоосго, хавтанцар гэх мэт)-ыг ашиглан бага маркийн бетон эдлэл хийх хотын тохижилт, өнгө үзэмжийг сайжруулахад ашиглах

Хаягдлыг дахин ашиглах, эко технологитой, дээр дурдсан 3-4 бүтээгдэхүүнийг технологийн нэг шугамаар үйлдвэрлэх боломжтой болно.

### **Барилгын хог хаягдлыг дахин ашиглах менежментийн ерөнхий схем**



### **Нөөцийн судалгаа**

Хаягдал үнс, барилгын хатуу хог хаягдлыг ашиглах боломж нь эдгээрийг ашиглан барилгын материал гарган авах явдал юм. Үүний тулд механикжсан ажиллагаатай бага оврын үйлдвэр төлөвлөх зайлшгүй шаардлагатай. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтвортой явуулахын тулд түүхий эдийн нөөц хангалттай байх нь чухал үзүүлэлт юм. Манай Дархан-Уул аймгийн хувьд ДЦС-ын үнсэн сангийн үнсний нөөц болон жил тутам шинээр хаягдаж байгаа үнсний хэмжээ 58000-65000 тн байгаа нь хангалттай нөөцтэй байгааг харуулж байна.

Мөн ойрын 5 жилийн хугацаанд Дархан суманд дахин төлөвлөлтөд орохоор төлөвлөгдсөн барилга байгаа ба мөн хувь хүмүүс болон албан байгууллагын барилгын завсар үйлчилгээний явцад 2020 оны байдлаар 245,05 тн орчим барилгын хатуу хог хаягдал гарсан байна.

## **ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

Дархан орчмын шохойн үйлдвэрүүдээс жилд дунджаар 22 200тн хаягдал гардаг байна. Мөн хайрга, дайрга, элсний карьеруудаас жилд дунджаар 300 000м<sup>3</sup> хаягдал гардаг байна.

Хүснэгт 97. ДДЦС ТӨХК-ийн үнсэн сангийн мэдээлэл

№	Хог хаягдлын нэр	Байршил	Талбай	Хэмжээ /жилийн дундаж/	Бохирдол
1	Хаягдал үнс	Дархан-Уул аймаг 15-р баг үйлдвэрийн районд	64.52 га	58000-65000 тн	Химийн болон ахуйн бохирдол байхгүй

Хүснэгт 98. 2020 онд Дархан сумын нутаг дэвсгэрээс гарсан хог хаягдлын хэмжээ

Сар	Тохижилт		Барилгын хог	
	Нийт рейс	Хогийн хэмжээ /тн/	Нийт рейс	Хогийн хэмжээ /тн/
1-р сар	1	1,500	3	15,050
2-р сар	-	-	2	9,100
3-р сар	28	119,400	2	8,700
4-р сар	24	85,600	6	28,800
5-р сар	8	35,200	11	32,900
6-р сар	37	200,000	15	45,000
7-р сар	36	145,250	-	-
8-р сар	65	351,100	-	-
9-р сар	33	114,100	-	-
10-р сар	22	112,550	-	-
11-р сар	15	46,300	12	52,550
12-р сар	-	-	13	52,950
Нийт	269	1,211,000	64	245,050

### **БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

#### **Ерөнхий ойлголт**

Түүхий эдийн нөөц, бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг үндэслэн ДЦС-ын хаягдал үнс, айл өрхөөс хаягдсан түлшний үнс шаарга, барилгын буулгалтын хатуу хог хаягдал, шохойн үйлдвэрийн хаягдал, дайрга, хайрга, элсний карьерын хаягдлыг ашиглан дараах хоёр үйлдвэрийг байгуулах боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- Хуурай хольцын үйлдвэр
- Бага маркийн бетон эдлэлийн үйлдвэр


Энэхүү 2 үйлдвэрийг цогц байдлаар төлөвлөх боломжтой бөгөөд ингэснээр түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглах, нэг шугамаар гарч ирсэн материалаа нөгөө шугамд түүхий эдээр ашиглах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх өөрийн өртгийг буурах, байр, талбай, тоног төхөөрөмж ашиглалт сайжрах зэрэг давуу талтай болно.

## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Бусад барилгын хог хаягдлыг эх үүсвэрээс цуглуулан нөөцлөөд Улаанбаатар хот, Дархан суманд байрлах хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэх боломжтой гэж үзэж байна.

Барилгын хог хаягдал дахин ашиглаж барилгын материал үйлдвэрлэх үйлдвэр дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:


- Үнс бэлтгэх цех
- Механик дайрга, элс бэлтгэх цех
- Бетон эдлэл үйлдвэрлэх цех
- Хуурай хольц үйлдвэрлэх цех



Зураг 128. Барилгын хог хаягдал дахин ашиглаж барилгын материал үйлдвэрлэх схем



## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ




Зураг 129. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн цогцолборын ерөнхий төлөвлөлт

## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

### ҮНС БЭЛТГЭХ ЦЕХИЙН ТАНИЛЦУУЛГА

ДЦС-ийн хаягдал үнс нь үнсэн санд хуримтлагдах ба түүний чийглэгийн хэмжээ харилцан адилгүй байдаг. Чийгтэй үнсийг (ойролцоогоор 20-35%) хүрдэн хатаагуурын тусламжтайгаар хатааж үйлдвэрлэлд хэрэглэх боломжтой болгох хэрэгтэй. Үнсийг 10%-иас ихгүй чийглэгтэй болтол хатаах шаардлагатай.




Зураг 130. Үнс хатаах хүрдэн хатаагуурын схем

Эх сурвалж: <https://www.keramzit-aleksin.ru/investoram/>

Хүснэгт 99. Хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн судалгаа

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ, ширхэг	Нэгжийн үнэ, төгрөг	Нийт үнэ, төгрөг
1	Тэжээгүүр	2	1680000	3360000
2	Туузан зөөгүүр	3	1400000	4200000
3	Шурган зөөгүүр	2	1500000	3000000
4	Соронзон сеператор	1	616000	616000
5	Доргиурт шигшүүр	1	7358000	7358000
6	Ачигч	1	8900000	8900000
7	Тээвэрлэх машин	1	4500000	4500000
8	Хатаах хүрд/	1	1890000	1890000
9	Горелка	1	6626000	6626000
10	Ханцуйт шүүлтүүр	1	4883760	4883760
11	Элеватор ЭЛГ 160	1	4683000	4683000
12	Силос	1	13637400	13637400
13	Бункер	3	3577900	10733700
14	Аэродинамик систем	1	2500000	25000000
15	Тоног төхөөрөмжийн угсралтын зардал	1	13000000	13000000
16	Автоматжуулалтын удирдлагын систем	1	36000000	36000000
<b>Нийт /төг/</b>				<b>147 387 860</b>

## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ



Зураг 131. Үнс хатаах технологи ажиллагааны дараалал

## **ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

### Хүснэгт 100. Цехийн ажиллах горим

№	Цехийн нэр	Хоногт ажиллах цаг	Сард ажиллах хоног	Жилд ажиллах хоног
1	Үнс бэлтгэх цех	5	22	210

### Хүснэгт 101. Цехийн хүчин чадлын хуваарилалт

№	Цехийн нэр	Цагийн хүчин чадал, тн	Хоногийн хүчин чадал, тн	Сарын хүчин чадал, тн	Жилийн хүчин чадал, тн
1	Үнс бэлтгэх цех	10	50	1 100	10 500

Үнс бэлтгэх цех нь цагт 10 тонн хүртэл хуурай үнс бэлтгэх хүчин чадалтай байхаар төлөвлөв. Ингэснээр жилд 10500 тонн үнс хатаах боломжтой. Барилгын хуурай хольц, бетон эдлэл үйлдвэрлэх цехүүдийн жилийн хэрэгцээний үнсний хэрэглээ 2458 тн гэж гарсан. Энэ хэрэгцээг нэмэгдүүлэх боломжтой. Үнс хатаах хүрдэн хатаагуурын ашиглалтыг нэмэгдүүлэх дараах боломж байна гэж үзэж байна. Үүнд:

- Хатаагуурын жилд ажиллах хугацааг багасгах
- Хатаасан үнсийг цементийн үйлдвэрт зарах
- Үнс хатаах ба механик дайрга, элс хатаах ажиллагааг нэг төхөөрөмжөөр явуулах

## **ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

### **МЕХАНИК ДАЙРГА, ЭЛС БЭЛТГЭХ ЦЕХИЙН ТАНИЛЦУУЛГА**

Барилгын хог хаягдлыг барилга, засвар болон буулгах үйл ажиллагаанаас гарсан хатуу хог хаягдал хэмээн тодорхойлдог. Барилгын хог хаягдал гэж тодорхойлсон материалууд болох мод, тоосго, бетон, шил, төмөр зэрэг нь барилга угсралт, барилга засвар, барилга буулгалтын ажлаас үүсдэг. Мөн шинэ барилга барихад цементийн хаягдал гарч дунджаар тонн цемент/ цементэн бүтээгдэхүүний 5% нь хаягдал болдог ажээ.

Ийнхүү хаягдал гарч буй гол шалтгаан нь:

- Бетон шахагч помп ажиллуулах үед гарах бетоны үлдэгдэл
- Буруу тооцоолол, төлөвлөлт
- Техникийн асуудлууд

Бетон зуурмагийн үйлдвэрүүдийн дунд 10-20 мм дайрга, 0-5 мм болон 10- 20 мм хайрга хамгийн түгээмэл ашигладаг бол бусад төрлийн түүхий эдийг бетон зуурмагийн үйлдвэрлэлд маш бага хэмжээгээр ашиглаж байна. Мөн хаягдал тоосгыг дахин боловсруулж бетонд нэмэлтээр ашиглаж болно. Барилгын хог хаягдлыг хүлээн авах тэжээгүүр, бутлуур, шигшүүр гэсэн үндсэн тоног төхөөрөмжөөр дамжин боловсруулагдана. Бэлэн болсон бүтээгдэхүүнийг бетон зуурмагийн үйлдвэрт нийлүүлнэ.

Барилгын хаягдлаас үйлдвэрлэлийн технологи

Нураасан барилгын хог хаягдлыг үйлдвэрлэн тээвэрлэн авч ирэх.

Хүлээн авах бункерээр дамжин бутлуурт өгөгдөнө.

Барилгын хог хаягдлаас бүтээгдэхүүн 3 төрлийн хэмжээгээр шигшүүрээс ангилж, 0-5мм элсийг хатаагаад дараагийн шугамруу шилжүүлнэ.

*Эх сурвалж: Каритас Чех Републикийн гаргасан “БХХДБ судалгааны тайлан ”2020*

#### **Бүтээгдэхүүний эрэлтийг тооцох**

Бүтээгдэхүүний шууд эрэлтийг тооцохын тулд бид ажилтан нэг бүрийн үйлдвэрлэж буй хайрга, дайрганы хэмжээний тухай мэдээллийг ашиглав.


Бетон зуурмагийн үйлдвэрийн ажилтны тооноос тэдгээрийн механик хайрга, дайрганы эрэлтийг тооцвол 20 ажилтантай компанид эрэлтийн хэмжээг 6340м<sup>3</sup> болж байна. Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьд хайрга, дайрганы жилийн хэрэгцээ нь 117520м<sup>3</sup> болж байна.

*Эх сурвалж: Каритас Чех Републикийн гаргасан “БХХДБ судалгааны тайлан ”2020*


Дархан –Уул аймагт 2021 оны байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа шохойн үйлдвэр жилд 37000 тн түүхий эд үйлдвэрлэж байна. Нийт 5 карьер үйл ажиллагаа явуулж жилд 3 сая м<sup>3</sup> хайрга, дайрга олборлож Улаанбаатар хот болон бусад аймагт нийлүүлж байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд барилга угсралтын 78 компани, барилгын материал үйлдвэрлэлийн 25 аж ахуй нэгж байгууллагууд ажиллаж байна.

## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ




Зураг 132. Барилгын хатуу хаягдлыг бутлах цехийн технологи дараалал





## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ



Зураг 133. Элс хатаах технологи схем

1-Хүлээн авах бункер, 2,3,5-Туузан зөөгүүр, 4-Хатаах хүрд, 6-Элеватор, 7-Ханцуйт шүүлтүүр, 8-Мэдрэгч, 9-Силос

Хүснэгт 102. Цехэд шаардлагатай тоног төхөөрөмжүүд

№	Тоног төхөөрөмж	Тоо хэмжээ	Түүхий эд
1	Тэжээгүүр	1	Механик дайрга
2	Туузан зөөгүүр	2	
3	Хацарт бутлуур	1	
4	Соронзон сеператор	1	
5	Динамик бутлуур	1	
6	Туузан зөөгүүр	2	
7	Доргиурт шигшүүр	1	
8	Ачигч	1	
9	Автоматжуулалтын удирдлагын систем	1	
9	Шанагат зөөгүүр	1	Механик элс
10	Хатаах хүрд	1	
11	Горелка	1	
12	Туузан зөөгүүр	1	
13	Ханцуйт шүүлтүүр	1	
14	Силос	1	
15	Автоматжуулалтын удирдлагын систем	1	

Хүснэгт 103. Цехийн ажиллах горим

№	Цехийн нэр	Хоногт ажиллах цаг	Сард ажиллах хоног	Жилд ажиллах хоног
1	Механик дайрга, элс үйлдвэрлэх цех	8	22	198

## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Хүснэгт 104. Цехийн хүчин чадлын хуваарилалт

№	Цехийн нэр	Цагийн хүчин чадал, тН	Хоногийн хүчин чадал, тН	Сарын хүчин чадал, тН	Жилийн хүчин чадал, тН
1	Механик дайрга, элс үйлдвэрлэх	10	80	1760	15840

Хүснэгт 105. Тоног төхөөрөмжийг худалдан авах үнэ

№	Тоног төхөөрөмж	Тоо хэмжээ, ш	Үнэ, төг
1	Тэжээгүүр	1	1,680,000
2	Туузан зөөгүүр	2	2,784,000
3	Хацарт бутлуур Access PE - 200×400	1	32,000,000
4	Соронзон сеператор	1	6,160,000
5	Роторт бутлуур ДК 400М 600х600х1200	1	9,030,000
6	Туузан зөөгүүр	2	10,096,000
7	Доргиурт шигшүүр	1	7,358,000
8	Ачигч	1	89,000,000
9	Тээвэрлэх машин	2	90,400,000
10	Хатаах хүрд	1	18,900,000
11	Горелка	1	6,626,000
12	Туузан зөөгүүр	2	3,990,000
13	Ханцуйт шүүлтүүр	1	4,883,760
14	Элеватор ЭЛГ 160	1	4,683,000
15	Силос	1	13,637,400
16	Бункер	2	3,577,900
17	Тоног төхөөрөмжийн угсралтын зардал		13,650,000
18	Автоматжуулалтын удирдлагын систем	2	70,960,000
<b>Нийт /төг/</b>			<b>397,416,060</b>

Хүснэгт 106. Шууд хөдөлмөрийн зардал

№	Албан тушаал	Хүний тоо	Цалин
1	Технологи инженер- ажилтан-1	1	1200000
2	Механик инженер-1	1	1200000
3	Цахилгааны инженер-1	1	1200000
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан-1	1	1000000
5	Оператор	1	1000000

## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Барилгын үйлдвэрлэл нь улирлын чанартай учир 3-11 дүгээр сард ажиллахаар тооцоолж үйлдвэрлэлийн төлөвлөгөөг боловсруулсан.

Хүснэгт 107. Үйлдвэрлэлийн ажлын төлөвлөгөө

	Үзүүлэлт	нэгж	2021 оны сарууд							Жилийн дүн
			3-4	5-6	7	8	9	10	11	
1	Ажиллах өдөр	өдөр	44	44	22	22	22	22	22	198
2	Нэг машины даац	тонн	25	25	25	25	25	25	25	175
3	Рейсийн тоо	удаа	4	5	5	5	5	5	5	34
4	Тээвэрлэж ирэх түүхий эдийн хэмжээ	тонн	4400	5500	2750	2750	2750	2750	2750	23650
5	Барилгын хог хаягдал	м <sup>3</sup>	2934	3666	1834	1834	1834	1834	1834	15770
6	Бетоны хольцтой хаягдлын хэмжээ	м <sup>3</sup>	2494	3079	1559	1559	1559	1559	1559	13367
<b>Эцсийн бүтээгдэхүүн</b>										
1	Механик элс <5	35%	872	1077	545	545	545	545	545	4674
2	Механик хайрга 5-10	28%	698	862	436	436	436	436	436	3740
3	Механик хайрга 10-20	37%	922	1139	576	576	576	576	576	7002

Хүснэгт 108. Бүтээгдэхүүний борлуулалтын төлөвлөгөө

1	Бүтээгдэхүүний нэр	Нэгж	2021	2022	2023	2024	2025
1	Механик элс <5	м <sup>3</sup>	4674	4907	5152	5152	5152
2	Механик хайрга 5-10	м <sup>3</sup>	3740	3927	4123	4123	4123
3	Механик хайрга 10-20	м <sup>3</sup>	7002	7355	7722	7722	7722
2	Борлуулалтын орлого	төг	2021	2022	2023	2024	2025
1	Механик элс <5	13200	61,696,800	64,772,400	68,006,400	68,006,400	68,006,400
2	Механик хайрга 5-10	11000	41,140,000	43,197,000	45,353,000	45,353,000	45,353,000
3	Механик хайрга 10-20	12000	84,024,000	88,260,000	92,664,000	92,664,000	92,664,000

## **ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ**

### **БАГА ОВРЫН БЕТОН ЭДЛЭЛ ҮЙЛДВЭРЛЭХ ЦЕХИЙН ТАНИЛЦУУЛГА**

Эрдсэн буюу органик барьцалдах материал, том ба нарийн ширхэгтэй дүүргэгч, ус, тусгай нэмэлтийг тодорхой харьцаагаар авч нэгэн төрлийн найрлагатай болтол хольж өгөгдсөн хэв, хашлагад цугтаж нягтруулаад тогтоосон технологиор бэхжүүлж гарган авсан өндөр бат бэхтэй зохиомол чулуун материалыг бетон гэнэ.

Бетон эдлэл хийх түүхий эдийн орц, найрлага

Цемент~300кг/м<sup>3</sup>

Үнс~50 кг/м<sup>3</sup>

Элс~600кг/м<sup>3</sup>

Дайрга~1200кг/м<sup>3</sup>

Ус~150кг/м<sup>3</sup>

Нийт: 2300 кг/м<sup>3</sup>



Зураг 134. QMJ4-30 маркийн бетон эдлэл үйлдвэрлэх машин

Хүснэгт 109. Техникийн үзүүлэлт

Машины марк	QTJ4-30	Горим	Механик
Хүчин чадал	12.7 кв	Хүчдэл	220/380/В
Чичирхийллийн хүч	35.5 кН	Хэвлэх хугацаа	20 сек
Хяналт	PLC	Доргиурын төрөл	Платформ доргиур
Автомат	Тийм	Хэмжээ (L*W*H)	4000*1500*2860мм
Weight	3Т	Pallet Size	850*550mm

## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ



Хэвлэх машин



Зуурагч



Хяналтын самбар



Туузан зөөгүүр



Бүтээгдэхүүн хүлээн авагч

Зураг 135. Бетон эдлэлийн үйлдвэрт хэрэглэгдэх тоног төхөөрөмжүүд



Замын тоосго



Замын эко хавтан



Замын хавтан



Даацын блок


Зураг 136. Бетон эдлэлүүд

## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ



Зураг 137. Бага маркийн бетон эдлэл үйлдвэрлэх технологи дамжлага

1, 2-зуурагч тогоо; 3-туузан зөөгүүр; 4-хэвлэх машин;  
5-асаах; 6-хяналтын самбар; 7-бэлэн бүтээгдэхүүн хүлээн авах тавцан



Зураг 138. Бага маркийн бетон эдлэл үйлдвэрлэх технологи ажиллагааны дараалал



## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Зураг 139. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлын үзүүлэлт

Бүтээгдэхүүн	Хэмжээ, мм	Эдлэлийн эзлэхүүн, м <sup>3</sup>	Цагийн хүчин чадал, ширхэг	Хоногийн хүчин чадал, ширхэг
Явган замын тоосго	240x115x53	0,00146	4680	37440
Нүхтэй блок	390x190x190	0,014	720	5760

Зураг 140. Үйлдвэрлэл, үйлчилгээний хүчин чадлын төлөвлөлт

№	Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Нэг өдөрт үйлдвэрлэх хэмжээ	Жилд ажиллах хоног	Жилийн үйлдвэрлэлийн дээд хэмжээ буюу төслийн хүчин чадал
1	Явган замын тоосго	ш	37 440	210	7 862 400
2	Нүхтэй блок	ш	5 760	210	1 209 600
	<b>Нийт</b>				<b>9 072 000</b>

Цехийн хүчин чадлыг эзлэхүүнээр илэрхийлье.

Явган замын тоосго:  $7862400\text{ш} * 0,00146\text{м}^3 = 11\,471\text{м}^3$

Нүхтэй блок:  $1209600\text{ш} * 0,014\text{м}^3 = 16\,934\text{м}^3$

Нийт:  $28\,407\text{м}^3$

Зураг 141. Шаардагдах түүхий эд

№	Түүхий эд материалын нэр төрөл	Хэмжих нэгж	1 м <sup>3</sup> зуурмагт орох хэмжээ	Жилийн нийт хэрэгцээ	Нэгжийн үнэ, төгрөг	Нийт үнийн дүн, төгрөг
1	Портландцемент	тн	0,3	8 522	172 000	1465784000
2	Элс	м <sup>3</sup>	0,5	23 861	16 500	393706500
3	Дайрга	м <sup>3</sup>	0,82	57 949	22 000	1274878000
4	Үнс	м <sup>3</sup>	0,05	1 420	-	0
5	Ус	тн	0,15	4 261	1000	4261000
	<b>Нийт</b>					<b>3 138 629 500</b>

## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

### БАРИЛГЫН ХУУРАЙ ХОЛЬЦ ҮЙЛДВЭРЛЭХ ЦЕХИЙН ТАНИЛЦУУЛГА



Эрдсэн барьцалдуулагч, дүүргэгч материал, тусгай зориулалтын полимер нэмэлт бодисыг зохистой харьцаагаар хуурайгаар хольж найруулсан бүтээгдэхүүнийг хуурай хольц гэнэ.

Хуурай хольцын технологид усны зарцуулалтыг багасгах, уян налархайжуулах нэмэлт чухал үүрэг гүйцэтгэнэ. Ус үл нэвтрүүлэх ба ан цавд тэсвэртэй, барьцалдах чадвар өндөртэй болгохын тулд хуурай хольцын найрлагад устай эмульс үүсгэх, хуурай жингийн 5%-иас ихгүйгээр усанд уусамтгай нунтаг полимер нэмэлт хийдэг

Зураг 142. Барилгын хуурай хольц үйлдвэрлэх цех

Манай улсад 10 гаруй хуурай хольцын үйлдвэр ажиллаж дотоодын хэрэгцээний 30 гаруй хувийг хангаж байгаа ба хар замаска, блокны цавуу, хөөсөнцрийн цавуу, шал тэгшлэгч, плитаны цавуу, торны цавуу, шавардлагын болон шалны бэлэн зуурмаг, цагаан замаска зэрэг хуурай хольцыг үйлдвэрлэж байна.

Энэхүү төслөөр цагт 5 тонн хуурай хольц үйлдвэрлэх цех байгуулахаар төлөвлөв.

Хуурай хольцын үйлдвэрлэлийн технологи

- 1) Түүхий эдийг бэлтгэх
- 2) Дүүргэгч материалыг хатаах, дулааны боловсруулалт хийх
- 3) Ширхэглэлээр нь шигшиж ялгах
- 4) Тугнах
- 5) Барьцалдах материал болон полимер нэмэлтийг тугнах
- 6) Хольж зуурах
- 7) Савлах
- 8) Бэлэн бүтээгдэхүүний агуулахад хураах, хадгалах

Хуурай хольцод тавигдах шаардлага

/MNS6424-2013 Барилгын ажилд хэрэглэх цавуу. Техникийн шаардлага/


Чийглэг - Хуурай цавууны чийглэг жингийн 0,2%-иас ихгүй байна.

Нунтаглалт - Зарим үйлдвэрүүд байгалийн нарийн ширхэгтэй элсийг нунтаглахгүйгээр шууд савлан нийлүүлж байгаа нь нунтаглалтын шаардлагыг хангахгүй байна.

Нунтаглалтын шаардлага нь 02 шигшүүр дээрх үлдэгдэл 15%-иас ихгүй байна.


Асгаасан нягт - Хуурай цавууны асгаасан нягт  $1200\text{кг}/\text{м}^3$ -ээс багагүй,  $1800\text{кг}/\text{м}^3$ -ээс ихгүй байна.

## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ



Зураг 143. Барилгын хуурай хольц үйлдвэрлэх технологи ажиллагааны дараалал

1-клапан, 2-шүүлтүүр, 3-силос, 4-буулгах хаалт, 5-шурган зөөгүүр, 6-жингийн тугнуур, 7-хуурай хольц холигч, 8-ачаалах бункер, 9- завсрын бункер, 10-хаалт, 11-савлах машин, 12-туузан зөөгүүр, 13-шүүх төхөөрөмж



Зураг 144. Барилгын хуурай хольц үйлдвэрлэх технологи схем

### Хүснэгт 110. Цехийн ажиллах горим

№	Цехийн нэр	Хоногт ажиллах цаг	Сард ажиллах хоног	Жилд ажиллах хоног
1	Барилгын хуурай хольц үйлдвэрлэх цех	8	22	210

## ХАВСРАЛТ-4. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЖИШИГ ТӨСӨЛ

Хүснэгт 111. Цехийн хүчин чадлын хуваарилалт

№	Цехийн нэр	Цагийн хүчин чадал,тн	Хоногийн хүчин чадал, тн	Сарын хүчин чадал, тн	Жилийн хүчин чадал, тн
1	Барилгын хуурай хольц	5	40	880	8400

### Шаардагдах материал, түүхий эдийн зардал

Үйлдвэрлэл үйлчилгээ явуулахад шаардагдах материал түүхий эдийн зардлыг жилийн үйлдвэрлэлт борлуулалтын төлөвлөгөөнд тулгуурлан материал түүхий эдийн зарцуулалтын буюу орцын норм, зах зээлийн үнэ зэргийг харгалзан тооцож нэгтгэнэ. Жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг ханган биелүүлэхэд шаардагдах үндсэн ба туслах материал түүхий эдийн зардлын хэмжээг харуулав.

Хүснэгт 112. Барилгын хуурай хольц үйлдвэрлэх цехийн түүхий эд, материал судалгаа

№	Түүхий эд, материалын нэр	Түүхий эдийн хувь хэмжээ, %	1 тонн хуурай хольцод орох хэмжээ, тн	Нэгжийн үнэ, төгрөг	Жилийн хэрэгцээ, тн	Жилд зарцуулагдах түүхий эдийн зардал, төгрөг
1	Цемент	25	0.25	172 000	2100	361 200 000
2	Гөлтгөнө	8	0.08	1 000	672	672 000
3	Хатаасан үнс	12	0.12	-	1008	-
4	Механик элс	50	0,5	-	4200	-
5	Химийн нэмэлт	5	0,05	2 800 000	420	1 176 000 000
<b>Нийт тоо хэмжээ</b>		<b>100</b>	<b>1</b>		<b>8400</b>	<b>1 537 872 000</b>

Хүснэгт 113. Барилгын хуурай хольц үйлдвэрлэх цехийн тоног төхөөрөмжийн зардал

№	Төхөөрөмжийн нэрс	Тоо ширхэг	Үнэ, рубль
1	Жингийн тугнуур БД600	1	3 073 250
2	Хуурай хольц холигч	1	
3	Нэмэлтийн бункер БД 50	1	
4	Силос	3	
5	Шурган зөөгүүр	3	
6	Савлах машин	1	871 200
7	Тоос суулгах систем	1	1 038 000
8	Компрессор К-2	1	
9	Автоматжуулалтын удирдлагын систем	1	
<b>Нийт үнийн дүн, рубль</b>			<b>4 982 450</b>
<b>Нийт үнийн дүн, төгрөг</b>			<b>184 450 299</b>

## ХАВСРАЛТ-5. ЭМНЭЛГИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ ЖИШИГ ТӨСӨЛ

### ХАВСРАЛТ-5. ЭМНЭЛГИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ ЖИШИГ ТӨСӨЛ

#### Эмнэлгийн хаягдал устгах бага хүчин чадлын цехийн судалгаа

Дархан сумд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 52156 кг /52.15 т/ эмнэлгийн хог хаягдал үүссэн ба үүнээс аюулгүй эмийн хайрцаг 8.73 тн, халдвартай хог 41.52 тн, эмгэг хог 1.96 тн тус тус үүссэн байна. Сард 4.3 тн, хоногт 0.2 тн эмнэлгийн хог хаягдал үүсэж байна нь судалгаагаар гарсан.



Дархан сумд эмнэлгийн аюултай төрлийн хог хаягдал үүсгэдэг Эрүүл мэндийн байгууллага болон эмийн сан, зарим байгууллагуудаас Нэгдсэн эмнэлэг нь хамгийн ихээр хог хаягдал үүсгэдэг болох нь тогтоогдсон ба 21.5 тн/жил хог хаягдал буюу нийт хаягдлын 41.2%-ийг үүсгэж байна. Нэгдсэн эмнэлгээс 3 км-ийн радиуст Дархан сумын эрүүл мэндийн салбарын 50 орчим хувь нь даган оршиж байгаа зэрэг нь хог хаягдал цуглуулах, ариутгах цэгийг Нэгдсэн эмнэлгийн байршил дээр байгуулах нь эдийн засгийн хувьд тээвэрлэлтийн зардлыг бууруулах, тээвэрлэлтийн цаг хугацааг хэмнэх зэрэг олон давуу талуудтай болох нь харагдаж байна.



Зураг 145. Хог татан төвлөрүүлэх болон боловсруулах цэгийн байрлал.




Эмнэлгийн хог хаягдлыг цуглуулах, ариутгах, устгах цехийн технологи нь дээр дурдагдсан “Элемент” ХХК жишиг технологи дээр суурилсан тээвэрлэлт, ариутгал, устгал, ландфилл гэсэн шат дамжлагатай байх ба эмнэлгийн хаягдал устгах бага хүчин чадалтай цехэд шаардлагатай тоног төхөөрөмж, машин техникийг жагсаалт гаргалаа.

## ХАВСРАЛТ-5. ЭМНЭЛГИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ ЖИШИГ ТӨСӨЛ

Хүснэгт 114. Шаардлагатай тоног төхөөрөмж, машин техник



№	Шат дамжлага	Техник, төхөөрөмж
1	Хог хаягдлыг цуглуулах	Одоо Нэгдсэн эмнэлэгт эмнэлгийн хаягдлыг цуглуулж байгаа зарчмыг хэвээр нь ашиглах /зардал гарахгүй/
